

**Гарчиг**

ЕРӨНХИЙ ХЭСЭГ.....	4
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УВС АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ОДООГИЙН БАЙДАЛ .....	6
1.1. Хүн ам зүй .....	6
1.1.1. Хүн амын тоо .....	6
1.1.2. Хүн амын суурьшлын төлөв байдал.....	7
1.1.3. Хүн амын насны бүтэц: .....	9
1.2. Нийгэм, эдийн засаг.....	10
1.2.1. Аж үйлдвэр .....	10
1.2.2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт .....	13
1.2.3. Барилгын салбар:.....	15
1.2.3. Дэд бүтэц.....	17
1.2.4. Тээвэр, харилцаа холбоо:.....	18
1.2.5. Боловсрол.....	19
ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ЦАГ УУРЫН ОНЦЛОГ .....	20
2.1. Газрын гадарга,газарзүйн онцлог.....	20
2.1.1.Газарзүй.....	20
2.1.2 Газрын гадарга.....	21
2.2. Уур амьсгалын үндсэн нөхцөл. ....	23
2.2.1. Аргачлал, мэдээ мэдээлэл.....	23
2.2.2. Дулааны горим .....	23
2.2.3. Чийгийн горим.....	29
2.2.4 Салхины горим .....	31
2.2.5. Ургамлын дулааны хангамж. ....	34
2.2.6. Ургамлын чийгийн хангамж. ....	38
2.3. Уур амьсгалын өөрчлөлт.....	41
2.3.1. Агаарын температур .....	41
2.3.2 . Хур тунадас.....	44
2.4. Бэлчээрийн ургамал, ургац .....	44
2.4.1. Цэвдэг .....	47
2.4.2. Өндөр уулын мөнх цас, мөс ба цасан бүрхүүл.....	49
2.4.3. Усны нөөц .....	49
2.5. Байгалийн гамшиг.....	51
2.5.1. Гамшигт үзэгдлийн давтагдал.....	51
2.5.2. Цөлжилт. ....	51
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЛАНДШАФТ, НУТАГ ДЭВСГЭРИЙН ЦОГЦОЛБОР НӨХЦЛИЙН МУЖЛАЛТ, ТОЙРГУУД.....	53
3.1. Байгаль, нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийн мужлалт .....	53
3.2. Байгаль, нутаг дэвсгэрийн муж, тойргуудын онцлог .....	54
3.2.1. Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон муж, Хан Хөхийн нурууны ойт хээр бүхий тойрог (Х-3).....	54
3.2.2. Монгол - Алтайн өндөр уулын муж, Хархираа-Түргэний өндөр уулс, хотгорын тойрог (Х-11).....	61
3.2.3. Алтайн ар говийн цөлөрхөг муж, Увс нуурын хотгорын тойрог (Г-1), Хяргас нуурын хотгорын тойрог (Г-2).....	68
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР АШИГЛАЛТЫН БАЙДАЛ .....	79
4.1. Малын тоо, толгой, өсөлт .....	79
4.1.1. Эрчимжсэн мал аж ахуй .....	81
4.2. Бэлчээрийн газрын ангилал. ....	83
4.2.1. Бэлчээр усжуулалтын байдал.....	89

4.2.2. Бэлчээр хадлангийн газарт гарсан хохирлын байдал .....	93
4.3. Хадлан, тэжээлийн байдал .....	94
4.3.1 Хадлангийн газрын байршил, түүний нөөц .....	96
4.3.2. Бэлчээр, хадлангийн газрын хамгаалалт .....	97
4.4. Тариалангийн газрын ашиглалт .....	98
<b>ТАВДУГААР БҮЛЭГ. ХҮН АМ, СУУРЬШЛИЙН БҮС НУТАГ</b> .....	103
5.1. Хот тосгон бусад суурин газрын одоогийн байдал .....	103
5.2. Хот, суурин газар, суурьшлийн бүсийн инженер-геологийн нөхцөл .....	105
5.2.1. Газрын гадарга .....	105
5.2.2. Өндөржилт .....	105
5.2.3. Ус зүй, усан хангамж .....	106
5.2.4 Ул хөрсний ус .....	106
5.2.5. Инженер-геологийн үйл явц .....	106
<b>ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ЗАМ, ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗАР</b> .....	107
6.1. Зам, тээврийн зорулалттай газрын одоогийн байдал .....	107
6.2. Шугам сүлжээний газрын одоогийн байдал .....	111
<b>ДОЛООДУГААР БҮЛЭГ. ОЙН САН БҮХИЙ ГАЗАР</b> .....	115
7.1. Ойн сан бүхий газрын өнөөгийн байдал .....	115
7.2. Ойн сангийн газрын хэмжээ, өөрчлөлт .....	117
7.3. Тусгай хамгаалалттай газар нутгийн ойн сан .....	120
7.4. Ой зохион байгуулалтын арга хэмжээний талаар .....	120
7.5. Ойн бүс тэдгээрийн ашиглалт хамгаалалтын дэглэм .....	122
7.6. Ойг нөхөн сэргээх шаардлага .....	126
7.7. Ойг хамгаалах арга хэмжээний талаар .....	126
7.7.1. Ойг түймрээс хамгаалах арга хэмжээний талаар .....	127
7.7.2. Ойн хөнөөлт, шавьж, өвчнөөс хамгаалах арга хэмжээний талаар .....	128
7.8. Ойн төлөв байдал, чанар үнэлгээ, таксацын үзүүлэлтийн өөрчлөлт .....	128
7.9. Сүүлийн жилүүдэд ойг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хийгдсэн ажлууд .....	130
<b>НАЙМДУГААР БҮЛЭГ. УСАН САН БҮХИЙ ГАЗАР, УСНЫ САВ ГАЗРУУДЫН ТӨЛӨВ БАЙДАЛ</b> .....	137
8.1. Ерөнхий байдал .....	137
8.1.1. Ус ашиглалтын одоогийн байдал .....	138
8.2. Гадаргын усны горим, төлөв байдал .....	144
8.3. Усны сав газрууд .....	146
8.3.1. Увс аймгийн нутаг дэвсгэрт хамаарах усны сав газрууд .....	146
8.3.2. Увс аймаг дахь усны сав газруудын усны нөөц, горим .....	148
8.4. Усны сав газрын үндсэн гол горхи, нууруудын тодорхойлолт .....	152
8.4.1 Хяргас нуур-Завхан голын сав газар .....	152
8.4.2 Хар нуур-Ховд голын сав газар .....	153
8.4.3. Увс нуур-Тэсийн голын сав газар .....	154
8.4.4. Увс аймгийн 0.5км <sup>2</sup> -аас дээш талбайтай нуур тус бүрийн товч тайлбар, тодорхойлолт .....	155
<b>ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР</b> .....	163
<b>АРАВДУГААР БҮЛЭГ. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, АМРАЛТ ЗУГААЛГЫН БҮС НУТГИЙН СУДАЛГАА</b> .....	181
9.1. Аялал жуулчлалын тохиромжтой газрууд .....	182
9.2. Түүх соёлын дурсгалт газрууд .....	186
9.3. ХанХөхий нурууны Улсын тусгай хамгаалалттай газар нутгаар аялах аялал жуулчлалын маршрут .....	190
9.3.1. Маршрут Хяргас-Ханхөхий аялал .....	190
9.3.2. Эмчилгээний аяллын маршрут .....	192
9.3.3. Уулын бүсийн аяллын маршрутын санал .....	193

9.3.4. Сагил сумын аяллын маршрут 3 – 5 хоног .....	196
9.3.5. Ховд сумын аялал жуулчлалын маршрут 5 – 7 хоног .....	197
9.3.6. Тариалан сумын аялал жуулчлалын маршрут 3 – 5 хоног .....	198
АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ . УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ОДООГИЙН БАЙДАЛ .....	199
11.1. Уул уурхайн газрын ашиглалтын өнөөгийн байдал, нөөцийн үнэлгээ .....	199
Ашигласан материалын жагсаалт .....	223

## ЕРӨНХИЙ ХЭСЭГ

Газар нь байгаль, дэлхийн үүсэл хөгжлийн дүнд бий болсон байгалийн бүх баялгийг өөртөө агуулсан сав шимийн цогц учир түүний ашиглалтын хэм хэмжээ нь өөрийнх нь унаган чадавхи, бодит нөхцөл, нөөцөөр тодорхойлогддог.

Аймаг, орон нутгийн бие даасан тогтвортой хөгжлийг хангахад байгалийн нөөц баялгийг экологид сөрөг нөлөөлөлгүйгээр ашиглах нь юу юунаас чухал. Үүнийг шийдвэрлэхэд газрын нөхцөл, нөөцийг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоож, газрын экологийн чадавхид тохирсон үйл ажиллагааг явуулах, нийгмийн хэрэгцээ шаардлагын дагуу байгалийн баялгийг газраар дамжуулан эдийн засгийн салбаруудаар ээлж дараатайгаар эргэлтэнд оруулах, оновчтой хувиарлаж, урт хугацааны туршид үр ашигтай тогтвортой ашиглуулах явдал юу юунаас чухал байна.

Монгол Улс 1990 оны эхээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нэгдэж, экологид тулгуурласан нийгэм-эдийн засгийн хөгжлийн жишгийг хүлээн зөвшөөрсөн орон учраас газар болон газраас үндэстэй байгалийн нөөцийг экологийн элдэв төрлийн доройтолгүй ашиглах үндэсний хэмжээний бодлогыг хэрэгжүүлж байна. Үүнийг хэрэгжүүлэх нэг гол нөхцөл нь эдийн засгийн хөгжлийн бүсчлэлийн ерөнхий бүдүүвчтэй уялдсан салбарын хөгжлийн бодлогыг тодорхойлж, түүнд шаардлагатай газрын хэмжээ, байршлыг оновчтой тогтоож, газрыг урт хугацааны туршид экологийн болон эдийн засгийн хувьд үр ашигтай ашиглах явдал юм. Газрын харилцааны өнөөгийн нөхцөлд үүнийг хэрэгжүүлэх механизм нь аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө юм.

Ажлын даалгаварт заасанчлан энэхүү ажлын зорилго нь Увс аймгийн бэлчээрийн ба эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, хүн амын хотжилт ба нутагшил суурьшил, дэд бүтэц, аялал жуулчлал, амралт, сувилал зэрэг тэргүүлэх салбаруудыг хөгжүүлэхэд шаардагдах газрын нөхцөл, нөөц, төлөв байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, газрыг үр ашигтай оновчтой ашиглах, эзэмших, бүсийн экологи-эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хадгалан бие даан хөгжих боломжийг газар зохион байгуулалтын төлөвлөлтийн аргаар нээн харуулахад оршино.

Газрын суурь судалгааны үр дүнд Увс аймгийн байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийг бодитойгоор илрүүлэх, газрыг зориулалтын дагуу урт хугацааны туршид тогтвортой ашиглах, ашиглалтын зориулалт бүрт нийцсэн ашиглалт-хамгаалалтын горимыг тогтоох, ашиглалтын зориулалтыг шинэчлэхэд үүсэх экологи-эдийн засгийн үр ашгийг тооцоход шаардлагатай бүх төрлийн мэдээлэл цуглуулсан юм. Үүнд:

1. Увс аймгийн тухай ерөнхий ойлголт
2. Увс аймгийн байгаль цаг уур, онцлог нөхцөл
3. Ландшафт, тойргууд
4. Увс аймгийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал,

5. Хүн амын тоо, өсөлт, шилжилт хөдөлгөөн
6. Хөдөө аж ахуйн газрын ашиглалтын одоогийн байдлын судалгаа
7. Ойн сан бүхий газар ашиглалтын одоогийн байдлыг судалгаа
8. Усан сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтын одоогийн байдал
9. Хот суурины газар, суурьшлийн бүсийн төлөв байдал,
10. Зам шугам сүлжээний газрын одоогийн байдал
11. Тусгай хэрэгцээний газрын судалгаа
12. Увс аймгийн аялал, жуулчлал, амралт зугаалгын газрын одоогийн байдал, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ
13. Увс аймгийн газар нутаг дээрхи ашигт малтмалын судалгаа тэдгээрийн хайгуул, ашиглалтын одоогийн байдал зэрэг хүчин зүйлсийн мэдээллийг оруулсан болно.

Энэ зорилгын хүрээнд бүс нутгийн газрын нэгдмэл сангийн ашиглалт хамгаалалтын одоогийн байдал, цаашид төлөвлөлтийн үе шатуудаар хэрхэн яаж өөрчлөгдөх, газрын доройтлыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, доройтолд орсон газруудыг нөхөн сэргээх зэрэг үндсэн асуудлыг шийдэхэд түлхэц өгөх юм.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УВС АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ОДООГИЙН БАЙДАЛ

Улс орны нийгэм-эдийн засгийн хөгжил, хүн амын амьдрал, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа нь газар болон түүний нөөц баялагтай салшгүй холбоотой учраас бүс нутгийн газар ашиглалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг зохиохдоо нийгэм эдийн засгийн голлох үзүүлэлтүүд, тэдгээрийн хөгжлийн төвшинтэй уялдуулах шаардлагатай байдаг.

Увс аймаг нь Монгол орны баруун хязгаарт төвлөрсөн зах зээлээс нилээд алслагдмал орших боловч баруун талаараа Баян-Өлгий аймаг, Хойд талаараа ОХУ-ын Тува, урд талаараа Ховд, Завхан аймгуудтай хил залган оршдог нь бүсийн худалдаа-эдийн засгийн харилцааг хөгжүүлэхэд нэн таатай нөхцлийг бүрдүүлдэг.

### 1.1 . Хүн ам зүй

#### 1.1.1. Хүн амын тоо

Увс аймаг 2014 оны 1 дүгээр сарын байдлаар 73.8 мянган хүн амтай. 19.7 мянган өрхтэй, нийт хүн амын 30.9 хувь нь хот, 69.1 хувь нь хөдөөгийн хүн ам. Тэдгээрийн 40.2% нь дөрвөд, 35.2 % нь баяд, 15.3 % нь халх, 9.3 % нь хотон болон бусад ястан амьдардаг. Тус аймагт хамгийн олон тоотой ястан нь дөрвөдүүд. Дөрвөдүүд Бөхмөрөн, Давст, Өлгий, Өмнөговь, Сагил, Түргэн, Ховд сумдын нийт нутгаар, Улаангом, Наранбулаг сумын нутгийн зүүн хагаст оршин сууж байна. Баядууд ихэвчлэн Тэс, Зүүнговь, Малчин, Хяргас сумдад, халхууд Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан, Баруунтуруун сумдад, харин хотон ястан Тариалан суманд байдаг.

Монгол улсын хэмжээнд хүн амын тоогоороо бусад аймгуудтай харьцуулахад 2000 онд 8 дугаарт жагсаж байсан бол 2013 онд 11 дүгээрт жагсаж хүн амын тоо буурсан боловч, баруун бүсийн аймгуудаас 2000 онд ганцхан Говь-Алтай аймгийн өмнө орж байсан бол 2013 онд Говь-Алтай, Завхан аймгуудын өмнө орж байна.

Суурин амдарч байгаа хүн ам 2000 оноос 12.1 мянган хүнээр буюу 13.8 хувиар, 2005 оноос 5.4 мянган хүнээр буюу 6.7 хувиар тус тус буурч, харин 2012 оноос 1.5 мянган хүнээр буюу 2.0 хувиар өссөн байна. 2000 оноос хойш хүн амын тооны өсөлтийн хурдыг хронологын дунджын аргаар тооцож үзэхэд жил бүр 1.3 хувиар хүн амын өсөлт буурч байсан байна.

Нэг өрхөд 3.7 хүн ногдож байна. Энэ үзүүлэлт нь 2000 оноос 0.49 пунктээр, 2005 оноос 0.36 пунктээр, 2010 оноос 0.06 пунктээр, 2012 оноос 0.01 пунктээр тус тус буурч байна. Хүйсийн харьцаа 2000 онд 100.2, 2005 онд 98.1, 2010 онд 100.5, 2013 онд 99.2 байгаа нь манай аймгийн хүн амд эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь ойролцоо байгаа бөгөөд хүйсийн тэнцвэртэй байдлыг харуулж байна. Энэ онд хүйсийн харьцаа 99.2 байгаа нь 100 эмэгтэйд 99 эрэгтэй ногдож байна.

Улсын дундаж наслалт 2000 онд 63.2 аймгийн дундаж наслалт 60.9 байсан бол 2013 онд улсын дундаж наслалт 69.1, аймгийн дундаж наслалт 67.7 болж жил дараалан нэмэгдэж байна. Улсын дундаж наслалт 2000 оныхоос 5.9 жил, 2005 оноос 3.9 жил, 2012

оноос 0.4 жил, мөн аймгийн дундаж наслалт 2000 оныхоос 6.8 жил, 2005 оныхоос 4.9 жил, 2012 оныхоос 0.4 жилээр тус тус нэмэгдсэн байна.

Улсын хэмжээнд хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалт 2013 оны байдлаар 69.1, эрэгтэйчүүдийнх 65.4, эмэгтэйчүүдийнх 75.0 байна. Монгол улсын хэмжээнд манай аймгийн хүн амын дундаж наслалт 67.7 байгаа нь 21 аймгийн сүүлээсээ хоёрдугаарт Хөвсгөл аймгийн өмнө орж байна.

Аймгуудын хувьд хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалтыг үзэхэд Баян-Өлгий, Дундговь, Төв, Булган, Говьсүмбэр аймаг улсын дунджаас харьцангуй өндөр буюу 2.3-3.5 жилээр их, Дорнод, Хөвсгөл аймаг харьцангуй бага буюу 1.3-3.9 жилээр бага байна. Дундаж наслалтын ялгаатай байдал нь тухайн аймгийн нас баралтын түвшин, ялангуяа нялхсын нас баралттай холбон тайлбарлаж болно.

Улсын хэмжээнд 1990 оноос хойш хүн амын жилийн цэвэр өсөлт буурч байсан ч сүүлийн 3 жилд төрөлт нэмэгдэж 1000 хүн амд ногдох төрөлт 2006 онд 19.0 болж, 2005 оныхоос 1.2 пунктээр нэмэгдэж байсан бол 2010 онд дахин буурч 23.1 болж 2009 оноос 2.4 пунктээр буурсан бол энэ онд 2012 оноос 1.5 пунктээр өссөн байна. Аймгийн 1000 хүн амд ногдох төрөлт улсын дунджаас 2000 онд 6.0 пунктээр, 2005 онд 3.8 пунктээр, 2010 онд 3.1 пунктээр, 2013 онд 0.2 пунктээр тус тус дээгүүр байна. /Үндэсний статистикийн хорооны мэдээлэлээс/

### 1.1.2. Хүн амын суурьшлын төлөв байдал


Увс аймаг нь засаг захиргааны нэгжийн хувьд хүн амынхаа тоо хэмжээгээр харилцан адилгүй 19 сумаас бүрддэг. 2013 оны жилийн эцсийн статистикийн судалгаагаар аймгийн нийт хүн ам 75518 гэж бүртгэгдсэнээс эрэгтэй 37598, эмэгтэй 37920 байна. Үүнээс аймгийн төвд нийтдээ 25574, эрэгтэй 12561, эмэгтэй 13013. Сумын төвд нийтдээ 15441 хүн байна гэж бүртгэгдсэнээс эрэгтэй 7621, эмэгтэй 7820 байна. Харин хөдөөд нийтдээ 34503 хүн тоологдсоноос эрэгтэй 17416, эмэгтэй 17087 байна гэж тус тус бүртгэгдсэн байна.

Хүснэгт № 1.1. Хүн амын тоо, байршилаар, сумаар

Сумдын нэр	Нийт хүн ам	Үүнээс										
		Эрэгтэй	Эмэгтэй	Аймгийн төвд			Сумын төвд			Хөдөөд		
				Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
Баруунтуруун	2,385	1217	1168	0	0	0	1427	702	725	958	515	443
Бөхмөрөн	2,180	1108	1072	0	0	0	787	391	396	1393	717	676
Давст	1,748	870	878	0	0	0	585	284	301	1163	586	577
Завхан	1,722	829	893	0	0	0	639	306	333	1083	523	560
Зүүнговь	2,231	1241	1172	0	0	0	702	354	348	1711	887	824
Зүүнхангай	2,231	1137	1094	0	0	0	1202	630	572	1029	507	522
Малчин	2,404	1228	1176	0	0	0	643	326	317	1761	902	859
Наранбулаг	4,356	2171	2185	0	0	0	1058	524	534	3298	1647	1651
Өлгий	2,121	1059	1062	0	0	0	434	216	218	1687	843	844
Өмнөговь	4,348	2144	2204	0	0	0	956	448	508	3392	1696	1696
Өндөрхангай	3,155	1573	1582	0	0	0	991	498	493	2164	1075	1089
Сагил	2,267	1164	1103	0	0	0	565	282	283	1702	882	820

Тариалан	3,679	1819	1860	0	0	0	1350	669	681	2329	1150	1179
Түргэн	2,015	1000	1015	0	0	0	727	360	367	1288	640	648
Тэс	5,280	2673	2607	0	0	0	877	429	448	4403	2244	2159
Ховд	2,222	1078	1144	0	0	0	816	394	422	1406	684	722
Хяргас	2,426	1248	1178	0	0	0	721	362	359	1705	886	819
Цагаанхайрхан	1,972	994	978	0	0	0	961	446	515	1011	548	463
Улаангом	26,594	13045	13549	25574	12561	13013	0	0	0	1020	484	536
<b>Нийт</b>	<b>75518</b>	<b>37598</b>	<b>37920</b>	<b>25574</b>	<b>12561</b>	<b>13013</b>	<b>15441</b>	<b>7621</b>	<b>7820</b>	<b>34503</b>	<b>17416</b>	<b>17087</b>

Зураг№ 1.1. Хүн амын тоо, байршлаар



Аймгийн нийт хүн амын 35% буюу 26594 хүн Улаангом хотод, Тэс сум 7% буюу 5280, Өмнөговь, Наранбулаг сумдууд 6% буюу 4348 - 4356, Тариалан сум 5% буюу 3679, Өндөрхангай 4% буюу 3155, Мөн аймгийн ихэнх сум болох Цагаанхайрхан, Хяргас, Ховд, Түргэн, Сагил, Өлгий, Малчин, Зүүнхангай, Зүүнговь, Баруунтуруун, Бөхмөрөн сумдууд нийт хүн амын 3% буюу 2015 – 2426 хүн, харин Завхан, Давст сумд нь 2% буюу 1722-1748 хүнтэй гэж тус тус бүртгэгдсэн болно.


Хүснэгт№ 1.2. Нийт өрхийн тоо

Сумдын нэр	2010	2011	2012	2013
Улаангом	6,770	6,977	7,043	7,404
Баруунтуруун	746	736	745	726
Бөхмөрөн	562	536	539	544
Давст	437	449	448	442
Завхан	499	489	495	497
Зүүнговь	675	660	647	656
Зүүнхангай	656	613	631	630
Малчин	637	636	644	633
Наранбулаг	1,042	1,042	1,049	1,047
Өлгий	531	535	541	555
Өмнөговь	1,035	1,044	1,068	1,045
Өндөрхангай	924	859	858	871
Сагил	632	607	600	628
Тариалан	896	897	894	902



Түргэн	532	540	535	546
Тэс	1,299	1,298	1,277	1,290
Ховд	627	643	628	621
Хяргас	651	649	619	630
Цагаанхайрхан	581	589	584	581
<b>Нийт</b>	<b>19,732</b>	<b>19,799</b>	<b>19,845</b>	<b>20,248</b>


Зураг№ 1.2. Хүн амын дундаж өсөлтийн хувь, сумдаар:



Графикаас харахад сүүлийн нэг жилийн хугацаанд аймгийн хэмжээнд Улаангом сум хамгийн их өсөлт 6.0 хувь буюу 1496 хүнээр нэсэгдсэн бол бууралтын хувьд хамгийн их Зүүнговь сум -7.8 хувь буюу 203 хүнээр буурсан байна. Өмнөговь, Завхан, Өлгий, Улаангом, Ховд, Өндөрхангай, Сагил, Бөхмөрөн, Тэс, Хяргас, Цагаанхайрхан, Зүүнхангай, сумдын суурин хүн ам өнгөрсөн оноос 0.1-6.0 хувиар өсч бусад сумдын хүн амын тоо 0.1-/-7.8/ хувиар буурсан байна.

### 1.1.3. Хүн амын насны бүтэц:

Аймгийн нийт хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2005 онд 50.4%, 2010 онд 49.9%, 2013 онд 50.2 %-ийг тус тус эзэлж байна.




Зураг№ 1.3. Нийт хүн ам, мянган хүнээр, хүйсээр

Хөдөлмөр эрхлэж буй 32.5 мянган хүн үүнээс төрийн албан хаагч 3.8 мянга. Ажилгүйдлийн түвшингээр Баян-Өлгий аймгийн дараа 2 дугаарт ордог . 2010 оны байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүд 1230 болж, сүүлийн 4 жилийн дундаас 23.5 % буурчээ.

## 1.2. Нийгэм, эдийн засаг

### 1.2.1. Аж үйлдвэр


Аж үйлдвэрийн чиглэлээр 89 аж ахуйн нэгж үйл ажиллагаа эрхэлж 2014 оны эхний 6 сард 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2.4 тэрбум төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 16.8 %-иар буюу 343.8 сая төгрөгөөр өссөн байна.




Зураг№ 1.4. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт /сая төг, 2014оны зэрэгцүүлэх үнээр/

Оны үнээр 3.0 тэрбум төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэж 3.5 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн оны мөн үеэс үйлдвэрлэлт 16.8, борлуулалт 16.5%-иар өслөө.

Зураг№ 1.5. Нийт бүтээгдэхүүн, борлуулалтын орлого /оны үнээр, сая төг /



Нийт үйлдвэрлэлийн 41.7%-ийг дулаан түгээлт усан хангамж, 42.3%-ийг боловсруулах салбарын үйлдвэрлэл, 16.0%-ийг уул уурхай олборлолт эзэлж байна.




Зураг№ 1.6. Аж үйлдвэрийн салбарын бүтэц

Дэд салбараар тооцвол нийт үйлдвэрлэлтийн 18.5%-ийг хүнс ундааны үйлдвэрлэлт, 39.7%-ийг дулаан үйлдвэрлэлт, 18.5%-ийг уул уурхайн олборлолт, 13.6%-ийг барилгын материалын үйлдвэрлэл, 6.1%-ийг өлөн гэдэс боловсруулалт, 2.1%-ийг усан хангамж, 2.7%-ийг арьс шир, гутал үйлдвэрлэл, 0.4%-ийг мод модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 0.4%-ийг хувцас үйлдвэрлэл, 0.4%-ийг бусад боловсруулах үйлдвэрлэл эзэлж байна.



Зураг № 1.7. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн бүтэц

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад аж үйлдвэрийн салбарт эзлэх уул уурхай олборлолтын салбар 6.1 пунктээр өсч, боловсруулах үйлдвэр 4.1 дулаан түгээлт усан хангамжийн салбар 2.0 пунктээр буурсан байна.



Зураг № 1.8. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлт бууралт / 2010 I-VI=100% /

Хүснэгт № 1.3. Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

Салбарын ангилал	НБ,оны үнээр, 2013 I-XII	2005 оны зэрэгцүүлэх үнээр				
		2009 I-XII	2010 I-XII	2011 I-XII	2012 I-XII	2013 I-XII
<b>1.Эрчим хүч түгээлт усан хангамж</b>	2380.5	1010.9	1145.3	1124.4	1553.5	1680.7
Үүнээс: Дулаан	2262.5	936.0	1070.5	1045.8	1461.6	1607.1
Цахилгаан	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Усан хангамж	118.0	74.9	74.8	78.6	91.9	73.6
<b>2. Уул уурхай олборлолт</b>	1116.6	680.4	696.7	624.4	346.0	481.7

Үүнээс: Алт		308.3	314.9	26.2		
Нүүрс	1116.6	372.1	381.8	598.2	346.0	481.7
Давс						
<b>3. Боловсруулах үйлдвэр</b>	4976.6	3340.6	3943.0	4318.8	2190.3	2016.1
<b>3а. Хүнс ундааны үйлдвэрлэл</b>	3385.0	3001.7	3333.2	3658.4	1427.6	1162.2
Үүнээс: Мах загас	1495.6	1095.4	1124.8	1436.1	80.6	341.8
Сүү сүүн бүтээгдэхүүн	10.3	6.7	0.5	3.0	4.6	4.6
Гурил гурилан бүтээгдэхүүн	1428.7	158.6	251.1	356.7	370.3	630.9
Ундаа архи	367.2	1711.0	1906.7	1805.2	915.0	128.2
Хүнсний бусад бүтээгдэхүүн	83.2	30.0	50.1	57.4	57.1	56.7
<b>3б. Бусад боловсруулах үйлдвэр</b>	1591.6	338.9	609.8	660.4	762.7	853.9
Үүнээс: Хувцас үйлдвэрлэлт	25.0	3.4	6.9	3.9	4.6	11.6
Мод модон бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	53.6	24.6	52.5	43.7	55.4	39.2
Барилгын материал үйлдвэрлэлт	944.2	59.4	282.5	314.1	404.3	506.3
Арьс шир гутлын үйлдвэрлэл	228.7	30.0	30.9	49.8	126.3	128.8
Өлөн боловсруулалт	257.5	198.8	215.4	200.1	147.8	124.9
Бусад боловсруулах үйлдвэрлэлт	82.6	22.7	21.6	21.5	24.3	43.1
Бүгд	8473.7	5031.9	5785.0	6067.6	4089.8	4178.5
Борлуулалтын орлого /оны үнээр/	8766.6	9068.7	11975.5	13370.4	8698.4	8766.6
Ажиллагсдын тоо	-	572	607	705	730	752
Хөдөлмөрийн бүтээмж /сая төг/	-	8.8	9.5	8.6	5.6	5.6

**1.2.2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт****МАА-н үйлдвэрлэл**

Мал аж ахуйн салбарт нядалгааны жингээр 25484.9 тонн мах, 22337.1 тонн сүү, 1255.1 тонн хонины ноос, 279.3 тонн ноолуур, 63.5 тонн тэмээний ноос, 559.2 мянган ширхэг арьс, шир үйлдвэрлэв. Өмнөх оныхтой харьцуулахад иахны үйлдвэрлэл, нядалгааны жингээр 16315.3 тонн, сүүний үйлдвэрлэл 2399.4, ноолуур 17.2, хонины ноос 160.1, тэмээний ноос 5.6 тонн, арьс шир 335.2 мянган ширхэгээр тус тус өссөн байна.

*Хүснэгт № 1.4. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, биет хэмжээгээр*

Малын төрөл	2010	2011	2012	2013	2013/2012	
					Хувь/%/	Зөрүү
<b>Мах, нядалгааны жингээр, тонн</b>	<b>7497,3</b>	<b>7559,4</b>	<b>9169,6</b>	<b>25484,9</b>	<b>277,9</b>	<b>16315,3</b>
Адууны	133,2	586,0	877,0	2413,5	275,2	1536,5
Үхрийн	1384,4	1538,0	2277,6	5192,3	228,0	2914,7
Тэмээний	299,2	192,9	302,9	735,4	242,8	432,5
Хонины	3929,9	3666,4	3308,0	10575,9	319,7	7267,9
Ямааны	1749,6	1568,5	2402,6	6567,8	273,4	4165,2
<b>Сүү, тонн</b>	<b>12340,5</b>	<b>17837,7</b>	<b>19937,7</b>	<b>22337,1</b>	<b>112,0</b>	<b>2399,4</b>
Гүүний	1007,1	1749,3	1911,7	2224,5	116,4	312,8
Үнээний	9489,8	12164,1	14160,1	15615,7	110,3	1455,6
Ингэний	141,0	196,6	246,5	246,8	100,0	0,3
Хонины	1038,6	1178,7	1201,5	1397,7	116,3	196,2
Ямааны	6664,0	2549,0	2417,9	2852,8	118,0	434,9
<b>Ноос, ноолуур, тн</b>	<b>1921,1</b>	<b>1328,2</b>	<b>1474,7</b>	<b>1591,9</b>	<b>107,9</b>	<b>117,2</b>
Тэмээний ноос	59,7	54,4	57,9	63,5	109,7	5,6
Хонины ноос	1472,6	999,1	1095,0	1255,1	114,6	160,1
Ямааны ноос	311,4	217,4	256,1	273,3	106,7	17,2
<b>Арьс шир, мян.ш</b>	<b>1061,5</b>	<b>404,6</b>	<b>224,0</b>	<b>559,2</b>	<b>249,6</b>	<b>335,2</b>
Тэмээний	2,1	6,2	0,4	1,8	450,0	1,4
Адууны	10,7	14,4	4,0	10,8	270,0	6,8
Үхрийн	29,8	1,0	8,3	25,3	304,8	17
Хонины	439,7	213,7	92,5	295,3	319,2	202,8
Ямааны	296,7	127,6	83,3	226,0	271,3	142,7

### Газар тариалан

Аймгийн хэмжээнд 8697.8 тн үр тариа, 2821.5 тн төмс, 2860.4 тн хүнсний ногоо, 865.5 тн тэжээлийн ургамал хураан авсан байна. Өнгөрсөн оноос хураан авсан үр тариа 1123.4 тн, хүнсний ногоо 270.1 тн – оор өсч, төмс 253.4 тонноор буурсан байна.


Хураан авсан үр тарианы 36.5, төмсний 76.1, хүнсний ногооны 80.9 хувийг иргэд хураан авсан байна.



Зураг № 1.9. Хураан авсан үр тариа

Хураан авсан үр тарианы 98.3 хувь нь Баруунтуруун, Тариалан, Сагил сумдад, төмсний 86.9 хувь нь Улаангом, Баруунтуруун, Тариалан, Наранбулаг сумдад, хүнсний ногооны 91.6 хувь нь Улаангом, Баруунтуруун, Тариалан, Наранбулаг, Сагил сумдад тус тус ноогдож байна.

Хураан авсан үр тариа өмнөх 3 жилийн дунджаас 23.7 хувиар, төмс 8.2, хүнсний ногоо 38.9 хувиар тус тус өссөн байна.



Зураг № 1.10. Хураан авсан хүнсний ногоо/тн/

## Хүснэгт № 1.5. Ургац хураалт сумаар, жил, бүрийн эхний 12 сарын байдлаар

Сумдын нэр	Төмс			Хүнсний ногоо			Байгалийн хадлан			Тэжээлийн ургамал
	2012 I-ХИ	2013 I-ХИ	2013ХИ /2012ХИ	2012 I-ХИ	2013 I-ХИ	2013ХИ /2012ХИ	2012 I-ХИ	2013 I-ХИ	2013ХИ /2012ХИ	
Баруунтуруун	520	432	83.1	247	260	105.3	3890	3967.2	102.0	
Бөхмөрөн	15	39	260.0	22	20	90.9	3600	3999.5	111.1	5
Давст	35.1	5.8		23.8	13.2		2405	3195	132.8	4
Завхан	0.82	2.5	304.9	1.0	1.3	126.5	300	300	100.0	
Зүүнговь	26	26	100.0	28	30	107.1	1200	1500	125.0	
Зүүнхангай	20	15	75.0	1.5	3	200.0	2000	2475	123.8	86
Малчин	13.2	12.5	94.7	24	8.2	34.2	1000	1169.9	117.0	
Наранбулаг	119.3	121	101.4	74.4	108.1	145.3	1120	4087.3	364.9	720
Өлгий	22.7	44.5	196.0	22	39	177.3	500	683.2	136.6	21.5
Өмнөговь	44.5	46.5	104.5	20.3	36	177.3	1032	1200	116.3	18
Өндөрхангай	48.5	5.7	11.8	28.9	4.8	16.6	2000	2285.8	114.3	
Сагил	44.8	46	102.7	41	72.8	177.6	2050	2159.1	105.3	
Тариалан	276	210	76.1	215	260	120.9	4500	5592	124.3	
Түргэн	66.3	42	63.3	28.7	32	111.5	1255.8	1599.9	127.4	
Тэс	13.3	6	45.1	1.71	8	467.8	16300	9248.5	56.7	
Ховд	17	2	11.8	18.1	1.5	8.3	1750	1945.3	111.2	5
Хяргас	24	42	175.0	22	27.5	125.0	1720	2043.6	118.8	6
Цагаанхайрхан	43.4	33	76.0	21	15.0	71.4	692	610.7	88.3	
Улаангом	1725	1690	98.0	1750	1920	109.7	3600	5905	164.0	
<b>Нийт</b>	<b>3071.9</b>	<b>2821.5</b>	<b>91.8</b>	<b>2590.4</b>	<b>2860.4</b>	<b>110.4</b>	<b>50914.8</b>	<b>53967</b>	<b>106.0</b>	<b>865.5</b>


## Хүснэгт № 1.6. Тариалсан талбай, хураасан жимс, жимсгэнэ

Төрөл	Тариалсан талбай	Хэмжих нэгж	Бүгд	Үүнээс	
				Чацаргана	Үхрийн нүд
Бүгд дүн	Нийт тариалсан талбай	Га	478.6	399.5	79.1
	Нийт бут, модны тоо	Ш	694732	497980	196752
	Үүнээс: үр жимсээ өгөх бут	Ш	623720	429070	194650
	Хураасан ургац-бүгд	Кг	758280	524820	233460
	Үүнээс:зах зээлд борлуулсан	Кг	749860	517110	232750
	Борлуулалтын орлого нэг бутнаас авсан жимс	Мян.төг	1514020	1048620	465400
		кг	1.2	1.2	1.2
Иргэд	Нийт тариалсан талбай	Га	150.6	116.5	34.1
	Нийт бут, модны тоо	Ш	190482	128730	61752
	Үүнээс: үр жимсээ өгөх бут	Ш	157820	98170	59650
	Хураасан ургац-бүгд	Кг	198720	127260	71460
	Үүнээс:зах зээлд борлуулсан	Кг	190500	119750	70750
	Борлуулалтын орлого нэг бутнаас авсан жимс	Мян.төг	394300	252900	141400
		кг	1.3	1.3	1.2
ААНэгж	Нийт тариалсан талбай	Га	328	283	45
	Нийт бут, модны тоо	Ш	504250	369250	135000
	Үүнээс: үр жимсээ өгөх бут	Ш	465900	330900	135000
	Хураасан ургац-бүгд	Кг	559560	397560	162000
	Үүнээс:зах зээлд борлуулсан	Кг	559360	397360	162000
	Борлуулалтын орлого нэг бутнаас авсан жимс	Мян.төг	1119720	795720	324000
		кг	1.2	1.2	1.2

## 1.2.3. Барилгын салбар:


Барилгын гүйцэтгэгч 59 аж ахуйн нэгжүүд барилгын 96 объектод 77.6 тэрбум төгрөгийн БУИЗ-ын ажил гүйцэтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс /инфляциар засварласанаар / 47.5%-иар өссөн байна. Барилгын салбарын ажиллагсдын тоо 1402 байгаа нь өнгөрсөн оноос 29.9%-иар өссөн байна.





Зураг№ 1.11. Барилга угсралт их загварын ажил /инфляци-8.8, сая төг/


Барилга объектод 18.2 тэрбум төгрөгийн ажил гүйцэтгэсэн нь өнгөрсөн оноос 18.6 хувиар, инженерийн барилга байгууламжийн 59.4 тэрбум төгрөгийн ажил гүйцэтгэсэн нь өнгөрсөн оноос 59.4%-иар өссөн.



Зураг№ 1.12. Барилгын ажлын хувийн жин

Нийт барилга угсралтын ажлын 23.4%-ийг барилга объектын ажил, 76.6%-ийг инженерийн барилга байгууламж эзэлж байна. Инженерийн барилга байгууламжийн ажлын дийлэнхийг хятад улсын Шин Жан Ши Фа компаний гүйцэтгэсэн Улаангомоос Наранбулаг чиглэлийн 90 км хатуу хучилттай хар зам, Тээлийн гүүрээс хяргас нуур чиглэлийн 85 км хатуу хучилттай хар зам, тээлийн гүүрээс хяргас нуур хүртэлх 15 км хатуу хучилттай хар зам, нисэх буудлын онгоц хөөрөх буух зурвасын засварын ажлууд 84.7%-ийг эзэлж байна.





Зураг № 1.13 Ашиглалтанд оруулсан барилга объектын тоо

2013 оны туршид барилгын гүйцэтгэгч ААН-үүд нийт 18.0 тэрбум төгрөгийн үндсэн фонд бүхий 49 объект ашиглалтанд оруулсан нь өнгөрсөн оны үеэс объектын тоо нь 21-аар буюу 75.0%-иар нэмэгдсэн байна. Увс барилга ХХК 400.0 сая төгрөгийн үндсэн фонд бүхий бизнес инкубатор төвийн барилга, Арвижих Увс ХХК 1458,1 сая төгрөгийн ҮФ бүхий 20 айлын орон сууц, 87 сая төгрөгийн ҮФ бүхий цэцэрлэгийн гаднах шугам, Хүдэнгийн уурхай ХХК 100.0 сая төгрөгийн ҮФ бүхий Зүүнхангай сумын ахуйн үйлчилгээний төвийн барилга, Мөнхжим өргөө ХХК 49.8 сая төгрөгийн ҮФ бүхий харигийн модон гүүр, 2078.9 сая төгрөгийн ҮФ бүхий шинэ ирээдүй цогцолбор сургуулийн өргөтгөл, Дэглийн цагаан ХХК 57.0 сая төгрөгийн ҮФ бүхий Улаангом сумын автобусны зогсоол, Амарсанаа ХХК 955.4 сая төгрөгний ҮФ бүхий Халамж үйлчилгээний төвийн барилга, 700.0 сая төгрөгийн ҮФ бүхий Наранбулаг сумын соёлын төвийн барилга, 30.0 сая төгрөгийн ҮФ бүхий Завхан сумын усан оргилуур, Эрдэнэ дэглий ХХК 16.4 сая төгрөгийн ҮФ бүхий 3-р цэцэрлэгийн машины зогсоол, Дэвшил увс ХХК 198.4 сая төгрөгийн ҮФ бүхий Улаангом сумын 6,7,9,10-р багийн контор, Их үен ХХК 400.0 сая төгрөгийн ҮФ бүхий барилгын сургалтын төвийн барилга, Цагаан хөшөө ХХК 1.7 тэрбум төгрөгийн ҮФ-той 30 айлын орон сууц, 710.0 сая төгрөгийн ҮФ бүхий 4-р цэцэрлэгийн өргөтгөл, Ундрага констрашин ХХК 948.7 сая төгрөгийн ҮФ бүхий 16 айлын орон сууц, Баян цагаан ХХК 2300.0 сая төгрөгийн ҮФ бүхий 50 айлын орон сууц, Дэвшил Увс ХХК 350.7 сая төгрөгийн ҮФ бүхий Бөхмөрөн сумын нэгдсэн халаалт, Мөнхийн ундраа ХХК, Сагил сумын цэцэрлэгийн барилга, Дүрт уул ХХК хүүхэд залуучуудын парк, Шинэ барилга ХХК 22 айлын орон сууц, Сан тех увс ХХК Улаангом сумын цахилгааны шугамын ажил зэрэг томоохон барилга объектуудыг ашиглалтад хүлээлгэж өгөөд байна.

#### 1.2.4. Дэд бүтэц

2008 оноос хөрөнгө оруулалт эрс нэмэгдэж, дэд бүтэц түүний дотроос авто зам барих асуудалд онцгой анхаарч байна. “Шинэ Улаангом” хөтөлбөрийн хүрээнд орон сууцны дулаан, цэвэр усны 282 м, бохирын 300 м, цахилгааны 630 квт-ын дэд өртөө, 0.4 квт-ын 200 м кабель шугам татаж, бүх орон сууцанд дулаалга хийж, барилгын гадна


фасадыг шинэчилсэн. Мөн хот дотор 16.9 км хатуу хучилттай зам, явган хүний 10.38 км зам шинээр тавьж, зам дагуу 9.52 км гэрэлтүүлэг, гэр хорооллын 800 гаруй өрхийн хашаанд гадна гэрэл тавих ажил хийж, Улаангом-Тээл хүртэл 15 км хатуу хучилттай автозамыг барьж ашиглалтад оруулсан. 2011 онд “Дэглий цагаан” нисэх буудлын иж бүрэн барилгыг ашиглалтад оруулснаар нислэгийн аюулгүй байдал бүрэн хангагдаж, орон нутгийн болон олон улсын нислэг хүлээн авах боломж бүрдэж, үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдлээ.

Эрчим хүчний дэд бүтцийн хувьд Улаангом хот, Завханаас бусад сумдын төвийг 1996-2000 онд ОХУ-ын эрчим хүчний системтэй холбосон. Харин Завхан сумын төв Ховдын Дөргөний УЦС-аас цахилгааны эх үүсвэрээр хангагдаж байна. Хөдөөд малчин өрхүүд нарны эх үүсвэрээр цахилгаан эрчим хүч хэрэглэж байна.

### 1.2.5. Тээвэр харилцаа холбоо:

Зорчигч тээвэр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэд 2013 оны байдлаар 53.4 мянган зорчигч тээвэрлэж 34641.5 мян хүн км-ийн зорчигч эргэлт хийснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зорчигчдын тоо 20.5%-иар, зорчигч эргэлт нь 89.9%-иар тус тус өссөн байна.

Ачаа тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэд 49.7 мян.тн ачаа тээвэрлэж 21417.9 мян тн км-ийн ачаа эргэлт хийснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тээсэн ачаа нь 2.5 ачаа эргэлт нь 44.9%-иар тус тус өссөн байна.



Зураг № 1.14 Тээсэн ачаа эргэлт /мян.тн/


Харилцаа холбооны хувьд жуулчид дэлхийн аль ч улс оронтой саадгүй харилцахаар хэмжээнд хүрсэн. Мэдээлэл холбооны суурь сүлжээ тоон технологид шилжин, өндөр хурдны интернетийн дэд бүтэцтэй болж, 13 сум шилэн кабельд, 6 сум сансрын ВИСАТ системд, 4 сум Wi-Fi утасгүй интернетэд холбогдоод байна. Аймгийн хэмжээнд одоо 5 төрлийн үүрэн телефоны сүлжээг иргэд ашиглаж байна. Улаангом суманд Мобикомын өндөр хурдны Wi-Fi утасгүй интернетийн сүлжээг 10 цэгт суурилуулан, иргэд үнэ төлбөргүй ашиглах нөхцлийг бүрдүүлсэн.

Холбооны үйл ажиллагаа эрхэлж, мэдээнд хамрагддаг аж ахуйн нэгж газрууд 380.0 сая төгрөгийн орлоготой ажилласны 26.2% нь хүн амаас орсон ба өнгөрсөн оны мөн үеэс нийт орлого нь 3.0%-иар буюу 11.1 сая төгрөгөөр өссөн байна.

Холбооны газраар үйлчлүүлсэн цахилгаан мэдээний тоо 28.6 %-иар өсч, бичиг, захидал, боодол хүргүүлэх үйлчилгээ 1.5 %-иар буурсан байна.

Кабелийн телевиз хэрэглэгчид 2414 болж өнгөрсөн оны үеэс 63.7%-иар өслөө.

Аймгийн бүх сумдад үүрэн телефоны операторууд үйл ажиллагаа явуулж байгаа ба тэдний хэрэглэгчдийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 11.7%-иар өссөн байна.



Зураг № 1.15. Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо 2012 он, 2013 он

### 1.2.6. Боловсрол

Аймгийн боловсролын салбарт дээд сургуулийн салбар сургууль 1, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 1, Ерөнхий боловсролын сургууль 30 үүнээс цогцолбор сургууль 2, ахлах сургууль 15, дунд сургууль 7, бага сургууль 6, нийт суралцагчид 19594 хамран сургалт 97.1 хувьтай байна. Ерөнхий боловсролын сургуулиудад үндсэн багш 981, багшийн хангалт 100 хувь мэргэжлийн багшийн хангалт 97.7 хувьтай байна.

Орон нутагт дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх Хөдөлмөрийн дээд сургуулийн салбар сургуульд 5 мэргэжлээр 167 оюутан, мэргэжилтэй ажилчин бэлтгэх дипломын болон мэргэжлийн боловсрол олгох Улаангом коллежид 23 мэргэжлээр 1758 суралцагч суралцаж байна. Аймагт 2490 орны хүчин чадал бүхий 26 цэцэрлэг ажиллаж, 179 бүлэгт 5826 хүүхэд хамрагдсанаас цэцэрлэгийн 109 бүлэгт 3650, хувилбарт сургалтын 70 бүлэгт 2176 хүүхэд суралцлаа. Соёлын салбарын хувьд аймгийн хэмжээнд 19 соёлын төв, 385 суудалтай 20 номын сан, 13 кино цэг ажиллаж байна. 18 сумын Соёлын төвийг үндэсний хөгжмийн иж бүрэн зэмсгээр хангалаа. Жуулчдын сонирхлыг байнга татдаг “Ойрад” ХЖТ-ын хөгжмийг бүрэн шинэчилж, аймгийн төв номын сангийн номын фондыг 100 хувь электрон каталогид оруулж, цахим үйлчилгээнд шилжүүлсэн.


## ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ЦАГ УУРЫН ОНЦЛОГ

### 2.1. Газрын гадарга, газарзүйн онцлог

#### 2.1.1. Газарзүй.

Увс аймаг нь Монгол орны баруун хоймор Их нууруудын хотгорын хойд хэсэгт өргөрөгийн дагуу сунаж тогтсон 69.6 мян.хав.дөр.км газар нутагтай. Баруун талаараа 200 км Баян-Өлгий, өмнө талаараа 152 км Ховд аймаг, зүүн талаараа 340 км Завхан аймаг, хойд талаараа 575 км ОХУ-тай тус тус хиллэдэг. Нийслэл Улаанбаатараас 1417 км алслагдсан. Аймгийн төв Улаангом сум д.т.д 939 метр өндөрт оршдог.

Увс, Хяргас нуур түүний эргэн тойрны говийн бүс, Хархираа, Түргэн, Ханхөхийн өндөр уулс бүхий говь, цөлөөс өндөр уулын мөнх цас, мөсөн гол хүртэлх төв Азийн гадагш урсгалгүй ай савын босоо бүслүүрийн бүхий л хэв шинжийг тусгасан ландшафт газарзүйн өвөрмөц тогтоцтой. Нутгийн 8.2%-ийг уулын ойт хээр, 14.5%-ийг өндөр уулын, 37.7%-ийг хээрийн, 39.6%-ийг говь цөлийн бүс эзэлдэг.



Зураг № 2.1. Увс аймгийн байгаль нутаг дэвсгэрийн мужлалын зураг


Байгалийн мужлалтаар Увс, Хяргас нуурын хотгорын цөлжүү хээр, хуурай хээрийн дэд муж, Ханхөхийн нурууны дундаж өндөр бэлэрхэг уул бүхий хээр, хуурай хээр, ар хажуугийн ойн дэд муж, Монгол Алтайн зүүн хэсгийн /Хархираа, Түргэн/ цулдам уул, хотгор ян сарьдаг, уулын нуга, уулын хээрийн дэд мужид тус тус багтана. Ийнхүү мөнх цаст өндөр уулсын бүслүүрээс ойт хээр, говь цөлийн бүсэд шилжих байгалийн олон бүс

бүслүүрийг хамран орших нь аялал жуулчлалын олон төрөл хэлбэрийг сонирхогчдын атаархал, хүсэл тэмүүллийг өөрийн эрхгүй татдаг. Нутгийн баруун хэсэгт Хархираа уул /4037м/, Дэглий Цагаан /4278м/, Түргэн уул /4035м/, Алтан Хөхий уул /3350м/, Цагаан шувуут уул /3496м/, Улаан өндөр /2404м/, Байрам уул /2950м/, зүүн хэсэгт Ханхөхийн нурууны ноён оргил Дуулга /2928м/, Онц уул /2280м/, Хөх өндөр /2436м/, Цагдуулт уул /2329м/ зэрэг өндөр уулстай нь уулын аялал хөгжих гол нөхцөл бүрдсэнийг илтгэнэ.


Хамгийн нам цэг нь д.т.д 758.9 м Увс нуурын түвшин, хамгийн өндөр цэг нь далайн түвшинээс дээш 4278 метрт өргөгдсөн Дэглий цагаан ноён оргил юм. Увс нуурын хотгорын зүүн талд Ханхөхийн нурууны араар Бөөрөг дэлийн элс /дэлхийн бөмбөрцгийн хамгийн хойшоо түрж орсон манхан элс хойд өргөргийн 500181/ баруунаас зүүн тийш 180 км үргэлжилдэг.

### **2.1.2 Газрын гадарга.**

Монгол орны экосистем янз бүр байх нь газар орчмын бүрхэвчийн олон янз байдлыг бий болгох үндэс болдог. Байгалийн бүс бүслүүр бүрт ойн бүрхүүл, гол, нуур, мөнх цас мөсөн гол зэрэг гадаргын усны нөөц байрладаг. Эдгээр газрын гадаргын олон янз байдлыг зайнаас тандсан хиймэл дагуулын мэдээгээр тодорхойлж зураглах, мөн олон хугацааны мэдээгээр өөрчлөлтийг судлах туршлага нэгэнт дэлхий нийтийн хэрэглээ болоод байгаа билээ. Манай орны хувьд ч орон зайн хувьд бага ялгах чадвартай (1км) NOAA төрлийн цуврал хиймэл дагуулын NDVI буюу ургамлын нормчилсон индексийн мэдээгээр газрын бүрхэвчийг 1992, 2002 оны байдлаар зураглаж Монгол орны хэмжээгээр өөрчлөлтийг үнэлсэн байдаг (С.Хөдөлмөр нар 1996). Энэхүү судалгаагаар гадаргын ус болон мөнх цас, мөсөн гол 31-36 хувиар, ойн бүрхүүл 26 хувиар буурсан харин элс, ургамалгүй газар, цөлийн хээр 46-64 хувиар нэмэгдсэн гэсэн үр дүн гарсан байдаг (С.Хөдөлмөр нар 1996).




Зураг № 2.2. Ландсат хиймэл дагуулын болон газрын бүрхэвчийн зураг



Зураг№ 2.3. Өндөршлийн зураг

2010 оны МОДИС хиймэл дагуулын 250м ялгах чадвартай мэдээгээр газрын бүрхэвчийн зургийг боловсруулан үзэхэд Увс аймгийн нутагт газрын гадаргын гол, нуур, голын нуга, өндөр уулын тайга, ой, тариалангийн талбай, хээр, хуурай хээр, цөлийн хээр, заримдаг цөл зэрэг ангиуд байгаа нь энэ бүс нутгийг газрын бүрхэвчийн бараг бүх төрлийг агуулсан нутаг болохыг гэрчилж байна. (2.3-р зураг).



Зураг№ 2.4. Увс аймгийн хөрсөн бүрхэвчийн зураг

## 2.2. Уур амьсгалын үндсэн нөхцөл.


### 2.2.1. Аргачлал, мэдээ мэдээлэл

Судалгаанд Увс аймгийн Улаангом, Тэс, Баруунтуруун, Өмнөговь, Завхан станц болон Сагил, Бөхмөрөн, Давст, Наранбулаг, Хяргас зэрэг сумдууд дахь цаг уурын харуулуудын олон жилийн ажиглалтын мэдээг ашиглав. Уур амьсгалын өөрчлөлтийн судалгааг 1940-2013 онуудад ажиглагдсан агаарын температур, хур тунадасны мэдээгээр хийсэн.

Судалгаанд авч хэрэглэсэн мэдээллийг статистиктийн үндсэн аргууд болох цувааны нийлбэр, дундаж, хазайлт, давтагдал, алдааг тодорхойлдог аргуудаар боловсруулалт хийсэн. Мэдээлэл боловсруулах, хүснэгт, график байгуулах, харьцуулах, зураглах, орон зайн анализ зэрэг үйлдлүүдийг газар зүйн мэдээллийн системийн ArcGIS, Spatial Analyst, Co-kriging интерполяцийн арга, мөн хиймэл дагуулын зураг мэдээг дүрс боловсруулалтын ERDAS Imagine программ болон Excel хүснэгтэн програмуудыг тус тус ашигласан. Мөн Монгол улсын үндэсний атлас, уур амьсгал, усны нөөцийн атласаас шаардлагатай зураг, материалуудыг авч ашиглав.

### 2.2.2. Дулааны горим

**Жилийн дундаж агаарын температур:** Агаарын хоногийн дундаж температур 10 сарын 15-аас  $0^{\circ}$  градусаас доош орж хүйтрэх ба 4 сарын 10-аас дулаарч эхлэдэг буюу 200-220 хоног нь хүйтэн байдаг. Жилийн дундаж агаарын температур нилээд ялгаатай  $2.7^{\circ}\text{C}$  – аас  $-4.8^{\circ}\text{C}$  градусын хооронд хэлбэлздэг. Тухайлбал Увс нуураас холхон сумдад илүү дулаан ойр газар илүү хүйтэн байна. Жилийн дундаж температурын хувьд Завхан, Ховд, Бөхмөрөн, Наранбулаг, Хяргас сумуудад эерэг утгатай буюу хамгийн дулаан нь Хяргас суманд  $2.7^{\circ}\text{C}$ , бусад сумуудад сөрөг утгатай ба хамгийн хүйтэн нь Баруунтуруун суманд  $-4.8^{\circ}\text{C}$  байсан бол Улаангомд  $-3.7^{\circ}\text{C}$  байсан байна. Агаарын температурын жилийн явцыг харахад 1 дүгээр сард хамгийн хүйтэн, 7 дугаар сард хамгийн дулаан байдаг Монгол орны уур амьсгалын ерөнхий зүй тогтол давтагдаж байна



Зураг № 2.5. Сумдын жилийн дундаж агаарын температур

Манай орны мал сүрэг жилийн дөрвөн улиралд байгаль цаг уурын байнгын нөлөөлөл дор бэлчээрийн маллагаатай байдаг тул цаг агаарын огцом өөрчлөлт, эрс тэс уур амьсгал нь мал сүргийн тогтвортой өсөлтийг хангах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх, түүний эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд багагүй бэрхшээл учруулдаг.

Өөрөөр хэлбэл эрс тэс уур амьсгал малын амьдрах чадамж цаг агаар, уур амьсгалын нөхцлөөс хамааралтай байдаг болохоор цаг агаарын үзүүлэлтийн хэлбэлзэл малын дулаан солилцоо, амьдралын үйл ажиллагаанд шууд нөлөөлж түүний үр дагавар нь ашиг шимийн өөрчлөлтөөр илэрнэ. Мал маллагааны уур амьсгалын өртөнгийн судалгаанд жил, сарын дундажаас илүү хамгийн их бага өөрөөр хэлбэл хэлбэлзлийн мэдээ чухал. Иймд энд агаарын температурын үнэмлэхүйн их, бага утгыг авч үзлээ. /Хүснэгт№ 2.1/




## Хүснэгт№ 2.1. Сумдын агаарын температур

Үзүүлэлт	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
Улаангом													
Дундаж	-32.9	-30.2	-18.8	-0.4	11.3	17.9	19.2	16.9	10.2	0.2	-11	-26.7	<b>-3.7</b>
Үнэмлэхүй их	-12.0	-6.2	2.4	28.0	35.9	33.7	36.6	36.4	28.4	24.7	9.1	-3.8	<b>36.6</b>
Үнэмлэхүй бага	-49.6	-46.1	-40.2	-24.7	-8.3	-3.1	0.4	0.2	-8.7	-21.7	-39.1	-47.3	<b>-49.6</b>
Сагил													
Дундаж	-26.9	-26.1	-16.4	-0.6	12.3	20.2	20.4	18.8	12.5	2.6	-12.7	-25.9	<b>-1.8</b>
Үнэмлэхүй их	-6.2	-6.0	-3.0	25.0	28.5	36.7	38.1	38.4	29.1	27.3	10.5	-1.5	<b>38.4</b>
Үнэмлэхүй бага	-45.6	-42.5	-37.0	-26.0	-9.2	4.6	2.5	-4.2	-1.4	-15.2	-40.1	-47.0	<b>-47.0</b>
Тэс													
Дундаж	-34.1	-32.2	-20.8	1.6	13.4	19.7	21.3	19.0	11.8	1.5	-12.2	-27.9	<b>-3.6</b>
Үнэмлэхүй их	-18.0	-10.0	5.1	22.9	33.1	39.0	35.0	38.7	30.3	22.7	7.2	-5.5	<b>39.0</b>
Үнэмлэхүй бага	-53.8	-49.8	-43.5	-30.5	-12.8	-1.6	4.0	-0.9	-9.7	-20.5	-33.4	-45.5	<b>-53.8</b>
Баруунтуруун													
Дундаж	-31	-28.7	-17.9	-0.9	10.4	16	17.5	15.5	9	-0.3	-13.6	-25.7	<b>-4.1</b>
Үнэмлэхүй их	4.5	1.9	5.4	26.1	30.2	33.9	35	35.8	32.1	25	19.9	5.9	<b>35.8</b>
Үнэмлэхүй бага	-49.9	-45.8	-40.6	-31	-16.3	-6.4	0.4	-4.8	-12	-40.2	-35.8	-47.1	<b>-49.9</b>
Завхан													
Дундаж	-26.7	-22.3	-8.7	4.8	13.6	19.3	21.2	19.1	12.4	2.9	-9.8	-20.1	<b>0.5</b>
Үнэмлэхүй их	1	8.2	18.5	31.5	34.4	37	38.1	37.1	34.2	27.8	16.6	5.3	<b>38.1</b>
Үнэмлэхүй бага	-46.5	-45.6	-36	-20.6	-7.6	-0.8	5.5	2.8	-7.4	-17.6	-30.4	-38.2	<b>-46.5</b>
Өмнөговь													
Дундаж	-22.3	-18.8	-8.6	1.3	9.4	15	16.5	14.5	8.1	-0.2	-10.4	-18.9	<b>-1.2</b>
Үнэмлэхүй их	3.2	8.2	17.5	26.6	28.3	32	36	38.9	29.2	24.4	11.9	9.6	<b>38.9</b>
Үнэмлэхүй бага	-45.5	-42.3	-35.6	-24.1	-16.9	-3	1.5	-2.7	-18.5	-22	-31.8	-42.8	<b>-45.5</b>
Бөхмөрөн													
Дундаж	-21.6	-15.8	-7.0	4.2	12.0	18.8	19.6	16.3	11.4	1.6	-10.1	-20.0	<b>0.8</b>
Үнэмлэхүй их	0.4	3.9	14.2	21.2	29.1	30.3	28.7	29.5	22.3	18.5	7.7	-3.6	<b>30.2</b>
Үнэмлэхүй бага	-44.2	-35.3	-26.9	-15.3	-8.2	2.4	3.6	-0.7	-5.6	-15.3	-29.8	-38.9	<b>-44.2</b>

Дээр өгүүлсэнчлэн тухайн газар орны уур амьсгалын ерөнхий төлөв буюу горимийг хамгийн багадаа 30 жил буюу түүнээс урт цуваатай цаг уурын мэдээний дунджаар илэрхийлдэг. Уур амьсгал судлалаас гаргах шаардлагатай бас нэг үзүүлэлт бол орон зайн тархац юм. Увс аймгийн хойд талын сумдын хувьд өндөрлөг газраа хүйтэн нам дор газраа илүү дулаан байдаг ерөнхий зүй тогтол хадгалагдаж байна.

Жилийн доторх хуваарилалтын хувьд Монгол орны нийт нутгийн цаг агаарын хуваарилалтын нэгэн адил 1 дүгээр сард хамгийн хүйтэн, 7 дүгээр сард хамгийн дулаан байна. Ерөнхийдөө Увс аймаг манай орны нэлээн хүйтэн өвөл болдог газрын нэг. 1 дүгээр сарын агаарын дундаж температур  $-21.6^{\circ}\text{C}$ -с  $-34.1^{\circ}\text{C}$ -ын хооронд хэлбэлзэнэ.




Зураг № 2.6. 1 ба 7-р сарын агаарын температурын орон зайн тархац

Жилийн хамгийн дулаан буюу 7-р сард  $16.5-21.3^{\circ}\text{C}$  хооронд байгаа нь энэ нутагт харьцангуй сэрүүн зун болдгийн зэрэгцээ “0” градус хүрч сэрүүсэх тохиодол гардаг ба өвөл нь хамгийн хүйтэн байдаг Тэс суманд зундаа хамгийн халуун буюу  $21.3^{\circ}\text{C}$  хүрдэг байна. Улаангом, Өмнөговь, Баруунтуруун, Бөхмөрөн зэрэг сумдад харьцангуй сэрүүн зун болдог байна.

Агаарын үнэмлэхүйн бага температур хамгийн хүйтэндээ Тэсд  $-53.8^{\circ}\text{C}$ , хамгийн дулаандаа Бөхмөрөнд  $-44.2^{\circ}\text{C}$ , харин Улаангомд  $-49.6^{\circ}\text{C}$  хүрч хүйтэрч байсан байна (2.1-р хүснэгт). Эндээс харахад сарын дундаж, үнэмлэхүйн бага температурын хувьд ч Улаангомд хамгийн хүйтэн өвөл болдог бөгөөд зөвхөн 1 дүгээр сарын дундаж температур л гэхэд бусад сумдаас  $3-11^{\circ}\text{C}$  -аар хүйтэн байдаг байна. Мөн Монгол оронд 1940 оноос хойш хэмжсэн бүх хэмжилтүүдээс агаарын үнэмлэхүй бага температур 1976 оны 12 дугаар сард Увс аймгийн Зүүнговь суманд  $-55.3^{\circ}\text{C}$  хүрч байсан мэдээ байдаг.

Харин үнэмлэхүйн их температур Сагил, Завханд  $38.1^{\circ}\text{C}$ , хамгийн багадаа Бөхмөрөнд  $28.7^{\circ}\text{C}$ , харин Улаангомд  $36.6^{\circ}\text{C}$  хүрч халж байжээ (2.1-р хүснэгт). 7 сарын орон зайн тархцын зургаас харахад уулын өндөрлөг хэсэгтээ сэрүүн, нам газраа сэрүүвтэр, говьдоо дулаан зун болно.



Зураг № 2.7. Агаарын дундаж, үнэмлэхүй температурын сарын явц

Зургаас харахад Улаангом сумын агаарын дундаж болон үнэмлэхүйн бага температур хамгийн их байгаа нь нэг талаас Увс нуурын хонхор нь эргэн тойрон өндөр уулсаар хүрээлэгдсэн тул намраас эхлэн хүйтэн агаар хуралдан тогтдог, нөгөө талаас газрын гадарга туяарлын замаар дулаанаа их алддагтай холбоотой юм.


Ер нь тухайн газар орны уур амьсгалд газрын гадаргуугийн өндөршил, өргөрөг, усан орчин, ургамлан бүрхэвч, салхины зүг чиг чухал нөлөө үзүүлдэг буюу Увс нуур эргэн тойрныхоо сум, ялангуяа Улаангом хотын уур амьсгал, цаг агаарт маш их нөлөөтэй байна. Өөрөөр хэлбэл Увс нуур орчиндоо бичил уур амьсгалыг бий болгож байна.

Аливаа нэг үйл ажиллагааны төлөвлөлт хийхэд тухайн газар орны уур амьсгалын горимыг заавал тусгах шаардлагатай болдог. Ийм учраас уур амьсгалын өөрчлөлт дэлхий нийтийн байгаль орчны эн тэргүүний асуудал болж улс орон бүр одорхой ажил хийж байна. Өөрөөр хэлбэл ямарч үйл ажиллагаа орон зай, цаг хугацааны дотор явагдаж л байгаа бол тухайн газар орны уур амьсгалд зохицох шаардлагатай гэсэн үг.

Уур амьсгалын судлалаас гаргах шаардлагатай бас нэг үзүүлэлт олон жилийн явц юм. Цаг агаарын мэдээний хамгийн урт цуваа бүхий Улаангом цаг уурын станц дээр 1940-2013 онуудад хэмжсэн мэдээгээр (Хавсралт 1) олон жилийн явцыг жил, сараар гаргалаа. Улаангом орчимд сүүлийн 70 гаруй жилийн хугацаанд агаарын жилийн дундаж температур  $2.26^{\circ}\text{C}$  –р нэмэгдсэн байна (2.7-р зураг). Энэ нь Монгол орны хэмжээн дэх өөрчлөлттэй их ойролцоо байна (Монголын Үндэсний Илтгэл, 2010).

Мөн 70 гаруй жилийн явцаас харахад Улаангом орчмын агаарын температур 1975 он хүртэл тасралтгүй нэмэгдэж байсан (цэнхэр шугам) бол 1975-с 1985 он хүртэл арваад

(ногоон шугам) жил огцомдуу буурсан байна. Тэгээд түүнээс хойш 2008 он хүртэл нэмэгдэж 2008-2011 оны хооронд 1-2 цельсийн градусаар буурсан байна.



Зураг № 2.8. Улаангом сум орчмын агаарын жилийн дундаж температурын олон жилийн явц

Сар сараар нь авч үзвэл өвлийн сарууд тухайлбал 12, 1-3 саруудын дундаж температур 1970-д оны дунд хүртэл нэмэгдэж байснаа түүнээс хойш өдийн хүртэл буурч байна. Ялангуяа 1,2 сарын дундаж температур 2000 оноос хойш илүү эрчимтэй буюу цельсийн 5 градусаар 12, 3 сарынх цельсийн 2-3 градусаар буурчээ. Тэгэхээр Увс нуур орчимд илүү хүйтэн өвөл болдог болсон байна.

Агаарын температурын өсөлт хавар, зун, намрын улиралд өөрөөр хэлбэл 4-11 сард 1980-д оноос ажиглагдаж эхэлсэн байна. Энэ хугацаанд 4-9 сарын дундаж температур 7 сард цельсийн 4 градусаар бусад саруудад цельсийн 1-2 градусаар нэмэгджээ. Харин 9 сарын температурт ямар нэг өөрчлөлт ороогүй байхад 11 сарын температур цельсийн 2 градусаар нэмэгджээ. Эндээс харахад Увс нуур орчим зундаа бүгчим халуун нэмэгдэж байгаа байж болох юм.


Судалгааны бүс нутгийг уур амьсгалыг өөр бусад газартай харьцуулж үзэх мөн цаг уурын станц байхгүй буюу уур амьсгалын төлөв байлыг олон жилийн явцыг харуулах хангалттай мэдээ байхгүй сумдын уур амьсгалд гарч байгаа өөрчлөлтийг гаргахын тулд Монгол орны 69 станцын 1961-2011 оны агаарын температурын олон жилийн өөрчлөлтийн хандлагын шугаман регрессийг тооцож, абсолют өөрчлөлтийн орон зайн тархалтыг гаргалаа. Үүнд цэгэн мэдээллийг интерполяцлахдаа Co-kriging аргаар тооцсон. Энэ тооцооны дүнг 14-р зурагт үзүүлээ. Эндээс харахад судалгаанд хамрагдсан Монгол орны нийт нутгийн хэмжээгээр 0.4–2.9 градусаар дулаарсан бол Увс аймагт хамгийн их дулаарсан байна. Тухайлбал Бөхмөрөн, Ховд орчимд 1.8<sup>0</sup>C Сагил сум орчимд 2.2<sup>0</sup>C, Баруунтуруунд хамгийн их буюу 2.9<sup>0</sup>C-аар дулаарсан байна. Эдгээр дүн Улаангом станцын дүнтэй харьцуулахад ялгаа нь 0.06-0.46<sup>0</sup>C байгаа нь өөр бусад сар улирлын өөрчлөлтийг Улаангом станцын дүнгээр авахад болохоор байна.

### 2.2.3. Чийгийн горим

Жилийн нийлбэр хур тунадасны орон зайн тархалтын тооцооны үр дүнг харвал нам өргөрөгийн нутгаар буюу говь цөлийн бүсэд жилдээ арав хүрэхгүй см хур тунадас орох бөгөөд заримдаа энд хэдэн жил ч бороо орохгүй тохиолдол бий. Энэ нь агаарт агуулагдаж буй усны уурын тоо хэмжээ бага байдагтай шууд холбоотой юм. Оронзайн тархацын хувьд Хангайн нуруу, Хөвсгөл, Хэнтийн уулсаар 300-400 мм, Монгол Алтайн болон ойт хээрийн бүсэд 250-300 мм, хээрийн бүсэд 150-250 мм, говь цөлийн бүсэд 150-50 мм орчим хур тунадас унана.

Монгол орны газарзүйн өргөргийн дагуух хур тунадасны тоо хэмжээ газарзүйн нам өргөргөөс өндөр өргөрөг рүү шилжих тусам эрс ихэсдэг байна. Энэ нь газарзүйн өндөршилтэй шууд холбоотой бадаг. Жишээлбэл, 7 сард хойд өргөргийн 42 градусын бүслүүр дээр 31 мм, өргөргийн 46 градусын бүслүүр дээр 52 мм, өргөргийн 50 градусын бүслүүр дээр 96 мм хур тунадас тус ордог байна. Энэ зүй тогтол жилийн хамгийн хүйтэн 1-р сард мөн жилийн нийлбэр үед ч гэсэн хадгалагдаж байна.

Хур тунадасны 85% орчим нь жилийн дулаан улиралд /VI-IX сард/ үүнээс зөвхөн 7, 8 дугаар сард 50-60% нь орно.



Зураг № 2.9. Увс аймгийн жилийн нийлбэр хур тунадасны оронзайн тархац


Намрын анхны цас 10 сарын 1-2 дугаар арав хоногт орж, сүүлийн цас 4 сарын 2 дугаар арав хоногийн дунд үеэр орж хайлдаг буюу жилийн 110-150 хоногт цасан бүрхүүлтэй байдаг. Цасан бүрхүүлийн зузаан 10-15 см хүрнэ. Хархираа, Түргэний орчимд ойролцоогоор 130 мм тунадас жилдээ ордог байна.

Тунадасны гуравны нэг хувь нь зөвхөн 7 сард, 66 хувь нь 5-8 сард, 9 хувь нь 9 сард 6 хувь нь 5 сард унана. Нэгэнт 10 сарын 1-2 дугаар арав хоногт цас орж эхлэн 4 сарын 2 дугаар арав хоногийн дунд үеэр сүүлийн цас ордог болохоор үлдсэн 20 хүрэхгүй хувийн тунадас өвөл цас хэлбэрээр унана (2.2-р хүснэгт).

## Хүснэгт№ 2.2. Сумдын сарын дундаж тунадас

Станцууд	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Нийлбэр
Улаангом	2.3	2.2	3.9	3.8	7.3	22.3	39.5	22.6	15.1	4.6	8.5	4.1	156.9
Сагил	0.4	0.9	0.9	0.4	0.4	12.2	20.0	2.5	2.1	1.1	0.6	0.3	41.8
Тэс	2.9	3.1	5.7	12.5	16.2	38.4	60.2	56.6	13.5	10.0	7.9	5.4	232.4
Баруунтуруун	4.3	3.1	7.7	13.2	14.2	27.6	55.3	39.8	25.2	12.3	9.3	6.3	218.3
Ховд	0.4	0.2	1.2	7.1	7.0	12.1	23.6	9.7	11.7	2.8	2.2	1.9	78.9
Завхан	0.9	0.7	1.1	1	2.9	9.5	16	10.9	5.4	1.2	0.9	1.4	51.9
Өмнөговь	0.7	0.6	1.5	3.6	6	20.6	41.5	25.4	12.3	1.9	1.1	1.4	116.6
Бөхмөрөн	0.1	0.8	0.2	1.2	3.3	20.8	27.9	19.3	12.1	3.1	6.8	4.0	99.6


Мөн сумдаас Түргэн, Улаангом сумд унах хур тунадасны хэмжээгээр илүү чийглэг харин Сагил илүү гандуу байдаг байна.



Зураг№ 2.9. Сумдын сар, жилийн нийлбэр тунадас

Увс аймгийн хэмжээгээр хур тунадасны хэмжээ сүүлийн 70 гаруй жилд хэрхэн өөрчлөгдөж буйг үзүүлэхийн тулд Увс аймгийн Улаангом цаг уурын станц дээр 1940-2013 онуудад хэмжсэн мэдээг ашиглаж тооцоо хийлээ. Тооцоог хийхдээ сар бүрийн хур тунадасны хэмжээг өөр хооронд нь нэмж өөрчлөлтийн явцыг жил жилээр бодуулсан. Тооцооны үр дүн буюу сүүлийн 70 орчим жил бүрийн нийлбэр хур тунадасны өөрчлөлтийн явцын графикийг шугаман трендийн аргаар илэрхийлж 11-р зурагт үзүүлэв (А). Энэ зургаас Улаангом орчмын тунадас 1940-д оны сүүлээс 1970-д оны дунд хүртэл буурч дараа 1980-д оны дунд хүртэдх богинохон хугацаанд эрчимтэй нэмэгдэж түүнээс хойш өдийг хүртэл буюу сүүлийн 25 жилийн хугацаанд буурч байгаа харагдаж байна.

Харин нийт 70 гаруй жилийн хугацаанд бүхэлд авч үзвэл нэмэгдэж байгаа болон буурч байгаа мэдэгдэхүйц өөрчлөлт харагдахгүй байна. Мөн явцаас Увс нуур орчмын тунадасны өөрчлөлт агаарын температурын өөрчлөлттэй ямар нэг хэмжээгээр уялдаатай байна. Тухайлбал температур нэмэгдэхэд тунадас буурч, буурахад нэмэгдэж байна.



Зураг№ 2.10. Улаангом орчмын жилийн нийлбэр тунадас, цасны олон жилийн явц

Өвөл зуны болон байгаль, цаг уурын хамгийн тохиромжтой нөхцөлд мал амьдрах хэвийн нөхцөл бүрдэж ашиг шим, удамшлын чадамж дээд зэргээр илэрдэг. Тэгэхээр байгаль, цаг уурын тохиромжтой нөхцөл өөрчлөгдөх нь малын бие мах бодид сөргөөр нөлөөлж дарамт болсноос тарга хүч, ашиг шим нь муудах ялангуяа энэ нөлөө малын бие мах бодийн зохицон дасах чадварын хэмжээнээс хэтэрвэл үхэж хорогддог байна (Төмөржав, 2004, Туваансүрэн нар, 1996). Агаарын температурын халуун хүйтнээс цасан бүрхүүл жилийн туршид бэлчээрийн маллагаанд байгаа монгол малын бэлчээрлэх нөхцөл болдог. Иймд энд өвлийн (цас) тунадасны өөрчлөлтийг тусад нь авч үзлээ.

Улаангом орчим хамгийн их цас 1954 онд (68 см) хамгийн бага нь 1942 (6.5 см) онд унасан байна. Мөн 1940-д оноос нэмэгдэж 1950-д оны дунд үеэс 1970-д оны дунд үе хүртэл буурч түүнээс хойш өнөөг хүртэл нэмэгдэж байна. Түүнчлэн 1999-2002 хүртлэх дараалсан зудтай байсан онуудад 22-59 мм, 2009-2010 оны зудтай жилд 50-58 мм зузаан цас унасан байна (2.10-р зураг).


Увс аймгийн тунадасны өөрчлөлтийн хэмжээг Монгол орны өөр бусад хэсэгт өөрчлөгдсөн байдалтай харьцуулсан зургийн доор үзүүлээ. Энэ зургаас харахад Увс аймгийн нутаг хур тунадас 4-40 мм-ээр нэмэгдсэн хэсэгт орсон байгаа бөгөөд станцаар нь авч үзвэл Улаангомд 27 мм, Өмнөговь, Баруунтуруунд 11.4-11.7мм, харин Завханд 36,5 мм-ээр нэмэгдсэн байна.

Монгол орны газар зүйн өргөргийн дагуух хур тунадасны тоо хэмжээ газарзүйн нам өргөргөөс өндөр өргөрөг рүү шилжих тусам эрс ихэсдэг. Энэ нь газарзүйн өндөршилтэй шууд холбоотой.

#### 2.2.4 Салхины горим


Салхины горим нь агаар мандлын орчил урсгал, агаарын даралт, тухайн нутгийн физик газар зүйн нөхцлөөс ихээхэн шалтгаалдаг.

Монгол орны тал хээр, говь, цөлийн бүс нь салхи ихтэй байдаг. Жилийн дундаж салхины хурд энэ бүс нутагт 4-6 м/с. Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгийн уулс хоорондын хөндийд 1-2 м/с, бусад нутгаар 2-3м/с орчим байдаг. Тус орны 250 хот суурин орчимд хийсэн цаг уурын хэмжилтийн мэдээгээр нутгийн дөрөвний нэг орчимд нь жилийн дундаж салхины хурд 4.0 м/с-ээс их. Ихэнхдээ баруун, баруун хойд, хойд зүгийн салхи зонхилох боловч газрын хотгор гүдгэрийн нөлөөгөөр орон нутгийн ялангуяа уул-хөндийн салхи элбэг тохиолдоно. Монгол орны нутгийн 41.3%-ийг эзлэх говь-цөлийн бүсэд сул шороо элбэг, салхи ихтэй тул шороон шуурга олонтаа тохиолдоно. Энэ бүс нутагт жилдээ 30-100 өдөр, Монгол элсний өмнөд захад жилдээ 120 өдөр шороо хийснэ. (2.11-р зураг).



Зураг№ 2.11. Жилд шороо хийсдэг өдрийн тооны газарзүйн тархац

Увс аймгийн нутгаар салхины сарын дундаж хурд 0,3-3,3 м/с-ийн хооронд хэлбэлзэх ба дунджаар 2 орчим м/с, салхины хамгийн их хурд 28-40 м/с хүрдэг бол 15 м/с-ээс их салхитай өдөр дунджаар 12 өдөр тохиолддог байна. Улаангом станцад 3 ба 4-р сард салхины хамгийн их хурд 40 м/с хүрдэг бол хүчтэй салхитай өдрийн тоо харьцангуй цөөн буюу 4 хоног ажиглагддаг байна.



Зураг№ 2.12. Салхины дундаж болон хамгийн их хурд, м/с


Салхины дундаж хурд сумдын хувьд 1.3 м/с-2.2 м/с байна (2.3-р хүснэгт). Салхины сарын дундаж хурд альч сард 4-өөс хэтрэхгүй. Салхины хамгийн их хурд ихэнх сумдад 20 м/с буюу түүнээс доош байна. Салхи намуун байх давтагдал өвлийн улиралд хамгийн их



/45.1-52.7%/ байдаг нь энэ бүс нутагт хүйтэн улиралд эсрэг циклон тогтвортой байрладагтай холбоотой.

*Салхины чиглэл:* Салхины чиглэл нь тухайн газар орны хотгор гүдгэрийн онцлогоор голчлон тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл уулархаг орон нутагт жилийн хүйтэн улиралд хүйтэн агаар өндөрлөг газраасаа нам газар луугаа чиглэн урсах хүндийн хүчний салхи зонхилох ба жилийн дулаан улиралд шатлуур багатай нам даралтын оронд салхины чиглэл тогтворгүй болох хандлага ажиглагдана.

Увс аймгийн нутагт газрын хотгор гүдгэрийн онцлогоос болоод уулын хавцал дагуу баруун, зүүний салхи ажиглагдана. Салхины чиглэлийн тухайд өмнөдийн салхины давтагдал жилийн турш бусад чиглэлийн давтагдлаас давуу байдаг онцлогтой. Өмнөдийн салхины давтагдал өвөл хамгийн их 40 гаруй хувь хавар, намар адилхан 22-28 орчим хувь, харин зун хамгийн бага буюу 15 орчим хувь байна. Тэгэхдээ салхины хурдаас харахад өмнөдийн хүчтэй салхи гарах магадлал бага байна. Зуны цагт баруун хойд, хойд зүгийн салхи давамгайлна (2.13-р зураг).



Зураг № 2.13. Улаангом станцын салхины зүгийн давтамж

## Хүснэгт № 2.3. Салхины хурд

Үзүүлэлт	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
					Улаангом								
Салхины дундаж хурд	0.7	0.8	1.0	1.5	2.0	1.6	1.3	1.4	1.3	1.3	1.1	1.9	1.3
Хүчтэй салхитай өдөр (15 м/с-эсс дээш)	0	0	0	0	1	1	0	0	1	1	0	0	4
Салхины хамгийн их хурд	11.0	9.0	12.0	17.0	13.0	14.0	12.0	14.0	20.0	17.0	12.0	11.0	20.0
					Тариалан								
Салхины дундаж хурд	0.9	0.7	1.6	2.4	2.6	2.6	2.5	2.5	2.8	2.1	1.7	0.6	1.9
Хүчтэй салхитай өдөр (15 м/с-эсс дээш)	0.0	1.0	2.0	1.0	1.0	1.0	2.0	0.0	1.0	1.0	0.0	0.0	10.0
Салхины хамгийн их хурд	12.0	16.0	15.0	19.0	18.0	14.0	16.0	14.0	15.0	15.0	12.0	13.0	19.0
					Сагил								
Салхины дундаж хурд	1.7	1.8	2.6	2.4	2.4	1.6	1.9	2.1	2.1	2.9	1.7	2.1	2.1
Хүчтэй салхитай өдөр (15 м/с-эсс дээш)	1	0	0	1	1	1	0	0	0	0	0	0	4
Салхины хамгийн их хурд	18.0	12.0	12.0	20.0	20.0	16.0	14.0	12.0	12.0	12.0	12.0	10.0	20.0
					Өмнөговь								
Салхины дундаж хурд	1.1	1.5	2.3	3.3	3.2	2.7	2.2	2.1	2.3	2.3	2.1	1.3	2.2
Хүчтэй салхитай өдөр (15 м/с-эсс дээш)	1	1	2	2	3	1	0	0	1	0	1	0	12
Салхины хамгийн их хурд	24	32	34	40	33	22	20	24	20	24	38	24	40
					Завхан								
Салхины дундаж хурд	0.7	0.9	2	3.1	3	2.7	2.4	2.4	2.3	1.8	1.5	0.8	1.9
Хүчтэй салхитай өдөр (15 м/с-эсс дээш)	1	1	2	2	3	1	0	0	1	0	1	0	12
Салхины хамгийн их хурд	20	21	34	34	34	26	20	20	24	24	24	14	34
					Тэс								
Салхины дундаж хурд	0.8	1.1	1.0	1.4	1.8	1.4	1.5	1.3	1.4	1.1	1.1	1.7	1.3
Хүчтэй салхитай өдөр (15 м/с-эсс дээш)	1	1	0	2	1	0	0	1	0	2	1	1	10
Салхины хамгийн их хурд	20	18	14	18	18	12	14	16	12	20	15	16	20
					Бөхмөрөн								
Салхины дундаж хурд	0.9	2.1	2.7	3.6	3.1	2.2	1.7	2.0	3.0	2.8	1.9	0.8	2.2
Хүчтэй салхитай өдөр (15 м/с-эсс дээш)	3	1	1	2	2	0	0	0	0	0	0	1	10
Салхины хамгийн их хурд	18.0	15.0	15.0	18.0	16.0	12.0	12.0	12.0	12.0	13.0	15.0	14.0	18.0

**2.2.5. Ургамлын дулааны хангамж.**

Хөрсний дулааны гол эх үүсвэр нь нарны энерги юм. Энэ нь 1см<sup>2</sup> талбайд босоогоор минут бүрд буух цацрагийн хэмжээгээр илрэх бөгөөд ойролцоогоор 1,946 калори дулаан юм. Хөрсний дулааны горим нь түүний дулааны шинж чанараас шалтгаална.

Ургамлын ургах энергийн эх булаг дулаан нь навчин дахь шим бодисын нийлэгжилт, үрийн ургах, жигд цухуйх, ногоон масс үүсэх, үндэс, цэцэглэлт, үр жимс тогтох, ургац боловсроход шийдвэрлэх нөлөөтэй.

Үр ургах үеэс эхлээд ургац боловсрох хүртэл нийлбэр дулааны хэмжээгээр таримлууд адилгүй. Жишээ нь: буудай 1600-2200<sup>0</sup>С; хөх тариа 1700-2100<sup>0</sup>С; хошуу будаа 1900-2300<sup>0</sup>С ;

төмс 1300-3000<sup>0</sup>С; чихрийн манжин 2400-3700<sup>0</sup>С; цагаан будаа 3000-4500<sup>0</sup>С; хөвөн 3500-5000<sup>0</sup>С дулаанд сайн ургана. Тэжээлийн горим, цаг уурын нөхцөл, ургалтын хугацаа, газар нутгийн резьефийг хамааруулан шинжиж байх хэрэгтэй.

Температурын хэлбэлзэл ихтэй байх нь ургамлын өсөлт хөгжилд муу нөлөөтэй. Тохиромжтой дулаан нь бусад хүчин зүйлүүдийг тааламжтай болгоно. Дулаан дугагдалтай байх нь өсөлт, хөгжилтийг удаашруулдаг. Хэт их дулаан ба халалт ургамлын ферментийн үйл ажиллагаа, фотосинтезийг зогсоож, ургалт зогсох төдийгүй үхэхэд хүргэнэ.

Агаарын болон хөрсний температурын нөхцөлөөр ихээхэн өвөрмөц, жилийн агаарын температур -1-2с байдаг ба хамгийн дулаан нь болох 7,8-р хангайд агаарын температур 15-20с, Говьд 22-28с, Хөвсгөл орчимд 9,6,-9,7с байдаг. Ааарын температур маш их хэлбэлзэлтэй бөгөөд жилийн хамгийн их хэлбэлзэл 86-90с, хоногийн агаарын температурын хэлбэлзэл мөн их бөгөөд хавар 3,4-р сар, намар 9-р сард хамгийн их нь 20-27с хүрдэг.

Агаарын температурын +5с –аас дээш үргэлжлэх хугацааг ургамал ургалтын бүрэн хугацаа гэж үздэг. Энэ хугацаанд өвөлжих ба үр тариа, олон наст өвс тариалах боломж илүүтэй юм.

+10с-аар дээш дулаантай хоногийн тоог ургамал ургалтын тохиромжтой дундаж хугацаа гэнэ. Энэ хугацаанд наранцэцэг, чихрийн манжин, хүнсний ногоо, буурцагт үр тарианы тарималууд сайн ургана.

+15с дээш хоногийн тоог дулаанд дуртай ургамлын ургалтын хугацаа гэнэ. Энд эрдэнэ шиш, хөвөн, усан үзэм зэрэг ургамлууд сайн ургана.

Ургамал ургалтын хугацаанд үргэлжлэл манай орны бүс бүрд харилцан адилгүй байдаг бөгөөд Их нууруудын хотгорт буюу Увс аймгийн нутагт +5с-ээс дээш дулаан байх хугацаа 5-р сарын 7-нд эхэлж, 10-р сарын 7-нд дуусч, 153 хоног үргэлжилдэг байна. Харин +10с-ээс дээш дулаан байх хугацаа 5-р сарын 25-нд эхэлж, 9-р сарын 20-нд дуусч, 118 хоног үргэлжилдэг байна.

Хаврын эцсийн хүйтрэлт орой, намрын эхний хүйтрэлт эрт болдог учир таримлыг зөв сонгон тариалах, эсвэл цочир хүйтрэлтээс хамгаалах, хүлэмжийн тариалан эрхлэх, хучлага +6 хэрэглэх аргыг өргөн нэвтрүүлэх нь чухал байдаг.

Доктор Ph.D Б.Жамбаажамц “Хөдөө аж ахуйн уур амьсгалын нөөц” (1983) номондоо Монгол орны газар нутгийг +10С-ээс дээшхи идэвхитэй температурын 80%-ийн хангамжтай нийлбэрээр нь:

<1250с бол хүйтэн бүс

1250-1750с бол сэрүүн бүс

1750-2250с бол сэрүүвтэр бүс

2250-2750с бол дулаавтар бүс

>2750с бол дулаан бүс

гэж ангилсан байна.

Түүнчлэн ургамлын чийг хангамжийн бүсийг ургамлын чийгийн 80%-ийн хангамжаар тооцоолсон хуурайн зэргийг гаргахдаа:

<1.0 бол чийглэг

1.1-2.5 бол чийглэгдүү

2.6-4.0 бол хуурайдуу

4.1-5.5 бол хуурай


> 5.5 бол нэн хуурай

гэж тус тус хязгаарлан ангилсан байна.

Дээрх үзүүлэлтүүдийг 7-р сарын агаарын дундаж температур, хур тунадас, ууршилт, дутагдал чийгийн мэдээтэй хам боловсруулан Монгол орны хэмжээгээр ургамлын дулааны болон чийгийн хангамжийн зургийг боловсруулж, бүс бүслүүр бүрийн уур амьсгалын статистик үзүүлэлтүүдийг тодорхойлсон (4 ба 5-р хүснэгт) байна (Монгол улсын Үндэсний атлас).

Хүснэгт № 2.4. Монгол орны ургамлын дулаан хангамжийн нөхцөл

№	Дулааны бүслүүр	Дэд бүслүүр	Тухайн нөхцөлд тариалах боломжтой бүлэг таримал	+10с-аас дээш темп-н нийлбэр, °С	+5с-аас дээш темп-н нийлбэр, °С	7-р сарын дундаж темп, оС	Цочир хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа/өдөр /	Таримал ургамал ургах хугацаа /өдөр/	Байгалийн ургамал ургах хугацаа /өдөр/
1	Хүйтэн	Нэн хүйтэн	Дулаалгатай ба хагас дулаалгатай таримал	< 400	< 720	< 8	< 45	< 20	< 90
2		Хүйтэн	Ургах хугацаа богино, эрт болцтой хүнсний ногоо	400-1000	720-1325	8 – 13	45 – 70	20 – 55	90 – 115
3		Хүйтэвтэр	Эрт болцтой таримал	1000-1400	1325-1730	13 – 15	70 – 90	55 – 80	115 – 135
4			Эртэвтэр болцтой таримал	1400-2000	1730-2230	15 – 19	90 – 110	80 – 115	135 – 160
5	Сэрүүн	Сэрүүн	Дунд болцтой таримал	2000-2600	2230-2940	19 – 22	110 – 140	115 – 150	160 – 190
6			Хожуувтар болцтой таримал	2600-3000	2940-3345	22 – 23	140 – 160	150 – 175	190 – 200
7			Хожуу болцтой таримал	> 3000	> 3345	> 23	> 160	> 175	> 200



Зураг № 2.14. Увс аймгийн ургамлын дулаан хангамжийн байдал


Ургамлын дулаан хангамжийн хувьд Увс аймгийн уулархаг газраар буюу Хархираа, Түргэний уулс, Хан Хөхийн нуруугаар хүйтэвтэрээс нэн хүйтэн бүслүүр дайрах ба бусад нам дор сэрүүн газраар буюу аймгийн нийт нутгийн 70 гаруй хувьд дулаан хангамж таримал болоод байгалийн ургамал ургахад арай илүү тохиромжтой буюу таримал ургамал 80-150, байгалийн ургамал 135-190 хоног ургах боломжтой байна.

Хүснэгт № 2.5. Увс аймгийн ургамлын дулаан хангамжийн байдал

Код	Дулааны бүс	Дэд бүслүүр	Тухайн нөхцөлд тариалах боломжтой бүлэг таримал	Талбай, км.кв	Эзлэх хувь, %	
1	Хүйтэн	Нэн хүйтэн	Дулаалгатай ба хагас дулаалгатай таримал	3824.39	5.4	
2		Хүйтэн	Ургах хугацаа богино, эрт болцтой хүнсний ногоо	3765.67	5.3	
3		Хүйтэвтэр		Эрт болцтой таримал	13473.26	19.0
4				Эртэвтэр болцтой таримал	19359.1	27.4
5	Сэрүүн	Сэрүүн	Дунд болцтой таримал	30349.91	42.9	

**2.2.6. Ургамлын чийгийн хангамж.**

бүс, дэд бүслүүрийн хувьд Увс аймгийн нутгийн 70 гаруй хувьд чийг багатай байгаа хэдий ч орон зайн тархалтын хувьд чийг багатай нутагд дулааны хувьд сэрүү бүслүүр давхцаж байгаа учраас байгалийн ургамал ургах нөхцөлийг бүрэлдүүлж байна.



Зураг№ 2.15. Ургамалын чийгийн хангамжийн нөхцөл.

Хүснэгт№ 2.6. Увс аймгийн ургамлын чийг хангамжийн байдал

Код	Чийгшлийн бүс	Чийг хангамжийн дэд бүс	Талбай, км.кв	Эзлэх хувь, %
1	Чийг хүрэлцээтэй	Илүүдэл чийгтэй, чийгтэй	3827.49	5.4
2	Чийг хүрэлцээгүй	Чийгтэйвтэр	3009.35	4.3
3		Гандуувтар	3417.11	4.8
4		Гандуу, нэн гандуу	10808.38	15.3
5	Чийг багатай	Хуурайвтар, хуурай	22772.12	32.2
6		Нэн хуурай	26937.87	38.1

Хүснэгт№ 2.7. Улаангом станцын агаарын дундаж температур, 1940-2013

Он	Сар бүрийн агаарын дундаж температур [deg C]												Дундаж
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
1940	-29.3	-24.0	-8.2	0.5	8.2	13.5	15.1	12.6	7.1	-1.3	-14.1	-23.3	-3.6
1941	-27.6	-25.1	-13.0	-0.5	6.5	14.5	18.2	15.7	7.1	-2.5	-13.3	-21.1	-3.4
1942	-23.5	-24.0	-5.6	-0.1	6.0	14.2	16.1	15.3	7.8	-2.5	-13.1	-22.7	-2.7
1943	-29.0	-23.0	-10.0	1.3	10.0	14.2	18.0	14.6	7.0	-1.2	-14.3	-23.5	-3.0
1944	-28.1	-24.3	-11.5	0.6	6.7	16.1	18.5	15.1	8.5	-3.1	-19.0	-35.0	-4.6
1945	-33.2	-30.7	-14.1	2.7	8.8	14.7	16.0	14.2	8.0	-0.5	-11.8	-23.5	-4.1
1946	-28.0	-22.0	-18.0	1.3	6.8	17.0	20.8	16.1	6.1	-0.3	-12.6	-28.7	-3.5
1947	-30.5	-24.0	-14.5	2.2	9.0	14.5	15.6	14.0	8.0	-2.5	-20.5	-32.1	-5.1
1948	-26.3	-25.5	-6.0	3.5	6.0	16.0	18.2	15.5	6.5	-3.6	-17.3	-20.0	-2.8

1949	-25.3	-18.3	-13.2	1.2	8.0	14.0	18.0	13.8	7.2	0.3	-15.0	-30.0	<b>-3.3</b>
1950	-26.0	-23.5	-9.2	-0.7	9.2	16.0	18.6	14.6	7.7	-2.3	-16.7	-22.8	<b>-2.9</b>
1951	-29.0	-21.3	-15.3	-4.3	9.5	16.6	16.3	14.1	6.1	-0.3	-13.2	-21.3	<b>-3.5</b>
1952	-26.3	-26.6	-10.6	-0.7	9.5	15.6	17.5	14.5	6.6	-5.8	-21.2	-29.3	<b>-4.7</b>
1953	-29.3	-26.7	-10.7	-1.2	7.8	15.5	17.0	16.1	8.2	-0.5	-16.0	-26.0	<b>-3.8</b>
1954	-26.6	-24.5	-15.3	-0.6	5.3	16.3	17.3	16.8	8.6	-3.0	-13.1	-33.5	<b>-4.4</b>
1955	-27.7	-22.5	-16.0	-0.6	8.1	14.1	17.0	16.8	7.0	-2.2	-11.3	-19.6	<b>-3.1</b>
1956	-25.3	-24.1	-11.7	-0.8	8.1	14.1	16.1	15.3	7.2	-2.3	-18.3	-28.7	<b>-4.2</b>
1957	-30.7	-28.1	-13.2	0.6	7.1	15.5	14.3	13.0	5.1	-1.8	-13.1	-22.5	<b>-4.5</b>
1958	-26.6	-21.5	-12.7	-0.5	9.5	15.2	16.6	15.3	7.5	-1.1	-14.0	-19.2	<b>-2.6</b>
1959	-24.5	-19.2	-7.0	1.3	8.7	13.5	16.1	14.5	7.2	0.3	-20.0	-26.7	<b>-3.0</b>
1960	-27.6	-19.8	-9.6	0.2	6.8	14.1	16.7	14.0	7.2	-2.5	-15.7	-24.6	<b>-3.4</b>
1961	-26.0	-20.1	-8.7	3.2	7.3	12.7	16.0	13.1	7.5	-2.3	-14.2	-24.5	<b>-3.0</b>
1962	-25.8	-20.3	-10.5	-0.6	7.7	13.6	16.2	15.1	7.3	-1.3	-16.3	-17.1	<b>-2.7</b>
1963	-21.1	-17.0	-4.7	-2.3	9.6	14.3	16.3	16.0	6.8	-2.0	-11.0	-20.7	<b>-1.3</b>
1964	-24.0	-27.0	-10.8	2.0	9.8	14.5	16.1	15.2	7.0	-4.5	-10.5	-22.8	<b>-2.9</b>
1965	-25.6	-20.5	-8.3	0.5	9.2	15.6	15.1	14.8	7.3	0.5	-13.2	-22.1	<b>-2.2</b>
1966	-24.6	-18.5	-10.0	-1.5	9.5	14.0	14.6	14.3	8.6	-0.8	-13.7	-26.7	<b>-2.9</b>
1967	-25.7	-21.1	-8.5	0.5	11.2	13.7	16.5	14.7	7.8	-0.3	-16.2	-25.0	<b>-2.7</b>
1968	-26.5	-23.3	-8.2	0.8	8.0	15.7	18.7	13.7	5.7	-1.6	-15.5	-23.1	<b>-3.0</b>
1969	-31.8	-28.1	-10.8	0.3	8.5	16.2	17.2	13.2	6.3	-0.3	-12.2	-21.8	<b>-3.6</b>
1970	-23.2	-19.1	-15.0	0.5	8.1	16.0	18.3	16.5	5.8	-1.2	-15.6	-24.5	<b>-2.8</b>
1971	-25.7	-24.0	-14.5	0.2	9.0	13.6	15.7	14.5	6.0	-0.5	-8.8	-21.5	<b>-3.0</b>
1972	-23.2	-22.0	-7.3	1.5	10.0	16.0	17.7	14.5	7.2	-2.1	-12.5	-21.2	<b>-1.8</b>
1973	-23.1	-18.8	-7.3	1.0	8.0	16.7	15.5	13.8	10.1	-2.0	-9.0	-17.1	<b>-1.0</b>
1974	-21.1	-20.3	-11.8	1.8	8.5	14.8	17.5	17.5	7.2	-4.1	-13.3	-24.5	<b>-2.3</b>
1975	-21.7	-19.0	-8.0	0.1	9.0	15.3	16.2	16.7	10.3	1.0	-9.5	-22.8	<b>-1.0</b>
1976	-20.3	-14.1	-10.8	-0.8	7.6	15.0	17.1	13.5	9.7	-1.6	-18.5	-23.3	<b>-2.2</b>
1977	-30.5	-22.5	-9.7	0.6	8.0	15.3	18.7	17.1	9.5	-0.1	-12.0	-21.6	<b>-2.3</b>
1978	-24.7	-21.5	-8.8	0.7	8.3	15.0	15.0	14.2	7.5	-2.3	-13.0	-22.6	<b>-2.7</b>
1979	-26.0	-17.0	-8.5	-1.8	9.2	15.7	16.6	14.1	5.7	0.5	-16.1	-23.1	<b>-2.6</b>
1980	-27.0	-22.0	-14.0	-3.5	8.2	15.8	18.5	15.7	6.5	-3.5	-10.7	-22.5	<b>-3.2</b>
1981	-26.0	-20.7	-7.5	3.2	8.5	14.8	19.5	13.3	8.1	-5.0	-16.0	-20.6	<b>-2.4</b>
1982	-23.4	-18.8	-9.4	3.3	8.0	14.7	16.2	14.6	7.3	0.1	-14.8	-22.1	<b>-2.0</b>
1983	-22.7	-20.8	-8.4	-2.0	10.9	11.9	15.4	14.6	7.1	-0.4	-10.3	-20.0	<b>-2.1</b>
1984	-25.5	-24.0	-12.3	-1.5	10.8	15.0	16.0	13.2	7.6	-0.6	-13.5	-24.2	<b>-3.3</b>
1985	-24.8	-22.1	-14.7	0.2	9.0	13.8	15.9	13.4	5.3	-1.3	-14.1	-24.7	<b>-3.7</b>
1986	-23.5	-20.8	-9.2	-1.5	10.5	16.6	15.9	14.6	8.1	-1.1	-17.2	-22.5	<b>-2.5</b>
1987	-23.4	-20.4	-14.0	2.1	8.7	12.6	16.0	14.7	8.3	-3.5	-16.1	-20.7	<b>-3.0</b>
1988	-25.9	-22.8	-12.9	-0.3	7.3	13.9	16.4	15.2	8.1	-0.7	-10.3	-19.6	<b>-2.6</b>
1989	-22.1	-19.3	-7.6	3.2	9.7	13.9	17.0	15.2	6.0	0.6	-14.5	-19.0	<b>-1.4</b>
1990	-26.7	-16.7	-4.5	-0.3	9.8	12.4	16.4	13.1	7.1	3.1	-12.7	-20.8	<b>-1.7</b>
1991	-26.7	-19.5	-10.7	-0.8	8.7	14.9	16.2	17.3	7.3	-0.1	-13.1	-21.8	<b>-2.4</b>
1992	-22.5	-16.7	-8.4	1.4	11.2	17.5	16.4	14.1	6.6	-2.1	-12.3	-22.2	<b>-1.4</b>
1993	-27.4	-15.1	-5.6	1.1	8.0	13.5	16.0	13.7	9.0	0.7	-17.3	-19.4	<b>-1.9</b>
1994	-24.0	-19.8	-10.4	2.6	9.2	16.2	16.5	14.5	6.9	-2.0	-8.3	-19.8	<b>-1.5</b>
1995	-25.0	-18.5	-9.1	-1.2	5.3	13.8	17.3	15.4	7.2	0.4	-10.0	-20.0	<b>-2.0</b>
1996	-24.5	-20.2	-10.6	-0.2	10.8	12.6	17.5	15.6	7.5	-0.2	-17.1	-19.8	<b>-2.4</b>
1997	-22.9	-17.3	-4.4	3.3	9.9	16.2	17.9	15.4	7.0	-1.3	-13.5	-25.8	<b>-1.3</b>
1998	-31.0	-16.1	-7.1	4.8	9.6	13.0	19.4	15.7	9.8	0.6	-13.8	-23.1	<b>-1.5</b>
1999	-22.0	-14.5	-13.0	3.1	11.8	15.9	20.4	16.1	8.6	-2.2	-11.1	-21.2	<b>-0.7</b>
2000	-27.8	-22.2	-6.8	2.0	11.9	19.7	19.1	16.3	9.7	-3.7	-20.3	-21.8	<b>-2.0</b>
2001	-29.2	-23.7	-8.3	1.6	9.3	17.4	19.3	17.2	10.5	0.5	-12.8	-26.6	<b>-2.1</b>
2002	-22.5	-17.9	-6.6	0.2	10.1	17.8	21.5	19.2	8.3	-4.4	-18.8	-27.9	<b>-1.8</b>
2003	-20.6	-15.1	-9.3	3.1	9.4	16.3	18.6	13.4	9.4	-1.4	-14.7	-24.9	<b>-1.3</b>
2004	-24.8	-17.3	-11.8	4.6	10.0	18.6	19.7	16.8	10.0	-0.6	-12.7	-20.3	<b>-0.7</b>
2005	-35.2	-36.5	-21.0	3.7	11.2	18.5	21.7	17.8	10.5	3.1	-7.4	-27.5	<b>-3.4</b>
2006	-31.7	-25.1	-15.4	1.7	10.1	18.4	19.5	16.5	10.4	1.8	-4.8	-18.6	<b>-1.4</b>

2007	-27.9	-23.6	-15.0	6.6	13.7	18.1	23.0	18.8	12.4	0.7	-8.1	-23.8	<b>-0.4</b>
2008	-35.7	-31.4	-11.7	4.6	12.4	19.6	20.9	18.2	10.4	2.7	-5.0	-23.6	<b>-1.6</b>
2009	-32.9	-28.1	-19.0	2.4	13.2	16.1	20.3	17.5	9.6	2.6	-13.0	-28.3	<b>-3.3</b>
2010	-35.0	-34.1	-19.1	-2.0	10.3	19.3	20.6	16.6	11.2	2.6	-6.0	-23.7	<b>-3.3</b>
2011	-36.6	-27.0	-19.1	3.7	11.1	19.9	19.2	18.5	9.6	3.3	-9.0	-23.5	<b>-2.5</b>
2012	-34.3	-32.4	-19.8	3.9	11.5	20.6	21.2	17.0	11.9	1.9	-11.0	-27.8	<b>-3.1</b>
2013	-30.9	-27.6	-9.4	5.2	10.5	16.9	20.3	18.1	8.9	0.8	-5.9	-17.5	<b>-0.9</b>

Хүснэгт № 2.8. Улаангом станцын хур тунадасны нийлбэр, 1940-2013

Он	Сар бүрийн нийлбэр хур тунадас [mm]												Нийлбэр
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
1940	0	0	0	37.6	18.6	2.6	60.1	60.1	19.1	0	0	0	198.1
1941	12.6	0.9	0	0	0	13.1	35.1	59.1	55.4	2.1	0	0	178.3
1942	1.1	2.2	0	0	37.1	0	37.6	60.1	7.6	2.1	0	1.1	148.9
1943	0.5	1	1.6	12.2	3	38.6	22.7	68.9	16.1	0	3.5	0.7	168.8
1944	2.6	0.7	2	5.7	13.2	10.6	12.8	12.3	12.7	5.3	3.3	1.3	82.5
1945	0.6	1.5	3	1.3	1	28	26.2	62.5	2.2	0.1	3.8	4.7	134.9
1946	0.8	1.1	1.4	0.6	3.8	0.5	33.8	42.3	29.9	4.4	1.1	1.2	120.9
1947	0.9	0.7	0.4	2.6	3.9	11.3	2.1	30.3	0.2	1	16	5.6	75
1948	3.2	1	1.7	1	9.4	32.6	34.4	14.4	15.5	0	5	0.3	118.5
1949	1.4	1	2.1	0.2	3.9	4.2	15.8	7.6	0	8.4	5.7	11.9	62.2
1950	3	2.1	0.6	15.1	3.3	21.3	40.4	28.9	1.3	5.4	6.5	6	133.9
1951	1.9	2	11.6	23.6	23.2	60.1	60.1	60.1	11.1	0	0	0	253.7
1952	6.7	3.9	2.8	3.5	3.8	65.5	92	22.8	6.9	5.7	9	3.3	225.9
1953	6.2	6	2.1	0.1	38.7	7.1	28.3	47.6	12.8	2.1	9.8	2	162.8
1954	2	1.9	2.9	4.6	1.3	31.4	43.1	3.6	41.5	13	39.9	3.7	188.9
1955	2.5	1.8	2.5	0	7.9	17	84.7	16.9	20.5	5.5	5.2	1.4	165.9
1956	1.7	5.6	5	8.9	4.6	14.7	19.7	9.6	1.2	0.5	15.3	6.7	93.5
1957	0.9	3.5	1.8	5.4	6.9	7.4	14.2	31.4	22.2	14	4.8	8.4	120.9
1958	4.9	1.1	1.4	2.1	6.7	34.5	79.3	46.2	12.3	0.6	7.4	7.3	203.8
1959	5.6	2.6	2.1	3	10.2	19.3	21.5	32.3	16.8	0.5	16	0.9	130.8
1960	3.9	5.3	10.3	4.1	0.3	41.4	43.8	18.4	17.1	13.8	7.9	8.4	174.7
1961	4.9	2.3	6.3	2.6	8.2	49.1	25.1	24.8	9.6	8	6.1	2.7	149.7
1962	1.8	2	0	0	0	13.5	49.1	30.8	5.7	13.8	5.1	3.1	124.9
1963	3.3	4.1	3.6	4.6	3.9	19.9	64.9	21.6	7.2	2.4	6.8	4.9	147.2
1964	0.2	0.1	7.4	15.4	5.2	10.9	46.4	69.3	7.1	0.6	3.5	5.1	171.2
1965	2.4	1	4.9	3.6	2.5	22.4	6.7	8.7	9.5	0.1	3.5	0.5	65.8
1966	0	5.3	6.5	3.5	11.8	80.1	41.4	24.1	30.9	0	1.5	4.4	209.5
1967	0.2	0.2	2.3	0	31.5	87.6	35.3	22.8	15.2	6.4	10.4	6.4	218.3
1968	0.8	1.9	11.1	1	8.6	8	19.4	34.7	18.9	0.2	6.1	2.7	113.4
1969	0.6	0.1	1.4	0.2	0.6	42.3	9.7	27.6	5.6	0.1	5.6	2.3	96.1
1970	0.6	1	0	4.5	6.9	2.2	115.6	21.5	63.2	0	4.4	2.7	222.6
1971	4.3	2	2.2	3.4	1	0	25.5	7.8	6.6	0	6.2	4.1	63.1
1972	0.3	0.8	0.2	3.7	4	9	30.8	4.6	1.8	2.9	3.9	2.1	64.1
1973	0	3.8	0.7	0.4	3.7	9.6	7.7	37.3	12.7	10	7	4.2	97.1
1974	1.6	2.3	7.6	9	0.1	5.2	27.5	6.6	8.2	3.1	5.7	0.7	77.6
1975	2.5	0.8	6.1	7.3	3.8	4.3	7.2	21.9	40.3	2.9	8.4	0.2	105.7
1976	2.5	2.1	12	9.8	13.9	22.7	68.3	7.5	6.6	19.9	6.5	1.5	173.3
1977	0.5	1.3	0	1	12.6	17.9	45	10.5	5.7	5.4	7.8	4	111.7
1978	1.2	3.2	6.1	0.9	7.8	7.4	19.6	8.9	10.6	0.5	9.1	6.4	81.7
1979	4.2	2.1	0.5	1	0.1	8.6	55.7	12.1	18.3	3.4	5.1	4.1	115.2
1980	0	0	2.5	4	12	12	8.2	4.2	2.3	0.8	15.9	7.7	69.6
1981	1.6	1.7	0.9	14.6	0.9	1	13.5	29.7	24.5	5.8	11.9	1.3	107.4
1982	2	0.8	8.9	1.4	7	54.4	88.1	34.4	4	1.6	9.4	10	222
1983	2.8	0.9	0.4	10.3	1.6	58.4	26.2	21.9	14.8	6.6	2.7	7.9	154.5
1984	4.9	0.4	1.1	4	5.4	20.6	80.6	26	29.5	12.8	7.5	0.9	193.7
1985	0.9	3.5	0	0.9	25	37	39	46.3	2.5	3.8	10.6	5.6	175.1




1986	0.9	1	0.2	0	0.5	177	41.5	19.4	6.8	11.5	8.2	9.8	276.8
1987	0	5.6	2.4	9.1	8.2	7.9	24.5	33.4	31.7	6.6	7.4	2.4	139.2
1988	0.3	2.7	1.3	1.3	5.7	31.3	22.3	1.9	2.6	13	7.1	8	97.5
1989	6.2	0.9	2.5	0.5	0.7	34.4	31.4	9.8	16.9	0	15.9	10.6	129.8
1990	4.9	1	6.6	1.5	3.8	22	56.6	56.6	1	0	5.4	5.4	164.8
1991	2.2	1.6	0.7	0.4	0.6	70.4	8.8	51.9	7.1	1.6	16.3	6.4	168
1992	1.5	1.7	3.7	0.4	0	5.1	94	60.7	28.2	0	14.8	17.4	227.5
1993	1.3	6.4	7.1	0.9	7.5	52.5	84.3	55	19.4	3.7	6.7	5.5	250.3
1994	6.1	2.7	3.3	6	7.6	42.3	122.4	12.9	27	5.5	3.4	11.1	250.3
1995	2.5	0.7	9.2	1.8	3.9	4.4	25.7	33.1	1.9	0	1.3	9.1	93.6
1996	1.4	1.6	4	0.5	10	16	16.4	34.6	7.1	1	9.1	4.6	106.3
1997	2.6	1.2	1.6	1.3	7.6	43.2	89.4	55.4	8.7	0	5.9	0.8	217.7
1998	1.6	2.5	0.6	3	2.5	14	18.1	23.2	5.9	1.5	8.4	3.3	84.6
1999	1.4	2	7	0	5	1	22	41.6	11	6.4	6.9	11.5	115.8
2000	15.9	2.7	0	8.7	8.2	33.2	21.7	36.2	5.9	11.9	15	5	164.4
2001	6	0.8	6.5	1.8	2.9	9	11	27	4	0	22	9	100
2002	0.4	2	4	8	6	17	32	2	0	0.8	12	2	86.2
2003	3	3	0	13	10.8	20	120	39	14	12	4	2	240.8
2004	3	2	2	2.1	17	9.8	51	13.4	7.2	0	8	15	130.5
2005	0.9	0.9	5	2.3	13	15.4	12.2	42.2	14.6	1.4	12.2	2.7	122.8
2006	3.5	3.1	0.9	1.6	9.4	15.5	73	20.4	1.5	9	7.2	9.5	154.6
2007	0.2	2.3	0.3	7.8	6.2	19.4	4.7	8.9	2.8	8.8	15	5	81.4
2008	0.9	7.6	4.1	1	9.7	18.5	26.2	6	11.1	12.2	3.7	6.1	107.1
2009	0.7	4.8	7.5	3.1	2.9	11.4	10.6	22.8	20.9	9.9	15.3	8.5	118.4
2010	3.1	3.5	4.2	0.8	20.1	39.8	24.3	14.1	6.9	33	10.9	2.8	163.5
2011	0.5	2.6	5.3	1.1	3	14.4	25.4	8	1.1	6.6	3.1	2.6	73.7
2012	1.3	2.7	0.0	12.9	6.1	30.0	26.4	55.5	12.6	3.7	13.5	1.6	166.3
2013	1.7	5.0	1.7	1.1	1.9	18.1	21.0	71.1	11.4	7.6	7.5	5.3	153.4

### 2.3. Уур амьсгалын өөрчлөлт


#### 2.3.1. Агаарын температур

Агаарын дулаан, хүйтний өөрчлөлт. Монгол улсын хэмжээнд агаарын жилийн дундаж температур сүүлийн 70 жилд  $2.14^{\circ}\text{C}$  хэмээр нэмэгдсэн. Энэхүү үр дүнг монгол орны нийт нутаг дэвсгэрийг хамран байрласан 48 станцын олон жилийн ажиглалт хэмжилтийн цувааны шугаман хамаарлаар тооцон гаргасан болно. Энэхүү өсөлт нь дэлхийн дундаж температурын өсөлтөөс давж гарсан үзүүлэлт юм.



Зураг№ 2.16. Монгол орны нийт нутгаар дунджилсан жилийн дундаж агаарын температурын олон жилийн явц /1961-1990оны нормоос хазайсан утгаар/

Агаарын температурын олон жилийн явцыг улирлаар аваад үзвэл зуны улирлаас бусад улирал болоод жилийн дундаж байдлаар хугацааны сүүл рүүгээ /1990-2010 он/ дулааралтын эрчим суларч байгаа, өвлийн улиралд бүр сулхан хүйтрэлт илэрч байна.



Зураг№ 2.17. Зуны улирлын агаарын температурын олон жилийн явц /1961-1990 оны нормоос хазайсан утгаар/

Агаарын дулаан хүйтний хувьд илт мэдэгдэж байгаа нэг онцлог өөрчлөлт бол халуун өдрийн тоо огцом нэмэгдэж байгаа явдал юм. Халуун өдрийн тооны олон жилийн явцыг авч үзвэл Их нууруудын хотгороор 10 жилд 5-8 өдрөөр нэмэгдсэн харагдана.


Өвлийн агаарын дундаж температур мөн өссөн хандлагатай байна. Сүүлийн 70 жилд өвлийн температур ойролцоогоор 3.3°C-аар өссөн байна. Ерөнхийдөө уулархаг нутгаас бусад бүсэд халуун өдрийн тоо нэмэгдэж байна.

Дэлхийн дулааралтын нөлөөгөөр халуун өдрийн тоо дунджаар 16-25 хоногоор нэмэгдсэн, эсрэгээр хүйтэн өдрийн тоо 13-14 хоног буурсан, мөн ургамал ургах хугацаа 14-19 хоногоор нэмэгдсэн байна. Халуун өдрийн тоо 7-12 -оор нэмэгдэж, харин хүйтэн өдрийн тоо 3-6 хоногоор буурсан байна. Шөнийн температурын 90 ба 10 хувийн хангамжаас харгалзан давсан ба доош орсон хоногийн тоо өдрийнхийг бодвол арай эрчимтэй байна.

### 2.3.2 . Хур тунадас

Хур тунадасны орон зай ба цаг хугацааны хувьсал өөрчлөлт температурынхаас илүү их байдаг. Иймд температуртай харьцуулбал хур тунадасны хандлагыг тооцоход илүү хүндрэл учирна. Урт цуваагаар тооцсон хандлагын үнэмшлийн түвшин 90 хувь байна.Өвлийн хур тунадас ерөнхийдөө нэмэгдэж, харин дулаан улирлын болон зуны хур тунадас буурч байгаа нь илэрхий харагдана.

Жилд унах хур тунадасны хэмжээ багассан хандлагатай байна. Жилийн хур тунадасны явц нь дулаан улирлын хур тунадасны, түүний дотор жилийн нийлбэрийн 70%-ийг эзлэдэг зуны хур тунадасны явцаар тодорхойлогддог. Доорхи зурагт жилийн нийлбэр хур тунадасны олон жилийн явцыг үзүүлэв.



Зураг№ 2.18. Жилийн нийлбэр хур тунадасны олон жилийн явц

Ургамал ургалтын хугацааны хур тунадасны горимд орж байгаа бас нэг өөрчлөлт бол нийт хур борооны хэмжээний дотор аадар хур борооны хэмжээ нэмэгдэж байгаа явдал юм. Харин зуны хур тунадасны өөрчлөлт нь олон жилийн дундажтайгаа харьцуулахад өвлийнхийг бодвол бага нэмэгдэх хандлага байна.

### 2.4. Бэлчээрийн ургамал, ургац


Монгол орон далай тэнгисээс ихээхэн алслагдсан (хамгийн ойрын Шар тэнгис хүртэл 900 км, агаарын урсгалын салхин дээд талд байрлах Атлантын далай хүртэл 6000 км), Евразийн эх газрын төвд далайн мандлаас ихээхэн өндөр өргөгдсөн (нутгийн дундаж өндөршил 1580 м орчим), агаарын зонхилох урсгал талдаа өндөр уул нуруудаар хүрээлэгдсэн эх газрын эрс тэс хуурай уур амьсгалтай. Энэ утгаараа манай оронд ган, зуд, цасан болон шороон шуурга байгаль, цаг уурын гамшигт үзэгдлүүд элбэг тохиолдож байна. Тухайлбал, сүүлийн хэдэн арван жилийн дотор уур амьсгалын өөрчлөлт, хүний хүчин зүйлийн хам нөлөөгөөр цөлжилт, байгалийн гамшгийн давтагдал нэмэгдэх, усны

нөөц, биологын элдэв зүйл хомсдох, газрын чадавхи доройтох явц идэвхжиж, улс орны нийгэм эдийн засагт төдийгүй байгалийн нөхөн сэргээгдэх нөөцөд сөргөөр нөлөөлж байна.

Бэлчээрийн мал аж ахуйд тулгуурласан эдийн засагтай манай орны хувьд гангийн давтагдал ихсэх нь цөлжилтийг бий болгох, бэлчээрийн ургацыг бууруулах, ургамлын төрөл зүйлийг хязгаарлах сөрөг нөлөө үзүүлснээр зун, намрын улиралд мал тарга тэвээрэг авч чадахгүй байж, өвөл, хаврын улиралд зуданд нэрвэгдэж хорогдоход хүргэдэг төдийгүй газар тариалан эрхлэлтэнд ч сөргөөр нөлөөлөх аюул учруулдаг.

Монгол улсын сум бүрээр зуншлагатай, гандуу, гантай гэсэн чанарын үнэлгээний 1973-2000 оны мэдээллийг нэгтгэж гаргасан гангийн давтагдлын (гандуу+ган) орон зайн тархалтаас (Нацагдорж, Дуламсүрэн, 2003) харахад Увс аймгийн нийт нутгийн 50 орчим хувьд ган давтагдах магадлал 21-40% буюу 3 жил 1 удаа ган болох магадлалтай байна.

Цаг уурын станц, харуулын сүлжээнд ургамлын ургалтын үед 5-9-р сар бүрийн 25-нд хашаалаагүй талбайд хэмждэг биомассын мэдээг 1984 оноос хойшхи хугацаагаар УЦУОХ-ээс авч боловсруулав. Мөн АНУ-ын Агаар сансрын уудмыг судлах үндэсний газар (NASA)-аас боловсруулан дэлхийн хэмжээгээр гаргадаг МОДИС хиймэл дагуулын 2000-2011 оны 16 хоногийн NDVI (Normalized Difference Vegetation Index) мэдээг БОМТ-өөс авч боловсруулж тооцоолол хийв. Увс аймгийн нутагт хөдөө аж ахуйн цаг уурын ажиглалт хийдэг харуулуудын 1984-2011 онд хийсэн ургацын ажиглалтын мэдээллээс харахад бэлчээрийн ургамлын биомасс ихэнх сумдын нутгаар буурсан байна (14-р зураг).




Зураг № 2.19. Бэлчээрийн ургамлын биомассын өөрчлөлт (ц/га) 1984-2011 он

Монгол орны хэмжээгээр биомассын өөрчлөлтийг зураглахдаа жил бүрийн нийт 323 станц, харуулын 8-р сарын мэдээний өөрчлөлтийн шугаман регрессийн коэффициентийн утгаар үнэллээ.

Биомассын тоон утга нь хэт бага тоон утгын хооронд хэлбэлзэж байгаа болон ажиглалтын цувааны урт харилцан адилгүй байгаагаас өөрчлөлтийн хандлагын коэффициентийн утга бага байсныг тооцоололд тохиромжтой, өөрчлөлт нь харагдахуйц болгох зорилгоор 1000-аар үржүүлж тооцов.

Станц, харуулуудын 37.2 хувьд биомасс өссөн, 2.5 хувьд өөрчлөгдөөгүй, харин 60.4 хувьд буурсан хандлага ажиглагдсан. Бууралт болон өсөлт бүрийн өөрчлөлтийн коэффициентийн утгыг сул ба хүчтэй гэж хувааж үзлээ. Тухайлбал, өсөлтийн тоон утга 0.1-ээр их бол хүчтэй, 0-0.1-ийн хооронд байвал сул өсөлт ажиглагдсан, бууралтыг мөн сөрөг утгаар -0.1-ээс бага бол хүчтэй, 0- -0.1 бол сул бууралт ажиглагдсан, 0 бол өөрчлөгдөөгүй гэж ангилж үзлээ.


ArcGIS-ийн цэгэн мэдээг интерполяц хийдэг аргуудаас Co-kriging аргыг ашиглан GDEM мэдээг оролцуулан интерполяцлаж үзлээ.



Зураг№ 2.20. Увс аймаг орчмын биомасс, NDVI-ийн өөрчлөлт

Увс аймгийн нутгаар газрын ажиглалтын болоод хиймэл дагуулын мэдээгээр тооцоолсон биомассын хэмжээ өмнөд хэсэгт хамгийн ихээр өссөн буюу 4.79 ц/га-аар өссөн бол хойд хэсгээрээ хүчтэй бууралт (1.19 ц/га) ажиглагдсан байна.

Ургамлын бүрхэцийн өөрчлөлтийг үнэлэхдээ МОДИС хиймэл дагуулын NDVI буюу ургамлын нормчилсон ялгаврын индексийн 2000-2011 оны мэдээг ашиглалаа. Увс аймгийн нийт нутгаар ургамлын бүрхэц 2000-2011 оны хооронд буурах хандлагатай өөрчлөгдсөн байна.




Зураг№ 2.21. Ашигласан MODIS/NDVI зураг мэдээ

**2.4.1. Цэвдэг**

Мөнх цэвдэг хойд өргөргийн 430–аас хойш нутагт орших ба нийт нутгийн 63 хувьд цэвдэгт хөрс тархсан байна.

Мөнх цэвдэг гэж 2 жил буюу түүнээс дээш жил хөрсний гүний температур нь 00С-ээс бага байдаг газар нутгийг хэлдэг. Мөнх цэвдэг тархсан байдлаар нь үргэлжилсэн, тасалданги, элбэг, алаг цоог, ховор алаг цоог, тохиолдлын, өнжмөл, улирлын тархалттай гэж 7 бүсэд ангилж үздэг.



Зураг № 2.22. Монгол орны цэвдгийн газарзүйн тархалт


Өргөрөг хойшлох тутам цэвдгийн тархалт нэмэгдэж, үргэлжилсэн цэвдэгтэй газар элбэг болно. Мөн сүүлийн 50-иад жилийн хугацаанд термокарст, солифлюкци, термоэрози, халиа зэрэг цэвдэгт үзэгдэл нилээд идэвхитэй явагдах болов. Олон жилийн бөөргийн орой гэсэж доош сууж хонхор үүсэх, бөөргийн мөс хайлж хонхорт нуур тогтох, мөсөрхөг цэвдэгтэй ул хөрс гэсэж термокарстын нуур үүсэх зэрэг үзэгдэл элбэг тохиолдох болов. Цэвдгийн тархалт, хэмжээг тодорхойлоход хүндрэлтэй байдаг. Цэвдэгийн тархалтыг агаарын температурыг ашиглан тооцох аргыг өргөн ашигладаг боловч хөрсний гүний температур, агаарын температур хоорондоо өөр байдаг. Цэвдэгийн тархалт, гүн зэргийг загварчлах ихэнх аргууд нь хөрсний дулаан дамжуулалт дээр тулгуурласан байдаг бөгөөд энэ нь хөрсний физик, ус дулааны тухай өргөн мэдээлэл шаарддаг.

Цэвдгийн бүс багасаж байгаа бүсүүдэд хөрсний чийг мэдээж нэмэгдэнэ. Хөрсний чийг нэмэгдэх нь магадгүй тохиолдлын цэвдэгтэй бүсэд бэлчээрийн гарц нэмэгдэх нөхцөл бүрдэх эерэг талтай байж болно. Харин бусад бүс нутгийн хувьд хөрс чийгээр хэт ханаж бэлчээр намагжих, хот суурин газрын барилга байшин суух, зам гүүр эвдрэх гэх мэт сөрөг нөлөө гарч болох юм. Мөн хөрсний чийг нэмэгдэх нь газрын дээрх болон газрын доорх усны харилцан уялдааг нэмэгдүүлж гадаргын усны тухайлбал гол мөрний урсац, нуурын усны түвшин цэвдгийн эхэн үеийн эрчимтэй хайлалтын үед нэмэгдэж цаашид ус намаг ширгэж хөрс хуурайших нөхцөлд гадаргын болон газрын доорх усны нөөц багасч улмаар хатаж ширгэх сөрөг үр дагаврыг авчирч болох юм.



### 2.4.2. Өндөр уулын мөнх цас, мөс ба цасан бүрхүүл.

Өвлийн улиралд маш бага хур тунадас унах тул цасан бүрхэвчинд агуулах усны хэмжээ мөн хязгаарлагдмал болно. Гэхдээ голын жилийн урсацын 10-30% нь хаврын улиралд хайлсан цас мөснөөс бүрдэнэ.



Зураг № 2.23. Монгол орны нутаг дэвсгэр дээрхи цасан бүрхүүлийн байдал,

**Өндөр уулын мөстөл.** Мөстөлийн өөрчлөлтийг дэлхий нийтээрээ уур амьсгалын өөрчлөлтийн хамгийн тод индикатор гэж үздэг. Мөстөл бүхий бүс нутагт мөстөлийн хэмжээ, талбай улам л хумигдсаар байна. 2002 оноос эхлэн мөстөлийн байнгын ажиглалт хэмжилтийг хийж байна.

### 2.4.3. Усны нөөц


Увс аймгийн нутагт орших гол горхиуд нь Төв Азийн гадагш урсгалгүй голуудын ай савд багтах бөгөөд гол төлөв Алтай нуруу түүний салбар уулс болох Хархираа, Түргэний уулсаас болон Хангайн нурууны салбар уулсаас эх авч урссан голууд байдаг.

Тус аймагт манай орны гадагш урсгалгүй бараг бүх томоохон голууд байдаг ба тэдгээр нь Увс, Хяргас, Ачит, Айраг нууруудад цутгаж эдгээр нуурыг усаар тэжээж байдаг. Дотоодын урсгалтай голуудаас хамгийн том нь Ховд гол бөгөөд тэрээр Алтай таван богдоос эх авч Баян-Өлгий аймгийн нутгаар дамжин урссаар Увс аймгийн нутгийн гүн рүү оролгүй захлан урссаар Хар-Ус нуурт цутгадаг. Бөхмөрөн гол ОХУ-ын нутгаас эх авч урссаар Монгол улсын нутагт ирж Ачит нуурт цутгадаг. Хархираа гол нь Хархираа уулын мөсөн гол, мөнх цаснаас эх авч урсах ба адагтаа олон салаалж зарим салаа нь Увс нуурт хүрэлгүй хайрган хөрсөнд шургаж замхардаг. Зүүнговь сумын Баяннуур болон Дэлгэр, Баянбулгуудаас эх авсан Нарийн гол Боригдэлийн элсийг туулж урссаар адагтаа багашиг дельт үүсгэн Увс нуурт цутгадаг ба бэлчээрийн усан хангамжинд чухал ач холбогдолтой юм. Хангайн нуруунаас эх авсан Завхан, Хүнгүй голууд Увс аймгийн Завхан сумын нутгаар урсч адагтаа гонзгойдуу дельт үүсгэн Айраг нуурт цутгаж түүгээр дамжин ус нь Хяргас нуурт ордог. Эдгээр голууд нь бэлчээрийн усан хангамжинд чухал нөлөөтэй.

Увс аймгийн нутаг дэвсгэр том, дунд, жижиг нуурууд элбэгтэйгээрээ онцлог бөгөөд эдгээр нууруудаас хамгийн том нь Увс, Хяргас, Айраг, Үүрэг, Ачит нуурууд бөгөөд Айраг, Үүрэг, Ачит нууруудын талбай нь 100 км<sup>2</sup>-аас их тул томоохон нуурт тооцогдоно. Эдгээр том, томоохон нууруудаас гадна Хар-Ус, Шаазгай, Баян, Цавдан, Цагаан, Тахилт, Өлгий, Далай нуур зэрэг маш олон нуурууд байдаг. Эдгээр нууруудаас Ачит, Айраг, Баян нуурууд цэнгэг устай бөгөөд бусад нуурууд нь шорвог устай төдийгүй заримаас нь давс олборлодог. (Завханы Далай нуур, Өмнөговийн Давсан нуур гэх мэт)

Увс аймгийн нутаг дэвсгэр дээр 70 гаруй гол горхийн мянга хүрэхгүй км урттай ил задгай тогтмол урсац байгаа нь 1 км<sup>2</sup> талбайд 0.01 км ногдож байгаа нь маш бага үзүүлэлт юм. Энэхүү гол мөрний усны нягтшил нь аймгийн нутаг дэвсгэрийн хэсэг бүрт харилцан адилгүй Тэс суманд хамгийн өндөр, Өлгий, Өмнөговь, Наранбулагт бага байх нь мэдээж.

Увс аймгийн гол горхийн ихэнх хэсгийн усны тэжээгдэл нь гүний уснаас 15-25%, хур борооны уснаас 25-40%, мөнх цасны уснаас 35-55%-ийн эх үүсвэртэй байдаг. Эдгээр үзүүлэлтийг Хангайн нуруунаас эх авсан голуудтай харьцуулахад борооны ба гүний уснаас авч буй тэжээл нь бага харин мөнх цаснаас тэжээгдэх нь илүү байна. Иймд Хархираа, Түргэн тэдний салбар уулсаас эх авсан голууд дулаан улиралд мөнх цас, мөсөн гол хайлах хэмжээгээр хур бороогүй байсан ч усаар тэжээгдэж байдаг онцлогтой. Энэ ч учраас Хангайн аймгуудын гол горхины усны хамгийн их урсац 4, 5-р сард тохиож байхад Увс аймагт усны хамгийн их зарцуулалт 5, 6-р сард байна.



Зураг № 2.24. Монгол орны гадаргын усны зураг

Мөсний үзэгдлийн өөрчлөлт. Сүүлийн үеийн судалгаагаар гол мөрөн нууранд мөсний үзэгдэл эхлэх, мөсөн бүрхүүл тогтох задрах, үргэлжлэх хугацаа болон мөсний зузаанд мэдэгдэхүйц өөрчлөлт гарч байна.

Тухайлбал намар голд мөсний үзэгдэл эхлэх ба мөсөн бүрхүүл тогтох хугацаа хойшилж байгаа бөгөөд орон нутгийн уур амьсгалын нөхцөл байдлаас хамааран энэ хугацаа газар газар өөр өөр юм.

Гол мөрөн, нуурын мөсний үзэгдэл эхлэх, арилах, үргэлжлэх хугацаа өөрчлөгдөж байгаагийн зэрэгцээ мөсөн бүрхүүлийн зузаан ч багагүй нимгэрчээ.

## **2.5. Байгалийн гамшиг**

Нийгэм, эдийн засаг, байгаль орчинд учрах гамшиг, түүний дотор байгалийн гамшиг гэж юуг хэлэх вэ гэдэг талаар хоорондоо зөрүүтэй олон тодорхойлолт байхын дээр эрсдлийн удирдлагад хэрэглэгддэг томъёоллууд зөрүүтэй ч байдаг. ХХ зууны ерээд оныг “Байгалийн гамшигийн аюулыг бууруулах олон улсын арван жил” болгон зарлах тухай НҮБ-ын Ерөнхий ассамблейн 42 дугаар чуулганы 169 дүгээр тогтоолд өгсөн тодорхойлолтоор ч байгалийн гамшиг гэдэгт хүний амь нас, хүний бүтээсэн баялагт хохирол учрахыг ойлгосноос бус байгаль орчинд хохирол учрах, орчноор дамжин нийгэм, эдийн засагт хохирол учрахыг тооцоогүй юм. Гэтэл байгалийн аюултай үзэгдэл гамшигийн хэмжээнд хүрэх нь нийгэм-эдийн засгийн өртөх байдал талаасаа гадна орчны доройтолтой холбоотой байх нь элбэг. Нөгөө талаар орчны доройтол эргээд нийгэм-эдийн засагт сүйрэл дагуулах нь ч элбэг.

### **2.5.1. Гамшигт үзэгдлийн давтагдал.**

Сүүлийн хориод жилийн дотор цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн давтагдал ерөнхийдөө нэмэгдэх хандлагатай байгаа боловч тодорхой тренд үүсгэхээр илэрхий өөрчлөлт илрэхгүй байгаа юм.

Байгалийн гамшигт үзэгдлээс томоохон нутаг хамаарсан, удаан хугацаагаар /6 цагаас дээш/ үргэлжилсэн цасан шуурга хамгийн ноцтойд тооцогдоно. Ийм цасан шуурганы үед хээр гадаа яваа малчид хамгийн их хэлмэгддэг. Харин ган, зудын давтагдалт болон агаар мандлын конвекцийн гаралтай багаахан нутаг хамаарсан аюултай үзэгдэл /хүчтэй аадар, нөөлөг салхи, аянга цахилгаан, том мөндөр/ ихсэж байгаа байна.


### **2.5.2. Цөлжилт.**

Орчин үед хүн төрөлхтний өмнө тулгарч байгаа нэг аюул бол хүний үйл ажиллагаа ба уур амьсгалын өөрчлөлтийн явцад улам бүр эрчимжиж байгаа цөлжилтийн процесс юм. Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ийн конвенцоор цөлжилт гэж “хуурай хуурайвтар, чийг дутмаг бүс нутагт янз бүрийн хүчин зүйлс, түүний дотор уур амьсгалын өөрчлөлт, хүний аж ахуйн үйл ажиллагааны улмаас газрын доройтол болох явц” гэжээ. Газар гэсэн ойлголтонд хөрс, ус, ургамал ба бусад биомасс мөн түүнчлэн системийн дотор явагдаж буй экологийн болоод гидрологийн процессыг багтаасан газрын биобүтээмжит системийг хэлж байна.

Цөлжилтийн антропоген хүчин зүйлийн гол нь малын хөлөөр бэлчээр талхлагдах явц юм. Мэдээж энд бас уул уурхайн үйл ажиллагаа, авто тээвийн хөдөлгөөн гэх зэрэг техноген элэгдэл орно. Ойт хээр, хээрийн бүсийн бэлчээрт мал бэлчээрлэлтийн нөлөө ихсэхэд ургамлын зүйлийн тоо цөөрөх, чийгсэг ургамал багасах, хуурайсаг ургамал ихсэх явц

ажиглагдахын дээр нийт ургацын хэмжээ мэдэгдэхүйц багасаж, мал иддэггүй ургамал ихэсдэг зүй тогтол илэрч байна.

**Цөлжилтийн өнөөгийн байдал.** Цөлжилтийн асуудал нь байгалийн гамшгийн онцгой нэг хэлбэр бөгөөд зарим мэдээллээр Монгол орны бэлчээрийн 70 орчим хувь ямар нэг хэмжээгээр цөлжилтөнд өртсөн байна.



Зураг № 2.25. Монгол орны цөлжилт, газрын доройтлын байдал, 2006 он

Одоо цагт явагдаж байгаа цөлжилтийн уур амьсгалын хүчин зүйл нь ургамал ургалтын хугацааны агаарын температурын өсөлт, үүнээс уламжлан дэвсгэр гадаргын ууршиц эрс нэмэгдэж байхад түүнийг дагаад хур тунадасны хэмжээ зохих хэмжээгээр /ууршицын алдаглыг нөхөх хэмжээнд/ нэмэгдэж чадахгүй, харин ч ихэнх нутагт буурч байгаа, ургамлыг халууны дарамтанд оруулах хэт халуун өдрийн тоо нэмэгдэж байгаа, жилийн дулаан улиралд ордог хур борооны дотор аадар хур борооны эзлэх хувийн жин хориод хувиар нэмэгдсэн, хур борооны нийт үргэлжлэх хугацаа богиноссон, цасан бүрхүүл эрт арилж ургамал ургахаас өмнө хөрс нүцгэн байдаг хоногийн тоо ихэссэн, үүнээс үүдээд өнгөн хөрсний сул элс, шороо салхинд хийсэх буюу шороо шуурах потенциал боломж нэмэгдсэн зэрэг олон хүчин зүйлийг тоочиж болно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЛАНДШАФТ, НУТАГ ДЭВСГЭРИЙН ЦОГЦОЛБОР НӨХЦЛИЙН МУЖЛАЛТ, ТОЙРГУУД

### 3.1. Байгаль, нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийн мужлалт

Увс аймгийн нутаг дэвсгэр нь байгалийн нутаг дэвсгэрийн цогцолбор мужлалтаар Увс, Хяргас нуурын хотгорын цөлжүү хээр, хуурай хээрийн дэд муж, Ханхөхийн нурууны дундаж өндөр бэлэрхэг уул бүхий хээр, хуурай хээр, ар хажуугийн ойн дэд муж, Монгол Алтайн зүүн хэсгийн /Хархираа, Түргэн/ цулдам уул, хотгор ян сарьдаг, уулын нуга, уулын хээрийн дэд мужид тус тус багтана. Ийнхүү мөнх цаст өндөр уулсын бүслүүрээс ойт хээр, говь цөлийн бүсэд шилжих байгалийн олон бүс бүслүүрийг хамран орших нь аялал жуулчлалын олон төрөл хэлбэрийг нэгэн зэрэг хөгжүүлэх давуу талтай.

Увс аймаг нь байгалийн нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийн 3-н бүсээс говийн бүс, хангайн бүсэд хамаарна. Хангайн бүс нутгаас Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон муж, Монгол алтайн өндөр уулын муж, Говийн бүс нутгаас Алтайн ар говийн цөлөрхөг мужид тус бүр хамаарна. Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон муж нутгаас Ханхөхийн нурууны ойт хээр бүхий тойрог- Х3, Монгол Алтайн өндөр уулын мужаас Хархираа-Түргэний өндөр уулс, хотгорын тойрог- Х11, Алтайн ар говийн цөлөрхөг мужаас Увс нуурын хотгорын тойрог- Г1, Хяргас нуурын хотгорын тойрог – Г2 тус бүрд хамаарна.



Зураг № 3.1 Увс аймгийн байгаль нутаг дэвсгэрийн мужлалын зураг

Эндээс тус аймгийн нутаг дэвсгэр, байгаль газарзүйн нөхцлөөрөө эрс ялгагдсан хэсгүүдээс бүрдэж байгааг харж болно. Өөрөөр хэлбэл тус аймгийн нутагт говь цөл, цөлөрхөг газрууд, өндөр уулс, ойт хээр зэрэгцэн хослон оршдог өвөрмөц онцлог бүхий газар нутаг юм.

*Хүснэгт № 3.1. Мужийн Увс аймгийн нийт нутаг дэвсгэрт эзлэх талбай*

Д/д	Бүс нутаг	Мужийн нэр	Мужийн нийт талбай	
			Мян. га	хувь
1	Хангайн бүс	Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон муж	1883,2	27,06
2		Монгол - Алтайн өндөр уулын муж	1210,7	17,39
3	Говийн бүс	Алтайн ар говийн цөлөрхөг муж	1639,0	23,55
Нийт дүн			4732.9	68

Эндээс харахад хамгийн их талбайтай муж нь Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон муж, хамгийн бага талбайг Монгол - Алтайн өндөр уулын муж эзэлж байна.

Ингээд байгалийн нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийн муж, тойргуудын байгалийн нөхцлийн онцлогыг тус бүрд нь авч үзье.

Хангайн бүс нутаг

Хангайн бүс нутаг нь 15-н мужтайгаас Увс аймагт харьяалагдах хоёр муж байна.

Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон муж (Х-3)

Монгол Алтайн өндөр уулын муж (Х-11)

Хангайн нуруу нь тус орны бараг төв хэсэгт ерөнхийдөө баруун хойноос зүүн урагшаа чиглэн 750 гаруй км урт үргэлжлэх бөгөөд энэ тогтолцоонд Хангайн нурууны ноён оргил Отгонтэнгэр түүний салбар уулс болон Хан Хөхийн нуруу, Тарвагатай, Булнайн нуруу багтана. Эндхийн уулсын үнэмлэх өндөр дунджаар 3000 м орчим боловч зарим оргил далайн төвшнөөс дээш 3500-4000 м хүрнэ. Хамгийн өндөр оргил Отгонтэнгэр уул 4021 м хүрнэ. Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон муж нь Хан Хөхийн нурууны ойт хээр бүхий тойрог (Х-3), Булнайн-Тарвагатайн нурууны ой, тайга бүхий тойрог (Х-4), Хангайн тэгш өндөрлөгийн тойрог (Х-5) гэсэн 3 тойрогт хуваагдана. Эдгээр тойргууд нь байрлал, өндөр намын ялгаа, ландшафтын бүтэц, ашиглалтын түвшин зэрэг олон үзүүлэлтээр өөр хоорондоо ялгарна.

### **3.2. Байгаль, нутаг дэвсгэрийн муж, тойргуудын онцлог**

#### **3.2.1. Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон муж, Хан Хөхийн нурууны ойт хээр бүхий тойрог (Х-3)**

Хангайн гол нурууны хамгийн баруун талын томоохон салбар болох Хан Хөхийн нуруу, түүний зүүн талын салбар уулс хамрагдана. Хан Хөхийн нуруу Их Нууруудын хотгор руу гүн түрж орсон тул Увс, Хяргас нуурын хонхорыг бие биеэс нь зааглан оршино. Хан Хөхийн нуруу Хангайн гол нурууг бодвол намхан, хамгийн өндөр нь зүүн хэсэгт байгаа Хан Хөхийн ууланд 2928 м хүрнэ. Эндээс баруун тийшээ болоход гадаргын үнэмлэхүй өндөр намсан Тогтохын шилтэй залгах бөгөөд түүний оргил Хүрмэн овоо 2356 м өндөр юм. Эндэхийн уулс голчлон эрт төрмөлийн эриний эхэн үеийн боржин, талст занар зэрэг чулуулгаас бүтсэн байна.

Хан Хөхийн нурууны ар хажуу нь налуу, оройгоосоо бэл рүүгээ алгуур намсаж Увс нуурын хотгорт шилждэг бол өвөр хажуу нь хана шиг эгц байдалтай, Хяргас нуурын хотгор руу огцом бууж нийлсэн байна. Хан Хөхийн нуруу зүүнээс баруун тийш бараг өргөргийн дагуу сунаж байрласан учраас түүний ар, өвөр хажуугийн хөрс, ландшафтын байдал хоорондоо эрс тэс ялгаатай ажээ. Үүнд: Хан Хөхийн нурууны ар хажууд нуга, ой мод, хээр бүх уулыг бүрхэж байхад өвөр хажуу нь ой модгүй болж хаяагүй хуурай хээрүүд үзэгдэх ба хуурай сайраар сүрхий хэрчигдсэн байдаг ажээ.

Хан Хөхийн нуруунаас богино голууд эх авч уулын тэгш өргөн хөндийгөөр урсана. Эдгээр хөндий нь дээд бүсдээ бага налуу ба доод бүсдээ эрс гүн болж ирэх бөгөөд энд чулуурхаг хавцал олонтоо тохиолдоно. Мөстлийн ул мөр Хан Хөхийн төв хэсэгт үлджээ. Нурууны оройн хэсгээр тэгшрэлийн гадаргын үлдэц сайн хадгалагдаж үлдсэн тул уулсын орой хавтгай хэлбэртэй байна. Хан Хөхийн уулсын ар хормой дагуу эртний тетоник гүний хагарал байрласнаас үзэхэд энэ тойрог нь газар хөдлөлтийн идэвхтэй мужид багтана.

*Уур амьсгалын хувьд* тус мужийн тойргууд нь өөр хоорондоо нэлээд ялгаатай. Ялангуяа Хан Хөхийн нурууны ойт хээрийн тойрог (Х-3) нь ихээхэн ялгаатай болно. Учир нь Хан Хөхийн уулс Алтайн ар говийн цөлөрхөг муж дотор нэлээд баруун зүг түрж тогтсон байгалийн сонин үзэгдэл (феномен) юм. Орчноосоо харьцангуй өндөр Хан Хөхийн нуруу нь зундаа сэрүүвтэр, өвөлдөө дулаавтар, хур чийг харьцангуй их тул ойт хээрийн шинжийг агуулсан байдаг. Энэ тойрогт мэдээний урт цуваатай цаг уурын станц байхгүй бөгөөд гол төлөв бүрэн бус мэдээтэй, цөөн жил ажилласан цаг уурын харуулууд ажилладаг тул уур амьсгалын нөхцлийн талаар нарийвчлан тодруулах үндэслэл муутай байгаа болно. Энд жилийн дундаж агаарын температур  $-2^{\circ}\text{C}$ , хамгийн хүйтэн 1 дүгээр сард  $-25^{\circ}\text{C}$ , хамгийн дулаан 7 дугаар сард  $+20^{\circ}\text{C}$  орчим байдаг нь дурдсан мужийн бусад тойрогтой харьцуулахад хүйтний улиралд илүү хүйтэн, зундаа арай дулаан байгаа нь цөлөрхөг газрын хүрээлэлд оршдогийн илрэл юм.

Эндхийн цөлөрхөг нутагт жилдээ 100 орчим мм тунадас ордог бол Хан Хөхийн нуруу орчим үүнээс 2 дахин их буюу жилийн нийлбэр хур тунадас 200 орчим мм байдаг. Гэхдээ энэ нь Хангайн бусад тойргоос 20-50 мм-ээр бага байна. Уур амьсгалын нөхцлийн нэг онцлог нь Тэс, Идэр голын хөндий, уулс хоорондын хөндий хотгор газартаа өвөл нэн хүйтэн байдаг. Баян-уул (Завхан) суманд 1-р сард үнэмлэхүй хамгийн бага температур 1981 онд  $-52^{\circ}\text{C}$  хүрч хүйтэрсэн бөгөөд үнэмлэхүй бага температурын дундаж нь  $-45^{\circ}\text{C}$  байдаг. Түүнчлэн ийм байдал Баянтэс, Сонгино, Түдэвтэй, Идэр, Яруу зэрэг сумын цаг уурын станц, харуулд тэмдэглэгдсэн байна.

Зундаа сэрүүвтэр, дулаан улирлын дундаж агаарын температур  $+13 - +15^{\circ}\text{C}$  орчим байдаг боловч заримдаа их халах явдал тохиолддог. Тухайлбал, дээр дурдсан Баян-уул суманд 1974 оны 6-р сард үнэмлэхүй хамгийн их температур  $+37^{\circ}\text{C}$  хүрч байсан байна. Энд 7 дугаар сарын 2-р арав хоногт хамгийн их температур бараг жил бүр  $30^{\circ}\text{C}$  хүрч болох (90%-ийн хангамжтай) бөгөөд 10 жилийн 5-д нь  $+27^{\circ}\text{C}$ , 10 жилд 1 удаа  $+24^{\circ}\text{C}$  хүрч байсан байна. Иймд энэ тойрогт эх газрын эрс тэс уур амьсгалын нөхцөл хүчтэй илэрдэг байна.

**Ургамлан нөмрөг.** Ургамалжилтын хувьд нэг талаас Сибирийн тайгын элементүүд, нөгөө талаас Монголын хээрийн төлөөлөгчид мөн Дагуурын элементүүд нэвтэрч байршсан учир уулын хээр, уулын ойт бүслүүр ээлжлэн солигддог. Хангайн нурууны тагд Алтай-Соёны өндөр уулын элементүүд нилээд бий. Залуу унаган ургамлуудаас гадна Төвд бягзаа, их бушилз зэрэг Гималайн өндөр уулсын үлдвэр ч энд бий. Тагдаа бушилз, өлөн-бушилзат, алаг өвст намгархаг нугатай, хаг, хөвдөт царамтай тагийн сөөгөн ширэнгэтэй. Уулсынхаа арыг дагаж саруул шинэсэн ой зонхилох боловч Тарвагатай болон Булнайн уулсын ой нь тайгажуу шинжийг үзүүлдэг.

Хангайн нурууны олонхи уулсын хажуугаар ботууль-алаг өвст, үетэн-алаг өвст, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст уулын хээр өргөн тархсан байх ба тэнд Ленийн ботууль, саман дурваа, сунагар биелэг, сибирь ботууль, сибирь ба байгаль хялгана Шеллийн бутнуур зэрэг үетэн, зогдор, өлөн, хигмэл бивлэнцэр, одой далантүрүү, дагуур тайр, нарийн навчит тарна, цомогт баавар цэцэг зэрэг ургамлууд голлох байр эзлэнэ.

Өргөн хөндийнүүддээ хуурай шивээт хялгана, шивээт хялгана-агьт хээртэй. Харин хангайн нурууны баруун болон өвөр хэсгээр их хээржсэн тул түүгээр дамжин цөлөрхөг хээрийн ургамал энэ мужид нэвтэрсэн байдаг.

Одоогийн байдлаар 1214 зүйл ургамал бүртгэгдээд байгаа бөгөөд үүний дотор 151 зүйл өвслөг ургамал (тойргийн ургамлын 12.44%), 1063 зүйл модлог болон сөөглөг ургамал (87.51%) байна. Зүйлийн бүрдлээрээ хамгийн баялаг мужид орж байгаа бөгөөд модлог болон сөөглөг ургамлын тоо хамгийн олон. Энэ мужид байгаа ургамлыг экологийн бүлгээр нь ялгаж үзвэл:

- Чийгсэг, чийгсүү-хуурайсуу ургамал 336 зүйл (мужийн бүх ургамлын 27.68%)

- Намагсаг бүлгийн бүх ургамал 175 зүйл (14.41%)

- Усны ургамал 37 зүйл (3.05%)

- Хүйтсэг бүлгийн бүх ургамал 210 зүйл (17.3%)

- Чулуусаг бүлгийн ургамал 271 зүйл (22.32%)

- Элссэг ургамал 21 зүйл (1.73%)

- Давссаг ургамал 74 зүйл (6.1%) байгаа нь уулын хээр, тайгын ойн шинжийн аль алиныг нь харуулж, өндөр уул элбэгтэй тул тагийн ургамал ихтэйг, тойргийн захаар том том элсэн манхан шургаж орсон, нуур голын давс хужиртай эрэг, марз мараатай голууд байдгийг илтгэж байна.

**Бэлчээр тэжээлийн нөөц.** Тойргийн төв хэсэг Хан Хөхийн нурууны өндөрлөг хэсгээр цэвдэгт тайгын (заримдаа хүлэрлэг) хөрстэй шинэсэн, гацууран, хуш-шинэсэн, тайга ба сарьдаг орчмын тайрмал ойтой дайвар байдлаар ашиглах бэлчээр, уулын нугын, уулын нугат-хээрийн хөрстэй бушилзат хээршсэн бэлчээртэй. Зун-намарт сарлагт тохиромжтой.

Хан Хөхийн нурууны дунд бие, бэл орчмоор хар шороон, нугат-хар шороон хөрстэй боролзгоно бүхий алаг өвс-улалж-алтайн бутнуурт нугат-хээрийн бэлчээртэй, зун-намарт үхэр, адуунд тохиромжтой. 15-20 ц/га тэжээлийн нөөц бүхий, 800-850 кг/га тэжээлийн нэгжтэй (дундаж өндөр ба нам уулын орчмоор).



Сонгино хайрхан, Түдэвтэй уул, Хан Жаргалант уулсын хяраар зожир өвст, боролжит болон бусад сөөг, сөөгөнцөрт тундр бүхий уулын тундрын ба уулын нугын ялзмагт хөрстэй бушилзат бэлчээр, зун-намарт сарлагт тохиромжтой. Тэдгээрийн дунд бие, бэлээр нунтаг карбонатлаг хар хүрэн ба хар шороон хөрстэй алаг өвс-дааган сүүлт нугат-хээрийн ба хээрийн, нунтаг карбонатлаг сайргархаг хар хүрэн хөрстэй алаг өвс-хялганат, зүр өвс-хялганат, алаг өвс- хиаг-хялганат хээрийн бэлчээртэй зун-намарт бог мал.үхэр адуунд тохиромжтой. 8.0 ц/га тэжээлийн нөөцтэй, 400-440 кг/га тэжээлийн нэгжтэй.

**Хөрсөн бүрхэвч.** Энэ муж нь аядуу зөөлөн сэрүүн чийглэг уур амьсгалтай, ургамлын баялаг нөмрөгтэй, дулаан ба хүйтний ялгарал жигд бус байдаг нь хөрсөн бүрхэвч бүрэлдэн тогтоход чухал нөлөө үзүүлдэг. Хөрсөн бүрхэвчид уулын хөрс зонхилох ба эдгээрээс хамгийн их тархалттай нь уулын ойн хөрс юм. Уулын ойн хөрс Х-3 тойрогт хамгийн их тархсан ба Х-4, Х-5 тойрогт 20 гаруй хувьтай байна. Тал хөндийн хөрсний тархалт мужийн хэмжээнд 6.7 хувиас хэтрэхгүй байна. Бүс дундын хөрс 5-8 хувийг эзэлж байгаа элювийн элсэн хөрс Х-3 тойрогт бага хэмжээтэй тархжээ. Хөрс үүсгэгч эх чулуулгийн хурдас нь элюви, делюви, аллювийн хурдас бөгөөд голдуу шавранцар ба шаварлаг механикийн бүрэлдэхүүнтэй байх боловч сайргархаг ба элсэрхэг хурдас нилээд тааралддаг. Үржил шимээр харьцангуй сайн боловч үе давхаргын хөгжил жигд бус, чийг ба дулааны горим нь өмнөх тойргийн хөрснөөс дээр боловч дулаан нь таримал ургамлын өсөлт хөгжилтөнд хангалтгүй. Голын хөндий ба нуга-намгийн хөрсөнд цэвдэгшлийн нөлөө их. Хархираагийн уулс Хангайн тэгш өндөрлөгийн тойргийн баруун захаар цөлөрхөг хээрийн бор хөрс бага хэмжээгээр тааралдана. Хөрс нь голдуу шавранцар ба шаварлаг механикийн бүрэлдэхүүнтэй боловч Х-3, Х-5 тойргуудад элсэнцэр ба элсэрхэг хөрс нилээд тархжээ.

Хүснэгт № 3.2. Хан Хөхийн нурууны ойт хээрийн тойргийн хөрсний нөөц

Д/д	Хөрсний нэр	Х-3	
		га	%
1	Нуур	40517.47	1.13
2	Уулын тундрын ширэгт	6214.69	0.17
3	Уулын нугын/ уулын тайгын ширэгт	22533.07	0.63
4	Уулын нугат хээрийн болон уулын нугын	125564.87	3.49
5	Уулын тайгын цэвдэгт/уулын тайгын ширэгт	30882.01	0.86
6	Уулын тайгын ширэгт/ уулын карбонаттай хар шороон	213736.82	5.93
7	Уулын ойн ширэгт бараан/уулын хар шороон	26420.89	0.73
8	Уулын карбонаттай хар шороон/уулын карбонатгүй хар хүрэн	70832.44	1.97
9	Уулын хар шороон/ уулын хар хүрэн	669922.45	18.60
10	Уулын хар хүрэн/ уулын нимгэн хар шороон	990070.50	27.49
11	Уулын хүрэн/ уулын хар хүрэн	142343.36	3.95
12	Уулын карбонаттай цавар хүрэн/ уулын нимгэн цавар хүрэн/	7260.63	0.20
13	Толгодын карбонатгүй хар шороон/ нимгэн сайр чулуурхаг хар хүрэн	21323.23	0.59
14	Толгодын хар шороон/ нугат хар шороон	8391.71	0.23
15	Толгодын хар хүрэн/ нимгэн сайр чулуурхаг хар хүрэн	120171.13	3.34
16	Толгодын хүрэн/ нимгэн сайр чулуурхаг хүрэн	68031.20	1.89
17	Сайр чулуурхаг цайвар хүрэн	1801.53	0.05
18	Ердийн хар шороон/ нугат хар шороон	40969.82	1.14
19	ердийн хар хүрэн/ сайр чулуурхаг хар хүрэн	203121.84	5.64
20	Ердийн хар хүрэн/ далд глейрхэг хар хүрэн	47085.63	1.31
21	Давсархаг хар хүрэн/ хужир мараалаг хар хүрэн	143365.95	3.98

22	Ердийн хүрэн/ сайр чулуурхаг хүрэн	233221.47	6.48
23	Ердийн цайвар хүрэн/ сайр чулуурхаг цайвар хүрэн	61764.87	1.71
24	Сийрэг элсэн хүрэн	42431.99	1.18
25	Цөлөрхөг хээрийн бор/ сайрын болон элсэн хучаастай бор	20.78	0.00
26	Нугат намгийн цэвдэгт хужирлаг /нугын цэвдэгт хужирлаг/	4276.28	0.12
27	Нугын цэвдэгт/нугат хар шороон/	17411.82	0.48
28	Нугын хужир/ хужирлаг нуга/	9649.79	0.27
29	Аллобийн нугат намгийн/Аллобийн нугын хужирлаг/	25760.37	0.72
30	Аллобийн нугын/ Аллобийн нугын давсархаг/	8008.10	0.22
31	Аллобийн нугын хужирлаг ба Аллобийнүелсэн тогтоцтой	8426.66	0.23
32	Хужир марааны бүрдэл	1380.33	0.04
33	Хужир болон хужирлаг нугат бор	5388.86	0.15
34	Хагас бэхэжсэн элс	106265.91	2.95
35	Хөдөлгөөнт элс	55959.16	1.55
36	Хад асга	21005.31	0.58
37	Дүн	3601532.9	100.0

Ан амьтан. Энэ мужид нийтдээ 5 ангийн 338 зүйл буюу манай орны сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 51.9 % нь оршин амьдардаг байна /10-р хүснэгт/.

*Хүснэгт № 3.3. Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон мужийн сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүн*

Нэгж	Дэлэнтэн	Шувуу	Мөлхөгчид	Хоёр нутагтан	Загас	Дугариг амьтан	Бүгд
Баг	5	17	1	1	5	-	29
Овог	15	42	4	2	8	-	71
Зүйл	64 (46.0%)	251 (60.5%)	4 (19.0%)	2 (33.3%)	17 (10.0%)		338 (51.9%)

Тайлбар: Монгол оронд бүртгэгдсэн тухайн ангийн амьтдын зүйлийн бүрэлдэхүүний хэдэн хувийг эзэлж буйг хаалтанд бичив.

**Дэлэнтэн.** Энэ мужид 5 багт хамаарах 64 зүйл дэлэнтэн амьтан тэмдэглэгдсэн нь манай орны дэлэнтний зүйлийн 46.0 % болж байна. Эдгээрийн дотор шавжичтан, далавчтан тус бүр 5, туулайтан 6, мэрэгчтэн 26, махчтан 14, туурайтан 8 зүйл тус тус байна. Дэлэнтэн дотор зүйлийн тоогоор мөн л мэрэгчтэн /эндэхийн хөхтөний 40.6%/ , махчтан / 21.8%/ зонхилно.

Энэ мужийн нутаг дэвсгэрт хойноос умрын ой тайгын зүйлүүд /нохой зээх, баданга хүдэр, халиун буга, бор гөрөөс, зэрлэг гахай, чандага туулай, асганы огодой, бараа хэрэм/, өмнөөс Төв азийн хээрийн зүйлүүд /Монгол тарвага, шивэр алагдаага, хярс үнэг, шар үнэг, мануул мий, дагуур огодой, боролзон туулай, хэргэлзий оготно гэх мэт/, мөн өндөр уулын амьтан /аргаль хонь, янгир ямаа, суусар булга, цоохор ирвэс, тагийн огодой гэх мэт/ харилцан нэвтрэлцэж сууршсанаар онцлог. Энэ тойрогт агнуурын чухал ач холбогдолтой уламжлалт ангийн 24 зүйл амьтан тэмдэглэгдсэнээс 15 зүйлийн тархац нутаг, тоо толгой аль нэг хэмжээгээр багасан цөөрч ховордсоны дотор зүйл /цоохор ирвэс, голын халиу/ бараг устаж, 5 зүйл /суусар булга, мануул мий, баданга хүдэр, аргаль хонь, янгир ямаа/ ихээхэн ховорджээ.

Эндхийн дэлэнтэнээс монголын улаан номонд 5 зүйл /янгир ямаа, аргаль хонь, баданга хүдэр, цоохор ирвэс, голын халиу/, олон улсын улаан номонд 4 зүйл /голын халиу, цоохор ирвэс, нохой зээх, саарал чоно/, Монголын ховор амьтны жагсаалтанд 4 зүйл, /аргаль хонь, янгир ямаа, халиун буга/ оржээ. Ховордсон зэрлэг ургамал, амьтны худалдааны тухай олон улсын конвенцийн I, II хавсралтанд орсон 7 зүйл /I хавсралтанд:

цоохор ирвэс, голын халиу, II хавсралтанд: аргаль хонь, баданга хүдэр, шилүүс мий, мануул мий, саарал чоно/ бий.

**Шувуу.** Энэ мужид 17 баг, 42 овгийн 251 зүйл шувуу тэмдэглэсэн нь манай орны шувуудын зүйлийн бүрэлдэхүүний 60.5 % болно. Шувуудын дотор зүйлийн тоогоор бор шувууны багийн амьтад тэргүүлэх /122 зүйл буюу энэ мужийн шувуудын зүйлийн бүрэлдэхүүний 48.6 %/ бөгөөд дараа нь хөгчүү хэлбэртэн /34 зүйл буюу 13.5 %/, шонхор хэлбэртэн /26 зүйл буюу 10.3 %/, галуу хэлбэртэн /21 зүйл буюу 8.3 %/ тус тус ордог. Ийнхүү Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон мужийн нутаг дэвсгэрт оршин амьдрах дээрх 4 багийн 203 зүйл шувуу нь уг мужийн шувууны нийт зүйлийн бүрэлдэхүүний 80.8 %-ийг эзэлдэг ажээ.

Ан агнуурын тухай Монгол улсын хууль, тогтоомж, Зэрлэг амьтан, ургамлын зүйлийг Олон улсад худалдаалах тухай конвенцийн 1.2-р хавсралт, Монгол улсын ба Байгаль хамгаалах Олон улсын холбооны Улаан номонд орох зэргээр эрх зүйн хувьд ямар нэг хэмжээгээр хамгаалалтад авсан 43 зүйл шувуу /Усны үхэр, халбаган хошуут, хар өрөвтас, хээрийн галуу, хошуу галуу, гангар хун, явлаг сар, согсоот зөгийч сар, сохор элээ, цагаан элэгт, морин харцгай, үлэг харцгай, шунгаач харцгай, шилийн сар, талын сар, бахим бүргэд, тарважи бүргэд, цармын бүргэд, усны нөмрөг бүргэд, усны цагаан сүүлт бүргэд, ёл, цасны хажир бүргэд, тас, идлэг шонхор, эгэл шонхор, шууман шонхор, хайргууна шонхор, амарын турамдай шонхор, зээрд шонхор, начин шонхор, алтайн хойлог, хархираа тогоруу, хар тогоруу, өвөгт тогоруу, тоодог, азийн цууцаль, гуйвангуу ууль, шар шувуу, явлиг ууль, савагт ууль, дорнодын бүгээхэй, харсуун ууль, хув бэгбаатар, өгөөлэй шулганаа/ тус мужийн нутаг дэвсгэрт оршин амьдардаг. Энэ бол тухайн мужийн шувуудын аймгийн генофондын үнэт чанарыг илэрхийлэх нэг үндсэн үзүүлэлт болно.

Ус намгийн амьдралтай, спорт агнуурын өндөр ач холбогдол бүхий 21 зүйл, хөлдүү түүхий эдийн холбогдолтой 8 зүйл шувуу энэ мужид оршин амьдардаг. Мөн байгаль, экологийн тэргүүлэх зэргийн үүрэгтэй хэмээн тооцдог 26 зүйл өдрийн махчин шувуу, шар шувууны багийн 7 зүйлийг энд тэмдэглэсэн байна. Эдгээр нь тухайн мужийн мэрэгч амьтдын тоо толгойг зохицуулах, мал, элдэв амьтны сэг зэмийг устгахад тун чухал үүрэг гүйцэтгэдэг нь ойлгомжтой.

**Мөлхөгчид.** Энэ мужид хайрстны баг, гүрвэлийн салбар багт хамаарах замба гүрвэлийн овгийн цоохор хонин гүрвэл /*Phrynoscephalus versicolor*/, жинхэнэ гүрвэлийн овгийн монгол гүрвэл /*Eremias argus*/, могойн салбар багт хамаарах хар могойн овгийн рашааны могой /*Elaphe dione*/, хорчигнуурт могойн овгийн бамбай хоншоорт могой /*Aqkistrodon halys*/ гэсэн 4 зүйл тэмдэглэжээ. Цоохор хонин гүрвэл нь гол төлөв Их нууруудын хотгор, Нууруудын хөндийд усаа нийлүүлдэг голуудын хөндийг дагаж Хангайн нурууны өмнө ба баруун өмнүүр нэвтрэн орж ирсэн байна. Харин Монгол гүрвэлийн хувьд Орхон, Туулын сав дагуу Хануйн голын дунд хэсэг хүртэл оочин цоочин тархалттай юм. Нөгөө хоёр зүйл могойн хувьд Хангайн мужийн ойт хээр, хээр, уулын

хээр, нуга, намаг гэх мэт бараг бүх хэв шинжийн биотопд оршин амьдарна. Ялангуяа булаг, шандын эх, халуун, хүйтэн рашааны орчмоор элбэг.

**Хоёр нутагтан.** Хангайн мужид сүүлгүй хоёр нутагтны багт хамаарах бахын овгийн монгол бах /*Bufo raddei*/, мэлхийн овгийн шивэр мэлхий /*Rana amurensis*/ гэсэн 2 зүйл амьтан тэмдэглэжээ. Гол төлөв Хойд мөсөн далайн ай савын усан сангуудаар тархсан, элбэг тохиолдох зүйлүүд юм. Хангайн нурууны өврөөс эх авч Нууруудын хөндийд усаа нийлүүлдэг Байдраг, Түй, Онгийн голын эх орчмын нутаг, тэдгээрийн ай савд багтах булаг, шандаар монгол бах нилээд элбэг.

**Загас.** Энэ мужийн усан сангуудаар Хойд мөсөн далайн болон Тав Азийн ай савын гаралтай 5 баг, 8 овгийн 17 зүйл загас тархжээ. Агнуурын өндөр ач холбогдолтой тул, зэвэг, жарга, шивэр хадран, ердийн цурхай, улаан нүдэн, шивэр сугас, бух сугас, гутаарь, алгана зэрэг загас Хойд мөсөн далайн ай савын Идэр, Дэлгэр мөрөн, Хойд, Урд Тамир, Орхон, Хануй, Чулуут, Суман гол, тэдгээрийн цутгалууд, Тэрхийн цагаан нуурт элбэг. Хангайн нуруунаас эх авч Их нууруудын хотгорын Увс, Айраг, Нууруудын хөндийн Бөөн цагаан, Орог, Таацын цагаан, Улаан нуурт цутгадаг Тэс, Завхан, Байдраг, Түй, Онгийн голын ай савд дан ганц уулархаг Азийн цэнгэг усны *Oreoleuciscus* төрлийн 3 зүйлээс гадна *Rhoxinus* ба *Nemachilus* төрлийн агнуурын холбогдолгүй жижиг загаснууд бий.

**Ландшафтын онцлог.** Хан Хөхийн нуруу нь ландшафтын хувьд ихээхэн өвөрмөц бөгөөд газарзүйн байршил, гадаргын тогтоц, өндрийн байдал, уур амьсгал, хөрс, ургамалжилтын онцлогтой уялдаад уулын ар, өвөр хажууд хоорондоо эрс тэс ялгаатай ландшафтын хэв шинжүүд тархжээ. Энд ландшафтын босоо бүсшил их тод илэрдэг байна. Хамгийн өндөр Дуулга уул орчмын нүцгэн хад асга, чулуурхаг хажуу нь ян сарьдагийн ландшафттай. Харин Хонгилцогын даваа, Жаргалантын даваанаас урагш 2700-2800м үнэмлэхүй өндөртэй усан хагалбарын нуруунд уулын нуга тархжээ. Хан Хөхийн дээд бие жинхэнэ өндөр уулын бушилзат, бушилз-улалжит нугаар хучигдсан бөгөөд тэр нь дээшээгээ ургамалгүй шахам нураг асга бүхий ян сарьдагт шилждэг байна.

Хан Хөхийн нурууны өвөр хэсгийн эгц хажууд хуурай хээрийн, цөлийн хээрийн ландшафт зонхилж байхад уулын арын налуу хажууд тайгын, ойн, ойт хээрийн ландшафтууд тархсан байна. Энэ нуруунд тайгын ландшафт нь гол өндөрлөгийн ар хажууг барьж тогтжээ. Энд ар хажуугийн 1600м -ээс 2200- 2400м-ийн өндөрт, Хонгилцогийн голын урд нуруу болох Цагаан хайрхан /2512 м /, Мэндэх / 2430 м / зэрэг уулсын ар хажуу дагуу 1900-2300м-ийн өндөрт орших ба голын хөндий дагуу дээрхээс ч илүү өндөрт тархана.

Ойн ландшафт нь Баруун Туруун голын эхэн орших Толгой, Согоо зэрэг жижиг нууруудаас зүүн хойших нутгуудад тархана. Энэ ландшафт нь нутгийн төв хэсэгт 1700-1800м-ээс 200-2100 м хүртэл өндөрт ,захын уулсын ар хажуу дагуу 1600-1900 м-ийн өндөрт тархжээ. Эндэхийн уул нурууд өндрийн хувьд 2200м-ээс хэтрэхгүй, ихэвчлэн хавтгай орой хяртай, гол горхины сүлжээ, булаг шанд элбэгтэй юм. Энд гол төлөв ойн бараан хөрс тархах бөгөөд өтгөн шигүү өвслөг ургамал бүхий сийрэгдүү шинэсэн, шинэс-хусан ойтой. Өвслөг ургамалд элдэв өвс- үетэнт, элдэв өвс- үетэн- өлөн өвст бүлгэмдэл

голлоно. Ойт хээрийн ландшафт нь Хан Хөхийн нурууны баруун үргэлжлэл болох Тогтохын шилийн Түргэн голоос зүүн тийш Бор Бургасны гол хүртэлх уулын ар хажуу дагуу тогтжээ. Гэхдээ ой мод нь сийрэг, энд тэнд хэд гурваараа буюу хэсэг хэсгээрээ тохиолдох боловч тасралтгүй үргэлжилж гол оргилын арын их ойтой залгадаг.

Хээрийн ландшафт нь Хан Хөхийн ар хажуу дагуу хамгийн түгээмэл тархаж ой, тайгын ландшафтын доогуур биеэ даасан бүслүүр үүсгэнэ. Гадарга нь бөмбөгөрдүү, уулсын хажуу хэвгий багатай боловч хад чулуурхаг, голын хөндий, гуу жалгаар сүрхий хэрчигджээ. Энд Бор Бургасны голоос зүүн тийших нутагт 3-7 м, хааяа 10-12 м хүрэх өндөртэй үлдэгдэл хад цохио уулсын орой, хажуу дагуу их тааралдана. Хуурай хээрийн ландшафт нь Хан Хөхийн нурууны өмнөд энгэр хажуу дагуу голлон тархжээ.

Тарвагатайн нуруу түүний орчмын нутаг бол жинхэнэ уулт ой хээрийн район мөн. Энд ой, хээр хоёр талбайн хувьд бараг тэнцүү ажээ. Уулсын дээд хэсгээр хуш-шинэсэн тайга, түүнээс доош шинэсэн ой тархсан. Уулын өмнөд хажуу, энгэр нь уулын хээрээс бүрдэх ба хөндийн төв хэсэг чийг ихтэй намагжуу нугатай. Булнайн нурууны ар хажуу ойтой. Уулсын тэгш зоо модлог ургамалгүй, зөвхөн өндөр уулын нуга, нураг асга, намгаар хучигдсан байдаг.

Хангайн гол нуруунд өндөр уулын нуга түүнийг дагасан бут сөөгөн ширэнгэ ян оргилын намаг, хад чулуун нураг даган ноёрхдог. Өндөр уулын нугууд нь нэгэн жигд хэв шинжтэй бөгөөд энэ нь харьцангуй цөөн зүйл алаг өвс бүхий бушилз, бушилз -улалжит бүлгэмдлээс бүрдэнэ. Дээшлэхэд бушилзат нуга дундуур нураг асга бий болж түүнийг хэсэгхэн хувааж талбайг нь багасгана. Үүнээс бүр дээшлэхэд нүцгэн хад асга, нураг болж хувирах ба тэдгээрийн зайд тагийн цөөн зүйл ургамал ургана. Хангайн нурууны өндөрлөг хэсгээр ой багавтар тохиолдоно.

### ***3.2.2. Монгол - Алтайн өндөр уулын муж, Хархираа-Түргэний өндөр уулс, хотгорын тойрог (Х-11)***

Монгол Алтайн өндөр уулын муж нь тус орны баруун хагаст, улсын хилийн дагуу баруун хойноос зүүн урагш чиглэн 800 гаруй км урт сунаж тогтсон уулсын системийг хамаарна. Монгол Алтайн нуруу нь дурьдсан чиглэлд Говь- Алтайн нуруу болон үргэлжлэх ба баруун талдаа Их Нууруудын хотгор, өмнө талдаа Баруун хуурайн хотгортой тус тус хиллэнэ. Тус мужийн нутаг нь Баян- Өлгий аймгийн нутгийг бүхлээр нь. Ховд аймгийн ихэнх, Увс, Говь-Алтай аймгийн баруун хэсгийг тус тус хамарна.

Монгол-Алтайн өндөр уулын муж нь морфоструктурын онцлог, уулсын байрлал, чиглэл, үргэлжилсэн болон тусгаар байдал, ландшафтын нэгдмэл шинжээрээ Хархираа-Түргэний өндөр уулс, хотгорын тойрог (Х-11), Алтай Таван богдын өндөр уулын тойрог (Х-12), Мөнххайрханы өндөр уулын тойрог (Х-13), Хар азрага-Гичгэний нурууны өндөр уулын тойрог (Х-14) гэсэн 4 тойрогт хуваагдана.

Увс аймгийн нутаг дэвсгэрийн баруун хэсэг нь хамаарах Хархираа-Түргэний өндөр уулс, хотгорын тойрог (Х-11)-т Монгол Алтайн нурууны зүүн хойт захад орших Хархираа, Түргэний уулс багтах бөгөөд Ачит нуурын тектоник томоохон буурц хотгороор Монгол

Алтайн гол нуруунаас тусгаарлагдан зааглагдсан агаад ус хагалбар шугам нь ерөнхийдөө баруун хойноос зүүн урагш чиглэлд тохойрон оршсон байна. Хамгийн өндөр оргил мөнх цастай Түргэн уул далайн түвшнээс дээш 3878 метр өндөр юм. Хархираа, Түргэний уулсын зүүн хойт талд Цагаан Шивээтийн нуруу 3498 м/ мөн баруун хойноос зүүн урагш сунаж тогтжээ. Эдгээр нуруудын дунд Үүрэг нуурын хотгор оршино. Хархираа, Цагаан Шивээтийн уулс гадаад төрхөөрөө Монгол Алтайн уулстай адил шовх оройтой, эгц хажуутай, үнэмлэхүй болон харьцангуй өндрөөр нилээд их байдаг. Хархираа, Түргэний уулс нь их биш онь хөтлөөр хоорондоо нягт холбоотой бөгөөд Алтанхөхийн уулс өмнө зүгт хол орших бөгөөд нөгөө хоёроосоо нуурууд бүхий өргөн тал, хотос хотгоруудаар тусгаарлагдсан байна. Алтанхөхийн уулын ар хажуу нь эгц биш бөгөөд өвөр хажуу нь Ховд гол руу маш эгц ханан эрэг шиг хэлбэртэй түрж орсон байна. Энэ уул нь өндөр уулын хээрийн ландшафттай ба ой модгүй бөгөөд зөвхөн хуурай хавцал, жалгуудад бут сөөг ургасан байна. Хархираа, Түргэний уулс эрт цагт мөсдөж байсан бөгөөд түүний ул мөрүүд одоогийн ландшафтад нь тусгалаа олсон байна. Одоо ч гэсэн Хархираа ба Түргэн голын эхээр үлдэгдэл мөсөн голууд бий. Уулсын зөөлөн тэгшитгэгдсэн хотгор гүдгэртэй зэрэгцэн байгаа карууд, гүн тэвшин хөндий, морены хурдас, мөстлийн үеийн олон тооны жижиг нуур бол эдгээр уулсын онцлог шинжүүд юм. Эдгээр уулсын дээд хэсэг нь шавдагдаж угаагдсан өндөр тал газрын байдалтай бөгөөд түүний дээр нь Түргэн ба Хархираа уулуудын мөнх цаст бүлэг оргилууд шовойж үзэгдэнэ. Гүн хавцлуудаар урсах том биш гол, горхиуд нь эдгээр нурууг зүсэж, нууруудын хотгорын уулын хормой тал газруудад гарах боловч нууруудад хүрч чаддаггүй. Учир нь нууруудын хотгорын гадаргын сэвсгэр хурдсуудад шингэж орох ба тариалангийн газрыг усжуулахад зориулагддаг. Хамгийн их устай нь Хархираа гол бөгөөд өөрийн адагт байх ихээхэн хэмжээний тариалангийн газрыг усжуулна.

**Уур амьсгалын хувьд.** Монгол орны хамгийн өндөр уулсыг хамарсан энэ муж нь ерөнхийдөө далайн түвшнээс дээш 2000м түүнээс дээш өргөгдсөн чийглэг хүйтэн нутаг юм. Ийм учир ой тайга багатай, нүцгэн уулс зонхилсон гол оргилууд нь мөнх цастай болно. Хамгийн дулаан 7 дугаар сард агаарын дундаж температур 11-15°C, 4000 м-ээс дээш жилийн турш хасах температуртай байна. 1 дүгээр сарын дундаж агаарын температур -20 н- -22°C байна. Энд ургамлын дулааны хангамж дутмаг, Хар Азрага-Гичгэний нурууны өндөр уулын тойрог (Х14) тийш жилийн тунадасны нийлбэр багасаж ирдэг бөгөөд хонхор хотгор газартаа 100-200 мм тунадас ордог байна. Иймд ургамлын бүрхүүлээр тийм ч баялаг биш. Энд цас борооны ус, горхины усыг ашиглан газар тариалан эрхлэх, хүлэмж барьж хүнсний ургамлыг тариалж болох юм.

**Ургамлан нөмрөг.** Ургамалжилтын хувьд Монгол-Алтайн төвийн ба баруун хойд хэсгийн өндөр уулс нь бушилз, өлөнт ба хүйтсүү-хуурайсаг, зарим үетэн, мөн элдэв өвст тагийн туж, нугатай, хаг, хөвдөт царамтай. Зарим газраа тагийн нугаас дээш, ялангуяа урагш харсан хажуугаа дагаж өндөр уулын хуурай хээр бүр дээр өгсөж гарсан байдаг. Төгрөг навчит хус, зэгэл бургас, тошлог навчит бургас, тагийн тавилгана зэрэг намхан

сөөгөн ширэнгэ тагийн доод захаар хэсэг хэсгээрээ тохиолдоно. Энэ нь Хангай, Хэнтий, Хөвсгөлд байдаг торлогоос их өөр юм.

Монгол-Алтайн нурууны цөөхөн уул армаг тармаг, хэсэгхэн ойтой. Харин Ховдын голын эхэнд шинэс-хушин ойтой, Булган гол, Чигэртэй голын эхний гол өндөрлөгүүдийн араар, мөн Хасагт хайрхан, Тайшир уулын араар хэсэгхэн шинэсэн ойтой. Ховдын голын эх, Даян, Хотон, Хоргон нуурын орчимд жинхэнэ тайгын үлдвэр төдий ой бий. Ховдын голын дагууд хэд хэдэн уулсын хажуугаар нураг дагасан гацууран төгөл үлдэж хоцорчээ. Бас хэд хэдэн уулсын чийглэг ам, хавчилд Резниченкын хус, үслэг улиас-үлдвэр байдалтай тохиолдоно. Ой судлаачид Монгол-Алтайн ойг огтхон ч ашиглах боломжгүй, зөвхөн хамгаалалтад бүрэн авбал зохино гэж тогтоосон юм. Голын хөндийг дагасан чацарганы юмуу өргөст харганын ширэнгэ бий. Монгол- Алтайн нурууны өмнөд хэсэг төдийгүй, хойт хэсгээр нь өдлөг хялгана, таана, баглуур, шарилж зэрэг цөлийн ба цөлөрхөг хээрийн элементүүд ихэд дээшээ нэвтэрсэн байдаг юм. Энэ нь уг нуруунд өмнөд, баруун өмнөдөөс цөлийн хуурай халуун уур амьсгал хүчтэй нөлөөлж байдагтай холбоотой хэрэг. Зөвхөн Цэцэг нуур, Тонхил нуурын хотгорт л гэхэд өдлөг хялганат, таана-өдлөг хялганат, өдлөг хялгана-бударганат, дан бударганат, цөлөрхөг хээртэй. Давсархаг хотгортоо дэрс ихтэй байдаг.

Ургамлын аймгийн хувьд авч үзвэл нэг талаас Алтайн нурууны өндөр уулын ба умардын ойн төлөөлөгчид, нөгөө талаас говийн (цөл, цөлөрхөг хээрийн), түүгээр ч барахгүй Казахстаны (Зүүнгарын-Тураны) цөлийн ба хээрийн ургамлын аймгийн төлөөлөгчид энэ нуруугаар нэвтэрч холилджээ.

Энэ мужид одоогоор 1020 зүйл гуурст ургамал бүртгэгдсэний дотор 131 зүйл модлог, сөөглөг (тойргийн ургамлын 12.84%) ургамал, 889 зүйл өвслөг (74.12%) ургамалтай байна. Том мод, сөөг, сөөгөнцрийн хувьд Хангайгаас цөөн зүйлтэй, харин заримдаг сөөг, сөөгөнцрийн тоогоор Говь-Алтайн тойрогтой адил, бусад тойргуудаас хавьгүй олон зүйлтэй юм. Өвслөг ургамлын зүйлийн бүрдлийн хувьд нэлээд баялаг юм. Нэг, хоёр настны зүйлийн тоогоор (133 зүйл) Хангай, Монгол-Дагуурын тойрогтой ойролцоо юм. Ургамлын зүйлийн бүрдлийг экологийн бүлгүүдэд ангилж үзвэл:

хуурайсаг 11 зүйл (10.78%),  
хуурайсуу-чийгсэг 77 зүйл (7.55%),  
чийгсэг 115 зүйл ургамал (11.28%),  
намагсаг 3 бүлгийн ургамал 93 зүйл (9.12%),  
уссаг 9 зүйл (0.88%),  
хүйтсэг 3 бүлгийн ургамал 207 зүйл (20.29%),  
чулуусаг 3 бүлгийн ургамал 312 зүйл (3.58%),  
давссаг 4 бүлгийн ургамал 86 зүйл (8.43%),  
апссэг ургамал 11 зүйл (1.08%) байна.

Үүнээс үзэхэд чулуусаг, хүйтсэг, хуурайсаг бүлгийн ургамал зүй ёсоор давамгайлж байгаа нь эндхийн ургамлын аймгийг уулын хуурай хээрийн төрхтэйгөөс гадна өндөр уулын ян сарьдаг, цармын ургамал чухал үүрэгтэйг давхар нотолж байна.

Хархираа-Түргэний өндөр уулс, хотгорын тойргийн төв хэсэг болох Хархираа-Түргэний уулсаар зожир өвст, боролжин болон бусад сөөг, сөөгөнцөрт тундр бүхий уулын тундрын, цармын өндөр уулын бэлээр, зун- намарт сарлагт тохиромжтой. Тойргийн хойд хэсэг Үүрэг нуурын эргээр баглуур-жигжиг хялганат бэлчээр, зун-намарт бог мал, тэмээнд тохиромжтой, 2-3.5 ц/га тэжээлийн нөөцтэй.

Ховд голын дагуу татмын нугын улиасан төгөл бүхий нугын алаг өвст бэлчээр, зун-намар үхэрт тохиромжтой. Ховд гол, Цаст Цамбагарав уулсын хоорондох хэсгээр алаг өвс-ерхөг, хялганат хуурай хээрийн дундаж өндөр уул, нам уулсын бэлчээртэй, бог мал, адуунд тохиромжтой. Цамбагарав уул нь зожир өвст, боролзот ба бусад сөөг, сөөгөнцөрт уулын тундрын, уулын нугын ялмагт бушилзат бэлчээртэй зун-намар сарлагт тохиромжтой. Тойргын урд хэсгээр цөлөрхөг хээрийн бор хөрстэй харгана- жигжиг хялганат бэлчээртэй бог мал, тэмээнд тохиромжтой.

**Хөрсөн бүрхэвч.** Хөрсөн бүрхэвчид уулын хөрснүүд зонхилох ба эдгээрээс хамгийн их тархалттай нь өндөр уулын хээрийн болон уулын хүрэн хөрсний дэд хэв шинжүүд давамгайлна. Х-11-13 тойргуудад уулын дунд биеэс доошлоод бэл хүртлээ, түүнчлэн уулс хоорондын өргөн, нарийн хөндийгөөр тал хээрийн хүрэн хөрсний хэв шинжүүд давамгайлж байхад Х-14 тойрогт цөлөрхөг хээрийн бор хөрсөөр солигдож байгаа нь энэ тойрогт цөлийн нөлөө нилээд хүчтэй байгааг харуулж байна. Уулын ба тал хөндийн хүрэн хөрс нийт талбайн 40-70 хувийг, бүс дундын хөрс 8 гаруй хувьтай байгаа ба цөлөрхөг хээрийн хөрс 4 орчим хувьтай байна. Эдгээрээс харвал энэ тойрогт цөлөрхөг хээрийн ландшафтын нөлөө байгаа ба хөрс үүсгэгч эх чулуулгийн хурдаст элюви ба элюви-делювийн хурдас давамгайлж, пролювийн ба нуурын хурдас ажиглагдана. Хөрс үүсгэгч эх чулуулаг нь шавранцар ба элсэнцэр механикийн бүрэлдэхүүнтэй байх боловч сайрархаг ба элсэрхэг хурдас нилээд тааралддаг.

*Хүснэгт № 3.4. Хархираа-Түргэний өндөр уулс, хотгорын тойрогийн хөрсний нөөц*

Д/д	Хөрсний нэр	Х-11	
		га	%
1	Нуур	63740.8	2.7
2	Уулын тундрын ширэгт	67208.6	2.8
3	Уулын нугын/уулын тайгын ширэгт	84610.3	3.6
4	Уулын нугат хээрийн болон уулын нугын	100632.7	4.2
5	Өндөр уулын бүдүүн ялмагт/уулын нугат хээр	8072.8	0.3
6	Уулын хурай хээрийн бүдүүн ялмагт/уулын нугат хээр	100905.2	4.2
7	Уулын тайгын ширэгт/уулын карбонаттай хар шороон	17798.4	0.7
8	Уулын хар шороон/уулын хар хүрэн	26121.8	1.1
9	Уулын хар хүрэн/уулын нимгэн хар шороон	52877.8	2.2
10	Уулын хүрэн/уулын хар хүрэн	671724.9	28.3
11	Уулын карбонаттай цавар хүрэн/ уулын нимгэн цавар хүрэн	40917.7	1.7
12	Толгодын хүрэн/нимгэн сайр чулуурхаг хүрэн	70118.9	3.0
13	Сайр чулуурхаг цайвар хүрэн	40793.7	1.7
14	Толгодын цөлөрхөг хээрийн бор	7535.2	0.3
15	Ердийн хар шороон/нугат хар шороон	5138.3	0.2
16	ердийн хар хүрэн/сайр чулуурхаг хар хүрэн	4784.3	0.2
17	Ердийн хүрэн/сайр чулуурхаг хүрэн	240948.4	10.1
18	Ердийн хүрэн/сайр чулуурхаг болон хужир мараалаг хүрэн	8248.9	0.3
19	Ердийн болон нугат хүрэн/үлдмэл нугат хүрэн	6616.1	0.3



20	Ердийн цайвар хүрэн/сайр чулуурхаг цайвар хүрэн	270981.4	11.4
21	Карбонаттай цайвар хүрэн/элсэн хучаастай цайвар хүрэн	9582.4	0.4
22	Сийрэг элсэн хүрэн	36295.3	1.5
23	Цөлөрхөг хээрийн бор	119250.1	5.0
24	Цөлөрхөг хээрийн бор/сайрын болон элсэн хучаастай бор	16270.2	0.7
25	Хужирлаг нугат бор/нугын хужирлаг	8164.1	0.3
26	Нугат намгийн цэвдэгт/намгийн цэвдэгт	1086.6	0.0
27	Нугын цэвдэгт/нугат хар шороон	955.6	0.0
28	Аллювийн намгийн	20866.6	0.9
29	Аллювийн нугат намгийн/Аллювийн нугын хужирлаг	19737.8	0.8
30	Аллювийн нугын/Аллювийн нугын давсархаг	115137.0	4.8
31	Аллювийн нугын хужирлаг ба Аллювийнүелсэн тогтоцтой	7120.8	0.3
32	Аллювийн үелсэн тогтоцтой ба Аллювийн нугын	2478.4	0.1
33	Хужир болон хужирлаг нугат бор	2548.3	0.1
34	Хагас бэхэжсэн элс	6557.4	0.3
35	Хад асга	99883.7	4.2
36	Мөнх цас мөсөн гол, эх чулуулгийн илэрц	21187.9	0.9
37	Дүн	2376898.5	100.0

**Ан амьтан.** Энэ мужид нийтдээ 5 ангийн 275 зүйл буюу манай орны сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 42.2 % нь оршин амьдардаг байна.

*Хүснэгт № 3.5. Монгол - Алтайн өндөр уулын мужийн амьтдын зүйлийн бүрэлдэхүүн*

Нэгж	Дэлэнтэн	Шувуу	Мөлхөгчид	Хоёр нутагтан	Загас	Дугариг амтан	Бүгд
Баг	5	16	1	1	2	-	25
Овог	15	40	6	1	4	-	66
Зүйл	64 (46.0 %)	194 (46.7 %)	64 (46.0 %)	10 (47.06%)	1 (16.6 %)	6 (3,5%)	-

Тайлбар: Монгол оронд бүртгэгдсэн тухайн ангийн амьтдын зүйлийн бүрэлдэхүүний хэдэн хувийг эзэлж буйг хаалтанд бичив.

**Дэлэнтэн.** Энэ мужид 5 баг, 15 овогт хамаарах 64 зүйл дэлэнтэн амьтан тэмдэглэгдсэн нь манай орны дэлэнтний зүйлийн бүрэлдэхүүний 46.0 % болно 1-р хавсралт/. Үүнээс шавжичтан 3, далавчтан 7, туулайтан 5, мэрэгчтэн 28, махчтан 14, туурайтан 6 зүйл байна. Дэлэнтний дотор зүйлийн тоогоор мэрэгчтэн /эндхийн хөхтний 43.7%/ зонхилж, дараа нь махчтан /21,8%/ орно.

Монгол Алтайн өндөр уулын мужийн ой бүхий Хархираа-Түргэн, Алтай Таван Богдын өндөр уулын тойрогт баданга хүдэр, халиун буга, бор гөрөөс, зэрлэг гахай, нохой зээх, шүлүүс мий, хүрэн баавгай, бараан хэрэм, улаан ойго, чандага туулай, умардын сарсаахай зэрэг умарын ой, тайгын гаралтай зүйлүүд нилээд хэмжээгээр нэвтрэн орсон байдаг. Харин Хархираа-Түргэний өндөр уул, хотгорын тойргийн Ачит, Үүрэг нуурын савын заримдаг цөлөөр Төв Азийн тал хээр, цөлийн элементүүд нэвтрэн орсон байна. Тухайлбал энд багваахайнханы 7 зүйл, туулайтаны 5 зүйл, шишгийнхэний 18 зүйл тэмдэглэгдсэний зэрэгцээ хар сүүлт зээрийн дэлхийн дархацын хамгийн баруун хойд цэг Ачит нуурын баруугаар давхцдаг байна. Энэ мужийн Мөнххайрхан, Хар азарга-Гичгэний өндөр уулсын тойрогт Төв Азийн өндөр уул, тал хээр, цөлийн зүйлүүд /бор туулай, монгол тарвага, цайвар үлийч, шивэр алагдаага, хярс үнэг, шар үнэг аргаль хонь, янгир ямаа болон бусад олон төрөл, зүйлийн мэрэгчтэн/ өргөн тархсан ажээ.

Энэ мужийн 64 зүйл дэлэнтний 51 зүйл буюу 79.6 % нь тоо толгойн хувьд элбэг болон ерийн амьтан юм. Аль нэг хэмжээгээр ховордсон амьтанд 13 зүйл буюу 20.3 % нь ордог. Эдгээрээс баданга хүдэр, халиун буга, зэрлэг гахай, аргаль хонь, цоохор ирвэс, шүлүүс мий зэрэг ан амьтан хүний шууд нөлөө буюу агнуураас болж ховордсон гэж үздэг.

Монгол Алтайн өндөр уулын мужийн нутаг дэвсгэрт хоёр зүйлийн тарвага тархжээ. Алтай тарвага нь Баян-Өлгий аймаг, Ховд аймгийн Ховд, Эрдэнэбүрэн сумдын нутагт Алтай, Сийлхэмийн нуруунаас урагш, Цамбагарав, Хөх Сэрхийн нуруунаас баруун тийш, Улаагчний даваанаас хойш нийтдээ 800.0 мянга орчим га талбайд, голын хөндий, уулын бэлээс таг, мөнх цасны зах хүртэл тохиолдоно. Алтайн нурууны нийт тарвага 2.5 саяд (мөндлийг тооцохгүйгээр) хүрэх бөгөөд үүний 0.5 сая толгой нь алтай тарвага, үлдэх 2.0 сая орчим нь Монгол тарвага байна.

**Шувуу.** Энэ мужийн нутаг дэвсгэрт нийт 16 баг, 40 овгийн 194 зүйл шувуу бүртгэгдсэн байна. Шувуудын дотор зүйлийн тоогоор бор шувууны багийн амьтад тэргүүлнэ. /100 зүйл буюу энэ мужийн шувуудын зүйлийн бүрэлдэхүүний 51.5 %/. Энэ мужид өдрийн махчин шувууны багаас 21 зүйл /10.8%/, хөгчүү, шонхор хэлбэртэнээс тус бүр 20 зүйл /тус бүр 10.3 %/, галуу хэлбэртэний 18 зүйл /9.2 %/ тус тус оршин амьдарна. Эдгээр 4 багийн 158 зүйл шувуу нь Монгол Алтайн өндөр уулын мужийн шувууны нийт зүйлийн бүрэлдэхүүний 81.4 %-ийг бүрдүүлдэг байна.

Тус мужийн өндөр уулын бүсэд гол төлөв Төв Азийн уулархаг нутгийн амьдралтай, эндхийн байгалийн нөхцөлд илүү зохицсон өдрийн ба шөнийн махчин шувууд, хэрээний овогийнхон зэрэг өндөрлөг ба тал хээр нутгийн зүйлүүд элбэг. Алтай Таван богд, Хархираа-Түргэний уулсын өндөр уулс, хотгорын тойргуудын өндөр уулын ой бүхий бүс нутгаар цэвдгийн цагаан ятуу, хур, нургийн сойр, хөгүү мэтийн ой, тайгын амьдралтай шувууд хойноос нэвтрэн ирж суурьшсан байдаг. Харин Хархираа-Түргэний хотгорын тойргийн Үүрэг, Ачит нуур, Ховд гол, Алтай Таван Богдын өндөр уулын тойргийн Хотон, Хурган, Даян, Толбо, Дөрөө, Тал нуур, Ховд, Сагсай, Ёлт голууд, Мөнххайрханы өндөр уулсын тойрогт орших Хөх нуур, Буянт, Булган, Цэнхэрийн гол зэрэг уулын цэнгэг уст том, жижиг олон нуур, голын хөндийн бүс нутаг нь ус, намгийн амьдралтай шунгууртан, орвиллог хэлбэртэн, галуу хэлбэртэн, тогоруу хэлбэртэн, хөгчүү хэлбэртэн болон бусад бүлгийн шувуудын сууршин амьдрах үндсэн гол орчин болдог.

Ан агнуурын тухай Монгол улсын хууль, тогтоомж, Зэрлэг амьтан, ургамлын зүйлийг Олон улсад худалдаалах тухай конвенцийн 1.2-р хавсралт, Монгол улсын ба Байгаль хамгаалах Олон улсын холбооны Улаан номонд орох зэргээр эрх зүйн хувьд ямар нэг хэмжээгээр хамгаалалтанд авсан 36 зүйл шувуу /Усны бух, цасч дэглий, халбаган хошуут, хар өрөвтас, хээрийн галуу, хошуу галуу, гангар хун, явлаг сар, сохор элээ, цагаан элэгт, үлэг харцгай, морин харцгай, шилийн сар, бахим бүргэд, тарважи бүргэд, цармын бүргэд, усны нөмрөг бүргэд, усны цагаан сүүлт бүргэд, ёл, ухаа хажир бүргэд, тас, идлэг шонхор, шууман шонхор, хайргууна шонхор, зээрд шонхор, начин шонхор, алтайн хойлог, хархираа тогоруу, өвөгт тогоруу, итэлгэн цахлай, реликт цахлай, шар шувуу, явлиг ууль, савагт ууль, хотны бүгээхэй, хув бэгбаатар/ тус мужийн нутаг дэвсгэрт оршин амьдардаг.

Ус намгийн амьдралтай, спорт агнуурын өндөр ач холбогдол бүхий галууны багийн 18 зүйл, хөлдүү түүхий эдийн холбогдолтой гол төлөв тахианы багийн 8 зүйл шувуу энэ мужид оршин амьдардаг. Мөн шар шувууны багийн 5 зүйлийг энд тэмдэглэсэн байна.

**Мөлхөгчид.** Энэ мужийн нутаг дэвсгэрт 3 овгийн 10 зүйл мөлхөгчид оршин амьдарна. Төв Азийн говь цөлийн гаралтай төмөр гүрвэл, цоохор хонин гүрвэл, замба гүрвэл, монгол гүрвэл, могой гүрвэл зэрэг зүйлүүд Монгол Алтайн нурууны өмнөд ба зүүн салбар уулсын хөндийг даган тус мужийн нутгийн нилээд гүнд тархсан байдаг. Алтай Таван Богдын өндөр уулын тойргийн Эрчис мөрний эх, Даян, Хотон, Хурган нуур орчмын өндөр уулын нуга, ой бүхий нутгаар зулзагалагч гүрвэл, эгэл загалмайт могой тэмдэглэгджээ. Харин Мөнххайрханы өндөр уулсын тойргийн баруун өмнө хэсгийн бэсрэг уулсаар гавшгай гүрвэл тохиолдоно. Рашааны могой, бамбай хоншоорт могой гэсэн хоёр зүйл нь энэ мужийн хамгийн янз бүрийн биотопт түгээмэл тохиолдох, өргөн тархалттай, элбэг мөлхөгчид болно. Эгэл загалмайт могой, гавшгай гүрвэл зэрэг зүйлүүд эрх зүйн ямар нэг хамгаалалтанд одоогоор ороогүй байгаа ч цаашдаа хамгаалалтанд авах шаардлагатай, ховор амьтад мөн.

**Хоёр нутагтан.** Энэ мужийн Мөнххайрханы өндөр уулсын тойргийн Булган голын савд ногоон бах хэмээх нэг зүйл хоёр нутагтан бий. Энэ нь явцуу тархалттай, полиплоид хромосом бүхий ховор амьтан учир манай улсын Улаан номонд орсон байна.

Загас. Монгол Алтайн өндөр уулын мужид 2 баг, 4 овгийн 6 зүйл загас бүртгэв. Эдгээрээс монгол хадран, шивэр хадран, алтайн сугас, зарам загаснууд нь спорт агнуурын ач холбогдолтой. Зарам загасыг Толбо, Хонгор Өлөнгийн нуур, усан санд 1982 онд нутагшуулсан билээ. Монгол хадран, Алтайн сугас зэрэг нь Төв Азийн унаган загаснууд болно.

**Ландшафтын онцлог.** Монгол Алтайн гол нуруунд өндөр уулын ян сарьдаг, уулын нуга, уулын хээрийн ландшафт голлох боловч салбар уулсад цөлийн нөлөө их туссан байдаг. Ялангуяа Баруун хуурайн хотгорыг хүрээлэн орших Алтайн нурууны өвөр хажуунуудад хуурай хээр, цөлжүү хээрийн ландшафт ноёрхдог байна.

Уулархаг ландшафтын гол онцлог нь түүний өндрийн бүсшил үүсгэх явдал юм. Гэвч тухайн орчны үнэмлэхүй өндөр, хажуугийн зүг зовхисын ялгаанаас ландшафтын бүслэг байдал их хамаарахаас гадна ландшафтын дотоод бүтэц ч ихээхэн алаг цоог байдаг. Уулсын хамгийн дээд давхарлагад ялгардаг ландшафтын онцгой хэв шинж бол хур цас мөс юм. Энэ нь Монгол Алтайн нурууны 10 орчим тооны өндөр оргилуудад тархах ажээ.

Ян сарьдгийн ландшафт Монгол алтайн нуруунд нийтдээ 3000-ээс дээш өргөгдсөн хэсэгт тохиолдох ба мөнх цастай уулсад 3250м-ээс дээш цасны хил хүртэл, мөнх цасгүй уул нуруудад 3300-3350м-ээс дээших уулсын орой, хажууг хамардаг байна. Өндөр уулын нугын ландшафт Монгол Алтайн нурууны тэгшивтэр гадаргатай далайн түвшнээс дээш 3000 м, түүнээс дээш өргөгдсөн уулсад тархжээ. Уулын хээрийн ландшафт Монгол Алтайн нуруунд хамгийн их тархсан. Ялангуяа тусгаар орших өндөр уулсад уулын хээрийн ландшафт голлоно.

### **3.2.3. Алтайн ар говийн цөлөрхөг муж, Увс нуурын хотгорын тойрог (Г-1), Хяргас нуурын хотгорын тойрог (Г-2)**

Говийн бүс нутаг нь 4-н мужтайгаас Алтайн ар говийн цөлөрхөг мужын Г-1, Г-2 тойргуудад Увс аймгийн нутаг дэвсгэр оршино

#### **Тойргуудын онцлог**

Увс нуурын хотгорын тойрог.

Энэ нь идэгдэл хуримтлалын хэв шинжит хотгор гүдгэрийн төрөлд орох тектоник гаралтай буурц хотгор юм. Их нууруудын хотгорын хамгийн нам бөгөөд хойт хэсэгт байрлана. Увс нуурын хотгорын орших үнэмлэхүй өндөр нь 759 - 1500 метрийн хооронд, дундаж өндөр нь 1200- 1400 метр бөгөөд захаараа 1600 - 1700 метр хүрнэ. Увс нуурын хотгор нь өргөргийн дагуу сунаж тогтсон бөгөөд хамгийн нам газарт /759 м/ нь Монголын хамгийн том давстай нуур болох Увс нуур оршино. Энэхүү хотгорын ерөнхий байдал нь дорнод хэсэгтээ элс ихтэй бөгөөд баруун талын зарим хэсэгт эртний том нуурын хурдсууд болон довцог элснүүд тодорхой ажиглагдана. Энд хуримтлалын гаралтай Цагааншувуут, Хан Хөхий ба бусад уулын хормойгоор орших уулын хормойн налуу талууд нь олон тооны хуурай сайраар зүсэгдсэн байна.

Гадарга ерөнхийдөө налуу ба түүн дээр идэгдэл хуримтлалын гарал бүхий цав толгод / 950 - 1170 м / , ухаа гүвээт тал, идэгдлийн сууры тал, элсэн тарамцаг, эртний нуурын дэнж зэрэг олон төрлийн хэлбэр, хэв шинжийн хотгор гүдгэр зонхилно. Хуримтлалын материалаас нуур, нуур - аллювийн хурдас нилээд зузаан байх ба мөн элсэн тарамцаг хэсэг хэсгээр их тархаснаас гадна Их нууруудын хотгор руу орсон томхон голын адагт аллювийн элс, хайрган хурдас нэн элбэг байна. Энд хуримтлалын гаралтай сэвсгэр хурдас түгээмэл тархасны дотор элсэн тарамцаг / Бөөрөг дэл, Алтан элс г.м / чухал байр эзэлнэ. Нуурын зүүн хэсэгт орших Бөөрөг дэлийн элс нь элсэн тарамцгуудаас хамгийн том нь болно. Энэ нь 4000 гаруй км<sup>2</sup> талбайг эзлэн орших ба түүний хамгийн урт нь 180 км, өргөн нь 40-45 км болно. Элсэн талбай нь баруун - хойд - баруунаас зүүн - өмнө - зүүн чиглэлд зурвас байдлаар сунаж тогтсон байх бөгөөд цааш зүүн тийш салхины зонхилох чиглэлийн дагуу үргэлжлэнэ. Увс нуурын эргэн тойронд жинхэнэ нуур- аллювийн хурдаст хуримтлалын тал нилээд газрыг хамрах бөгөөд тэнд нуурын эртний далан дэнж тодорхой илэрсэн байна. Ийм талыг Тэс, Хархираа болон бусад голууд ихээхэн идэж хэрчсэн байдаг. Нуурын талууд нь 770 -800 метрийн үнэмлэхүй өндөрт орших ба өргөн нь дундажаар 10- 15 км зурвас байдалтай үргэлжлэх бөгөөд намаг, үлдэгдэл нуур, хужир марцтай байна. Увс нуурын хотгорын баруун, зүүн хэсгүүд хоорондоо эрс ялгаатай болохыг тэмдэглэх хэрэгтэй юм. Энэхүү зааг ялгаа нь Баян нуурын хагаралаар тусгаарлагдсан байна. Баруун хэсэг бол хамгийн эрчимтэй доош суусан хэсэг бөгөөд өмнө, баруун талаараа хагаралуудаар тодорхой зааглагдсан байх ба түүний төвд нуур оршдог, нуурыг хүрээлж нуурын болон нуур - аллювийн хурдаснууд тогтсон, захаар нь харьцангуй хүчтэй налсан хормойн тэгш тал хөгжсөн, эвдрэлийн тэгш талууд байдаггүй бол хотгорын зүүн хэсэг нь харьцангуй өргөгдсөн , тогтвортой , тодорхой бус илэрсэн хил хязгаартай, захаар нь хуримтлалын болон эвдрэлийн тэгш талууд өргөн тархсан байна.

Нутаг дэвсгэрийн үндсэн хэсгийг эртний нуурын болон садраа адгийн дэнжилсэн тэгш талууд эзлэх бөгөөд үлэмж хэмжээгээр их биш зузаантай салхин гаралт элсээр хучигдсан байна.

#### Хяргас нуурын хотгорын тойрог /Г-2/

Гадаргынхаа байдлаар геоморфологийн биеэ даасан район болох Хяргас нуурын хотгор нь Хан Хөхий, Тогтохын шилийн суналын дагуу бараг өргөрөгийн чиглэлтэй тогтжээ. Хан Хөхийн нуруунаас Монгол Алтайн хойт салбарууд хүртэл өргөн их талбайг эзлэх бөгөөд Хан Хөхийн баруун үзүүр дэх уулзүйн хаалгаар Увс нуурын хотгортой холбоотой байдаг. Хяргас нуурын хотгорын гадарга нь бараг тал газрууд болон толгодоос ихэвчлэн бүрдэх бөгөөд мон тус тусдаа орших үлдэгдэл цохио, толгодуудаас бүрдэнэ. Тэдгээр нь заримдаа бүлэглэж, эвдлэгдсэн бөгөөд гол төлөв боржин чулуулгаас бүрэлдсэн төдий л өндөр биш өндөрлөгүүдийг бий болгодог. Тал газрууд нь хотгор гүдгэрийн дийлэнх хэлбэр дүрс болох боловч өргөрөгийн буюу бараг өргөрөгийн дагуу чигт олонтоо тохиолдох дэл хад, толгодуудтай холилдон оршино. Энэ тойрогт Монголын томоохон нуурууд болох - Хяргас нуур Айраг нуурын хамт, Хар ус нуур / Хойт далай / болон Хар нуур, Дөргөн нуурын хамт орно.

Хангайн болон Монгол Алтайн томоохон голуудын төгсгөл болох Хяргас нуурын хотгор нь харьцангуй сайн судлагдсан. Хотгорын хамгийн нам хэсгийг хойт хэсэгт нуурын тэгш тал, өмнө хэсэгт нуур аллювийн тэгш талууд эзлэн оршино. Хяргас нуурын дэнжийг олон судлаачид шинжилсэн бөгөөд дөрвөн төрлийн дэнжийг ялгасан байна. Үүнд: 1- р дэнж 20-30 метрийн харьцангуй өндөртэй 1050 - 1060 метрийн үнэмлэхүй өндөрт орших, 2- р дэнж 60 метрийн харьцангуй өндөртэй 1090 метрийн үнэмлэхүй өндөрт орших, 3- р дэнж 90 метрийн харьцангуй өндөртэй 1120 метрийн үнэмлэхүй өндөрт орших, 4- р дэнж 110-150 метрийн харьцангуй өндөртэй 1150 - 1180 метрийн үнэмлэхүй өндөрт орших дэнжүүд эдгээр болно.

Хяргас нуурын хотгорын зүүн хэсэгт Хангайн уулсын захаар зүүн тийшээ сунасан элс ихээхэн талбайг эзэлнэ. Ялангуяа Завхан ба Хүнгүй голуудын хоёр талаар түүний хөндийд хуримтлагдсан элс ихээхэн байна. Завхан голын зүүн эргийн дагуу орших "Монгол элс"-ний талбай 2724 км<sup>2</sup> юм. Энэхүү элс нь элсэн хүзүүвчээр дамжин Дөрөө нуурт хүрч очих Бага нуурын урьдах элстэй холбоотой. Дөрвөлжин гэдэг хадат толгодоос эхлэн Тээлийн гол хүртэл Завхан голын зүүн эргийн дагуу элс байдаг бөгөөд харин баруун гар талын элс нь улам их хэмжээний газрыг эзэлсэн байна. Тэдгээрийн талбай 1614 км<sup>2</sup> байна. Хяргас нуурын хотгорын гадарга дээр элс ба сайр чулуу элбэг байдаг. Хяргас нуурын орчмынх шиг хамгийн нам орших талууд нь цөлөрхөг байдалтай байна. Эдгээр цөл нь нуурын хотгороос холдох тутам говийн байдалтай болж, харин эргэн тойрны уулсын бэлээр бол чулуурхаг ба хадархаг хөрсөн дээрхи ховор тачир ургамал бүхий хуурай хээрүүд болон солигдоно. Хяргас нуурын хотгорын үнэмлэхүй өндөр нь 1034-1500 метрийн хооронд байна. Энэхүү хотгор нь нуур аллювийн хурдаст томхон хотгор бөгөөд түүний зүүн өмнөд хэсэгт эртний усан санд тунаж тогтсон Бор хяр / 2502 км<sup>2</sup> / -

ын элсэн тарамцаг үргэлжилнэ. Энэ элс Хангайн уулт өндөрлөг рүү түрж нилээд нутгийг хамрана.

Их нууруудын хотгорын элсний хэлбэр дүрс олон янз байна. Дөрөө ба Бага нуур хоёрын хооронд 60 метр хүртэл харьцангуй өндөртэй манхан элс байна. Манхан элс нь олон тооны нуурын буюу голын эргийн дагуу байдаг. Тухайлбал : Богдын голын адгаас доош Завхан гол нь манхан элсэн дундуур урсдаг. Эдгээр элс нь өнгөгүй, нүцгэн, нүүмтгий, долгиолсон байх бөгөөд шууд голын голдиролд тулж орчны өндөрлөгийг бүрхэх боловч төдийлэн зузаан биш тул үндсэн чулуулгийг нимгэн үеэр хучиж оршино. Энэ нь ялангуяа Бор хяр элсний районд олонтоо тохиолдоно. Ийм учраас зарим шинжээчид энд цул боржин чулуун “ шил “ орших бөгөөд хэдийгээр нилээд их харьцангуй өндөртэй боловч /200 метрээс дээш/ цөм хяраа хүртэл элсээр хучигдсан байна гэж үздэг. Тус тусдаа орших хадан уулс нь тод харагдаж, эрс хэлбэртэй уулсыг тогтооно. Ялангуяа Аргалант уул /2117 м/, Их буурал /2325 м/ , Отог /1883 м/ зэрэг үлдэгдэл уулсууд Хяргас нуураас зүүн тийш , Завхан болон Хүнгүй голын завсар олонтоо байна. Эдгээр уул нь нэг уул байсан бөгөөд хэсэглэгдэн эвдлэгдэж хэд хэдэн хэсэг тасарсан гэж үздэг. Энэхүү уулсын захаар тус тусдаа орших хадан цохио болон эгц хажуутай толгод шовойж харагдана. Ийм төрлийн үлдэгдэл уулсад Их, Бага Маргац уулнууд орох ба үлдэгдэл цохионы харьцангуй өндөр нь хэдэн арваад метр тухайлбал Дааган дэл /1556 м шиг 100-150 - иас дээш гарах нь ховор байдаг. Хар ус нуур, Хар нуурын хотгор нь зүүн талаараа Завхан голын дагуу орших Монгол элстэй хил нийлэх бөгөөд энэ хэсэгтээ гадаргын байдал ерөнхийдөө талархаг юм. Харин баруун хойт талаараа Алтан хөхий, зүүн урдуураа Жаргалант хайрханы уултай хил нийлнэ. Нууруудын эргэн тойронд аллювийн хурдаст тал нилээд газрыг хамрана.

Уур амьсгалын хувьд

энэ муж нь (Г1) Монголын хамгийн хойш түрж орсон цөлөрхөг нутаг юм. Энд эх газрын уур амьсгалын эрс тэс нөхцөл хамгийн тодорхой илэрдэг. Энд өвөл, зуны болон өдөр шөнийн температурын зөрүү хамгийн их, өөрөөр хэлбэл өвөлдөө нэн хүйтэн, зундаа халуун, хуурай уур амьсгалтай.

Увс нуурын хотгорын тойрог

Увс нуурын хотгорт жилийн дундаж агаарын температур  $-3.7^{\circ}\text{C}$ , хамгийн дулаан 7 дугаар сард  $-34.0^{\circ}\text{C}$  хүрдэг. Агаарын үнэмлэхүй хамгийн бага температур  $-48^{\circ}\text{C}$ , үнэмлэхүй хамгийн их температур нь  $+36^{\circ}\text{C}$  хүрдэг байна. Хаврын эцсийн цочир хүйтрэх хугацаа 5 дугаар сарын 20-доор болж, намрын анхны цочир хүйтрэл дунджаар 9 дүгээр сарын 20-доор эхэлдэг, хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 120-иод хоног буюу 4 сар үргэлжилдэг. Ургамал ургах дулааны хангамж сайтай, харин жилийн хур тунадасны хэмжээ 139 мм, дулааны улиралд 118 мм ордог ажээ. Бороотой өдрийн тоо 38 байдаг. Ийнхүү энэ тойрогт зөвхөн усалгаатай нөхцөлд газар тариалан эрхлэх боломжтой юм. Өндөр уулнаас эх авсан гол болон түр урсгалтай гол горхи, Тэсийн гол зэрэг усалгаанд ашиглах усны нөөцтэйгээрээ уг муж бусад тойргоос давуу нөхцөлтэй.

Хяргас нуурын хотгорын тойрог

Энэ тойрогт Хяргас, Хар нуур, Айраг нуур болон Завхан, Хүнгүйн голын адгийн цөлөрхөг нутаг хамрагдана. Увс аймгийн Завхан сумын нутагт жилийн дундаж агаарын температур  $-1.0^{\circ}\text{C}$  байдаг бөгөөд 7 дугаар сард  $16.3^{\circ}\text{C}$  байдаг. 1 дүгээр сард дунджаар  $-22^{\circ}\text{C}$  \*  $-24^{\circ}\text{C}$  байдаг байна. Жилийн нийлбэр тунадас 100-130 мм орчим болно. Дээр дурьдсан Завхан суманд жилийн нийлбэр хур тунадас 128 мм байдаг. Энэ нутагт хөрсний агротехникийн зохистой арга хэрэглэн цэнгэг устай нуур, хоолой, Завхан, Хүнгүйн голын усыг ашиглан тэжээлийн ургамал болон үр тариа хүнсний ногоо тариалах боломж байгаа. Ялангуяа суль, сульхир зэрэг нутгийн тэжээллэг ургамлыг тарималжуулах нь нэн чухал юм.

#### Ургамлан нөмрөг

Их нууруудын хотгорын төв хэсэг нь цөлийн, захын хэсэг нь цөлөрхөг хээрийн ургамалжилттай. Нууруудын эргэн тойронд нүцгэн юмуу шар бударганатай, нэг наст бударганатай байна. Заримдаа намгархаг хужирлаг нугатай, дэрстэй хотгор, хармагтай довнууд үзэгдэнэ. Увс нуурын хотгорт Казахстаны (Зүүнгар-Тураны) цөлийн төлөөлөгчид, тухайлбал таар, сээтэлж, цагаан газрын шарилж, шренкийн шарилж бүлгэмдэл үүсгэдэг. Тэдгээртэй хамт бор бударгана, крыловын хялгана ургана. Голын хайргатай, чулуутай сайр дагуу үслэг ба лавар навчит улиас хэсэг хэсгээр ургах ба намагжсан татмаар жижиг навчит хусан төгөлтэй. Их нууруудын хотгорын төв хэсэгт талархаг гадаргатай хайргархаг газраар өдлөг хялгана-бударганат, (ахар навчит баглуур, Зүүнгарын улаан бударгана, сөөгөн лууль оролцсон), өдлөг хялгана-агьт (төлөгчдүү боролзой оролцсон), дан өдлөг хялганатай, өдлөг хялгана-таанатай, өдлөг хялгана-хазаарганат цөлөрхөг хээр элбэг тааралдана. Мөн баглуурт, баглуур-улаан бударганат, элдэв бударгана-улаан бударганат жинхэнэ цөл хотгоруудын дагуу бий.

Олон нуурын хөндий нь хайргархаг, цөлөрхөг хээрийн хэв шинжид хамаарах өдлөг хялгана-таанат, өдлөг хялганат-хазаарганат, өдлөг хялганат- таана-баглуурт, харгана-өдлөг хялганат, говийн сайрын хялгана, таана (үндсэрхэг сонгино), ахар-навчит баглуур, төлөгчдүү боролзой, одой харгана зонхилно. Хөндийн нам доод хэсгээр баглуурт, бор бударгана-баглуурт цөлийн эвшлүүд, хужир марцлаг хотосоор бор бударгана, шар бударгана, улаан бударгана, нуур орчмын элсэрхэг хайргатай тэгширхэг газраар одой харгана, тэсэг, модлиг бударгана, алтан-шар шарилж зэргээс бүрэлдсэн сөөгөн хэвшлүүд тааралдана. Нууруудын хөндийн дагуух элс зүүн хэсгээр бунгийн харгана, сөөгөн шимэрс, бор шаваг оролцсон сийрэг загт цөл бий.

Алтайн ар говийн муж нь Монгол улсын нутаг дэвсгэрийн 9.29%-ийг эзэлнэ. Энэ мужид багтах Их нууруудын хотгорт 666 зүйл гуурст ургамал бүртгэгдсэний дотор 96 зүйл (тойргийн ургамлын 14.41%), модлог, сөөглөг ургамал, 570 зүйл (85.59%) өвслөг ургамал байдаг бол Олон нуурын хөндийд 346 зүйл гуурст ургамал бүртгэгдсэний дотор 50 зүйл (14.45%) модлог, сөөглөг ургамал, 296 зүйл (85.55%) өвслөг ургамал байна. Их нууруудын хотгорын ургамлыг экологийн үндсэн бүлгүүдэд хуваарилж үзвэл:

хуурайсаг ургамал 113 зүйл (16.97%),

хуурайсуу-чийгсэг 64 зүйл (9.61%),

чийгсэг 70 зүйл (10.51%)  
хуурайсуу чулуусаг 95 зүйл (14.26%),  
давссаг бүх бүлгийн ургамал-144 зүйл (21.62%),  
элссэг 37 зүйл (5.55%) байна.

Бас нуур, гол олонтой, ус чийгтэй хотгор нэлээд бий тул чийглэг ба усны ургамал үлэмж хувийг эзэлдэг юм. Олон нуурын хөндийн ургамлыг экологийн бүлгээр нь авч үзвэл:

хуурайсаг ургамал 85 зүйл (24.57%),  
хуурайсуу-чулуусаг 59 зүйл (17.05%),  
элссэг 26 зүйл (7.51%)  
чийгсэг 18 зүйл (5.2%),  
хуурайсуу чийгсэг 31 зүйл (8.96%),  
давссаг 4 бүлгийн ургамал-86 зүйл (24.85%),  
уссаг ургамал 15 зүйл (4.34%)  
намагсаг ургамал 3 бүлгийн 23 зүйл (6.65%) байна.

Эндээс үзэхэд ургамлын аймаг нь хуурайшилтын нөлөөнд илүү дассан цөлийн ургамал зонхилж, харин хүйтсэг ургамал огт байхгүй байна.

Увс нуурын хотгорын тойргийн төв хэсэг болох Увс нуурын эрэг, хөвөө, Тэс голын хөндийгөөр марзлаг нугын хөрстэй газраар цахилдагт бэлчээртэй. Зун-намарт тэмээ, үхэрт тохиромжтой, 10-20 (30) ц/га тэжээлийн нөөцтэй, 600- 800 (1000) кг/га тэжээлийн нэгжтэй. Тойргын баруун хойд хэсгээр алаг өвс-ботуульт нугат-хээрийн ба хээрийн бэлчээртэй, зун-намарт бог мал, адуунд тохиромжтой, 6-8 ц/га тэжээлийн нөөцтэй, 300-400 тэжээлийн нэгжтэй. Түргэн, Хархираа уулсын энгэр, бэлээр алаг өвс-ерхөг-хялганат, ерхөгт хуурай хээрийн бэлчээртэй, талархаг газраар таар, таар-шарилж, таар- бударганат цөлөрхөг хээрийн бэлчээртэй. 3-45 ц/га тэжээлийн нөөцтэй, 150- 200 кг/га тэжээлийн нэгжтэй. Тойргын урд хэсэг (Малчин сумын нутаг) шарилж-жижиг хялгана-таар, таар- шарилжит, таар-ботуульт цөлөрхөг хээр, цөлийн хээрийн бэлчээртэй, хонь, тэмээнд тохиромжтой, 3-4 ц/га тэжээлийн нөөцтэй, 200-250 кг/га тэжээлийн нэгжтэй. Тойргын зүүн өмнөд хэсэг Бөөрөг дэлийн элстэй хэсгээр, үетэн, алаг өвс- үетэн, шарилжит, сөөг бүхий элсний бэлчээртэй, (зээргэнэ, зээргэнэ- бударгант) зун-намарт тэмээнд тохиромжтой, 2-4 ц/га тэжээлийн нөөцтэй, 80- 100 кг/га тэжээлийн нэгжтэй. Тэс, Нарийн голын хооронд жижиг бутлаг үетэн-хялганат, харгана-хялганат хуурай хээрийн бэлчээртэй, үхэр, адуу, тэмээнд тохиромжтой, 3-4 ц/га тэжээлийн нөөцтэй, 300-350 кг/га тэжээлийн нэгжтэй.

Хяргас нуурын хотгорын тойрогийн төв хэсэг болох Хяргас нуурын баруун өмнөд хэсэг Айраг, Хар-Ус, Хар нуурын орчим нутгаар цөлийн бор саарал хөрстэй баглуурт бэлчээр, зун намарт тэмээнд тохиромжтой. Тал, хотгор газрын бэлчээрээр 4 ц/га тэжээлийн нөөцтэй, 300-340 кг/га тэжээлийн нэгжтэй. Тойргийн баруун, зүүн, зүүн өмнөд хэсгээр цөлөрхөг хээрийн бор хөрстэй баглуур-жижиг хялганат, цөлөрхөг хээрийн чулуурхаг бор хөрстэй бударгана- жижиг хялганат, бударганат цөлөрхөг хээр ба цөлийн хээрийн бэлчээртэй. Зун намарт бог мал, тэмээнд тохиромжтой 30ц/га тэжээлийн нөөцтэй,



150-180ц/га тэжээлийн нэгжтэй. Монгол элс, Бор хярын элс орчмоор хуурай хээрийн ба цөлөрхөг хээрийн харганат, үетэн-харганат, шарилжит элсний бэлчээртэй. Зун намарт бог мал тэмээнд тохиромжтой. 1.5 кг/га тэжээлийн нөөцтэй, 80-100ц/га тэжээлийн нэгжтэй. Хар-Ус нуур, Хар нуур, Ховд, Буянт голын цутгал хэсэгт нуурын хөвөөний нишингэт усны эрэг орчмын марзлаг нугын хөрстэй улалжит, цахилдагт марзлаг нугын бэлчээртэй. Намар-өвөл үхэр, тэмээнд тохиромжтой. 30кг/га тэжээлийн нөөцтэй, 900-1000ц/га тэжээлийн нэгжтэй.

### Хөрсөн бүрхэвч

Хөрсөн бүрхэвчид тал хөндийн хөрс давамгайлах боловч гадаргын онцлогоосоо шалтгаалж уулын хөрс нилээдгүй тархжээ. Ялангуяа Алтайн арын уулсын тойрогт уулын хөрсний эзлэх талбай 22% байхад Увс нуурын хотгор болон Их нуурын хотгорын тойрогт 10 орчим хувь байна. Тал хөндийн цайвар хүрэн ба цөлөрхөг хээрийн бор хөрс элловын элсэн хөрс тархсан нь энэ муж хуурай цөлжүү шинжтэй болохыг илтгэнэ. Хөрс бус бүрдлийн хэмжээ Г-2 ба Г-3 тойрогт бусдаас их байгаа нь энд усны эвдрэлийн нөлөөгөөр бий болсон гуу жалга судаг их байдагтай холбоотой. Аллювийн нуга, нуга-намгийн хөрс Увс нуурын ба Их нууруудын тойрогт давамгайлсан нь гадаргын усны сүлжээ сайнтай холбоотой. Хөрсний давсжилт Алтайн арын уулсын тойрогт илүү байна. Эндхийн уулын хөрсний үе давхарга нимгэн, тогтворжилт муутай, ихээхэн чулуутай бартаатай байхад тал хөндийдөө тачир сийрэг ургамлан нөмрөгтэй. Г-1 ба Г-2-ийн хөрс элс болон жижиг хайргаар хучигдсан байдаг бол Г-3-т хайрга чулуун хучаастай. Уулсын орой нь эгц дээшээ түрсэн шовх хэлбэртэй, хад асга ихтэй, уулс хоорондын ам хөндийгөөр мөсдлийн хунхтай. Зарим уулсын оройд мөнх цас, мөсөн голын нөлөөгөөр намгархаг хөрс тогтсон байна. Энэ мужид ердийн болон сайр чулуурхаг цайвар хүрэн хөрс 30гаруй хувийг эзлэх ба цөлийн болон цөлөрхөг хээрийн хөрс 20 гаруй хувийг эзэлж байна. Бүс дундын нуга намгийн хөрс 6 орчим хувьтай байх ба хужир мараат шал, элсэн хөрс болон хад асга бүхий талбай 9%-тай байна.

Хүснэгт № 3.6. Алтайн ар говийн цөлөрхөг мужийн хөрсний нөөц

Д/д	Хөрсний нэр	Г-1		Г-2	
		га	%	га	%
1	Нуур	354065.95	15.42	384301.29	5.11
8	Уулын хар шороон/уулын хар хүрэн	808.44	0.04	20159.07	0.27
9	Уулын хар хүрэн/уулын нимгэн хар шороон	1651.37	0.07	37850.24	0.50
10	Уулын хүрэн/уулын хар хүрэн	158740.0	6.9	785419.0	10.4
11	Уулын карбонаттай цавар хүрэн/ уулын нимгэн цавар хүрэн		0.0	208653.4	2.8
13	Толгодын хар хүрэн/нимгэн сайр чулуурхаг хар хүрэн	83.7	0.0		0.0
14	Толгодын хүрэн/нимгэн сайр чулуурхаг хүрэн	255.1	0.0	411852.7	5.5
15	Сайр чулуурхаг цайвар хүрэн	54052.4	2.4	448722.9	6.0
16	Толгодын цөлөрхөг хээрийн бор		0.0	126134.6	1.7
18	ердийн хар хүрэн/сайр чулуурхаг хар хүрэн	5030.4	0.2		0.0
19	Ердийн хүрэн/сайр чулуурхаг хүрэн	195669.3	8.5	491363.6	6.5

20	Ердийн болон нугат хүрэн/үлдмэл нугат хүрэн		0.0	301.1	0.0
21	Ердийн цайвар хүрэн/сайр чулуурхаг цайвар хүрэн	480259.4	20.9	1196830.8	15.9
22	Ердийн цайвар хүрэн/нугат цайвар хүрэн		0.0	28669.7	0.4
23	Ердийн цайвар хүрэн/хужир марааны бүрдэл		0.0	19897.0	0.3
24	Карбонаттай цайвар хүрэн/элсэн хучаастай цайвар хүрэн		0.0	203717.6	2.7
25	Мараалаг цайвар хүрэн/сайр чулуурхаг цайвар хүрэн		0.0	235392.8	3.1
26	Сийрэг элсэн хүрэн	336580.3	14.7	173700.8	2.3
27	Мараалаг нугат хүрэн/үлдмэл нугат хүрэн/хужир марааны бүрдэл		0.0	2829.1	0.0
28	Цөлөрхөг хээрийн бор	19149.0	0.8	300603.0	4.0
29	Цөлөрхөг хээрийн бор/сайрын болон элсэн хучаастай бор	27437.2	1.2	242367.3	3.2
30	Цөлөрхөг хээрийн бор/хужир марааны бүрдэл	12987.9	0.6	1943.9	0.0
31	Цөлөрхөг хээрийн сайр чулуурхаг бор		0.0	135847.7	1.8
32	Цөлөрхөг хээрийн мараалаг бор/хужирлаг нугат бор		0.0	14447.1	0.2
33	Хээржүү цөлийн бор/хээржүү цөлийн сайр чулуурхаг бор	40151.2	1.7	53369.1	0.7
34	Хээржүү цөлийн бор/элсэн хучаастай бор болон хээржүү цөлийн мараалаг бор		0.0	236028.5	3.1
35	Хээржүү цөлийн мараалаг бор/шалархуу болон хагас бэхэжсэн элс		0.0	89932.8	1.2
36	Хээржүү цөлийн гөлгөнөт бор		0.0	102003.5	1.4
37	Элсэн хучаастай бор/элсэн хучаастай сийрэг бор	1167.7	0.1	32191.2	0.4
38	Хужирлаг нугат бор/нугын хужирлаг	14076.5	0.6	27615.6	0.4
44	Сайрын бор саарал		0.0	2167.1	0.0
45	Нугат намгийн цэвдэгт/намгийн цэвдэгт	47156.5	2.1		0.0
47	Нугын цэвдэгт/нугат хар шороон		0.0	45.1	0.0
48	Нугын хужир/хужирлаг нуга	4223.7	0.2	43693.5	0.6
49	Аллювийн намгийн	461.2	0.0	57268.1	0.8
50	Аллювийн нугат намгийн/Аллювийн нугын хужирлаг	65290.8	2.8	38781.6	0.5
51	Аллювийн нугын/Аллювийн нугын давсархаг	114069.2	5.0	207953.6	2.8
52	Аллювийн нугын хужирлаг ба Аллювийнүелсэн тогтоцтой	54710.4	2.4	53541.9	0.7
53	Аллювийн үелсэн тогтоцтой ба Аллювийн нугын		0.0	8405.3	0.1
54	Хужир марааны бүрдэл		0.0	13129.6	0.2
55	Нугын иж бүрдэл		0.0	14419.5	0.2
56	Хужир болон хужирлаг нугат бор	96633.7	4.2	84254.1	1.1
57	Хужир болон хагас бэхэжсэн элс	23062.9	1.0	24001.5	0.3
58	Шал шалархуу		0.0	1500.4	0.0
60	Хагас бэхэжсэн элс	109255.2	4.8	216349.4	2.9
61	Хөдөлгөөнт элс	70736.9	3.1	731189.6	9.7
62	Хад асга	7863.8	0.3	12975.0	0.2
	Дүн	2295630.1	100.0	7521820.4	100.0

**Ан амьтан.** Энэ мужид нийтдээ 5 ангийн 332 зүйл буюу манай орны сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 51.4 % нь оршин амьдардаг байна.

Хүснэгт № 3.7. Алтайн ар говийн цөлөрхөг мужийн сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүн.

Нэгж	Дэлэнтэн	Шувуу	Мөлхөгчид	Хоёр нутагтан	Загас	Дугариг амтан	Бүгд
Баг	5	18	1	2	2	-	28
Овог	16	45	5	2	3	-	71
Зүйл	61 (43.8%)	255 (61.4%)	9 (42.8%)	3 (50.0%)	7 (4.14%)	-	335 (51.4%)

Тайлбар: Монгол оронд бүртгэгдсэн тухайн ангийн амьтдын зүйлийн бүрэлдэхүүний хэдэн хувийг эзэлж буйг хаалтанд бичив.

**Дэлэнтэн.** Энэ мужид 5 баг, 16 овгийн 61 зүйл дэлэнтэн амьтан тэмдэглэгдсэн нь манай орны дэлэнтний зүйлийн бүрэлдэхүүний 43.8 % болж байна. Үүнээс шавжтан 3 /эндхийн дэлэнтний зүйлийн бүрэлдэхүүний 4.9 %/, далавчтан 7 /11.5%/, туулайтан 5 /8.2 %/, мэрэгчтэн 33 /54.1 %/, махчтан 11 /18.3 %/, туурайтан 6/9.8 %/ зүйл байна.

Энэ мужийн дэлэнтэн амьтдын үндсэн цөмийг тал хээр, цөлийн гаралтай зүйлүүд /дэлдэн зараа, уссаг багваахай, умардын сарсаахай, сахалт багваахай, дагуур огодой, үхэр огодой, боролзон туулай, бозлог зурам, хул чичүүл, шаргал чичүүл, орог зусаг, хөх шишүүхэй, сүүллэг шишүүхэй, говь шишүүхэй, зээрд сохдой, хадны барагчин, гэрийн хулгана, шивэр алагдаага, говийн алагдаага, монголжин даахай, элсч савгадаахай, хярс үнэг, шар үнэг, өмхий үен, мануул мий, хар сүүлтий, цагаан зээр г.м./ бүрдүүлдэг. Эдгээрээс Алтайн ар говийн цөлөрхөг мужийн бүх төрлийн биотопор тохиолдох өргөн тархалттай бөгөөд тооны хувьд зонхилох зүйлүүд нь дэлдэн зараа, уссаг багваахай, умардын сарсаахай, сахалт багваахай, үхэр огодой, боролзон туулай, бозлог зурам, шаргал чичүүл, орог зузга, хөх шишүүхэй, сүүллэг шишүүхэй, говь шишүүхэй, зээрд сохдой, шивэр алагдаага, говийн алагдаага, элсч савгадаахай зэрэг болно.

Энэ мужийн хэмжээнд ямар нэг хэмжээгээр ховордсон амьтанд 8 зүйл /Азийн минж, тавруу атигдаахай, цоохор ирвэс, зэрлэг гахай, татаар бөхөн, хар сүүлтий, цагаан зээр, янгир ямаа, аргаль хонь/-ийг оруулав. Эдгээрээс ганц тавируу атигдаахай л байгалийн аясаар ховор тохиолдох амьтан болно. Үлдсэн 7 зүйл амьтан хүний шууд нөлөө буюу агнуураас болж ховордсон ажээ.

Азийн минжийг Булган голын саваас Хяргас нуурын хотгорын тойргийн Ховд голын савд шилүүлэн тавьсан нь эдүүгээ тархац нутгаа тэлж, үр төлөө өгснөөр үндсэндээ шинэ нутагт дасан нутагших үедээ шилжээд байна. Гэвч хүн, мал, аж ахуйн үйл ажиллагааны улмаас тоо толгойн хувьд төдийлэн өсөхгүй байгаа юм. Одоогоор Ховд голын сав нутаг 130-150 толгой минжтэй болжээ. Мөн Увс нуурын хотгорын Тэсийн голын хэсэг 1985 онд цөөн тооны минж шилжүүлэн тавьсан нь амжилттай нутагшсан гэж үздэг. Гэхдээ тэдгээрийн тоо толгойн талаар судалгааны ямар нэг мэдээ байхгүй.

Дорнод Монголоос Хяргас нуурын хотгорын тойрогт багтах Хомын тал түүний орчмын нутгуудад цагаан зээр сэргээн нутагшуулах ажлыг 1988-1990 онд зохион байгуулсан нь тун амжилттай болсон билээ. Судалгааны дүнгээс үзвэл багаар тооцоход Хомын талд 2970 буюу 1000 га дахь нягтшил 1,8 толгой, Завхан голын зүүн нутагт 1650 буюу 1000 га дахь нягтшил 0.5 толгой тус тус байна /Лхагвасүрэн, 2000/.

Алтайн ар говийн муж бол хар сүүлтийн үндсэн тархац нутаг юм. Өмнөговийн Даланзадгадаас баруун тийш Орог нуурын зүүн сэжүүр хүртлэх Говь Гурван Сайхан, Их, Бага, Арц Богдын ар хоолой нутагт 1000 га-д 0.2-10.5 толгой ногдох 18.5 мянга, Их нуурын хотгорт 1000 га-д 0.1-2.2 толгой ногдох 1.1 мянга орчим, Шаргын говьд 0.5-2.5 толгой ногдох нягтшилтай 1.7 мянга, Нууруудын хөндийгөөр (Халиуны хоолой, Бигэрийн хотгор, Улаан шандын хоолой, Орог нуурын хөндий) Их Улаан нуур хүртэлх нутагт 1000 га-д 0.1-2.5 ногдох 2.8 мянга орчим толгой байна /Амгалан, 2000/.

Энэ мужийн Увс нуурын хотгорын Тэс, Нарийн гол, Хяргас нуурын хотгорын Хар ус, Хар, Зэргийн цагаан нуур, Ховд, Буянт голын адгийн зэгс хулст нутгаар зэгсний зэрлэг гахайн /*Sus scrofa nigripes*/ цөөн тооны бүл оршин амьдарна. Монгол улсын улаан номонд орсон, цөлийн бүсийн энэхүү унаган салбар зүйлийн тоо толгой сүүлийн жилүүдэд хулгайн агналт, мал аж ахуйн үйл ажиллагааны сөрөг нөлөөллийн улмаас эрс хорогдох хандлагатай болжээ.

**Шувуу.** Энэ мужийн нутаг дэвсгэрт нийт 18 баг, 45 овгийн 252 зүйл шувуу бүртгэгдсэн нь манай орны жигүүртний нийт зүйлийн бүрэлдэхүүний 61.4 % болно. Шувуудын дотор зүйлийн тоогоор бор шувууны багийн амьтад тэргүүлнэ. /101 зүйл буюу энэ мужийн шувуудын зүйлийн бүрэлдэхүүний 39.6 %/. Энэ мужид хөгчүү хэлбэртний багийн 55 зүйл /21.5 %/, галуу хэлбэртний багийн 28 зүйл /9.8 %/, шонхор хэлбэртний багийн 24 зүйл /9.4 %/, тус тус оршин амьдарна. Эдгээр 4 багийн 207 зүйл шувуу нь Алтайн ар. говийн цөлөрхөг мужийн шувууны нийт зүйлийн бүрэлдэхүүний 81.5 %-ийг бүрдүүлдэг байна. Тус мужийн Говь Алтайн салбар уулсын тойрогт өндөр уулын экологийн нөхцөлд дасан зохицсон шонхор хэлбэртэн, шар шувуу хэлбэртэн, бор шувууны болон тахианы багийн олон зүйл тархжээ. Харин Увс, Хяргас нуур, Нууруудын хөндийн тойрогт ус намгийн амьдралтай олон зүйл шувуу оршин амьдарна. Ер нь эдгээр тойргийн нутаг дэвсгэрт багтах Увс, Хяргас, Хар ус, Хар, Дөргө, Айраг, Бигэр, Бөөнцагаан, Орог, Улаан, Таацын цагаан, Адгийн цагаан нуурууд, тэдгээрийн үндсэн цутгал болох Тэс, Ховд, Буянт, Цэнхэр, Завхан, Хүнгүй, Байдраг, Хүнгүй, Онгийн голуудын сав газар бол жигүүртний зүйлийн бүрэлдэхүүнээр нэн баялаг, олон янзын элементээс бүрэлдсэн нутаг болно. Учир нь дээр дурьдсан усан сангууд нь дэлхийн бөмбөрцгийн хойд хагасын хүйтэн сэрүүн бус нутаг ба Энэтхэг хятадын хойг, Зүүн өмнөт Азийн дулаан бүс нутгийн хооронд жилийн улирлаар ээлжлэн явагддаг шувуудын нүүдлийн үндсэн зам, тэдгээрийн үүрлэн өндөглөх, зусах үндсэн түшиц газар болдог. Дурьдсан нутагт ус, намгийн амьдралтай шунгууртан, орвилог хэлбэртэн, галуу хэлбэртэн, тогоруу хэлбэртэн, хөгчүү хэлбэртэн болон бусад бүлгийн шувууд зусч, үрждэг.

Ан агнуурын тухай Монгол улсын хууль, тогтоомж, Зэрлэг амьтан, ургамлын зүйлийг Олон улсад худалдаалах тухай конвенцийн 1.2-р хавсралт, Монгол улсын ба Байгаль хамгаалах Олон улсын холбооны Улаан номонд орох зэргээр эрх зүйн хувьд ямар нэг хэмжээгээр хамгаалатанд авсан 51 зүйл шувуу /Борцгор хотон, усны бух, цасч дэглий, халбаган хошуут, хар өрөвтас, хээрийн галуу, хошуу галуу, хуруурт хун, гангар хун,

гунгар хун, ямаан сүүлт, явлаг сар, сохор элээ, цагаан элэгт, саарал цагаан элэгт, үлэг харцгай, морин харцгай, шилийн сар, тарважи бүргэд, цармын бүргэд, усны нөмрөг бүргэд, усны цагаан сүүлт бүргэд, цасны хажир бүргэд, тас, идлэг шонхор, шилийн шонхор, шууман шонхор, эгэл шонхор, хайргууна шонхор, зээрд шонхор, начин шонхор, алтайн хойлог, гургуул, хархираа тогоруу, цэн тогоруу, өвөгт тогоруу, тоодог, жороо тоодог, хилэн жигүүрт, азийн цууцаль, итэлгэн цахлай, реликт цахлай, гуйвангуу ууль, шар шувуу, явлиг ууль, орволго ууль, савагт ууль, хотны бүгээхэй, харсуун ууль, хув бэгбаатар, хулан жороо/ тус мужийн нутаг дэвсгэрт оршин амьдардаг. Ус намгийн амьдралтай, дийлэнх нь спорт агнуурын өндөр ач холбогдол бүхий галууны багийн 28 зүйл, хөлдүү түүхий эдийн холбогдолтой гол төлөв тахианы багийн 5 зүйл шувуу энэ мужид оршин амьдардаг. Мөн шар шувууны багийн 8 зүйлийг энд тэмдэглэсэн байна.

**Мөлхөгчид.** Энэ мужийн нутаг дэвсгэрт 2 баг, 5 овгийн 9 зүйл мөлхөгч тэмдэглэсэн нь манай орны мөлхөгчдийн зүйлийн бүрэлдэхүүний 42.8 % болно. Эдгээрээс цоохор хонин гүрвэл, могой гүрвэл, рашааны могой, бамбай хоншоорт могой зэрэг нь тус бүс нутгийн төрөл бүрийн биотопт оршин амьдрах, түгээмэл тархалттай, тоо толгойн өндөр нягтшил бүхий мөлхөгчид юм. Говийн гүрвэл мөн энэ бүлэгт багтах боловч элс бүхий нутгуудыг шүтэн тархсанаар онцлог. Монгол гүрвэл нууруудын хөндийн тойргийн нутаг дэвсгэрт оочин цоочин тархалттай хэдий ч оршин байгаа газартаа тоо толгойн хувьд элбэг. Харин төмөр гүрвэл, сум могой, нарийн могой зэрэг амьтад нууруудын хөндийн тойргийн зүүн талын зарим нутгаар тохиолдоно. Нарийн могой бол Монгол улсын Улаан номонд орсон ховор зүйл юм.

**Хоёр нутагтан.** Сүүлтэй хоёрнутагтны багийн шивэр гүлмэрийг Увс нуурын хотгорын Тэсийн голын савын нэг цэгээс тэмдэглэсэн. Энэ бол Улаан номонд орсон ховор амьтан юм. Харин сүүлгүй хоёрнутагтны багийн монгол бах нь нууруудын хөндийн тойргийн усан сангуудаар өргөн тархсан, тоо толгойн өндөр нягтшилтай зүйл болно.

**Загас.** Алтайн ар говийн цөлөрхөг мужийн гол, нуурт 2 баг, 3 овгийн 7 зүйл загас тэмдэглэв. Эдгээрээс спорт агнуурын ач холбогдолтой *Oreoleuciscus pewzowi*, *Oreoleuciscus potanini*, *Oreoleuciscus humilis*, *Thymallus brevirostris* зэрэг 4 зүйл бий. Эдгээр нь Төв Азийн унаган амьтад болохын хувьд генийн өвөрмөц санг хадгалсан амьтад мөн.

**Ландшафтын онцлог.** Эндэхийн байгалийн ландшафт олон янз, нарийн бүтэцтэй. Ландшафтын бүтэц нь мужийн ихэнх нутагт хотгоруудын шинж төрхөөс зарим районд уулсын шинж байдлаас шалтгаална.

Их Нууруудын хотгорт Алтай, Хангайн нурууны зарим салбар уулс гүн түрж орсон нь ландшафтын тархалт, хуваарилалтад зохих ёсоор нөлөөлжээ. Иймд уг хотгорын хүрээнд хотгорын ландшафтаас гадна өндөр уул, дундаж уул, нам уул, ухаа гүвээт талын ландшафт тодорхой нутагт тархах нөхцөл бүрджээ. Үүнтэй уялдан хотгорын ёроолоос уулын орой хүртэл ландшафтын тодорхой хэвшинжүүд өндрийн болон хотгорын бүсчлэл үүсгэн тархана. Эдгээрээс хотгорын дотоод дахь уулсын хүрээнд ялгарах ландшафтууд харьцангуй бага талбайд тархана. Эдгээр ландшафтын тархалтын өвөрмөц онцлог нь ихэнхдээ хөрс, ургамалжилтын онцлогтой уялдан тодорхой эрэмбээр хотгорын бүсчлэл

үүсгэдэгт оршино. Энэ нь ялангуяа Увс, Хяргас, Шарга зэрэг бэлэрхэг уулсаар хүрээлэгдэн бие биенээсээ тусгаарлагдсан цөлөрхөг хотгоруудад хамгийн тод илэрнэ.

Увс нуурын хотгор нь Их Нууруудын хотгорын хамгийн хойт хэсэгт, хамгийн нам түвшинд орших тул ландшафтын онцлог, газарзүйн байрлалын хувьд ихээхэн өвөрмөц нутаг юм. Энд Увс нуур өөрөө том талбай эзлэх төдийгүй нуурыг тойрсон элсэн хуримтлал, хужир мараа, нуга, намгийн цогцолборууд нийлээд харьцангуй томоохон талбайд тархах боловч хотгорын ёроолоос эхлэн уулын хормой хүртэл бүсийн чанартай ландшафтын хэд хэдэн хэвшинж ялгарах ажээ (Даш,1995). Нөгөө талаар Увс нуурын хотгор нь Төв Азийн хуурай цөлийн тархалтын хамгийн хойт хил болж улмаар эдгээр гандуу нутаг нь хужир мараа, нугын ландшафттай хоршин экологийн өвөрмөц орчныг бүрдүүлж байдаг. Түүнээс гадна хотгор нь тийм том биш учраас тэнд ялгарах байгалийн бүсүүд түүний шилжилт бага талбай эзэлж тод илэрдэг байна. Их Нууруудын хотгорын өмнөд хэсэгт орших Шаргын хотгор нь байрлал, хэмжээ, хотойлтын гүнээс шалтгаалан Увс нуурын хотгор болон ер нь Их Нууруудын хотгорын бусад хэсгээс илүү цөлөрхөг шинжтэй. Шаргын хотгор нь ерөнхийдөө өргөргийн дагуу суналтай, баруунаас зүүн тийшээ 150-160 км урт, хойноос урагшаа 70-80 км өргөн нэлээд гүн хотойсон хотгор юм.

Нөгөө талаар Шаргын хотгорын төв хэсгээр хайрга чулуут өмнөдийн цөлийн ландшафт тархсан нь түүний Их Нууруудын хотгор дотроо илүү гандуу хуурай болохыг гэрчилнэ. Өмнөдийн цөлөөс дээш бүсчлэл үүсгэх умардын цөлийн ландшафт нь Дөргөн нуурын баруун хэсгээр Хар нуурын дунд бие хүртэлх хэсэгхэн газарт зурвас байдлаар үргэлжлэх нь бий. Харин заримдаг цөлийн ландшафт нь Шаргын говиос хойш Хүйсийн говь, Зэргийн хотгорыг дамжин Хяргас нуурын хотгор хүртэл үргэлжилнэ. Түүнээс хойш Увс нуурын хотгорын баруун хэсгээр бүс дундын ландшафттай холилдон алаг цоог байдлаар тархах ажээ. Шаргын хотгорын дээд бэлээр нарийн зурвас байдлаар илрэх цөлжүү хээрийн ландшафт нь Их Нууруудын хотгорт хамгийн өргөн тархалттай нь юм.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР АШИГЛАЛТЫН БАЙДАЛ**

Увс аймаг 2013 оны газрын нэгдмэл сангийн ангиллаар нийт газар нутгийн хэмжээ /га/-аар 6958539 ,үүнээс ХАА-н зориулалттай газар 5258606.68 га буюу Увс аймгийн газрын нэгдмэл сангийн ангиллын 75.5 хувийг эзэлж байна. Хадлангийн зориулалтын бүс газар 16838.76 га буюу 0.32 хувийг, Газар тариалангийн эргэлтийн талбай 46556.94 га буюу 0.89 хувийг тус тус эзэлж байна.

**4.1. Малын тоо, толгой, өсөлт**


2013 оны эцэст 2225.1 мянган толгой мал үүний дотор 17.9 мянган тэмээ, 76.9 мянган адуу, 122.6 мянган үхэр, 1081.3 мянган хонь, 926.4 мянган ямаатай болж тэмээ 1,0 мянга, адуу 6.5 мянга, үхэр 14.6 мянга, хонь 105.3 мянга, ямаа 67.1 мянган толгойгоор таван төрөлдөө өсч, өнгөрсөн оноос нийт малын тоо 9.6 хувиар буюу 194.4 мянган толгойгоор нэмэгдсэн байна.

2013 онд 7.5 мянган сарлаг тоологдсон нь нийт үхэр сүргийн 6.1 хувийг эзэлж байна. Сарлагийн тоо өмнөх оныхоос 2.7 хувиар буюу 0.2 мянган толгойгоор өссөн байна

Үүнээс нийт малын дотор хонь 48.5 хувь, ямаа 41.6 хувь, үхэр 5.5 хувь, адуу 3.4 хувь, тэмээ 0.8 хувийг эзэлж, нийт малын тоо өмнөх оныхоос 8.7 хувь хэмжээгээр өссөн байна.

*Хүснэгт № 4.1. 2013 оны нийт малын тоог сумдаар авч үзвэл/ малын төрлөөр/*

Сумдын нэр	тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа	бүгд
Баруунтуруун	97	4142	5145	15613	17605	42602
Бөхмөрөн	109	2814	4712	41251	50973	99859
Давст	198	1023	4181	29327	29630	64359
Завхан	5973	4090	885	23721	48869	83538
Зүүнговь	617	4876	8301	47135	27758	88687
Зүүнхангай	71	6339	5627	59316	43630	114983
Малчин	466	3171	5386	74872	40166	124061
Наранбулаг	2144	3792	4875	85150	72488	168449
Өлгий	1374	1994	1808	29618	51231	86025
Өмнөговь	1082	3519	5379	70052	73431	153463
Өндөрхангай	293	7265	7921	66040	62469	143988
Сагил	178	3122	7144	57190	50688	118322
Тариалан	682	1506	3372	54507	41664	101731
Түргэн	251	1796	3121	43017	32082	80267
Тэс	2290	10297	24617	162061	62492	261757
Ховд	1024	3756	4829	31980	67768	109357
Хяргас	395	3424	4680	78260	52274	139033
Цагаанхайрхан	273	3471	2659	50109	54764	111276
Улаангом	373	6551	17967	62066	46428	133385
<b>Дүн</b>	<b>17890</b>	<b>76948</b>	<b>122609</b>	<b>1081285</b>	<b>926410</b>	<b>2225142</b>



Зураг№ 4.1. Малын тоо


Сумдыг бүсчлэн тооцож үзвэл баруун бүсэд нийт малын 31.6 хувь буюу 702.6 мянган мал, зүүн бүсэд 27.6 хувь буюу 613.5 мянган мал, өмнөд бүсэд 18.6 хувь буюу 412.8 мянган мал, хойт бүсэд 16.3 хувь буюу 362.8 мянган мал, төвийн бүсэд 6.0 хувь буюу 133.4 мянган мал тус тус ноогдож байна.

Нийт мал сүргийн 99.6 /2215.3 мянга/ хувь нь амины аж ахуйд, 0.4 хувь нь /9.8 мянган/ албан газарт ноогдож , амины малын тоо өнгөрсөн оноос 196.7 мянган толгойгоор өссөн байна.

2013 онд 27.4 мянган мал бүхий 190 өрх гадагш шилжсэн бөгөөд үүнээс Цагаанхайрхан сумаас 19 өрхийн 9.9 мянган мал, Тэс сумаас 27 өрхийн 5.1 мянган мал, бусад сумдаас 0.1 – 2.0 мянган мал гадагш шилжсэн байна. Гадагш шилжсэн малын тоо өнгөрсөн оноос 3.0 мянгаар их байна

Хүснэгт№ 4.2. Увс аймгийн нийт малын тоо/ сүүлийн 5 жилээр/ мян.толгой

Аймаг	2009	2010	2011	2012	2013
Увс	2319.1	1619.3	1831.8	2030.7	2225.1



Зураг№ 4.2. Малын тоо, толгойн өсөлт

Увс аймгийн 2013 оны малын тоо толгой 2012 онтой харьцуулахад 194.4 мян.толгойгоор өссөн дүн гарсан байна. 2010 онд 1619.3 мян толгой хүртэл буурсан байна.Үүнээс адуу 76.9мян толгой, үхэр 122.6.мян толгой, тэмээ 17.8 мян толгой, хонь 1081.2 мян толгой, ямаа 926.4 мян толгойг эзэлж байна.



Хүснэгт№ 4.3. Мал сүргийн өсөлтийн чиг хандлага

Он	Бүгд мал мян.толгой			Бүгд хонин.толгой			Бэлчээрийн даац, %		
	2009-2012	2013-2016	2017-2020	2009-2012	2013-2016	2017-2020	2009-2012	2013-2016	2016-2020
Увс	3839.2	4811.5	5783.8	5310812	6570460	7830108	106.8	132.1	157.4

Эх үүсвэр: \*- ББХЕТөлөвгөө


Бэлчээрт хөнөөл учруулж буй үлийн цагаан оготнотой тэмцэх, мөн царцаа их тархсан тус аймагт байгаль орчинд халгүй буюу энгийн механик аргаар зохион байгуулах шаардлагатай байна.

Мөн цаашид усжуулах бэлчээр болон бэлчээр усжуулалтыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4.1.1. Эрчимжсэн мал аж ахуй

Цэвэр үүлдэр болон эрлийз, нутгийн шилдэг омгийн малын тоо

Эрчимжсэн фермерийн аж ахуй. Хот суурин газрын хүн амыг аюулгүй хүнс, тэжээлээр хангах хэрэгцээ шаардлагын улмаас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх талаар төр засгаас ихээхэн анхаарч байгаа билээ. Үүнтэй холбоотойгоор сүүлийн жилүүдэд эрчимжсэн фермерийн аж ахуйн тоо нэлээд нэмэгдэж, энэ чиглэлийн бизнес эрхлэгчдийн тоо өссөөр байна.



Зураг№ 4.3. Увс аймгийн эрчимжсэн МАА эрхлэх бүс нутаг

Нутгийн шилдэг омгоос гадна гадаадын үүлдэр сайтай малыг үржүүлэх буюу сайжруулагчаар ашиглах, нутгийн үүлдэрийнхээ удмын санд түшиглэн экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх асуудлыг бэлчээр ашиглалттай уялдуулан мал аж ахуйг аль болох зохистой хэмжээнд байлгах нь зүйтэй юм.

Үүний тулд томоохон хот суурингийн сүү-махны хэрэгцээг хангахын тулд хот суурингийн эргэн тойронд дунджаар 25 км-ээс дотогш зайд 50 үнээтэй сүүний фермерийн аж ахуйг байгуулах, мөн түүнчлэн хадлан, бэлчээрийн нөөц сайтай, дэд бүтцийн боломжтой нутгуудад махны чиглэлийн үхрийн аж ахуйг хөгжүүлэн зах зээлд борлуулснаар хөдөө аж ахуйн дотоодын бүтээгдэхүүний өсөлтийг хангах боломжтой гэж үзэж байна.

Эрчимжсэн мал аж ахуйн газрын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд бэлчээрийн зүйлийн бүрэлдэхүүнийг аль болох уураг ихтэй ургамлаар олшруулах, царгас, хошоонгор, тэжээлийн бусад үет ургамлуудыг тарих, хүнс ба малын тэжээлийн хосолмол зориулалттай ургамлыг тарих шаардлагатай.

*Хүснэгт № 4.4. Сүүний фермерийн аж ахуйн тоо*

Аймгийн нэр	Томоохон хотуудын нэр	Хүн ам /мян.хүн/	Жилийн дундаж сүүний хэрэглээ	Нэг үнээнээс авах ашиг шим /мян.литр/	Шаардагдах үнээ	Фермерийн тоо
Увс	Улаангом	25.2	5032.0	3.80	1324	26

2013 онд цэвэр үүлдрийн хонь 274.0 мянга, сайжруулсан үүлдрийн хонь 69.8 мянга, нутгийн шилдэг омгийн ямаа 124.0 мянга, сайжруулсан нутгийн үүлдрийн ямаа 71.4 мянга, нутгийн шилдэг омгийн адуу 12.5 мянга, цэвэр үүлдрийн үхэр 0.1 мянга, эрлийз үхэр 0,4 тоологдсон нь 2011 оныхоос цэвэр үүлдрийн хонь 13.9 мянгаар өсч, сайжруулсан нутгийн үүлдрийн хонь 2.4 мянгаар буурч, нутгийн шилдэг омгийн ямаа 20.7 мянга, нутгийн шилдэг омгоор сайжруулсан ямаа 39.3 мянга, шилдэг омгийн адуу 3.5 мянгаар тус тус өсчээ.

Цэвэр болон эрлийз, нутгийн шилдэг омгийн малын тоо								
	мян.тол						2013/2011	
	2007	2008	2009	2010	2011	2013	%	зөрүү
<b>Цэвэр үүлдрийн мал</b>	<b>435.2</b>	<b>311</b>	<b>390.7</b>	<b>270.475</b>	<b>260.2</b>	<b>274.1</b>	<b>105.4</b>	<b>13.9</b>
Үхэр			0.1	0.1	0.1	0.1	<b>128.2</b>	0.0
Хонь	435.2	311	390.6	270.4	260.1	274	<b>105.3</b>	13.9
Ямаа								
<b>Эрлийз мал</b>	<b>0.3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0.4</b>		
Үхэр	0.3	0	0	0	0	0.4		
Хонь								
Ямаа								
<b>Нутгийн шилдэг омгийн мал</b>	<b>195.9</b>	<b>164.9</b>	<b>135.5</b>	<b>94.2</b>	<b>112.3</b>	<b>136.5</b>	<b>121.5</b>	<b>24.2</b>
Үхэр								0.0
Хонь								0.0
Ямаа	180.5	150.2	123.4	83.3	103.3	124	<b>120.0</b>	20.7
Адуу	15.4	14.7	12.1	10.9	9	12.5	<b>138.9</b>	3.5
<b>Сайжруулсан нутгийн үүлдрийн</b>	<b>142.7</b>	<b>207.6</b>	<b>186.6</b>	<b>135.6</b>	<b>104.3</b>	<b>141.2</b>	<b>135.4</b>	<b>36.9</b>
Хонь	139.8	130.8	106.1	75	72.2	69.8	<b>96.7</b>	-2.4
Ямаа	2.9	76.8	80.5	60.6	32.1	71.4	<b>222.4</b>	39.3

тайлбар- \*2012 цэвэр эрлийз, нутгийн шилдэг омгийн малын тоо тоологдоогүй


Зураг№ 4.4. Цэвэр үүлдэр болон эрлийз, нутгийн шилдэг омгийн малын тоо

#### 4.2. Бэлчээрийн газрын ангилал.

Увс аймгийн газрын Байгалийн бэлчээр 4741725.59 га буюу 90.0 хувийг,үүнээс Өвөл, хаврын бэлчээр 1896690.236, Зун, намрын бэлчээр 2845035.354, хадлан 16838.76 га буюу 0.32 хувийг эзэлж байна.

Хүснэгт№ 4.5. Бэлчээрийн төрлөөр

№	Бэлчээрийн төрөл	Галбайн хэмжээ /мян.га/
1	Цэвэр бэлчээр	1554944.71
2	Чулуутай бэлчээр	2014281.044
3	Сөөгтэй бэлчээр	2145127.73
4	Довонтой бэлчээр	206796.88
5	Элс	3218.21
6	Хад асга	103689.21
7	Мөнх цас	16303.18
8	Сайр	9515.86
	Нийт	6053876.824



Зураг № 4.5. Бэлчээрийн төрх байдлын зураг

Хүснэгт № 4.6. Сумдын бэлчээрийн төлөв байдал, талбай /га/

№	Сум	Бэлчээрийн, талбай га	Үүнээс хэвийн	Чулуурхаг	Сөөгөрхөг	Довонтой	Эзлэх хувь, Хэвийн	Чулуурхаг	Сөөгөрхөг	Довонтой	Усны эвдрэл, гуу жалгатай	Элсний нүүдэлтэй	Хортхон мэргэчдийн нөлөөлөгтэй
1	Баруунтуруун	130875	0	43591	83954	3330	0.0	33.3	64.1	2.5	0	127068	
2	Бөхмөрөн	329595	0	153278	157573	18744	0.0	46.5	47.8	5.7	663		
3	Давст	322587	131472	36303	152652	2160	40.8	11.3	47.3	0.7	2		517
4	Завхан	406606	137182	12931	255804	689	33.7	3.2	62.9	0.2	1	64379	486786
5	Зүүнговь	199252	0		181585	17667	0.0	0.0	91.1	8.9	0	229709	
6	Зүүнхангай	229358	225203			4155	98.2	0.0	0.0	1.8	8		9196
7	Мэлчин	370586	163909	117913	84634	4130	44.2	31.8	22.8	1.1	1380	5400	
8	Наранбулаг	511474	67414	184103	220231	39726	13.2	36.0	43.1	7.8	15	930	
9	Өлгий	229996	120589	57132	52253	22	52.4	24.8	22.7	0.0	0	756	
10	Өмнөговь	272404	85402	78077	92707	16218	31.4	28.7	34.0	6.0	1	8000	
11	Өндөрхангай	382594	367654			14940	96.1	0.0	0.0	3.9	31		
12	Сагил	298855	0	112887	174778	11190	0.0	37.8	58.5	3.7	5		1900
13	Тариалан	229968	32957	122823	64054	10134	14.3	53.4	27.9	4.4	2009		
14	Түргэн	186142	84106	792	100119	1125	45.2	0.4	53.8	0.6	6		
15	Тэс	205327	59147		104795	41385	28.8	0.0	51.0	20.0	16923	9114	
16	Ховд	286325	12525	139061	120416	14324	4.4	48.6	42.1	5.0	579	2431	
17	Хяргас	312618	83962	181834	43689		26.9	58.2	14.0	1.0	37		
18	Цагаанхайрхан	358494	132123	147769	78602		36.9	41.2	21.9	0.0	0		
19	Улаангом	211545	99898	44582	31765	35300	47.2	21.1	15.0	16.7	730		

## Хүснэгт№ 4.7. Сумдын бэлчээрийн талхлагдлын байдал

№	Сум	Бэлчээрийн, талбай га	Үүнээс талхлагдсан	Дундзэрэг талхлагдсан	Багазэрэг талхлагдсан	Талхагдаагүй	Их талхлагдсан %	Дундзэрэг талхлагдсан %	Багазэрэг талхлагдсан %	Талхагдаагүй %	Худуг усны хүрэлээгүйгээс ашиглалтгүй, га	Алслагдсан га	Хад, аста, ян, сарьдг, га	Бусад шалтгаанаар бэлчээр ашиглах боломжгүй, га
1	Баруунтуруун	130875	6019	50706	2836	71314	4.6	38.7	2.2	54.5		32552		
2	Бөхмөрөн	329595	30995	1885	29592	267123	9.4	0.6	9.0	81.0			2412	1726
3	Давст	322587		22292	22292	278003	0.0	6.9	6.9	86.2				
4	Завхан	406606	689	61891	37548	306478	0.2	15.2	9.2	75.4		24858		
5	Зүүнговь	199252	11493	43406	10980	133373	5.8	21.8	5.5	66.9				
6	Зүүнхангай	229358	22056	35747	17341	154214	9.6	15.6	7.6	67.2				
7	Малчин	370586	19666	4283	23949	322688	5.3	1.2	6.5	87.1				
8	Наранбулаг	511474	12017	27006	39023	433428	2.3	5.3	7.6	84.7				
9	Өлгий	229996	34516	18329	15854	161298	15.0	8.0	6.9	70.1				
10	Өмнөговь	272404	16223	25348	24943	205890	6.0	9.3	9.2	75.6				
11	Өндөрхангай	382594	14940	30631	36457	300567	3.9	8.0	9.5	78.6		13398		
12	Сагил	298855	4472	7183	32821	254379	1.5	2.4	11.0	85.1		38679		
13	Тариалан	229968	12372	25735	22864	168997	5.4	11.2	9.9	73.5				
14	Түргэн	186142	221	15125	15346	155450	0.1	8.1	8.2	83.5				
15	Тэс	205327	13937	14162	19669	157558	6.8	6.9	9.6	76.7	3350			
16	Ховд	286325		13960	15356	257009	0.0	4.9	5.4	89.8			11935	2977
17	Хяргас	312618	4964	11907	18558	277189	1.6	3.8	5.9	88.7				
18	Цагаанхайрхан	358494	14579	51611	33095	259209	4.1	14.4	9.2	72.3				
19	Улаангом	211545	8900	26858	17879	157908	4.2	12.7	8.5	74.6				

## Хүснэгт № 4.8. Сумдын бэлчээрийн нөөц, хэрэгцээ, хүрэлцээ, даац

№	Сум	2002-2009 оны эхний малын дундаж тоо, бүгд	Үүнээс: Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Хонин толгойд шилжүүлбэл	Бэлчээрийн гэжээлийн хэрэгцээ, мянган тонн тэжээлийн нэгж (D)	100 га бэлчээрт оногдох хонин толгой	Бэлчээрийн нөөц, мянган тонн гэжээлийн:нэгж (S)	Дутагдаж, илүү гарч буй бэлчээрийн нөөц, мянган тонн гэжээлийн:нэгж	Бэлчээрийн даац %	Бэлчээрийн га-гийн ургац, ц/га
1	Баруунтуруун	33155	36	3205	3638	11900	14376	73494	24.2	56.2	21.3	-3.7	85.1	2.62
2	Бөхмөрөн	78995	80	2333	4193	32676	39713	112852	36.9	34.2	35.7	-2.7	93.0	1.75
3	Давст	65254	156	826	3813	29941	30518	87838	28.6	27.2	25.2	-4.7	84.4	1.26
4	Завхан	67509	4077	3498	794	18831	40309	124644	41.5	30.7	34.5	-7.9	81.4	1.37
5	Зүүнговь	96013	606	4869	7457	55442	27639	170601	56.0	85.6	52.2	-5.8	90.0	4.23
6	Зүүнхангай	113265	105	5508	4833	60796	42023	173667	57.1	75.7	51.7	-7.3	87.6	3.64
7	Малчин	124174	684	4061	4472	66609	48348	175899	57.7	47.5	54.3	-5.5	90.8	2.36
8	Наранбулаг	166539	2407	4940	4188	79112	75892	233577	76.8	45.7	70.4	-9.0	88.6	2.22
9	Өлгий	87196	1180	2207	1991	32062	49756	116596	38.3	50.7	33.3	-6.4	84.0	2.33
10	Өмнөговь	138522	932	4206	4841	66789	61754	193457	63.4	71.0	58.5	-7.3	88.9	3.46
11	Өндөрхангай	141211	482	7069	6809	65647	61204	223615	73.5	58.4	70.2	-5.8	92.4	2.96
12	Сагил	121837	224	2460	5839	58694	54621	164139	53.6	54.9	52.7	-3.1	94.5	2.85
13	Тариалан	127254	652	2332	4732	71767	47771	167334	54.7	72.8	53.6	-3.3	94.2	3.76
14	Түргэн	80583	501	1748	3550	43101	31683	111256	36.4	59.8	37.7	-0.1	99.7	3.27
15	Тэс	209060	1747	8185	21219	124989	52919	382844	125.4	186.5	130.2	0.0	100.0	10.23
16	Ховд	83916	727	3157	4221	24601	51211	127699	41.9	44.6	43.4	0.0	100.0	2.45
17	Хяргас	124968	462	4066	3689	68502	48249	171068	56.1	54.7	53.5	-4.7	92.0	2.76
18	Цагаанхайрхан	105403	317	3908	2789	47713	50676	144378	47.4	40.3	44.5	-4.6	90.6	2.00
19	Улаангом	129155	437	4654	14094	58723	51247	231044	75.5	109.2	72.9	-5.6	92.9	5.56703

Хүснэгт № 4.9. Сумдын 2002-2013 онд жилд дунджаар үйлдвэрлэсэн мал аж ахуйн бүтээгдэхүүн

№	Сум	Үйлдвэрлэсэн мах, бүгд, амьдын жингээр, тонн	Үүнээс: Тэмээний мах	Адууны мах	Ухрийн мах	Хонины мах	Ямааны мах	Үйлдвэрлэсэн махыг 2009оны зах зээлийн үнээр хувиарлалтгүйгээр	Үйлдвэрлэсэн тэмээний ноос, тонн	Адууны хөөвөр, хялгас, тонн	Ухрийн хөөвөр, хялгас, тонн	Хонины ноос, тонн
1	Баруунтуруун	703.9	1.1	130.8	188.5	194.3	189.1	1168.8	0.2	0.6	0.7	16.9
2	Бөхмөрөн	1371.0	2.4	95.2	217.3	533.6	522.4	2295.9	0.3	0.5	0.8	46.5
3	Давст	1126.4	4.6	33.7	197.6	489.0	401.5	1923.6	0.7	0.2	0.8	42.6
4	Завхан	1143.5	121.8	142.8	41.1	307.5	530.3	1748.7	17.2	0.7	0.2	26.8
5	Зуунговь	1872.3	18.1	198.7	386.4	905.4	363.6	3208.2	2.6	1.0	1.5	78.9
6	Зуунхангай	2024.0	3.1	224.8	250.4	992.9	552.8	3390.8	0.4	1.1	1.0	86.5
7	Малчин	2141.7	20.4	165.7	231.7	1087.8	636.0	3598.9	2.9	0.8	0.9	94.8
8	Наранбулаг	2780.9	71.9	201.6	217.0	1292.0	998.4	4585.4	10.2	1.0	0.8	112.6
9	Өлгий	1406.7	35.3	90.1	103.2	523.6	654.6	2281.1	5.0	0.4	0.4	45.6
10	Өмнөговь	2353.5	27.8	171.6	250.9	1090.7	812.4	3923.0	3.9	0.8	1.0	95.1
11	Өндөрхангай	2533.0	14.4	288.5	352.8	1072.1	805.2	4206.7	2.0	1.4	1.4	93.4
12	Сагил	2086.7	6.7	100.4	302.6	958.6	718.6	3536.9	0.9	0.5	1.2	83.5
13	Тариалан	2160.3	19.5	95.2	245.2	1172.1	628.4	3680.3	2.8	0.5	0.9	102.2
14	Түргэн	1391.0	15.0	71.3	184.0	703.9	416.8	2363.7	2.1	0.3	0.7	61.4
15	Тэс	4223.2	52.2	334.0	1099.6	2041.2	696.2	7381.1	7.4	1.6	4.2	177.9
16	Ховд	1444.7	21.7	128.9	218.7	401.8	673.7	2351.8	3.1	0.6	0.8	35.0
17	Хяргас	2124.4	13.8	165.9	191.2	1118.7	634.7	3563.8	1.9	0.8	0.7	97.5
18	Цагаанхайрхан	1759.3	9.5	159.5	144.5	779.2	666.7	2894.3	1.3	0.8	0.6	67.9
19	Улаангом	2566.5	13.1	189.9	730.4	959.0	674.2	4441.8	1.8	0.9	2.8	83.6

## Хүснэгт№ 4.9.-ийн үргэлжлэл

№	Сум	Ноолуур тонн	Үйлдвэрлэсэн ноос, ноолуурыг 2009оны зах зээлийн үнээр үнэлбэл, сая.төг	Үйлдвэрлэсэн сүү, мян.литр	Үүнээс: ингэний сүү	Гүүний айраг	Үнээний сүү	Хонины сүү	Ямааны сүү	Үйлдвэрлэсэн сүүг 2009онб зах зээлийн үнээр үнэлбэл, сая төг	Үйлдвэрлэсэн тэмээний шир, ш	Адууны шир, ш
1	Баруунтуруун	5.6	214.5	458.3	0.1	29.2	339.9	26.7	62.4	422.7	2	424
2	Бөхмөрөн	15.4	588.1	659.0	0.2	21.2	391.7	73.3	172.5	560.8	5	308
3	Давст	11.8	460.7	563.9	0.4	7.5	356.2	67.2	132.5	484.2	11	109
4	Завхан	15.6	660.1	334.8	11.4	31.8	74.2	42.3	175.1	253.6	279	463
5	Зүүнговь	10.7	469.8	987.2	1.7	44.3	696.7	124.4	120.0	890.2	41	644
6	Зүүнхангай	16.3	661.1	820.9	0.3	50.1	451.5	136.4	182.5	693.4	7	728
7	Малчин	18.7	766.7	816.1	1.9	37.0	417.8	149.5	210.0	673.3	47	537
8	Наранбулаг	29.4	1194.1	950.1	6.7	45.0	391.3	177.5	329.6	750.6	165	653
9	Өлгий	19.3	745.7	497.5	3.3	20.1	186.0	71.9	216.1	383.9	81	292
10	Өмнөговь	23.9	953.9	911.2	2.6	38.3	452.3	149.9	268.2	745.3	64	556
11	Өндөрхангай	23.7	936.8	1115.0	1.4	64.4	636.1	147.3	265.8	950.4	33	935
12	Сагил	21.1	830.6	937.5	0.6	22.4	545.5	131.7	237.2	790.2	15	325
13	Тариалан	18.5	765.1	833.6	1.8	21.2	442.1	161.0	207.5	687.2	45	308
14	Түргэн	12.3	502.6	583.3	1.4	15.9	331.7	96.7	137.6	490.3	34	231
15	Тэс	20.5	940.4	2572.2	4.9	74.5	1982.4	280.5	229.8	2370.5	120	1082
16	Ховд	19.8	746.2	702.7	2.0	28.7	394.3	55.2	222.4	592.7	50	418
17	Хяргас	18.7	763.1	746.3	1.3	37.0	344.7	153.7	209.5	601.6	32	538
18	Цагаанхайрхан	19.6	763.0	624.2	0.9	35.6	260.5	107.1	220.1	493.7	22	517
19	Улаангом	19.8	792.6	1714.7	1.2	42.4	1316.7	131.8	222.6	1573.6	30	615




## Хүснэгт № 4.9.-ийн үргэлжлэл.

№	Сум	Үхрийн шир, ш	Хонины арьс, мян.ш	Ямааны арьс, мян.ш	Үйлдвэрлэсэн арьс ширийг 2009оны зах зээлийн үнээр үнэлбэл, сая төг	Мал аж ахуйн нийт бүтээгдэхүүн, 2009оны үнээр сая төг	Нэг хонины толгойгоос үйлдвэрлэсэн мал аж ахуйн нийт бүтээгдэхүүн, төг	Нэг га бэлчээрээс үйлдвэрлэсэн мал аж ахуйн нийт бүтээгдэхүүн
1	Баруунтуруун	722	4.4	5.0	60.6	1866.6	25398	14263
2	Бөхмөрөн	832	12.0	13.8	135.2	3580.0	31723	10862
3	Давст	757	11.0	10.6	113.9	2982.4	33953	9245
4	Завхан	158	6.9	14.0	101.3	2763.8	22173	6797
5	Зүүнговь	1480	20.4	9.6	177.0	4745.3	27815	23815
6	Зүүнхангай	959	22.4	14.6	197.0	4942.2	28458	21548
7	Малчин	888	24.5	16.8	213.5	5252.5	29861	14173
8	Наранбулаг	831	29.2	26.4	276.1	6806.3	29139	13307
9	Өлгий	395	11.8	17.3	139.9	3550.6	30452	15438
10	Өмнөговь	961	24.6	21.5	234.3	5856.6	30273	21500
11	Өндөрхангай	1352	24.2	21.3	242.8	6336.6	28337	16562
12	Сагил	1159	21.6	19.0	210.7	5368.4	32706	17963
13	Тариалан	939	26.4	16.6	221.0	5353.5	31993	23280
14	Түргэн	705	15.9	11.0	140.2	3496.9	31431	18786
15	Тэс	4212	46.1	18.4	400.1	11092.1	28973	54022
16	Ховд	838	9.1	17.8	138.0	3828.7	29982	13372
17	Хяргас	732	25.2	16.8	213.6	5142.2	30059	16449
18	Цагаанхайрхан	554	17.6	17.6	174.8	4325.9	29962	12067
19	Улаангом	2798	21.6	17.8	241.9	7049.8	30513	33325

## 4.2.1. Бэлчээр усжуулалтын байдал.

Увс аймгийн ихэнхи сумдын бэлчээрийн даац хэтэрсэнээс бэлчээр ихээр талхлагдаж цөлжиж байна. Тус аймгийн бэлчээр усжуулалтын хувьд говийн бүсийн аймгуудыг бодвол харьцангуй сайн хэдий ч 2014 онд нийт 500 гаруй худаг ашиглагдаж байна.



Зураг № 4.6. Увс аймгийн бэлчээр усжуулалтын зураг /УГЗБЕТ-өөс/

Хүснэгт № 4.10. Увс аймгийн худгийн тоо

Д/д	Сумын нэр	Худгийн тоо	Зориулалт
1	Баруун-туруун	14	Бэлчээрийн усан хангамж
2	Бөхмөрөн	11	Бэлчээрийн усан хангамж
3	Давст	7	Бэлчээрийн усан хангамж
4	Завхан	34	Бэлчээрийн усан хангамж
5	Зүүнговь	20	Бэлчээрийн усан хангамж
6	Зүүнхангай	8	Бэлчээрийн усан хангамж
7	Малчин	49	Бэлчээрийн усан хангамж
8	Наранбулаг	28	Бэлчээрийн усан хангамж
9	Өлгий	36	Бэлчээрийн усан хангамж
10	Өмнөговь	80	Бэлчээрийн усан хангамж
11	Өндөрхангай	25	Бэлчээрийн усан хангамж
12	Сагил	11	Бэлчээрийн усан хангамж
13	Тариалан	12	Бэлчээрийн усан хангамж
14	Түргэн	13	Бэлчээрийн усан хангамж
15	Тэс	21	Бэлчээрийн усан хангамж
16	Ховд	16	Бэлчээрийн усан хангамж
17	Улаангом	10	Бэлчээрийн усан хангамж

Увс аймаг нь 2012 оны байдлаар бэлчээр усжуулалтын нийт 312 худаг тоологдож бүртгэгдсэнээс хамгийн их худагтай сум Малчин сум, хамгийн цөөн худагтай сум Давст сум байна.

## Хүснэгт № 4.11. Увс аймгийн доройтолд орсон, нөхөн сэргээх арга хэмжээ авах шаардлагатай газрын судалгаа/

№	Сумын нэр	Доройтолд орсон нийт талбай / га /	Хөдөө аж ахуйн газар бүгд /га /	Үүнээс		Хот тосгон бусад суурин газар бүгд / га/	Үүнээс / га /-аар		Ойн сан бүхий газар бүгд	Үүнээс /га /-аар		Усан сан бүхий газар	Үүнээс	
				Бэлчээрийн газарт	Тариалангийн талбай		Ургамалын бүрхэвчгүй болж цөлжиж буй газар	Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаас бохирдсон		Мод бут сөөгийг устгасан	Өвчин, шавьжид нэрвэгдэж түймэрт өртсөн		Ашигт малтмалын олборлолтоос эвдрэлд өртсөн эрэг хавийн газар	Гадаргын болон гүний ус бохирдсон
1	Баруунтуруун	15801.54	14960	13400	1560	13.04	5.44	7.6	828.5	39.5	789	0	0	0
2	Бөхмөрөн	2212	2100	2100	0	84.6	22.3	62.3	15	0	15	12.4	12.4	0
3	Давст	26285.1	25978.7	25226	752.7	72.4	60	12.4	214	120	94	20	20	0
4	Завхан	98067.7	98000	98000	0	67.7	62	5.7	0	0	0	0	0	0
5	Зүүнговь	98088.7	98079.3	98000	79.3	9.4	6	3.4	0	0	0	0	0	0
6	Зүүнхангай	18306.16	18280	18280	0	26.16	8.6	17.56	0	0	0	0	0	0
7	Малчин	7113.77	7087.5	7087.5	0	8.4	0	8.4	0	0	0	17.87	17.87	0
8	Наранбулаг	10081.35	10014.2	10000	14.2	61.4	45.6	15.8	0	0	0	5.75	5.75	0
9	Өлгий	305.69	179.26	167.26	12	126.43	111.62	14.81	0	0	0	0	0	0
10	Өмнөговь	15040.2	15000	15000	0	13.9	12.3	1.6	0	0	0	26.3	26.3	0
11	Өндөрхангай	57327.1	56650	56650	0	50.6	48.1	2.5	626.5	10	616.5	0	0	0
12	Сагил	44678.6	44275	44200	75	13.6	8	5.6	200	40	160	190	190	0
13	Тариалан	9896.37	9774.37	8800	974.37	112	26	86	0	0	0	10	10	0
14	Түргэн	53309.46	53136.1	52810.5	325.6	96.65	12	84.65	76.71	70.91	5.8	0	0	0
15	Тэс	1649.96	113	113	0	36.96	21.6	15.36	1500	1500	0	0	0	0
16	Ховд	18329.26	18300	18300	0	17.26	10.96	6.3	0	0	0	12	12	0
17	Хяргас	492.3	462.3	20	442.3	15	10	5	10	10	0	5	5	0
18	Цагаанхайрхан	13070.2	13000	13000	0	6.3	1.5	4.8	58.5	13.5	45	5.4	5.4	0
19	Улаангом	6398.31	3227.31	2865	362.31	1676	162	1514	1495	1495	0	0	0	0
20	Дүн	496453.77	488617.04	484019.26	4597.78	2507.8	634.02	1873.78	5024.21	3298.91	1725.3	304.72	304.72	0

## Хүснэгт№ 4.12. Увс аймгийн бэлчээрийн газрын доройтолд орсон, нөхөн сэргээх шаардлагатай газрын судалгаа

дд	Сумын нэр	Газрын байршил	Бэлчээрийн газарт	Доройтлын хэлбэр			Цаашид авах арга хэмжээ
				Талхлагдсан	Цөлжиж буй	Хортон, мэргэчид өртсөн	
1	Баруунтуруун	Алтан элсний хаяа дагуу замын орчин,	13400		13400		Түр хугацаагаар чөлөөлөх, усжуулах, олон наст, ойн зурвас тариалах
2	Бөхмөрөн	Алтан гадасны хэв, уушгийн улаан орчим	2100	2100			Усжуулах, сэлгэж ашиглах.
3	Давст	Хатуугийн уул, Уу ширэг, Бэд, хандгайт, торхилогын голын орчим	25226	12320	5260	7646	Сэлгэж ашиглах, түр хугацаагаар чөлөөлөх, хортон мэргэчидтэй тэмцэх
4	Завхан	Зогсоо хайрхан, завхан голын хөндий	98000	43335	52300	2365	Сэлгэж ашиглах, түр хугацаагаар чөлөөлөх, хортонтой тэмцэх
5	Зүүнговь	Хойд, дунд худаг, гурамсан, Баян голын эх, Урт булгын дэл, Зүүн хөдөө, харгант, Цагаан гол, Урд сай Шар толгой	98000	10900	85900	1200	Сэлгэж ашиглах, түр хугацаагаар чөлөөлөх, хортонтой тэмцэх
6	Зүүнхангай	Хацавчийн уул, баян овоо орчим	18280	12000		6280	Түр хугацаагаар чөлөөлөх, хортонтой тэмцэх
7	Малчин	Хяргас нуурын замын дагуу	7087.5	7087.5			Сэлгэж ашиглах, түр хугацаагаар чөлөөлөх.
8	Наранбулаг	Улаанууд, Балцгарын хөдөө	10000	5500	4500		Бэлчээрийн даацыг тогтоож малын хөлөөс чөлөөлөх.
9	Өлгий	Хашгаал, Нарийн	167.26		167.26		Ойн зурвас байгуулах,
10	Өмнөговь	Хүйтэн хөндий, ногоон нуур, туулай хар уулын орчим	15000	15000			Бэлчээрийн даацыг тогтоож малын хөлөөс чөлөөлөх.
11	Өндөрхангай	Дахилт, Залаа хөх, Нуурын түнгэ, Үхэр чулуут	56650	47748	1250	7652	Сэлгэж ашиглах, түр хугацаагаар чөлөөлөх, хортон, мэргэчидтэй тэмцэх
12	Сагил	Харигын зүүн баруун хөдөө, Сагилын голын зүүн баруун хөвөө, Эргэнэг, Баруун дардаа	44200	18550	2650	23000	Сэлгэж ашиглах, түр хугацаагаар чөлөөлөх, хортон, мэргэчидтэй тэмцэх
13	Тариалан	Адаргана, Хотгор, Шилийн бөгс	8800	7565		1235	Сэлгэж ашиглах, түр хугацаагаар чөлөөлөх, хортонтой тэмцэх
14	Түргэн	Бүгийн хэв, Цагаан эрэг, Довжоот, Улаан бураа, Хээр морьт, Бортын бөгс Таван хар	52810.5		38010.5	14800	Сэлгэж ашиглах, түр хугацаагаар чөлөөлөх, хортон, мэргэчидтэй тэмцэх
15	Тэс	Орлого, Бадаа, Цагаан булан, Үмхийн гадар, Завсрын цагаан	113	113			Бэлчээрийн даацыг тогтоож малын хөлөөс чөлөөлөх.
16	Ховд	Шивээрийн гол, олон нуур, ачит нуурын хөвөө	18300		13070	5230	Түр хугацаагаар чөлөөлөх, хортон, мэргэчидтэй тэмцэх
17	Хяргас	Тагийн булаг	20			20	Хортонтой, Мэргэчидтэй тэмцэх
18	Цагаанхайрхан	Шийрийн гозгор, Хөндлөн уул орчим	13000		10440	2560	Бэлчээрийн даацыг тогтоож малын хөлөөс чөлөөлөх. хортон, мэргэчидтэй тэмцэх
19	Улаангом	Шатат, Арсай, Хустын өвдөг, Хөндлөн бор нурган, Довны ферм	2865	1045	620	1200	Түр хугацаагаар чөлөөлөх, усжуулах, олон наст, ойн зурвас тариалах, хортон, мэргэчидтэй тэмцэх
20	Дүн		484019.26	183263.5	227567.76	73188	

**4.2.2. Бэлчээр хадлангийн газарт гарсан хохирлын байдал**

Увс аймгийн бэлчээрийн газрын нийт талбай 5528514.76 га үүнээс нөлөөлд орсон бэлчээрийн талбай 1700709.6 га байна.

*Хүснэгт№ 4.13. Нөлөөлд орсон бэлчээрийн талбай (га)*

№	Нийт бэлчээрийн талбай	Нөлөөлд орсон бэлчээрийн талбай	Үүнээс			
			Талхлагдсан	Үүнээс		Талхлагдсан бэлчээрийн нийт бэлчээрт эзлэх хувь
				их	дунд	
1	5258607	1700709.6	716124	228059	488065	12.9

*Хүснэгт№ 4.14. Бусад нөлөөлд орсон бэлчээрийн талбай (га)*

№	Нөлөөлд орсон бэлчээрийн талбай /га/	Үүнээс					
		Салхи, усны эвдрэлд орсон	Гуу жалгагай	Элсний нүүлтэд орсон	Мэргэгчид, хортон шавьжид идэгдсэн	Автогенийн нөлөөнд орсон	Бохирдсон
1	5258607	22335.4	949.3	447801	498399	12030	3058

Бэлчээрийн газрын талхлагдалд оруулж байгаа гол шалтгаан нь худаг ус байхгүй, байгалийн гол горхи ширгэсний улмаас малтай иргэд гол, нугын болон усаа бараадан хэт бөөгнөрч бууснаас, мөн бэлчээр ашиглалтын хугацаа уртссан, зуслан нутгийн хувиарлалт нь малын бөөгнөрөл ихтэй /задгай ус ба устай цэг барааддаг/, зохицуулалтгүй, бэлчээрийн ургамлыг бэхжүүлэхгүйгээр мөлждөг, бэлчээрийн хоногийн тоо урт /хаврын дунд үеэ намар цас ортол/ хүртэл нэг газраа байнга байх, хот суурин газрын орчимд малын бөөгнөрөл ихэссэн, автогений болон техногений нөлөөлөл их, ойт хээрийн бүсэд улирлын бэлчээрийн хувиар алдагдаж нүүж нутаг сэлгэх, отор хийхээ больсон, өндөр уулын бүсэд царцааны гаралт ихэссэн, мал өссөн, тал хээр, говийн бүсэд огтоно, хулганы хөнөөл, бий болсноос голлон шалтгаалж байна. Харин өвөлжөөний хавийн бэлчээр доройтолд орох нь харьцангуй бага. Энэ нь ашиглалтын хугацаа богинотой /цасан бүрхүүлтэй/, өвс ургамал мөн хөрс малын хөлд нэрвэгддэггүй/цасан жийрэгтэй/, ургамлыг биежсэн хойно /фотосинтез харьцангуй идэвхитэй/ мал бэлчээрлэдэг, хамгийн онцлог нь өвөлжөөний бэлчээр уламжлал ёсоор бараг хувийнх шиг хамгаалагддаг. Мөн уулархаг буюу талбай ихтэй /монгол хүний ойлголтоор уул мөлжүүртэй/ зэрэг онцлогт оршино.

Бэлчээр нутгийг зөв зохистой эдэлж ашиглахад:

- 1.Бэлчээрийн даацыг үл хэтрүүлэх
- 2.Тэжээлийн нөөцийг шавхахгүй
- 3.Ургамалд нөхөн төлжих хугацаа олгох
- 4.Сэлгэж ашиглах зэрэг үндсэн зарчмыг баримтлах шаардлагатай байна.

### 4.3. Хадлан, тэжээлийн байдал


Мал аж ахуйн тэжээлийн баазыг бэхжүүлэхэд хадлан онцгой чухал ач холбогдолтой. Тус аймгийн нутаг дэвсгэр нь өндөр уул элбэгтэй, уулс хоорондын өргөн, нарийн хөндий нь цөлөрхөг хээрийн ба цөлийн тачир сийрэг учраас хадланг дуртай газраасаа бэлтгэх боломжоор хязгаарлагдмал, энд тэнд алаг цоог жижиг жижиг талбайг энгийн аргаар усжуулан хаддаг.

Хүснэгт№ 4.15. Хадлангийн газар /мян.га/ 2013 оны байдлаар

№	Сумдын нэр	ХАА газар дахь хадлан	ТХГ газар дахь хадлан	Тэжээлийн ургамал тариалсан талбай
1	Баруунтуруун	1190		30
2	Бөхмөрөн	1762	1200	1
3	Давст	203.2		3
4	Завхан	30		
5	Зүүнговь	375.5		
6	Зүүнхангай	1088		4
7	Малчин	217.5		
8	Наранбулаг	306		
9	Өлгий	14		5
10	Өмнөговь	305		35
11	Өндөрхангай	1326.75		39.1
12	Сагил	387		9.3
13	Тариалан	1929.73		
14	Түргэн	1629		215
15	Тэс	3050	8741	
16	Ховд	411		8
17	Хяргас	565		6.5
18	Цагаанхайрхан	413.8		
19	Улаангом	1635.28		
Дүн	Бүгд	<b>16838.76</b>		<b>355.9</b>

Увс аймгийн ХАА газар дахь хадлангийн нийт хэмжээ **16.8** мян.га байна. Үүнээс тусгай хэрэгцээний газар дахь хадлангийн хэмжээ **9.9** мян.га байна. Хадлангийн голлох нутаг бүхий сум Тэс 3050 га, Тариалан 1929.7 га, Бөхмөрөн 1762 га, Баруунтуруун 1190 га, Түргэн 1629 га, Улаангом 1635га сумд юм.


Зураг№ 4.7. Хадлангийн талбай



Хүснэгт № 4.16. Бэлтгэсэн тэжээл, нэр төрлөөр /мян.тонн/

Тэжээлийн төрөл	Тэжээл бэлтгэсэн он, хэмжээ /т/					2012/2013
	2009	2010	2011	2012	2013	
Байгалийн хадлан	43.2	48	53.1	51.8	53.9	104.1
Сүрэл	0.8	0.7	3.2	0.4	0.4	100.0
Ногоон тэжээл	0.3	0.8	1.6	0.6	0.6	100.0
Гар тэжээл	1.8	1.6	2.5	1.9	2.2	115.8
Эрдэс тэжээл	0.1	0.1	0.02	0.4	2.1	20.0
Үйлдвэрлэсэн тэжээл бүгд /тэж.нэгж/	25.7	27.4	31.8	27.8	27.6	99.3
Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ноогдож буй тэжээл	7.9	11.5	11.9	9.4	8.4	89.4

Зураг № 4.8. Бэлтгэсэн хадлан, гар тэжээл.



2013 онд аймгийн хэмжээгээр тэжээлийн нэгжид шилжүүлснээр 27.6 мянган тонн тэжээл үйлдвэрлэсэн нь өмнөх оныхоос 0.7 хувиар буюу 0.2 мянган тэжээлийн нэгжээр буурсан байна.

2013 онд хонин толгойд шилжүүлсэн нэг малд аймгийн дунджаар 8.4 кг тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээл ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1.0 кг-аар буурсан байна. Судалгаагаар Увс аймгийн 19 сумаас хадлангийн талбай багатай сум байгаа нь Завхан, Өлгий сумд бөгөөд 2013 оны газрын нэгдмэл сангийн тайлангаар тус сум 30га, 14 га хадлантай гэж бүртгэгдсэн байна. Аймгийн хадлангийн талбайн (фондын хадлан тооцохгүйгээр) 75.4% нь 7 сумын нутагт төвлөрсөн байдаг нь аймгийн хадлангийн талбайн байршилд жигд бус Баруунтуруун, Тэс, Өндөрхангай, Улаангом зэрэг сумууд хангалттай хадлангийн талбайтай байхад Завхан, Өлгий, Өмнөговь, Наранбулаг сумууд хадлангүй юмуу маш бага хадлантай байна. Увс аймгийн хадлангийн газрууд нь ихэнхдээ гол горхийн сав дагуу болон тэдгээрийн нуурт цутгаж дельт үүсгэдэг хэсгүүдээр голлон байрласан байдаг тул ихэнхийг нь услах боломжтой.

Ус чийг хэт ихтэй газар байрласан хадлангийн газруудын ургамлын бүтэц төдий л сайн биш суан, шагшуурга, шимт тэжээлээр тааруу идэмж муутай ургамал голлодог. Энэ байдал ялангуяа Тэс сумын хадлангийн талбайн ихэнхэд ажиглагдаж байдаг тул тэнд

бэлтгэсэн хадлан зарим талаар борлуулалт муутай байх нь бий. Иймээс дээрхи нууруудад хадлангийн талбайн үндсэн сайжруулалт хийх шаардлагатай.

Мөн хадлангийн талбайн ашиглалт жигд сайн биш, услахаас өөр тордолт сайжруулалтын арга хэмжээ авдаггүй, хадлангийн газар багатай сумууд талбайгаа жил өнжөөхгүй хаддаг, хадах хугацааг жил жилд өөрчилдөггүй өөрөөр хэлбэл хадланг ургамлын вегетацын өөр өөр хөгжлийн шатанд хадах замаар олон наст ургамалд үр унагах бололцоо олгодоггүй зэрэг нийтлэг дутагдалтай байна.

#### 4.3.1 Хадлангийн газрын байршил, түүний нөөц

Хүснэгт № 4.17. Хадланд тохиромжтой газрын нөөц

Хадланд тохиромжтой газар /мян.га/	Үүнээс мян.га				
	Байгалийн хадлан	Үүнээс		Усалгаат хадлан	Бэлчээрээс хадах
		Сайжруулалт хийх	Сайжруулалт хийх		
49.7	7.8		41.6	10.1	0.4

Увс аймгийн нийт нутаг дэвсгэрийн хадланд тохиромжтой газар 49.7мян.га байна. Үүнээс байгалийн хадлан 7.8 мян.га, усалгаат хадлан 41.6 мян.га, бэлчээрээс хадах 0.4 мян.га байна. Усалдаг хадлангийн талбайг бууцаар бордох нь ургамлын ногоон массыг нэмэгдүүлдэг боловч хадлангаа бууцаар бордох ажил бараг хийдэггүй байна. Хадлангийн талбайгаа хашиж хамгаалах, услах явдал ихэнх сумаар хэвшил болж байгаа нь хадлангийн газрын ашиглалт, хамгаалалтанд гарч байгаа дэвшилттэй сайн тал болно

Усалгаагүй буюу байгалийн хадлан бүхий сумдад Зүүнговь, Түргэн, Малчин, Тариалан, Наранбулаг, Баруунтуруун, Хяргас, Зүүнхангай, Бөхмөрөн, Өндөрхангай, Цагаанхайрхан, Завхан, Тэс, Өмнөговь, Сагил, Түргэн бүхий сумд орно. Харин усалгаатай хадлан бүхий сумдад Тариалан, Бөхмөрөн, Тэс, Өмнөговь сумд орно. Бүсийн хувьд усалгаагүй хадлангийн дийлэнх нь Увс аймагт байдаг бөгөөд 48836.8 га хадланд тохиромжтой газар, 677 га бэлчээрээс хадах боломжтой газартай.

Хүснэгт № 4.18. Хадлангийн талбай, бэлтгэсэн өвсний хэмжээ

Аймаг, бүсийн нэр	Хадлангийн газар. мян га		Эзлэх хувь	2012 онд бэлтгэсэн өвс мян тонн	Га-ийн ургац кг-аар
	2000-2011	2012 он ГНСТ			
Увс	16.4	16.6	29.4	53.1	3126.5

Га-аас авах ургацын хэмжээ 31кг байна. Усалгаатай болон усалгаагүй хадлангаас авах тэжээлийн нөөцийн хэмжээг доорхи хүснэгтээр харуулав.

Хүснэгт № 4.19. Усалгаагүй хадлангийн тэжээлийн нөөц /хуурай өвс/

№	Аймгийн нэр	Тэжээл.нөөц бүгд Мян.тн	Үүнээс: мян.тн	
			Хадлан	Үүнээс
				Сайжруулалт хийсэн
1	Увс	48400.0	46800	1600.0

Хүснэгт № 4.20. Усалгаатай хадлангийн тэжээлийн нөөц /хуурай өвс/

№	Аймгийн нэр	Тэжээл.нөөц бүгд Мян.тн	Үүнээс: мян.тн	
			Усалгаатай хадлан	Үүнээс
				Сайжруулалт хийсэн
1	Увс	83200	62400	202.0



Энэ нь хадлангийн газрын ашиглалт бүсээр эрс ялгаатай, зүүн бүсээс бусад бүсэд жил бүр ихээхэн хэмжээний бэлчээрийн газрыг хадланд ашиглаж, бэлчээрт учруулах дарамтыг улам бүр нэмэгдүүлж байна.

#### **4.3.2. Бэлчээр, хадлангийн газрын хамгаалалт**

Увс аймгийн 2013 оны ГНС-ийн тайлангаас үзвэл бэлчээр, хадлангийн газрыг хамгаалах, нөхөн сэргээлтэд хамрагдсан талбайн хэмжээ 237805.0 га байна.

Газрын нэгдмэл сангийн ангилалд бүртгэгдсэн хадлангийн талбай бүрийн төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгүүлж, цаашид хадлан авах бололцоотой талбайг шинэчлэн тогтоож, аймгийн тусгай хэрэгцээнд авна.

Тэжээлийн нэг ба олон наст ургамал, уургийн агууламж ихтэй шинэ төрлийн таримал тариалах ажлыг бүх талаар нь хөхүүлэн дэмжих.

Аймаг, сум бүрт цаг агаарын нөхцөл хүндэрсэн үед ашиглах зориулалт бүхий өвс, тэжээлийн нөөцийн сан бий болгох.

Орон нутгийн түүхий эдэд тулгуурласан бага оврын тэжээлийн үйлдвэр байгуулах замаар малын тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх.

Инженерийн хийцтэй услалтын системүүдийг төслийн хүчин чадалд хүргэж, ашиглалтыг сайжруулах.

Шинээр инженерийн хийцтэй услалтын систем барьж малын тэжээл тариалалтыг нэмэгдүүлэх.

Гарах үр дүн: Хадлангийн талбай, олон настын тариалалт нэмэгдэж малын тэжээлийн үйлдвэрлэл, услалтын системийн хүчин чадлыг нэмэгдүүлснээр малын эрсдэл даах чадвар нэмэгдэж малын хорогдол багасана.

Хадлангийн талбайг тордож сайжруулдаггүй, хашиж хамгаалдаггүй, тодорхой эзэнд удаан хугацаагаар эзэмшүүлэхгүй байгаагаас ургац нь муудаж, хадлан хадах бололцоотой талбайн хэмжээ жилээс жилд багасаж байна.


#### 4.4. Тариалангийн газрын ашиглалт

Увс аймаг 13086.94 га тариалангийн газартай гэж бүртгэгдэж явагдагч гэсэн үүний ихэнх хэсэг нь “Өнжөөсөн” нэрээр атаржаад байгаа газар болно. Увс аймаг 1990 оноос өмнө 50 гаруй мянган га тариалангийн газартай байсан ба өөрийн аймаг төдийгүй бусад хэд хэдэн аймгийг гурилаар хангаж байжээ. Гэвч 1990-ээд оны эхэн үеэс энэ боломжоо алдаж одоо гурилынхаа хэрэгцээг ОХУ болон БНХАУ-аас импортоор хангаж байна. Одоогийн байдлаар Увс аймаг нь 9478.5 га газрыг тариалангийн зориулалтаар ашиглаж байна.

Хүснэгт № 4.21. Аймгийн тариалангийн газрын ашиглалтын байдал (га) 2013 оны байдлаар

Үзүүлэлт		Увс
Тариалангийн газар, бүгд /га/		<b>9478.5</b>
1	Тариалсан талбай	2755.4
Үүнээс	Үр тариа	1382.8
	Төмс, хүнсний ногоо	469.3
	Тэжээлийн ургамал	132.8
	Таримал ургамал, жимс жимсгэнэ	770.5
	Усалгаатай тариалан	2766
2	Уриншилсан газар	-
3	Өнжөөсөн талбай	6723
4	Атаршсан газар	35801

Зураг № 4.9. Тариалангийн талбайн байршил



Аймгийн тариаланд ашиглаж байгаа талбайн 85.7 хувь буюу 39938.3 га нь Баруунтуруунд, 3.1 хувь буюу 1460.6 га нь Улаангом суманд, 3.5 хувь буюу 1667.5 га нь Тариалан суманд, 2.6 хувь буюу 1233.4 га нь Сагил суманд, 1.1 хувь буюу 514.3 га нь Түргэнд, 0.7 хувь буюу 356.6 га нь Давст, 0.8 хувь буюу 416.2 га нь Хяргас суманд байна. Бусад суманд тариалангийн газар харьцангуй бага байна.

**4.5. Усалгаатай тариалангийн газрын судалгаа***Хүснэгт№ 4.22. Увс аймгийн инженерийн хийцтэй услалтын системийн судалгаа*

Сумын нэр	Усалтын системийн нэр байршил	Системийн хийц энгийн болон инженерийн бороожуулагчийн төрөл	Зориулалт хадлан бэлчээр үр тариа тэжээл жимс г.м	Ашиглалт анд орсон он	Талбайн хэмжээ га	Зонхилж байсан таримлын нэр	Тариалж байсан таримлын нэр
Баруунтуруун	Баруунтуруу	ферегат	Үр тариа тэжээл	1980	1909	буудай	Буудай царгас
Давст	Давст	МАА	Үр тариа тэжээл	1980	150	тэжээл	Тэжээл
Зүүнговь	Хар бураа	ваджанк	тэжээл	1983	128	тэжээл	Тэжээл
Малчин	Улаанбулаг	ДДН-70	тэжээл	1984	74	тэжээл	Тэжээл
Наранбулаг	Тээлийн боом	ДДН-70	тэжээл Ногоо	1984	83	тэжээл ногоо	тэжээл Ногоо
Өлгий	Сондуулт	МАА-200	тэжээл	1974	71	тэжээл	тэжээл
Өмнөговь	Хар хаг	ДДН-700	тэжээл	1975	156	тэжээл	тэжээл ногоо
Сагил	Улаанхотгор	ферегат	Үр тариа	1989	584	буудай	Буудай
Тариалан	Хархираа	ферегат	Үр тариа тэжээл	1980	2084	Буудай олон наст	буудай
Тариалан	Тээлийн боом	ферегат	Тэжээл тариа		477	Үр тариа	Буудай
Улаангом	Улаантолгой	ДДН-70	Чацаргана	1979	4775	жимс	чацаргана
<b>ДҮН</b>					<b>7061</b>		

*Хүснэгт№ 4.23. Усалгаатай талбай*

Сумын нэр	Усалтын системийн нэр байршил	Системийн хийц /энгийн болон инженерийн бороожуулагчийн төрөл/	Зориулалт /Хадлан бэлчээр, үр тариа, тэжээл, жимс/	Ашиглалтанд орсон он	Талбайн хэмжээ га	Одоогийн эзэмшигчийн нэр	Одоо ашиглагдаж байгаа талбайн хэмжээ га	Зонхилон таригдаж буй таримлын нэр	Тарьсан талбай га
Баруунтуруун	БТ	инженер	Үр тариа	1990	1909	Усжуулах ХХК	900	буудай	500
Давст	Хилэнцэг	инженер	Үр тариа тэжээл	1980	150	сум	20,4	Тэжээл ногоо	20,4
Зүүнговь	Хар бураа	инженер	тэжээл	1983	128	Баянбөөрөг ХХК	14	Тэжээл ногоо	14
Малчин	Улаанбулаг	ДДН-70	тэжээл	1984	74	ЗДТГ	29	Тэжээл ногоо	29
Наранбулаг	Тээл	ДДН-70	тэжээл	1984	83	ЗДТГ	83	Тэжээл ногоо	83
Өмнөговь	Хар хаг	ДДН-70	тэжээл	1975	156	ЗДТГ	59	Тэжээл ногоо	59
Өлгий	Сондуулт	МАА-200	Тэжээл	1974	71	ЗДТГ	5,7	ногоо	5,7
Сагил	Улаанхотгор	ферегат	Үр тариа	1989	474	Аривжих Увс ХХК	160	буудай	160
Тариалан	Хархираа	ферегат	Үр тариа	1989	2084	Алтандуулга ХХК	380	буудай	380
Тариалан	Тээлийн боом	ферегат	тэжээл	1984	477	Алдартулга ХХК	200	тэжээл	200
Улаангом	Улаантолгой	ДДН-70	жимс	1979	475	Увс чацаргана	170	Жимс тэжээл ногоо	170
<b>ДҮН</b>					<b>7061</b>		<b>1621,1</b>		<b>1621,1</b>

Тариалан сумын Тээлийн гол дээр байгаа ус хуримтлуулах усан сангийн боомтыг 2007 онд төслөөр сэргээсэн бөгөөд Наранбулагийн услалтын системийн бетонон сувагтай холболтгүй барьсан байна.

1990-ээд оны эхээр хуучнаар ЗХУ-ын буцалтгүй тусламжаар Баруунтуруун суманд 2000 га-д услалтын систем барьж ашиглалтанд өгснөөс одоогоор 300 гаруй га-д тариалалт хийж байна. Услалтын системийн толгойн барилга нь сумын төвийн дээд талд оршдог бөгөөд бетонон хийцтэй, 18 м-ийн өндөртэй, /магистраль/ гол хоолойгоор усаа авч өөрийн даралт үүсгэн Оросын “Волжанка ДКШ-64” бороожуулагч агрегатаар усалгааг хийдэг байна. Толгойн барилга, далангийн хамт хувьчлагдаж “Усжуулах” ХХК-ийн мэдэлд байж үр тарианы талбайг усалж байна.



Баруунтуруун сум. Услалтын системийн далан Хархираагийн услалтын системийн улаан буудайн талбай  
Зураг № 4.10. Услалтын систем

Торхилогийн гол дээр 1980-аад оны дундуур “Торхилог”-ийн услалтын системийг аймгийн УААБУТрест барьж ашиглалтанд оруулсан нь мөн ашиглалтгүй болсон байна. Уг систем нь 2 улсын хилийн ойролцоо байрладаг, төвөөсөө алслагдмал байрлалтайгаас газар дээрх байгууламжууд нь тоногдон утсан байна.

Сагилийн голын урсацанд тулгуурлан “Улаанхотгор”-ын услалтын системийг мөн ашиглалтанд оруулсан нь “Арвижих Увс” ХХК-ны мэдэлд байж мөн бага хэмжээгээр үр тариа тариалж ашиглаж байна.

#### Ус ашиглалт

Хархираа голоос 8 чиглэлд суваг шуудуугаар ус авч Тариалан сумын 74 иргэн, 2 аж ахуйн нэгж байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг. Иргэд нийт 111 га-д үр тариа, хадлан, төмс хүнсний ногоо, жимс чацаргана тариалж ардын уламжлалт энгийн усалгаат газар тариалан эрхлэн амьдарч байна.

“Алтан дуулга” ХХКомпани нь хуучин Хархираагийн 2000 га-ийн услалтын системийн 250 га-д үр тариа, хадлан тариалж өөрийн даралтат “Фрегат” агрегатаар бороожуулах усалгааг хийж ажиллаж байна.

Тээлийн голоос Наранбулаг сумын 122 иргэн, 3 аж ахуй нэгж байгууллагууд услалтын системийн бетонон сувгаар ус авч хадлан, үр тариа, жимс чацаргана тариалж 251.8 га-д газар тариалангийн үйл ажиллагаа явуулж байна.



Зураг№ 4.11. Усалгаатай тариалан

Хархираа голын ай сав газрын дагууд хүн амын төвлөрөл, суурьшил ихтэй, нутгийн ард иргэд нь ардын уламжлалт энгийн усалгаатай газар тариалан эрхэлдэгээс эдгээр голууд нь хамгийн их ачаалалтай гол болох нь харагдаж байгаа бөгөөд ус ашиглагчдын хэрэглээ нь гольдролын хэвийн урсацанд сөргөөр нөлөөлж байгаа болно.

Улаангом сум нь нийт 7043 өрхийн 25,1 мян хүн амтай, засаг захиргааны 11 багтай, газар нутаг 260,4 мян км квадрат бөгөөд сумын 150 иргэн 563 га-д, 17 аж ахуйн нэгж байгууллагууд 492-га талбайд дээрхи голуудаас усыг бух шуудуугаар татан авч газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэн амьжиргаагаа явуулдаг байна. Эдгээрээс зөвхөн жимс, чацарганы аж ахуйд 267 га-д тариалалт хийж ашиглаж байна.



Зураг№ 4.12 Улаангом сумын тариалангийн талбай

Хүснэгт№ 4.24. Газар тариалангийн бүс сумдад тулгарч буй хүндрэл, бэрхиээлийн талаар

Д/д	Сумын нэрс	Усалгааны гачигдлаас	Техник тоног төхөөрөмж дутагдалтайгаас	Эдийн засаг, санхүүгийн боломжгүйгээс	Техник тоног Төхөөрөмжийн үйлчилгээний үнэ хэт өндрөөс	Стандартын үр, бордоо байхгүйгээс	Газар тариалангийн мэргэжилтэн байхгүйгээс	Бүтээгдэхүүний борлуулалт муу, зах зээл байхгүйгээс	Хортон шавьж, мэрэгчидээс
1	Баруунтуруун	11	7	10	6	4	4	7	1
2	Наранбулаг	10	9	2	1	3		2	12
3	Тариалан	19	5	6	5	2	1	1	13
4	Түүргэн	11	8	5	7	3	1	2	9

5	Улаангом	14	12	11	13	1	2	9	9
<b>Бүгд</b>		65	41	34	32	13	8	21	44

Тариалан эрхлэхэд тулгарч буй хүндрэлээс гаргахад нэн тэргүүнд дараахь таван хүчин зүйлийг шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн байна. Үүнд: Услалтын систем барих, засварлах, ус хуримтлуулах хөв, далан байгуулах, худаг шинээр гаргах, засварлах гэсэн 65-н буюу 23%-н, Техник тоног төхөөрөмжийг урт хугацааны хүүгүй зээл, лизенгээр олгох асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх гэсэн 50-н буюу 18%-н, Тариалангийн талбай барьцаалж урт хугацааны хүү багатай зээл олгох гэсэн 60-н буюу 22%-н, Өнөөгийн цаг агаар уур амьгалын нөхцөлд тохирсон үр бий болгох шаардлагатай гэсэн 55-н буюу 20%-н, Газар тариалангийн талаар баримтлах бодлого шаардлагатай гэсэн 48-н 17%-н тус тус санал өгсөн байна.

**ТАВДУГААР БҮЛЭГ. ХҮН АМ, СУУРЬШЛИЙН БҮС НУТАГ****5.1. Хот тосгон бусад суурин газрын одоогийн байдал**

Увс аймаг газрын нэгдмэл сангийн ангилалын 2013 оны эцсийн байдлаар хот, тосгон бусад суурин газар 16608 га гэж бүртгэгдсэнээс барилга байгууламжийн дэвсгэр газар 3577.41га, нийтийн эдэлбэр газар 8219.3 га, үйлдвэрийн газар 40.06га, уурхайн дэвсгэр газар 3345.9га, гэр хорооллын газар 1425.2га гэж бүртгэгдсэн байна.

*Хүснэгт № 5.1. Хот, тосгон бусад суурины газар сумдад /га/*

Д/д	Сумдын нэр	Бүгд/га/	Барилга, байгууламжийн дэвсгэр газар	Нийтийн эдэлбэр газар	Үйлдвэрийн газар	Уурхайн дэвсгэр газар	Гэр хорооллын газар
1	Баруунтуруун	648.76	20.16	574.19	7.24		47.17
2	Бөхмөрөн	280.96	7.29	92.08	0.06	158.7	22.83
3	Давст	444.97	14.72	170.31		231	28.94
4	Завхан	68.97	4.36	52.61	2		10
5	Зүүнговь	257.99	6.39	220.55			31.05
6	Зүүнхангай	630.02	8.02	299.80	0.25	295.73	26.22
7	Малчин	627.24	157.58	430.85	1		37.81
8	Наранбулаг	383.95	11.12	233.29		112	27.54
9	Өлгий	111.61	8.67	82.24			20.7
10	Өмнөговь	585.05	12.17	469.84		50	53.04
11	Өндөрхангай	388.49	10.17	323.74	0.22		54.35
12	Сагил	204.11	5.96	171.26	0.87		26.02
13	Тариалан	2244.91	23.52	127.78	4.34	2045	44.27
14	Түргэн	799.87	64.62	354.65		355.9	24.7
15	Тэс	433.80	18.47	325.76		58.4	31.17
16	Ховд	198.50	9.98	164.84	0.55		23.13
17	Хяргас	1788.30	13.44	1746.21	1	2	25.65
18	Цагаанхайрхан	773.55	26.07	707.92	3.13	8.26	28.17
19	Улаангом	5707.92	3154.7	1671.37	19.4		862.45
Дүн		16608.03	3577.41	8219.35	40.06	3345.99	1425.21

Одоо байгаа хот суурин газрын хэмжээгээр багатай сумд Завхан, Өлгий, Сагил, Ховд зэрэг сумдууд байна. Эдгээр сумдууд нь аймгийн төвөөс алслагдмал, төв рүү нүүх хүн амын шилжилт хөдөлгөөний байдал, хөрс, ургамалжилтын хувьд газар тариалан, үйлдвэрлэл эрхлэхэд тохиромжгүй, үйлдвэрлэл, зам харгуй, эдийн засгийн хувьд сайн хөгжөөгүйн улмаас иргэдийн тогтмол суурьшмал байдал муу байдагтай холбоотой гэж үзэж байна. Харин төв суурин газартай ойр оршдог болон үйлдвэрлэл, зам харгуй сайтай, газар тариалан түлхүү хөгжсөн сумд болох Баруунтуруун, Тариалан, Хяргас, Цагаанхайрхан зэрэг сумдууд хот суурины газар нутгийн хэмжээгээр арай илүү байна. Энэ нь сумын эдийн засгийн нөхцөл бололцоо, иргэдийн тогтвор суурьшилтай ажиллаж амьдрах, зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж байна.

## Хүснэгт№ 5.2. Увс аймгийн сумдуудын суурин газрын 2003 болон 2014 оны өөрчлөлт га-аар

Д/д	Аймаг, сумдын нэр	Барилга байгууламжын дэвсгэр газар			Гэр хорооллын газар			Нийтийн ашиглалтын газар			Үйлдвэр			Уурхай			Бусад газар			Суурьшлын бүсийн нийт газар		
		2003	2014	%	2003	2014	%	2003	2014	%	2003	2014	%	2003	2014	%	2003	2014	%	2003	2014	,%
1	Баруунтуруун	15.62	20.16	<b>+29</b>	40.29	47.17	<b>+17.1</b>	575.51	574.19	<b>-0.2</b>		7.24			0					631.42	648.76	<b>+2.7</b>
2	Бөхмөрөн	10.21	7.29	<b>-28</b>	23.49	22.83	<b>-2.8</b>	93.51	92.08	<b>-1.5</b>		0.06		590	187.7	<b>-68.2</b>				717.21	309.96	<b>-56.8</b>
3	Давст	15.3	14.72	<b>-3.7</b>	11.93	28.94	<b>+142.6</b>	182.75	170.31	<b>-6.8</b>				209	231	<b>+10.5</b>				418.98	444.97	<b>+6.2</b>
4	Завхан	8.43	4.36	<b>-48.2</b>	8.38	10	<b>+19.3</b>	53.16	52.61	<b>-1.0</b>		2			0					69.97	68.97	<b>-1.4</b>
5	Зүүнговь	6.39	6.39	<b>0</b>	14.54	31.05	<b>+113.5</b>	239.56	220.55	<b>-7.9</b>					0					260.49	257.99	<b>-1.0</b>
6	Зүүнхангай	4.18	8.02	<b>+91.8</b>	15.27	26.22	<b>+71.7</b>	315.35	299.81	<b>-4.9</b>		0.25		5.7	295.73	<b>+5088.2</b>				340.5	630.03	<b>+85.0</b>
7	Малчин	160.54	157.58	<b>-1.8</b>	15.2	37.81	<b>+148.8</b>	299.52	430.85	<b>+43.8</b>		1			0					475.26	627.24	<b>+32.0</b>
8	Наранбулаг	13.42	11.12	<b>-17.1</b>	13.81	27.54	<b>+99.4</b>	245.57	233.29	<b>-5.0</b>					112					272.8	383.95	<b>+40.7</b>
9	Өлгий	21.02	8.67	<b>-58.7</b>	8.94	20.7	<b>+131.5</b>	82.66	82.24	<b>-0.5</b>					0					112.62	111.61	<b>-0.9</b>
10	Өмнөговь	10.77	12.17	<b>+12.9</b>	18.6	53.04	<b>+185.2</b>	506.5	469.84	<b>-7.2</b>				50	50	<b>0</b>				585.87	585.05	<b>-0.1</b>
11	Өндөрхангай	11.07	10.17	<b>-8.1</b>	25.35	54.35	<b>+114.4</b>	353.04	323.75	<b>-8.3</b>		0.22			0					389.46	388.49	<b>-0.2</b>
12	Сагил	40.54	5.96	<b>-85.2</b>	11.55	26.02	<b>+125.3</b>	151.51	171.26	<b>+13.0</b>		0.87			0					203.6	204.11	<b>+0.3</b>
13	Тарилан	12.41	23.52	<b>+89.5</b>	30.11	44.27	<b>+47</b>	148.78	127.78	<b>-14.1</b>	4.34	4.34	<b>0</b>	489	2045	<b>+318.2</b>				684.64	2244.91	<b>+227.9</b>
14	Түргэн	20.59	64.62	<b>+213.8</b>	14.69	24.7	<b>+68.1</b>	359.7	354.65	<b>-1.4</b>				40	355.9	<b>+789.8</b>				434.98	799.87	<b>+83.9</b>
15	Тэс	23.65	18.47	<b>-21.9</b>	30.47	31.17	<b>+2.3</b>	322.85	325.77	<b>+0.9</b>				58.4	58.4	<b>0.0</b>				435.37	433.81	<b>-0.4</b>
16	Ховд	42.71	9.98	<b>-76.6</b>	15.86	23.13	<b>+45.8</b>	50.33	164.84	<b>+227.5</b>		0.55			0					108.9	198.5	<b>+82.3</b>
17	Хяргас	51.81	13.44	<b>-74.1</b>	15.44	25.65	<b>+66.1</b>	254.99	1746.22	<b>+584.8</b>		1			2					322.24	1788.31	<b>+455.0</b>
18	Цагаанхайрхан	7.18	26.07	<b>+263.1</b>	15.5	28.17	<b>+81.7</b>	383.78	707.93	<b>+84.5</b>		3.13			8.26					406.46	773.56	<b>+90.3</b>
19	Улаангом	3187.58	3154.7	<b>-1</b>	231.1	862.45	<b>+273.2</b>	2362.42	1671.37	<b>-29.3</b>	19.4	19.4	<b>0</b>	3.6	0					5804.1	5707.92	<b>-1.7</b>
Аймгийн дүн		3663.42	3577.41	<b>-2.3</b>	560.52	1425.21	<b>+154.3</b>	6981.49	8219.36	<b>-15.1</b>	23.74	40.06	<b>+68.7</b>	1445.7	3345.99	<b>+131.4</b>				12674.87	16608.01	<b>+31.0</b>



Улаангом сумын нутагт 1960-аад оны үеэс Хархираагийн амралт гэдэг ганц амралтын газар байсан бөгөөд тэр нь 200 га орчим талбай эзэлдэг байжээ. Хожим нь түүний дэргэд Хүүхдийн зуслангийн газар нээгдэж энэхүү 2 амралтын газрын нийлбэр хэмжээ 238 га болсон байна. Энэ амралтын газраас гадна Хартэрмэсийн амралт 150 га, Цүнхэгийн амралт 25 га нийт амралтын газрын хэмжээ 413 га байна. Амралт, рашаан сувиллын газар хот тосгон бусад суурины ангиллын газарт 3.25%-ийг эзэлж байна. Хот суурины нийт газрын 21,2% нь баруун бүс нутагт байна.

Гадаргын мөнх цэвдэг болон усан хангамж дутмаг болон ундны усны тохиромжгүй байдлаас шалтгаалж Увс аймгийн Хяргас сум нь 1976-1985 онуудад өөр газар шинээр байгуулагдан суурьшсан байна.

Одоогоор бараг бүх сумд зарим сум дундын эмнэлэг, сургуулийг эс тооцвол бусад төрлийн үйлчилгээг аймгийн төвөөс авч байгааг өөрчилж эдийн засаг, аж ахуйн үйл ажиллагааны үр ашигтай шаталсан хэлбэрт оруулах шаардлага нийгмийн шинэчлэлт өөрчлөлтийн өнөөгийн амьдралаас урган гарч байна.

Хөгжлийн бодлогыг төгс хэрэгжүүлэх үүднээс үйлчилгээний зохистой хүрээнд эдийн засаг, аж ахуйн уялдаа холбооны үр ашгийг дээшлүүлэх, засаг захиргааны давхардлыг багасгах шаардлагатай байна.

## **5.2. Хот, суурин газар, суурьшлийн бүсийн инженер-геологийн нөхцөл**

### **5.2.1. Газрын гадарга.**

Газрын гадаргын налуу нь суурьшлын бүс газрын барилга, байгууламж барьж байгуулахад ихээхэн нөлөөтэй болохыг зураг төсөл боловсруулах, барилга байгууламж барих талбайн бэлтгэл, газар шорооны ажилтай шууд холбож үздэг. Газрын гадаргын налуу ихсэх тутам газар шорооны ажлын хэмжээ мөн төдий чинээ нэмэгддэгтэй холбоотой.

Иймд газрын гадаргын налууугийн олон төрөл байдал нь хот төлөвлөлтийн үүднээс эзлэхүүн, орон зайн төлөвлөлтөд өвөрмөц үүрэг гүйцэтгэх нь маргаангүй бөгөөд хот, суурингийн янз бүрийн үүрэг зориулалтын бүсүүдийг гадаргын налууугийн хүчин зүйл, тухайн суурингийн онцлог байдалтай уялдуулан төлөвлөж барьж байгуулах нь зүйтэй юм.

*Хүснэгт № 5.3. Газрын гадаргын хот байгуулалтын үнэлгээ*

№	Аймгийн нэр	Нийт талбай /км <sup>2</sup> /	Үүнээс тохиромж муутай талбай	
			/км <sup>2</sup> -аар/	/хувиар/
1	Увс	69585,0	14080,0	20,0

### **5.2.2. Өндөржилт.**

Хот, суурингийн байрлаж буй газрын өндөржилт ихсэх тутам агаарын хүчилтөрөгчийн агуулга болон температур буурч, өдөр шөнийн температурын зөрүү огцом өсч, салхины хүч ширүүсэн, агаарын хуурайшил нэмэгдэн, цаг уурын бусад өөрчлөлтүүдээс шалтгаалж, оршин суугчдын ая тухтай байдал алдагдан, эрүүл мэндэд нөлөөлөхөөс гадна барилга байгууламжийн ашиглалтад сөрөг үр дүн үзүүлдэг байна.

Эмнэлэг-биологийн шаардлагаас үндэслэн, хот байгуулалтын хувьд далайн түвшнээс дээш 1500 м хүртэл өндөржилттэй бол тохиромжтой, 1500-2500м хүртэл

хязгаарлагдмал тохиромжтой, 2500 м-ээс дээш тохиромж муутай нөхцөлд үнэлэгдэж байна.

### **5.2.3. Ус зүй, усан хангамж.**

Нутаг дэвсгэрийн хот байгуулалтын үнэлгээний үндсэн үзүүлэлтийн нэг нь хот, суурин газрын усан хангамжийн асуудал юм. Хөрсний усны түвшин 3.0 м-ээс доош бол нэн тохиромжтой, 1.0-3.0м бол хязгаарлагдмал тохиромжтой, 1.0м-ээс дээш бол тохиромж муутай ангилалд тооцогдоно. Газрын доорхи усны нөөцийн ашиглалтын модуль нь 2.0, 6.0, 30.0, 100,0 мянган хүнтэй хот сууринд харгалзан 0,1л/сек.км 2-оос дээш, 0.3 л/сек.км 2-оос дээш, 0,6 л/сек. км 2-оос дээш, 1,0 л/сек.км 2-оос дээш бол тохиромжтой гэж тооцдог.

### **5.2.4 Ул хөрсний ус.**

Хот, суурин газрын байршил, барилга байгууламжид нөлөөлөх нэлээд өвөрмөц хүчин зүйлийн нэг нь ул хөрсний ус юм. Хот байгуулалтын хувьд ул хөрсний усны түвшин 3.0м-ээс дээш гүнд орших бол нэн тохиромжтой, 1.0-3.0м-ийн гүнд хязгаарлагдмал тохиромжтой, 1.0м хүртэл буюу өндөр даралттай уст давхарга байрласан нөхцөлд тохиромж муутай гэсэн үнэлгээнд хамрагдана. Ул хөрсний усны түвшин өндөр байгаа нөхцөлд хот, суурин барилга байгууламж барьж байгуулахад инженерийн нэмэлт арга хэмжээ зайлшгүй авах шаардлагатай ба үүний улмаас уг барилга багууламжийн төсөвт өртөг нэмэгддэг жамтай юм.

Инженер-геологийн хамгийн төвөгтэй нөхцөл нь олон жилийн цэвдэг чулуулаг хөрс бөгөөд энэ хөрсний тархалтад газар орны хотгор, гүдгэрийн байдал, налуужилтын зүг зовхис, агаарын температур, хөрсний ус, түүний түвшин, хөдөлгөөний идэвх болон хурдсын төрөл зүйл, шинж байдал нөлөөлнө. Инженер-геологийн төвөгтэй нөхцөл, улирлын хөлдөлт гэсэлтээс хамаарч ул хөрсний хэв гажилт /овойлт, суулт, хөөлт гэх мэт / үүсэх үзэгдэл манай оронд нилээд элбэг тохиолддог. Ул хөрсний энэ хэв гажилтад цэвдэг чулуулаг хөрс, хөрсний усны түвшин голлон нөлөөлөх бөгөөд овойлт, суулт, хөөлт үүсгэдэг хөрсийг хот байгуулалтын хувьд хүчтэй, дунд, сул гэж ангилан үздэг.

### **5.2.5. Инженер-геологийн үйл явц**

Монгол орны нийт нутаг дэвсгэрт намаг, хужир, мараа, хуурай сайр, нуранги асга, хөндийлж болон олон жилийн цэвдэг чулуулаг, улирлын хөлдөлт, гэсэлтээс шалтгаалан үүсэх орчин үеийн геологийн үзэгдэлүүд нэлээд хэмжээгээр тархсан нь хот, суурингийн байршил, түүний цаашдын хөгжилд тодорхой хэмжээгээр нөлөөлдгийг харгалзан инженерийн нарийвчилсан тооцоог хийх нь чухал шаардлагатай болно.

Цэвдэгийн үзүүлэлтүүдээс хөлдөлтийн нөлөөллөөр ул хөрсөнд овойлт үүсдэг газар манай орны нутаг дэвсгэрт нэлээд хэмжээгээр тархсан нь туфур, дов, бөөрөг, улирлын хөлдөлтийн бөөрөг зэрэг олон төрлийн хэлбэрээр илэрч байна. Хөрсний овойлтын жижиг хэлбэр болох туфур нь хөндий хотгорын намагжсан хэсэг болон булаг, шандын ойролцоо үүсч бий болох ба дов бөөрөг нь Тэс голын сав газарт их хэмжээгээр тохиолдоно.

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ЗАМ, ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗАР****6.1. Зам, тээврийн зорулалттай газрын одоогийн байдал**

Увс аймаг нь Монгол улсын баруун хойт хэсэгт оршдог бөгөөд уул, даваа олонтой бөгөөд зам барьж байгуулахад нилээд хүнд нөхцөлтэй юм. Замын материалыг нийслэл хотоос хангадаг тул зам барилгын ажлын үнэ өртөг өндөр байдаг.


Баруун босоо тэнхлэгийн Улаангом-Боршоо буюу улсын хил хүртлэх 115 км хатуу хучилттай автозам ашиглалтанд орсон бөгөөд мөн Улаангом-Наранбулаг-Үзүүрийн булгийн 195 км хатуу хучилттай зам 2014 онд ашиглалтанд ороод байна. Улаангом-Наранбулаг-Хяргас-Сонгино чиглэлийн 346 км замаас Увс аймгийн нутагт 116 км, Завхан аймгийн нутагт 35 км хатуу хучилттай авто замыг барих ажил үлдэж байна. Засгийн газрын 2012-2016 оны мөрийн хөтөлбөрт тусгаснаар Улаангомыг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох ажлыг 2015 онд барьж дуусгана.

Мөн Тээлийн голын 75.72, Тэс сумын Нарийний голын 325 у/м төмөр бетон гүүрүүд ашиглалтанд оруулжээ. Авто замын хөдөлгөөний эрчим жилд дунджаар 4-5 хувиар өсөж байна.

Увс аймагт 2013 оны газрын нэгдмэл сангийн ангиллаар зам шугам сүлжээний газар нийт 46090.73 га талбайг хамарч байна. Үүнээс авто замын газар 41234.6 га газрыг, агаарын тээврийн газар 332.1 га газрыг хамарч байна.

*Хүснэгт № 6.1. Зам, шугам сүлжээний газар*

Сумдын нэр	Зам, шугам сүлжээний газар	
	нийт газар	зам тээврийн газар
Баруунтуруун	2404	2252
Бөхмөрөн	2798.28	2582
Давст	2039.02	1951
Завхан	2054.68	2052
Зүүнговь	2295.24	2248
Зүүнхангай	2832.43	2350
Малчин	2309.45	1896
Наранбулаг	3281.1	2902
Өлгий	2090.92	1908.4
Өмнөговь	4413.08	3750
Өндөрхангай	60.8	30
Сагил	2063.7	1820
Тариалан	3766	3458.9
Түргэн	1593.94	1226
Тэс	3383.18	3193
Ховд	1830	1762
Хяргас	2033.26	1496
Цагаанхайрхан	1827.48	1675
Улаангом	3014.17	2682.3
<b>Дүн</b>	<b>46090.73</b>	<b>41234.6</b>



Зураг№ 6.1. Зам шугам сүлжээний газар

Хүснэгт№ 6.2. Аймгийн төв сумуудын хоорондох зай,авто замын одоогийн байдал

№	Авто замын чиглэл	Хучилтын төрөл	Нийт зай /км/
1	Баруунтуруун	Ердийн хөрсөн	193.0
2	Бөхмөрөн	Ердийн хөрсөн	174.0
3	Давст	Ердийн хөрсөн	136.0
4	Завхан	Ердийн хөрсөн	161.0
5	Зүүнговь	Ердийн хөрсөн	139.0
6	Зүүнхангай	Ердийн хөрсөн	357.0
7	Малчин	Ердийн хөрсөн	99.0
8	Наранбулаг	Хатуу хучилттай	90.0
9	Өлгий	Ердийн хөрсөн	113.0
10	Өмнөговь	Ердийн хөрсөн	109.0
11	Өндөрхангай	Ердийн хөрсөн	286.0
12	Сагил	Ердийн хөрсөн	61.0
13	Тариалан	Ердийн хөрсөн	30.0
14	Түргэн	Ердийн хөрсөн	36.0
15	Тэс	Ердийн хөрсөн	155.0
16	Ховд	Ердийн хөрсөн	177.0
17	Хяргас	Ердийн хөрсөн	163.0
18	Цагаанхайрхан	Ердийн хөрсөн	226.0
19	Улаангом		
<b>Нийт</b>			<b>2705.0</b>
<b>Үүнээс хатуу хучилттай</b>			<b>90.0</b>
<b>Ердийн хөрсөн</b>			<b>2615.0</b>

Хүснэгт№ 6.3. Олон улсын чанартай болон улсын чанартай замуудын одоогийн байдал

Замын чиглэлийн дугаар	Авто замын чиглэл, нэр	Хучилтын төрөл	Хүчин чадал /км/
A1702	Улаангом -Боршоо	Хатуу хучилттай	115.0
	Улаангом-Наранбулаг-Хяргас-Сонгино	Хатуу /хуч. Ердийн хөрсөн	195.0 151.0
A1702	Улаангом-Ховд	Ердийн хөрсөн	190.0
A16	Улаангом Цагааннуур	Ердийн хөрсөн	152.0
A07	A1701 замаас-Өлгий	Ердийн хөрсөн	124.0
		Нийт	927.0
		Үүнээс хатуу хучилттай	310.0
		Ердийн хөрсөн	617.0


Олон улсын болон улсын чанартай 927.0 км замтай байгаас 2014 оны эцэст хатуу хучилттай 310.0км зам буюу 30.0 хувь, ердийн хөрсөн зам 617.0 км зам буюу 70.0 хувь нь байна.

Одоогийн байдлаар сумдуудыг аймгийн төвтэй холбосон 2705 км замтай бөгөөд үүнээс Наранбулаг сум 90 км хатуу хучилттай замаар аймгийн төвтэйгээ холбогдсон. Сагиль 7 км, Түргэн 4 км, Давст 27 км зайтай Улаангом-Боршоогийн хатуу хучилттай зам өнгөрч байна. Мөн Улаангом-Наранбулаг-Хяргас-Сонгинын хот хоорондын хатуу хучилттай замын 195 км нь ашиглалтанд орсон бөгөөд үлдсэн хэсгийг нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн дагуу 2015 онд ашиглалтанд оруулна. Энэ зам ашиглалтанд орсны дараа Зүүнхангай, Цагаанхайрхан, Хяргас, Малчин, Завхан, Өлгий, Өмнөговь, Баруунтуруун, Зүүнговь, Өндөрхангай зэрэг сумуудын төв ороход хатуу хучилттай замаар явж байгаад цаашлаад ердийн хөрсөн замаар явж орох нөхцөл бүрдэнэ.

Эндээс харахад цаашид Улаангом-Хяргас-Сонгины хатуу хучилттай зам ашиглалтанд орсноор аймгийн төвөөс сум хүртлэх ердийн хөрсөн зам 812.0 км болж багасахаар байна.

Хүснэгт№ 6.4. Увс аймгийн 2009-2013 оны тээсэн ачаа ба зорчигчдын судалгаа

№	Үзүүлэлтүүд	2009	2010	2011	2012	2013
1	Бүх төрлийн тээврээр тээсэн ачаа мян.тн	63.4	69.3	184.9	48.5	49.7
2	Бүх төрлийн тээврээр зорчсон зорчигчид мян.хүн	38.6	35.3	145.9	44.3	53.4




Зураг№ 6.2. Тээсэн ачаа болон зорчигчдын сүүлийн 5 жилийн байдал

Дээрх судалгаанаас үзэхэд ачаа тээвэр болон зорчигчдын урсгал жил бүр тодорхой хэмжээгээр өсөж байна. Мөн автомашины тоо жил дараалан сум бүрт өсч байгаа нь замын чанарт анхаарч түүнийг засаж сайжруулах шаардлага урган гарч байна.

Хүснэгт№ 6.5. Аймгийн хэмжээний авто машины тоог сүүлийн 5 жилээр

№	Сумуудын нэр	2009	2010	2011	2012	2013
1	Баруунтуруун	139	145	126	241	256
2	Бөхмөрөн	139	102	75	99	129
3	Давст	114	107	96	183	200
4	Завхан	90	92	67	75	136
5	Зүүнговь	132	125	108	206	242
6	Зүүнхангай	130	160	102	93	120
7	Малчин	130	114	122	151	192
8	Наранбулаг	131	135	145	235	309

9	Өлгий	141	115	88	161	198
10	Өмнөговь	107	152	126	233	438
11	Өндөрхангай	139	171	137	226	284
12	Сагиль	115	149	124	204	253
13	Тариалан	180	151	142	399	449
14	Түргэн	144	128	106	195	250
15	Тэс	137	185	126	271	307
16	Ховд	122	98	83	136	166
17	Хяргас	132	158	147	184	248
18	Цагаанхайрхан	112	113	80	104	137
19	Улаангом	1547	1994	2501	2994	3392
	Дүн	3881	4394	4501	6390	7706




Зураг№ 6.3. Автомашинь 5 жилийн судалгаа

**6.2. Шугам сүлжээний газрын одоогийн байдал**

Увс аймагт 2013 оны газрын нэгдмэл сангийн ангиллаар зам, шугам сүлжээний газар нийт 46090.73 га талбайг хамарч байна. Үүнээс шугам, сүлжээний газар 4524.03 га байна.

Хүснэгт № 6.6. шугам, сүлжээний газрын ангилал.

Сумын нэр	Үүнээс					Үерээс хамгаалах далан, сувгийн эзлэх талбай
	Шугам сүлжээний газар, бүгд	Холбооны шугам, холбооны мэдээлэл хүлээн авах станцын эзлэх талбай	Эрчим хүчний шугам, станцын эзлэх талбай	Ус, дулаан дамжуулах хоолойн эзлэх талбай	Ус шахах, өргөх байгууламжийн талбай	
Баруунтуруун	108.8	54.2	54.6			
Бөхмөрөн	216.28	204.09	12.19			
Давст	88.02	24.02	64			
Завхан	2.68	2.68				
Зүүнговь	47.24	31.21	16.03			
Зүүнхангай	482.43	481.93	0.5			
Малчин	413.45	37.75	375.7			
Наранбулаг	379.1	46.6	332.5			
Өлгий	182.52	88.01	94.51			
Өмнөговь	625.58	58.31	567.27			
Өндөрхангай	30.8	19.19	11.61			
Сагил	243.7	12.5	231.2			
Тариалан	307.1	71.8	214.5		0.8	20
Түргэн	177.74	16.54	161.2			
Тэс	190.18	12.63	177.55			
Ховд	68	46	22			
Хяргас	537.26	320.06	217.2			
Цагаанхайрхан	152.48	6.04	146.44			
Улаангом	270.67	70.57	191.4		1.5	7.2
<b>Бүгд</b>	<b>4524.03</b>	<b>1604.13</b>	<b>2890.4</b>		<b>2.3</b>	<b>27.2</b>



Зураг № 6.4. Шугам, сүлжээний газрын ангиллын график зураг

Холбоо харилцааны одоогийн байдал.

Холбооны үйл ажиллагаа эрхэлж, мэдээнд хамрагддаг аж ахуйн нэгж газрууд 2013 онд 380.0 сая төгрөгийн орлоготой ажилласны 26.2 хувь нь хүн амаас орсон ба 2012 оны

мөн үеэс нийт орлого нь 3.0 хувиар буюу 11.1 сая төгрөгөөр өссөн байна. Холбооны газраар үйлчлүүлсэн цахилгаан мэдээний тоо 28.6 хувиар өсч, бичиг, захидал, боодол хүргүүлэх үйлчилгээ 1.5 хувиар буурсан байна. Кабелийн телевиз хэрэглэгчид 2414 болж 2013 оны мөн үеэс 63,7 хувиар өсчээ. Аймгийн бүх сумдад үүрэн телефоны операторууд үйл ажиллагаа явуулж байгаа ба тэдний хэрэглэгчдийн тоо 2013 оны мөн үеэс 2014 онд 11.7 хувиар өссөн байна.

Хүснэгт № 6.7. Үүрэн телефон хэрэглэгчдийн сүүлийн 5 жилийн судалгаа

№	Үзүүлэлтүүд	2009	2010	2011	2012	2013
1	CDMA хэрэглэгч	2072	2227	1719	659	666
2	SKYTEL хэрэглэгч	8000	10000	11000	12500	19100
3	MOBICOM хэрэглэгч	12000	18500	19000	22000	25000
4	UNITEL хэрэглэгч	6850	11600	12000	14870	11000
5	G mobile хэрэглэгч	7436	9546	12200	14289	16056

Хар тарвагатайн нүүрсний уурхай, Хар Тэрмэсийн рашаан сувилалыг үүрэн холбооны үйлчилгээнд хамруулсан байна.



Зураг № 6.5. Шилэн кабелийн сүлжээний зураг

Нийт 17 сум аймгийнхаа төвтэй шилэн кабелиар холбогдсон бөгөөд шилэн кабелийн урт 1145 км урт байна. Тэс сум шилэн кабельд холбогдоогүй, Vsat станцаар холбогдсон байгаа юм.

#### Эрчим хүчний одоогийн байдал


Увс аймаг нь баруун бүсийн эрчим хүчний системд багтдаг ба ОХУ-аас 2 сум эрчим хүчээ авдаг байна. Одоогийн байдлаар бүх сум эрчим хүчний системд холбогдсон байна. Төвийн эрчим хүчинд холбогдоогүй сумдаас Баруунтуруун суманд 1.95 мян.кВт



нийлбэр чадалтай дизель станц ажилладаг нь хамгийн том болох бөгөөд цаашид 300кВт хүчин чадалтай жижиг УЦС, Өндөрхангай суманд 200кВт чадалтай жижиг УЦС барьсан нь тус сумыг дулааны улиралд цахилгаан эрчим хүчээр хангадаг.

Увс аймгийн Тэс суманд 35кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам ашиглалтад орж Малчин-Тэсийн 35 кВ-ын, 115 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд өртөөг ашиглалтанд оруулсан байна. Мөн Малчин сумаас Хар тэрмис хүртэлх 51 км, 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд өртөөний хамт шинээр баригдаж өнгөрсөн оны 10-р сарын 24-нд ашиглалтад оруулсан юм. Аймгийн Засаг даргын “Малчин-Тэсийн 35 кВ-ын 115 км, Малчин-Хар тэрмэсийн 10 кВ-ын 51 км, шугам шинэчлэх, дэд станцын хүчин чадлыг нэмэгдүүлэхийг судалж шийдвэрлэнэ” хэмээн “Ажилтай орлоготой Монгол хүн”хөтөлбөртөө тусгасан ажил ийнхүү хэрэгжлээ.

Тэс сум ОХУ-ын “Ошно” суурингаар дамжуулан цахилгаан эрчим хүчээ авдаг байсан бол эрчим хүчний төв эх үүсвэрт холбосноор орон нутгийн хэрэглэгчид эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагдах боллоо.



Зураг № 6.6. Увс аймгийн эрчим хүчний сүлжээний зураг

*Хүснэгт№ 6.8. Эрчим хүчний эх үүсвэр, ашиглалтанд орсон хугацаа, хүчин чадал.*

№	Сумдын нэрс	Эх үүсвэр	Ашиглалтанд орсон хугацаа	Хүчин чадал	Хөрөнгө оруулалт /сая төг /
1	Зүүнхангай	Баруунтуруун сумаас 15 кВ-ын 106.7км ЦДАШ	2008	15/0.4 кВ-ын 2х0,16МВА дэд станц	1259,8
2	Баруунтуруун	Хяргас сумаас 35 кВ-ын 47.5км ЦДАШ	2009	1х0.4 МВА дэд станц	1200
3	Өндөрхангай	Цагаанхайрхан- сумаас 15 кВ-ын 61,8 км ЦДАШ, Өндөрхангайн УЦС	2008	15/0.4 кВ-ын 2х0,16МВА дэд станц, Өндөрхангайн УЦС 200 кВт	780,45
4	Зүүнговь	Хяргас сумаас 15 кВ-ын 27.54 км ЦДАШ	2009	15/0.4 кВ-ын 2х0,16МВА дэд станц	350
5	Цагаанхайрхан	Баруунтуруун сумаас 15 кВ-ын 34,4 км ЦДАШ	2008	15/0.4 кВ-ын 1х0,1, 1х0,25МВА дэд станц	512,5
6	Тэс	Оочин тосгон (ОХУ)-аас 10 кВ-ын 30 км ЦДАШ	2008	1х0.25, 1х0.16 МВА дэд станц	384
7	Хяргас	Малчин сумаас 35 кВ-ын 47.14 км ЦДАШ	2009	1х0.4 МВА дэд станц	1187,9
8	Малчин	Улаангом сумаас 110 кВ-ын101.38 км ЦДАШ	2009	110/35/6кВ-ын 2х10МВА дэд станц	1522
9	Завхан	Дөргөний УЦС-аас 15 кВ-ын 60 км ЦДАШ	2007	1х025, 1х 0.1 МВА	680
10	Наранбулаг	Өлгий сумаас 10 кВ-ын 63,9 км ЦДАШ	2002	10/0,4 кВ-ын дэд өртөө 1х0.16, 1х0.1 МВА	377,6
11	Давст	Хандгайтын хилийн постоос 10 кВ-ын 28,7 км ЦДАШ	2003	10/0.4 кВ-ын дэд өртөө 1х0.1, 1х0.16МВА	128,2
12	Тариалан	Улаангом сумаас 35 кВ-ын 37 км ЦДАШ	2009	2х6,3 МВА дэд станц	932,4
13	Өлгий	Өмнөговь сумаас 35 кВ-ын 22 км ЦДАШ	1997	35/0,4 кВ- 1х1 МВА дэд станц	286,5
14	Улаангом	ОХУ-ын Чадан дэд станцаас Улаангомын шугам, дэд станц, 110кВ-ын шугам 101км 35 кВ-ын шугам 2х11 км	1988, 1995	110/35/10кВ-ын дэд станц 2х10МВА 35/6 кВ-ын дэд станц 2х10 МВА	528,5
15	Сагил	Улаангом сумаас 35 кВ-ын 10.2 км ЦДАШ	2000	35/0.4 кВ-ын дэд станц 1х0.4 МВА	99,4
16	Түргэн	Улаангом сумаас 10 кВ-ын 22,6 км ЦДАШ	1997	10/0.4 кВ-ын дэд станц 1х0.16, 1х0.25 МВА	63,7
17	Өмнөговь	Улаангом сумаас 110кВ-ын 117км 10 кВ-ын 3 км ЦДАШ	1995	110/35/10кВ-ын дэд станц 1х6, 3МВА 10/0.4 кВ-ын дэд станц 1х0.1, 1х0.25 МВА	612,4
18	Бөхмөрөн	Баян-Өлгий аймгийн Ногоонуур сумаас 10 кВ-ын 7.5 км ЦДАШ	2009	1х0.16, 1х0.1 МВА	45,75
19	Ховд	Баянөлгий аймгийн Алтанцөгц сумаас 10 кВ-ын 52.1 км ЦДАШ	2005	10/0.4 кВ-ын 1х0.025, 1х0.1, 1х0.16 МВА-гийн дэд станц	323

**ДОЛООДУГААР БҮЛЭГ. ОЙН САН БҮХИЙ ГАЗАР****7.1. Ойн сан бүхий газрын өнөөгийн байдал**

Ойн сангийн нийт талбай 236629 мян.га. Үүнээс ойгоор бүрхэгдсэн талбай 72519.9 мян.га Өөр хоорондоо болон хүрээлэн байгаа орчинтойгоо нягт уялдаа холбоотойгоор харилцан үйлчлэлцэж, уур амьсгал, хугацаа, хүмүүсийн ажиллагааны улмаас хэлбэр, хэмжээ, тоо, агуулгаараа байнга хувьсан өөрчлөгдөж байдаг мод, сөөг, өвслөг ургамал ба бусад амьд организмуудын цогцолбороос тогтсон тодорхой нэгэн (ландшафт) хэв төрхийн тогтоцыг ой гэдэг ойлголтонд хамруулдаг. Ойн модод нь бичил цаг уур, хөрсний тусгай бүтэцтэй экосистемийг бий болгодог.


*Хүснэгт№ 7.1. Ойн сангийн газар /Газрын нэгдмэл сангийн ангиллаар 2013/*

Д/д	Сумын нэр	Ойн сангийн талбай
		2013 он
1	Баруунтуруун	18034
2	Бөхмөрөн	420
3	Давст	2734
4	Зүүнхангай	18655
5	Малчин	6801
6	Наранбулаг	7039
7	Өндөрхангай	2729
8	Сагил	11829
9	Тариалан	2849
10	Түргэн	18176
11	Хяргас	8996
12	Цагаанхайрхан	7492.5
13	Улаангом	4463
	Дүн	<b>110217.5</b>

Ой мод нь экологийн онцгой ач холбогдолтойгоос гадна ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах тодорхой нөөцтэй, эдийн засгийн асар өндөр ач холбогдолтой, нөхөн сэргээгддэг байгалийн үнэт баялаг юм.

Увс аймгийн ойн санд 1990 онд ой зохион байгуулалтын ажлыг тус аймгийн ойн санг бүрэн хамруулан хийж 2002 онд “Ойн хайгуул төслийн төв”, Ханхөхийн нурууны БЦГазрын хэмжээнд, 2007 онд “Хөвчийн хоймор”ХХК нь Түргэн уулын ДЦГ, Цагаан шувуутын ДЦГазрын хүрээнд хэсэгчилэн хийгдсэн байдаг бөгөөд үүнээс өөр ойн сангийн талаарх судалгаа хийгдээгүй байна.“Гранд форест” ХХК 2011 онд Увс аймгийн ойд ой зохион байгуулалтын ажлыг хийж, 1990, 2002, 2007 оноос хойш ойн санд орсон өөрчлөлтийг гаргаж, таксацын үндсэн үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоожээ.

## Хүснэгт № 7.2. Ойн сангийн талбай ойн бүсээр ангилсан байдал



Ойн ургамалжилт

Хархираа, Түргэн, Ханхөхийн нуруунд өндөр уулын ургамалшил 2100-2400 метрээс авахуулаад уулсын бүр орой дахь мөнх цасны шугам хүртэл үргэлжилнэ. Энд уур амьсгал хуурайн улмаас модлог ургамал ургах нөхцөл муутайгаас тайгын бүслүүр бий болдоггүй, тагийн бүслүүр шууд уулын хээр ба ойн бүслүүрт шилжинэ. Тагийн бүслүүр нэн ширүүн хахир уур амьсгалын нөхцөлд оршдог тул тэндэх ургамалшил тачир юм. Тагийн бүслүүрт олон наст ургамал зонхилно. Олон наст өвсний дотор ксерофит шинжийн сибирийн бушилз, чийгэнд ивээлт улалжын зүйлүүд-хар цэцэгт улалж, нарийн цэцэгт улалж, зэнтгэр улалж, түүнчлэн тагийн буржгар, гоо дэвхэргийн цагаан, нангиад холтсон цэцэг, тагийн тооронцор, цав цагаан гичгэнэ, цагаан дэгд, сормууст сэрдэг зэрэг алаг өвс ургана. Тагийн бүслүүрийн уур амьсгал ширүүн тул нэг наст өвс бараг байхгүй, харин хаг, хөвд чухал үүрэгтэй байна. Тэнд бушилз, улалж, хаг, хөвд зонхилохын хамт хамгийн доод захаар нь явган бургас мэт намхан тачир бут ургадаг байна.

Уулын доод хэсгийн бүслүүрт тархан ургасан модод нь намхан, сийрэг, өвслөг нөмрөг багатай голчлон хөвд, сөөг, сөөгөнцөр ургамалууд тархсан байдаг бол харин уулын бэл хэсгээс доош модод нь өндөр, өтгөрөл ихтэй, өвслөг нөмрөгөөр баялаг болно. Голын татмын дагуу Бургас, Улиас, бут сөөг тархан ургана.

**7.2. Ойн сангийн газрын хэмжээ, өөрчлөлт**

2012 оны газрын тайлан бүртгэлээр Увс аймагт **110217.5 га** ойн сангийн газар байгаа гэж бүртгэгдэсний **72519.9 га** буюу 65.79% нь ой модоор бүрхмэл, **4512.1 га** буюу 4.09 % нь ойг нь огтолсон газар, 0.086% буюу **95.0 га** нь ой үржүүлгийн газар, **33090.5 га** буюу 30.02% нь ой мод тэлэн ургах нөөц газар гэж бүртгэгджээ. Эндээс үзвэл Увс аймгийн ойн сангийн газрын зөвхөн 65.79% одоогоор ой модтой, үлдэж буй 34.21% нь модыг нь огтолсон юмуу огт ой модгүй, ирээдүйд хэзээ нэгэн цагт ой тэлж ургах нөөц газраар бүртгэгдсэн байна.

Хүснэгт № 7.3. Ойн сангийн газрын талбайн өөрчлөлт, га-р

Дэд ангилал	2003 он	2012 он	Өөрчлөлт, га-р
Ой модоор бүрхэгдсэн газар	72569.4	72519.9	-49.5
Ой ой модыг нь огтолсон газар	4460.6	4512.1	51.5
Мод мод үржүүлгийн газар	89	95	6
Ой тэлэн ургах нөөц газар	33092.5	33090.5	-2
Ойн сангийн бусад газар	0	0	0
<b>Бүгд</b>	<b>110211.5</b>	<b>110217.5</b>	<b>6</b>

Увс аймгийн ойн сангийн газрын нөөц сүүлийн арван жилд 49.5 га-аар буурсан байна. Үүнээс ой модыг нь огтолсон газар 51.5 га-аар нэмэгдэж үүнийгээ дагаад мод үржүүлгийн газар 6 га-аар өссөн байна.

Ойг хамгаалахын зэрэгцээ ой байгалийн жамаараа нөхөн төлжиж ургах нөхцлийг бүрдүүлэх арчилгаа тордолт, цэвэрлэгээний болон ойн хортонтой тэмцэх ажил байнга хийгдэж байх ёстой. Гэтэл энэ чиглэлийн ажлууд огт хийгдэхгүй байгаагаас байгалийн жамаараа ширэнгэ үүсгэн ургаж байгаа зулзган моднууд гэрлээ булаацалдан сунасаар

хэдэн жилийн дараа нэг модонд ногдох экологийн орон зай хомсдосноос бүгдээрээ үхэж хувхайрдаг байна. Хэрэв уг ширэнгийг зулзаган үед нь сийрүүлж шилжүүлэн суулгах мэтийн арга хэмжээ авсан бол ой нөхөн төлжиж ургах нөхцлийг жинхэнэ утгаар нь бүрдүүлж чадахаас гадна ой үржүүлгийн газарт мод үржүүлэн өсгөж түүнийгээ шилжүүлэн суулгах замаар ажиллахаас хамаагүй хямд, найдвартай байх болно. Ийнхүү ширэнгэн ой үүсч эхлээд тордолтгүйгээс залуугаараа хувхайрч байгаа үзэгдэлтэй Ханхөхийн нуруунд газар сайгүй тааралдаж болно.

Ойг маш ихээр сүйтгэж байгаа нэг зүйл бол ойн хортой шавьж ихээр үржиж ой модыг сүйтгэдэг явдал юм. Увс аймгийн Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайран, Малчин сумуудын ой модтой газруудаар Сибирийн гэх тодотголтой ойн хортон шавьжийн тархалт хүрээгээ тэлж ой мод сүйтгэсээр байна. Урьд нь энэ үзэгдэлтэй авиа химийн аргаар тэмцдэг байсан бол одоо хөрөнгө санхүүгийн боломжгүйгээс гар аргаар тэмцэл явуулж байна. Энэ нь пестици дээр цэнэглэсэн бортгийг явган хүн үүрч хортон тархсан мод руу шүршүүрээрээр пестицидээ шүршдэг энэ шүршүүр нь 40 м хүртэл өндөрт цацдаг. Энэ арга нь бага талбайд үр дүн сайтай боловч их хэмжээний талбайд маш олон шавьж устгалд оролцох шаардлагатай болдог.

Увс аймгийн хувьд ойн сангийн газрын нөөц жил бүр багассан хувьтай байна. Энэ нь ойн сан бүхий газарт үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар мод бэлтгэх, ан хийх, дагалдах бусад баялгийг ашиглах, сүүлийн үед уул уурхайн үйлдвэрлэл явуулах, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх асуудал эрс нэмэгдэж байгаатай холбоотой юм. Увс аймгийн сүүлийн арван жилд ойн сангийн нөөц 49.5 га-аар буурсан байна.

Хүснэгт № 7.4. Ойн төлөв байдлын өөрчлөлт

Д/д	Аймгийн нэр	Ойн түймэрт өртсөн		Хортон мэргэчид өртсөн		Мод бутыг огтолсон		Нийт өөрчлөлтөнд орсон газар	
		Хэмжээ /га/	Эзлэх хувь	Хэмжээ /га/	Эзлэх хувь	Хэмжээ /га/	Эзлэх хувь	Хэмжээ /га/	Эзлэх хувь
1	Увс	152	0.1	27900	15.6	7137	4	35189	19.7

Ойн сан бүхий газрын дийлэнхи 79.2 хувь буюу 27900га газар хортон мэргэчид өртөж, 152 га ойн түймэрт өртөж, 7137 га газрын мод ба бутыг огтолсон байна.

Ойн хөнөөлт шавьж хүр эрвээхэйн өндөг ихээр тархсан газруудад устгал хийх, ойгоос их хэмжээгээр мод огтлохгүй байх зэрэг нийтлэг арга хэмжээ авах шаардлагатай байна. Сүүлийн жилүүдэд хүний үйл ажиллагааны болон байгалийн үйл явцын өөрчлөлтийн улмаас ой модны нөөц, төлөв байдалд ихээхэн өөрчлөлт орсоор байна.

## Хүснэгт№ 7.5. Увс аймгийн ойн сангийн талбай газрын төрлөөр

№	Аймгийн нэр	Ойгоор бүрхэгдсэн				Ойгоор бүрхэгдээгүй								Ойн талбай Дүн	Ойн бус талбай						Ойн бус талбай Дүн	Бүх талбай	
		Байгалийн ой	Сєєг торлог	Тарималой	Дүн	Тармаг ой	Шатсан ой	Мод бэлтгэсэн талбай	Байгалийн аясаар ойжиж байгаа талбай	Салхи, цасанд хунасан ой	Ойжуулсан талбай	Хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ой	Дүн		Цагаан энгэр	намаг	Хөрсний эвдрэлд орсон талбай	Мод үржүүлгийн газар	элс	Таг, царам			Тусгай зориулалтын халз зурвас
1	Увс	197,3	3,6	0,03	200,9	26,7	2,0	2,0	0,6			0,03	31,3	232,3	4,4			0,001				4,4	236,6

Тайлбар:

Ойгоор бүрхэгдсэн талбайд ойгой байгаа болон улсын ойн санд шилжүүлсэн таримал ой, бут сөөгөөр битүү хучигдсан талбай орно.

Ойгоор бүрхэгдээгүй талбайд одоогийн байдлаар ой байхгүй боловч цаашдаа ой ургах нөхцөл бололцоотой газрууд шатсан ой, мод бэлтгэсэн газар хамрагддаг

Ойн бус талбайд ойн сан доторх цагаан энгэр, таг царам, ойн цоорхой, мод үржүүлгийн талбай зэрэг газрууд ордог.

## Хүснэгт№ 7.6. Ойн сангийн талбайн ойн бүсийн ангилал / Талбай, га /

Д/д	Аймгийн, хотын нэр	Аж ахуйн бүсээр		Дүн
		Хамгаалалт / га /	Ашиглалт /га /	
1	Увс	224419	12210	236629

## Хүснэгт№ 7.7. Ойн сангийн байгалийн ойн талбай модны төрлөөр / Талбай, га /

№	Аймаг	Модны төрөл												Дүн
		шинэс	нарс	хуш	гацуур	жодоо	хус	улиас	улиангар	хайлаас	бургас	Тоорой	заг	
1	Увс	141357		1527	330		1315	11140			41678			197347

Улиас, хус, нарс маш бага хувийг эзэлж шинэс дангаараа хамгийн их хувийг эзэлж байна. Харин говийн заг ургадаггүй.

## Хүснэгт№ 7.8. Хамгаалалтын бүсийн ойн ангилал

Д/д	Аймгийн нэр	Дархан Цаазат Газар	Байгалийн Цогцолборт Газар	Байгалийн Нөөц газар	Дурсгалт газар	Ногоон бүсийн ой	100 га хүртэлх төгөл ой	30 хэмээс дээш налуу газрын ой	Улсын хилийн дагуух ой	Хориотой зурвасын ой	Дүн	
1	Увс	Талбай / га /	23359	60814	38718		30977	4267	10634	4815	50835	224419
		Нөөц / мян.шоометр /	1155.5	7902.4	915.1		3646.5	759.6	1302	549.5	3226.5	19457.1

### 7.3. Тусгай хамгаалалттай газар нутгийн ойн сан.

Увс аймгийн нутаг дэвсгэр дээр байдаг 5 хэсэг (3 нь ДЦГ, 1 нь БЦГ, 1 нь БНГ юм) газарт 87.62 мян га ойгоор бүрхмэл газар бүртгэгдсэн байна. Энэхүү ТХГН-т байгаа ой модтой газруудыг тусгай хамгаалалтанд авахаас урьд ойн сангийн газарт бүртгэгдэж байжээ.


Хүснэгт № 7.9. Хамгаалалтын бүсийн ойн талбай

Д/д	Бүрэлдэхүүнд багтах газар	Талбай		
		Мян.га	Хувь	
1	Увс нуурын ДЦГ	2.80	3.1	
2	ДЦГ	Түргэн уул	5.98	6.8
3		Цагаан шувуут уул	1.63	1.8
4	БЦГ	Хан хөхийн нуруу	65.85	75.15
5	БНГ	Тэсийн голын сав	11.36	12.96
ДҮН		<b>87.62</b>	<b>100.00</b>	

Тусгай хамгаалалттай газарт газар болоод байгальд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулах, ургамал, амьтны өсч үржих нөхцлийг хангах, хөрсийг нөхөн сэргээх, байгалийн гамшгаас учирсан хор уршгийг арилгах, түүнчлэн усны эхийг хамгаалах хориотой зурвасын ойн ашиглалтын горимоор зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг явуулдаг.

### 7.4. Ой зохион байгуулалтын арга хэмжээний талаар

Ой зохион байгуулалтаар ойн сангийн талбай, нөөц тархацыг аймаг, сумийн хэмжээгээр нь нарийвчлан тогтоож, ойн төлөв байдал, чанар өсөлтийн явцад үнэлэлт дүгнэлт гаргаж үүний үндсэн дээр ойг хамгаалах зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний үндэслэлийг боловсруулдаг билээ.



Зураг № 7.1. Ой хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө /УГЗБЕТ-өөс/



Мөн түүнчлэн ойн зохион байгуулалтын явцад газрын сангийн нэг хэсэг болох ойн сангийн газрын өөрчлөлтийг нарийвчлан тогтоодог.

*Хүснэгт№ 7.10. Увс аймагт явуулсан ойн зохион байгуулалт /оноор/*

№	Аймгийн нэр	Ой зохион байгуулалт хийгдсэн он	Ойн сангийн талбай, /мян.га/
1	Увс	2011	236.6

2011 онд явуулсан ойн зохион байгуулалтаар 236.6 мян.га газрын ойг хамгаалах зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан.

Ойн санг ойн талбай, ойн бус талбай гэсэн үндсэн хоёр хэсэгт ангилна. Ойн талбай нь дотроо ойгоор бүрхэгдсэн, ойгоор бүрхэгдээгүй талбай гэж хоёр хуваагдана. Ойгоор бүрхэгдсэн талбайд тухайн судалгааны үед ойтой байгаа (0.3 ба түүнээс дээш өтгөрөлтэй) болон улсын ойн санд шилжүүлсэн таримал ой, бут сөөгөөр битүү хучигдсан талбай орох ба ойгоор бүрхэгдээгүй ойн талбайд одоогийн байдлаар ой байхгүй боловч цаашдаа ой ургах нөхцөл бололцоотой газрууд (ойжиж байгаа газар, тармаг модод, ойжуулсан талбай), урьд өмнө ойтой байсан талбай (шатсан ой, мод бэлтгэсэн талбай г.м) тус тус хамрагдана.

Ойн бус талбайд ойн сан доторх цагаан энгэр, таг царам, хадлан, бэлчээр, гол, жижиг нуур цөөрөм, намаг, элс, мод үржүүлгийн талбай зэрэг газрууд орно. Ойн сангийн нийт талбай 236629 мян.га, үүнээс ойгоор бүрхэгдсэн талбай 200929 мян.га, байгалийн ой 197347 мян.га аймгийн нийт нутаг дэвсгэрийн 3.4 хувийг ойн талбай эзэлнэ.

Ойн сангийн нийт талбайн 98.16 хувийг ойн талбай, 1.84 хувийг ойн бус талбай эзэлж байна. Ойн талбайн 86.51 хувь нь ойгоор бүрхэгдсэн 13.49 хувь нь ойгоор бүрхэгдээгүй талбай эзэлж байна.

Ойгоор бүрхэгдсэн талбайн 98.22 хувийг байгалийн ой, 0.02 хувийг таримал ой, 1.76 хувийг торлог, ойгоор бүрхэгдээгүй талбайн 85.11 хувийг тармаг мод, 6.52 хувийг шатсан ойн талбай, 6.28 хувийг мод бэлтгэсэн талбай 2 хувийг ойжих талбай 0.09 хувийг ХШӨН талбай тус тус эзэлж байна.

Увс аймгийн ой гарал үүслийн хувьд өөрөө аясаараа сэргэн ургасан байгалийн ой бөгөөд бүрэлдэхүүний хувьд шилмүүст ой зонхилон ургасан байна. Бут сөөг ихэнхдээ гол горхины дагуу тархан ургана. Байгалийн ойн талбайг модны төрлөөр талбай, нөөцийг хүснэгт№ 7.11. -д харуулав.

*Хүснэгт№ 7.11. Байгалийн ойн талбай*

Д/д	Төрөл зүйл	Ойн талбай	Эзлэх хувь	Ойн нөөц /шоометр/
1	Шинэс	141357 га	71.1	18904610
2	Хуш	1527	0.77	249720
3	Гацуур	330	0.16	249720
4	Хус	1315	0.66	249720
5	Улиас	11140	5.6	707330
6	Бургас	41678	21.1	1021820
	Дүн	197347	100.0	20961670

**7.5. Ойн бүс тэдгээрийн ашиглалт хамгаалалтын дэглэм**

Хамгаалалтын бүсийн ойд зам гүүр барих, ус, эрчим хүч, холбооны шугам татах болон түймрээс хамгаалах шороон зурвас гаргах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг дэмжихэд чиглэсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн дагалт нөөцийг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглодог.

Хүснэгт № 7.12. Увс аймгийн ойн сангийн талбай ойн бүсээр ангилсан байдал

№	Сумдын нэрс	Дүн /га/
<b>Увс нуурын дархан цаазат газрын онгон бүсийн ой</b>		
1	Давст	721
<b>Дархан цаазат газруудын хамгаалалтын бүсийн ой</b>		
1	Баруунтуруун	103
2	Давст	3467
3	Сагил	77
4	Түргэн	1212
5	Тэс	3009
6	Ховд	114
	дүн	7982
<b>Ханхөхийн байгалийн цогцолборт газрын онцгой бүсийн ой</b>		
1	Өндөрхангай	10625
2	Цагаанхайрхан	797
	дүн	11422
<b>Дархан цаазат газруудын хязгаарлалтын бүсийн ой</b>		
1	Баруунтуруун	487
2	Бөхмөрөн	824
3	Давст	1753
4	Сагил	521
5	Түргэн	5169
6	Тэс	5902
	дүн	14656
<b>Ханхөхийн Байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс</b>		
1	Зүүнхангай	13740
2	Өндөрхангай	22832
3	Цагаанхайрхан	7441
	дүн	44013
<b>Тэсийн голын дагуух байгалийн нөөц газрын ой</b>		
1	Тэс	38718
	дүн	38718
<b>Сумдын ногоон бүсийн ой</b>		
1	Баруунтуруун	352
2	Зүүнхангай	3573
3	Малчин	2196
4	Наранбулаг	849

5	Өндөрхангай	2134
6	Сагил	8678
7	Тариалан	1840
8	Түргэн	5101
9	Цагаанхайрхан	6254
	Дүн	30977
<b>Голын дагуух хориотой зурвасын ой</b>		
1	Баруунтуруун	12498
2	Бөхмөрөн	3631
3	Давст	6042
4	Зүүнговь	1231
5	Өндөрхангай	1080
6	Сагил	4104
7	Түргэн	5361
8	Ховд	4931
9	Хяргас	10102
10	Цагаанхайрхан	1387
11	Улаангом	468
	Дүн	50835
<b>100 га хүртэлх төгөл ой</b>		
1	Малчин	4072
2	Сагил	195
	Дүн	4267
<b>30 хэмээс дээш налуу газрын ой</b>		
1	Наранбулаг	5894
2	Тариалан	1157
3	Улаангом	3583
	Дүн	10634
<b>Улсын хилийн дагуух хориотой бүсийн ой</b>		
1	Давст	1441
2	Сагил	3374
	Дүн	4815
<b>Ашиглалтын бүсийн ой</b>		
1	Зүүнхангай	7345
2	Малчин	2829
3	Түргэн	2036
	Дүн	12210
<b>Ханхөхийн байгалийн цогцолборт газрын аялал жуулчлалын бүсийн ой</b>		
1	Зүүнхангай	353
2	Өндөрхангай	5026
	Дүн	5379
<b>Нийтдүн</b>		<b>236629</b>

Мөн түүнчлэн ойн зохион байгуулалтын явцад газрын сангийн нэг хэсэг болох ойн сангийн газрын өөрчлөлтийг нарийвчлан тогтоодог.

Нийт хамгаалалтын бүсийн ойд 224419 га талбай хамаарч байгаа бөгөөд энэ бүсийн ойд явуулах үйл ажиллагааг төрөл тус бүрээр нь тодорхойлов.

**Дархан цаазат газрын онгон бүс.** Энэ бүсэд байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах шаардлагад нийцүүлж зөвхөн хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлнэ. Дархан цаазат газрын онгон бүсэд байгалийн төлөв байдлыг хөндөхгүйгээр зөвхөн ажиглах хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулж болох бөгөөд үүнээс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

**Дархан цаазат газрын хамгаалалтын бүс.** Хамгаалалтын бүсэд байгалийн унаган төрх, хэв шинжийг нь хадгалах шаардлагад нийцүүлж зөвхөн хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэхээс гадна ургамал, амьтны аймгийн өсч үржих нөхцөлийг хангах, байгалийн гамшгаас учирсан хор уршгийг арилгахтай холбогдсон биотехникийн арга хэмжээг байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр хэрэгжүүлнэ.

**Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс.** Дархан цаазат газрын хязгаарыг зааж өгсөн байдаг ба хязгаарлалтын бүсэд илүү өргөн хүрээтэй, үйлдвэрлэл, үйлчилгээний шинж чанар бүхий зарим ажил үйлийг хийхийг зөвшөөрдөг. Хязгаарлалтын бүсэд байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр зохих зөвшөөрөлтэйгээр дараахь үйл ажиллагаа явуулж болно.

**Байгалийн цогцолборт газрын онцгой бүс.** Энэ бүсийн ойд нэн ховор ургамал, амьтан оршин байх ба хүрээлэн буй орчиндоо хамгийн их чухал нөлөө үзүүлж унаган төрхийг нь зайлшгүй хамгаалах шаардлагаатай ойн сан орох ба түймрээс хамгаалах шороон зурвас гаргах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг дэмжихэд чиглэсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн дагалт нөөцийг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглодог.

**Хориотой зурвасын ой.** Хөрсний эвдрэлээс сэргийлэх, гадаргын болон газар доорх усны горимыг зохицуулахад ач холбогдол бүхий гол, горхины эх болон нуурын эргэн тойрны 5 километрийн доторх ой, голын урсгалын дагуу эргээс хоёр тийш болон рашаан, булаг шандын ундаргын эргэн тойрны 3 километрийн доторх ой хамаарна.

**Байгалийн цогцолборт газар.** Энэ бүсэд байгалийн өвөрмөц тогтоцтой ан амьтан шигүүртэн шувууд нүүдэллэн болон байнгын оршин байдаг ургамал болон модлог ургамлын зүйлээр баялаг газрууд орох ба зам гүүр барих, ус, эрчим хүч, холбооны шугам татах болон түймрээс хамгаалах шороон зурвас гаргах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг дэмжихэд чиглэсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн дагалт нөөцийг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглодог.

**Байгалийн нөөц газар.** Энэ бүсэд тэс голын дагуух бургасан ой хамаарагдаж байгаа бөгөөд 38718 га талбайг эзлэж байна. Зам гүүр барих, ус, эрчим хүч, холбооны шугам татах болон түймрээс хамгаалах шороон зурвас гаргах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг дэмжихэд чиглэсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн дагалт нөөцийг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглодог.

**Ногоон бүсийн ойн сан.** Ногоон бүсийн ойн гол үүрэг ач холбогдол нь төв суурин газрын ойр орчмын байгаль орчны тэнцэл, амралт, сувилалын болоод хүн амын эрүүл ахуйн нөхцлийг хангахад оршино. Увс аймгийн ногоон бүсийн ойн санд 34998 га буюу 14,79% нь тус аж ахуйн төрөлд хамрагдаж байна.

**Байгалын цогцолборт газрын аялал жуулчлалын бүс.** Энэ бүс нь ой нь байгалын өвөрмөц тогтоцтой нуур, гол горхи, хүрхэрээ, хөшөө дурсгал орох ба унаган төрхийг нь зайлшгүй хамгаалах шаардлагаатай ойн сан орох ба зам гүүр барих, ус, эрчим хүч, холбооны шугам татах болон түймрээс хамгаалах шороон зурвас гаргах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг дэмжихэд чиглэсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн дагалт нөөцийг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглодог.

**100 га хүртлэх ой сөөг ширэнгэ уулын өвөр энгэр төгөл ой.** Энэ төрөлд эх ойгоосоо таслагдмал бага хэмжээтэйгээр төгөл хэлбэрээр тархсан жижиг зураа, ширэнгэ, уулын өвөр энгэрийн төгөл ой хамаарах ба цаашид тэлж урган ойн сангийн талбай нэмэгдэхэд ихээхэн ач холбогдолтойн дээр талбайгаар нь хавтгайруулан огтолвол шууд хээржих хандлагатай байдаг тул хамгаалалтын бүсэд ордог.

**30 хэмээс дээш налуу .** Энэ аж ахуйн төрлийн ой нь ихэвчлэн ус хагалбарын шугам дагуу байрлах учраас хөрсийг салхи, усны элэгдэл эвдрэлээс хамгаалах, гол үүрэг ач холбогдолтой бөгөөд ургах орчных нь тохиромжтой нөхцлийг алдагдуулахгүй байх, ойн хэвийн өсөлт, өөрөө аясаараа сэргэн ургах нөхцлийг хангах үүднээс хамгаалалтын бүсэд оруулдаг.

**Улсын хил дагуух ой.** Улсын хилийн дагуух 5 хүртэл километрийн доторх 4815 га ой буюу ойн сангийн 2.03 хувь нь энэ аж ахуйн төрөлд хамаарч байна.

**Ашиглалтын бүс.** Ашиглалтын бүсийн ойд хамгаалалтын бүсэд хамрагдаагүй бүх ойг хамааруулана. Увс аймгийн хувьд энэ бүсэд 12210 га ойн талбай багтдаг. Ашиглалтын бүсийн ойгоос иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага мод, ойн дагалт нөөцийг ойн санг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тусгасан менежментийн төлөвлөгөөний дагуу ашиглах эрхтэй. Увс аймгийн ойн сангийн тархалтыг сумдаар / хүснэгт№ 7.13.-д / үзүүлэв.

*Хүснэгт№ 7.13..Увс аймгийн ойн сангийн тархалт / сумдаар/*

Д,д	Сумын нэр	Ойн сангийн талбай	Ойн сангийн талбай	Нутаг дэвсгэрийн эзлэх хувь	Ойн сангийн талбай	Нутаг дэвсгэрийн эзлэх хувь
		1995 он	2002-2007		2011 он	
1	Баруунтуруун	18168	10433	0,14	13440	0,19
2	Бөхмөрөн	1928	887	0,01	4455	0,06
3	Давст	4468	4468	0,06	13424	0,19
4	Зүүнхангай	31674	30516	0,4	25011	0,36
5	Малчин	6801	6832	0,09	9097	0,13
6	Наранбулаг	7039	7061	0,1	6743	0,09
7	Өндөрхангай	43089	45234	0,6	41697	0,60
8	Сагил	14043	12115	0,2	16949	0,24
9	Тариалан	2477	1222	0,02	2997	0,04
10	Түргэн	22007	17158	0,2	18879	0,27
11	Тэс	1370	2370	0,03	47629	0,69

12	Ховд	2151	6415	0,09	5045	0,07
13	Хяргас	9037	9042	0,12	10102	0,14
14	Цагаанхайрхан	17377	16260	0,2	15879	0,23
15	Улаангом	4340	4917	0,07	4051	0,05
	Дүн	<b>185969</b>	<b>174930</b>	<b>2,6%</b>	<b>236629</b>	<b>3,4%</b>

Газрын төрөл, таксацийн дундаж үзүүлэлт, насны бүлгийн өөрчлөлтүүдээс үзэхэд ойн сангийн газрын төрлийн өөрчлөлт ойн сангийн талбай нийт дүнгээрээ нэмэгдэж гарсан байна. Энэ нь Тэс, Зүүнговь сумдыг шинээр ойн сангийн бүртгэл тооллогод орсон учраас ерөнхий дүнгээрээ нэмэгдсэн үзүүлэлт гарч байгаа бөгөөд мөн урьд жилүүдэд орхигдуудсан байсан жижиг төгөл болон гол дагасан улиас, сөөг торлог зэргийг 2011 оны ой зохион байгуулалтаар нэмж авсан учир нийт ойн сангийн талбай нэмэгдсэн болно.


### **7.6. Ойг нөхөн сэргээх шаардлага**

Ойн санд учирч байгаа хорогдол хомсдлыг хязгаарлах, багасгахад ойг нөхөн сэргээх ажил чухал үүрэгтэй. Ойг нөхөн сэргээх ажил бол мод бэлтгэсэн, түймэрт шатсан, хөнөөлт шавжид нэрвэгдэж ойгүй болсон ойн талбай болон сэргэн ургалт хангалтгүй явагдаж байгаа газрыг ойжуулах, ойн байгалийн сэргэн ургалтад туслах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэн гүйцэтгэх явдал юм.

Ой нь уур амьсгалын эрс тэс хэлбэлзлийг зөөлрүүлэх, чийгийн хуримтлал хангамжийг сайжруулах, хөрсийг ус салхины элэгдлээс хамгаалах, элсний нүүлт хөдөлгөөнийг тогтоон барих, голын усны түвшин, гадаргын урсацыг тохируулах зэргээр хүрээлэн байгаа орчиндоо олон чухал хамгаалах үүргийг давхар гүйцэтгэдэг нөхөн сэргээгдэх чадвар бүхий байгалийн үнэт баялаг юм. Тиймээс ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглахын тулд экологийн тэнцвэрийг хадгалахад чиглэгдсэн үйл ажиллагааг зайлшгүй авах шаардлагатай юм.

### **7.7. Ойг хамгаалах арга хэмжээний талаар**

Ойн сангийн нийт талбайн 94.84 хувийг хамгаалалтын бүсийн ой, 5.1 хувийг ашиглалтын бүсийн ой эзэлж байна. Ойг хамгаалах арга хэмжээнд ойг түймэр, хөнөөлт шавж, өвчнөөс хамгаалах, хууль бус мод бэлтгэлийг хязгаарлах, ойн санг тусгай хамгаалалттай газар нутагт хамруулах, ойн санг нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох зэрэг арга хэмжээ багтана. Ойн сангийн газартай давхцаж байгаа уурхайн хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн давхцлыг дараах зураг, хүснэгтээр харуулав.



Зураг № 7.2. Ойн сангийн газартай давхцаж байгаа уурхайн хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн байршил

Хүснэгт № 7.14. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон ойн сангийн талбай, мян.га

Д/д	Аймгуудын нэр	Ойн сан	Давцаж буй ойн талбай	Эзлэх хувь
1	Увс	185,6	56,5	30,44

### 7.7.1 Ойг түймрээс хамгаалах арга хэмжээний талаар

Тухайн жилийн цаг уурын хуурайшилт, хур тунадасны байдлаас шалтгаалан жил бүр гарах түймрийн тоо, учруулсан хохирол харилцан адилгүй байдаг. Ерөнхийдөө хүснэгтээс харахад түймрийн тоо, нэмэгдсэн байгаа нь харагдана.

Төв, орон нутагт ойн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хангалтгүй анхаарч, түймэр гарсаны дараа унтраахад их хэмжээний хүн хүч, хөрөнгө зарцуулж байна.

Хүснэгт № 7.15. 2009-2012 онд гарсан ойн түймрийн тоо

Д/д	Аймаг	2009	2010	2011	2012
1	Увс аймаг	3	2	1	3

Увс аймгийн хувьд 2009-2012 оны хооронд 9-н удаа гал түймэр гарсан байна. Галыг унтраахад их хэмжээний хүн хүч, хөрөнгө зарцуулж хохирол учирсан байна. 2012 оны байдлаар 3-н удаагын гал түймэрт нийт 152 га газрын ой мод шатаж үгүй болсон байна. Энэ нь Увс аймгийн нийт ойн сангийн 0.1 хувь юм.

**7.7.2. Ойн хөнөөлт, шавьж, өвчнөөс хамгаалах арга хэмжээний талаар**

2012оны байдлаар хортон мэрэгчид өртсөн газрын хэмжээ 27900 га газар байгаа нь Увс аймгийн нийт ойн сангийн 15.6 хувийг эзэлж байна. Аймгийн хувьд ойн хөнөөлт, шавьж хортон мэрэгчдээс хамгаалах арга хэмжээг нэн даруй авах шаардлагатай байна.

*Хүснэгт № 7.16. Увс аймагт явуулсан ойн зохион байгуулалт /оноор/*

№	Аймгийн нэр	Ой зохион байгуулалт хийгдсэн он	Ойн сангийн талбай, /мян.га/
1	Увс	2011	236.6

2011 онд явуулсан ойн зохион байгуулалтаар 236.6 мян.га газрын ойг хамгаалах зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан. Увс аймгийн ойн санд 1990 онд ой зохион байгуулалтын ажлыг тус аймгийн ойн санг бүрэн хамруулан хийж 2002 онд “Ойн хайгуул төслийн төв”, Ханхөхийн нурууны БЦГазрын хэмжээнд, 2007 онд “Хөвчийн хоймор”ХХК нь Түргэн уулын ДЦГ, Цагаан шувуутын ДЦГазрын хүрээнд хэсэгчилэн хийгдсэн байдаг бөгөөд үүнээс өөр ойн сангийн талаарх судалгаа хийгдээгүй байна.

“Гранд форест” ХХК 2011 онд Увс аймгийн ойд ой зохион байгуулалтын хийж, 1990, 2002, 2007 оноос хойш ойн санд орсон өөрчлөлтийг гаргаж, таксацын үндсэн үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоожээ.

**7.8. Ойн төлөв байдал, чанар үнэлгээ, таксацын үзүүлэлтийн өөрчлөлт**

2011 онд шинэчлэн хийсэн ой зохион байгуулалтын материалын газрын төрлийн өөрчлөлтийн хүснэгтээс үзэхэд ойгоор бүрхэгдсэн талбайн ангилалд байгалийн ойн талбай 62563 га-р нэмэгдэж бут сөөг 4948 га талбайгаар хасагдан, харин ойгоор бүрхэгдээгүй талбайн тармаг 19328 га-р, шатсан ой 1179 га-р нэмэгдсэн бол мод бэлтгэсэн талбай 5109 га-р, ойжуулсан 191 га, ойжих 945 га талбайгаар тус тус хасагдсан, ойн бус талбайд цагаан энгэр 7955 га-р тус тус хасагдаж, нийт ойн талбай 63953 га – р нэмэгдэн гарсан байна.

Таксацын дундаж үзүүлэлтээс үзэхэд байгалийн ойн нөөц 2391470 м<sup>3</sup>, болц гүйцсэн хөгшин ойн талбай 8093.12 га талбайгаар нэмэгдэж, болц гүйцсэн хөгшин ойн нөөц 263130 шоо.метрээр багассан байна. Ойн бүх дундаж өсөлт 680339 шоо.метрээр дундаж бонитет 0.22 -оор нэмэгдсэн ба өтгөрөл 0.06, Болц гүйцсэн хөгшин ойн 1 га-н нөөц 13.33 шоо.метрээр хасагдаж Ойгоор бүрхэгдсэн талбайн 1 га-н нөөц 31.56 шоо.метрээр багасаж өсөлт нь 0.03 шоо.метрээр нэмэгдэж гарсан байна.

Насны бүлгийн өөрчлөлтөөс харахад залуу ойн талбай 933 га талбай, нөөц нь 43540 шоо.метр, дунд насны ойн талбай 32093 га талбайгаар нэмэгдэж нөөц нь 66790 шоо.метрээр багассаг, болц гүйцэж яваа ойн талбай 24873 га, нөөц нь 2764930 шоо.метр, болц гүйцсэн ойн талбай 7380 га талбайгаар нэмэгдэж, нөөц нь 263130 шоо.метрээр багассаг нийт дүнгээрээ талбай нь 62563 га-аар нөөц нь 2391470 шоо.метрээр нэмэгдэж гарсан байна.



## Хүснэгт№ 7.17. Увс аймгийн таксацын дундаж үзүүлэлтийн өөрчлөлт /2002-2007,2011 оны өөрчлөлт/

Модны төрөл	Он	Байгалийн ойн талбай, га	Бүх нөөц ш.м	Б.Г.Х ойн талбай, га	Б.Г.Х ойн нөөц ш.м	Бүх дундаж өсөлт ш.м	Дундаж			Б.Г.Х ойн 1га-н нөөц ш.м	Ойгоор бүрхэгдсэн талбайн 1-га-н	
							нас, жил	бонитет	өтгөрөл		Нөөц, ш.м	өсөлт. ш.м
<b>Аймгийн хэмжээгээр</b>												
Шинэс	2011	136747	18904610	99658	14131410	142904	131.07	4.56	0.53	139.66	138.87	1
	2002-2007	122360	17684620	95118	14540080	119186	148.37	4.37	0.55	152.86	144.52	0.97
Зөрүү		+14387	+1219990	+4540	-408670	+23718	-17	+0.19	-0.02	-13.20	-5.56	-
Хуш	2011	1527	249720	24	6720	1817	144.75	4.52	0.57	56	172.79	1.15
	2002-2007	1516	258930	381	69660	1770	146.23	4.30	0.52	182.83	170.79	1.16
Зөрүү		+11	-9210	-357	-62940	+47	-1.48	+22	+0.05	-126.83	+2	-
Хус	2011	1315	44120	280		1284	31.54	4.82	0.47		31	0.96
	2002-2007	4626	135640	270	20250	2368	57.26	4.79	0.47	75.0	29.32	0.51
Зөрүү		-3311	-91520	+10	-20250	-1084	-25.72	+0.03	-	-75.0	+1.06	+0.44
Гацуур	2011	330	34070	433.12		322	108.28	4.5	0.55		102	1.11
	2002-2007	143	18590	143	18590	143	130.0	5.0	0.50	130.0	130.0	1.0
Зөрүү		+187	+15480	+290.12	-18590	+179	-21.72	-0.5	+0.5	-130.0	-28	+0.11
Улиас	2011	11140	707330	4381	319040	12730	51.31	4.45	0.49	74.87	65	1.3
	2002-2007											
Зөрүү		+11140	+707330	+4381	+319040	+12730	+51.31	+4.45	+0.49	+74.87	+65	+1.3
Улиангар	2011											
	2002-2007	6139	472420	771	71720	8775	53.83	4.96	0.46	93.02	76.96	1.42
Зөрүү		-6139	-472420	-771	-71720	-8775	-53.83	-4.96	-0.46	-93.02	-76.96	-1.42
Бургас	2011	41678	1021820	0		41225	25.74	4.89	0.39		21	0.99
	2002-2007											
Зөрүү		+41678	+1021820	0		+41225	+25.74	+4.89	+0.39		+21	+0.99
Дүн	2011	197347	20961670	104776.12	14457170	200282		4.62	0.49	138.92	106.21	1.01
	2002-2007	134784	18570200	96683	14720300	132243		4.40	0.55	152.25	137.77	0.98
Зөрүү		+62563	+2391470	+8093.12	-263130	+680339		+0.22	-0.06	-13.33	-31.56	+0.03

Дээрхи хүснэгтээс үзэхэд Увс аймгийн ойн сангийн талбай 2002-2007 оны ой зохион байгуулалтаар 185,5 мян.га талбайтай, нөөц нь 19152,0 мян.м3 шоометр байсан бол 2011 оны ОЗБ-ын ажлаар ойн сангийн талбай 236629 га, нөөц 20961670 шоометр болж өөрчлөгдсөн байна.

### 7.9. Сүүлийн жилүүдэд ойг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хийгдсэн ажлууд

#### Ой, хээрийн түймрээс хамгаалах талаар

Жил бүр Аймгийн Засаг даргын захирамжаар түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын хэсэг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулан ажиллаж иржээ. Аймгийн БОАЖГ, ОБХ, Улаан загалмайн хороотой хамтран “Түймрээс хамгаалах” үзүүлэх сургалтыг бүсчлэн зохион байгуулан, хариуцлагын гэрээ байгуулах, гарын авлага материал, түймэртэй тэмцэх багажаар хангах зэрэг арга хэмжээ авч ирсэн байна.

2010 онд Баруунтуруун суманд байгуулсан ойн үрийн талбайг түймрээс хамгаалах ойн харлуулсан зурвасыг 6 км урттайгаар байгуулсан ба 2011 онд Сагил сумын ойн санд буюу хилийн онцгой хамгаалалтын бүсэд 44 км зурвас байгуулах зэргээр ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг зохион байгуулж, зохих үр дүнд хүрсэн байна. Гэвч сүүлийн 5 жилд 15 суманд 23 удаа ой хэрийн түймэр гарч, байгаль экологид 2.4 тэр бум төгрөгний хохирол учруулжээ. Мөн түүнчлэн аймгийн хэмжээнд явуулсан ой зохион байгуулалтын материалаас үзэхэд түймэрт нэрвэгдсэн 2042 га ойн талбай байна. Увс аймагт 2009-2013 онд гарсан ой, хээрийн түймрийн судалгааг хүснэгт № 7.19.-д харуулав.

*Хүснэгт № 7.19. Увс аймагт 2009-2013 онд гарсан ой, хээрийн түймрийн судалгаа*

Д/д	Үзүүлэлт	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	Дүн
1	Түймэр гарсан сумын тоо	3	2	1	6	3	15
2	Гарсан түймрийн тоо	2	2	1	11	7	23
3	Бүгд шатсан талбай га	2427,5	140	264	1761	1094	5686.5
4	Экологийн хохирол сая.төг	808.79	17.238.62	352.70	1021.04	226.17	2425.0
5	Нийт хохирол сая.төг	808.79	17.238.62	352.70	1021.04	226.17	

#### Ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх талаар

Сүүлийн жилүүдэд ойн хөнөөлт шавьж, өвчний тархалтын судалгаа явуулах, түүнтэй тэмцэх ажлыг зохион байгуулж, зохих үр дүнд хүрсэн хэдий ч одоо аймгийн хэмжээгээр зайлшгүй тэмцэл явуулах шаардлагатай 30437 га ойн талбай байгаа юм. Сүүлийн 5 жилд ойн хөнөөлт шавьж, өвчинтэй хийсэн тэмцлийн хэмжээг Хүснэгт № 7.20.-д харуулав.

*Хүснэгт № 7.20. Ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцсэн талбай*

д/д	Аймаг	2009	2010	2011	2012	2013	Дүн
		1650	21225	6400	11054	7500	47829



Зураг № 7.3. Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцсэн талбай

### Хамтын эзэмшлийн ойн менежментийг хөгжүүлэх

Ойг хамгаалах арга хэмжээний чухал нэг хэсэг бол ойн сангийн тодорхой хэсгийг ойн нөхөрлөлд эзэмшүүлэх явдал юм.

2013 оны жилийн эцсийн байдлаар 27 ойн нөхөрлөл 570 гаруй гишүүнтэй, дундаж өрхийн тоо 7 өрх, аймгийн хэмжээнд 22000 гаруй га талбай бүхий ойн сан эзэмшиж, хамгаалж байгаа бөгөөд нийт ойн сангийн 10 гаруй хувийг эзэлж байна. Ойн нөхөрлөлүүдийг чадавхижуулах, үйл ажиллагааг дэмжин, мэргэжлийн түвшинд ажиллуулах, нөхөрлөлийн гишүүдэд ойн анхан шатны мэдлэг олгох тал дээр анхааран ажиллаж, АСБТЗАИОХТ-ийн санхүүжилтээр МУИС-ын ой судлалын тэнхимийн 2 доктор багшийг урин Улаангомд 7 хоногийн сертификатын боловсрол эзэмшүүлсэн ба сургалтад 22 ойн нөхөрлөлийн гишүүн оролцож, ойн аж ахуйн арга хэмжээг хөтлөн явуулах анхан шатны мэдлэгтэй боллоо.

Мөн 11 нөхөрлөлийн ойн санд улсын төсвийн хөрөнгөөр ой зохион байгуулалтын ажлыг хийлгэжээ. Ойн албанаас 2011 онд 10 нөхөрлөлд загвар Ойн менежмент төлөвлөгөөг нь боловсруулж, хүлээлгэн өгсөн байна. 2011 онд Ойн газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын даргын тушаалын дагуу 7 нөхөрлөл тус бүр 10-15 га талбайд ойн цэвэрлэгээний ажил хийлгэсэн ба нөхөрлөлийн гишүүдэд чадавхижуулах сургалтыг явуулах, нөхөрлөлөөр ойг цэвэрлүүлэх, дагалт баялгийг ашиглуулах, гарын авлага материал болон багаж материалаар хангах зэргээр хамтран ажиллаж байна. Ойн нөхөрлөлийн судалгааг гаргаж, хүснэгт 7.20.-д харуулав.

## Хүснэгт № 7.20. Ойн санг гэрээгээр эзэмшиж буй нөхөрлөлийн судалгаа

№	Сумын нэр	Нөхөрлөлийн нэр	ИТХ-ын Шийдвэр Он, сар	Талбайн Хэмжээ /га/	Гишүүдийн тоо	Нөхөрлөлийн тоо					
						Үүнээс					
						ОЗБ хийгдсэн	ОЗБ хийгдээгүй	ОМТ хийж батлуулсан	ОМТ-гүй	Гэрчилгээ тэй	Гэрчилгээ гүй
1	Тариалан	Хангайн хишиг	2009.05.11 Дугаар 06	257	31	+		+		+	
		Овоот	2009.05.11 Дугаар 06	519	60	+				+	
2	Бөхмөрөн	Шар харгай	2009.12.29 Дугаар 12		24		+			+	
		Бураан төгөл	2009.12.29 Дугаар 12	545	23	+				+	
3	Ховд	Баялаг шар мод	2011.01.24 Дугаар 03	10	38		+		+	+	
		Баялаг тулга	2011.01.24 Дугаар 03	12	18		+		+	+	
4	Сагил	Харгайт	2009.05.06 Дугаар 23	1121	42	+		+		+	
		Хөх харгай	2009.05.26 Дугаар 29	888	27	+		+		+	
		Баянзүрх	2009.05.06 Дугаар 23	1966	32	+		+		+	
		Хар мод	2010.03.05 Дугаар 9	766		+			+		+
		Жинст хайрхан	2010.02.10 Дугаар 8	-			+		+		+
5	Түргэн	Арвижих рашаант	2009.12.27 Дугаар 32	248	62	+		+		+	
		Атар бөөрөг	2009.07.26 Дугаар 16	595	24	+		+		+	
6	Улаангом	Баянзуух	2009.02.12 Дугаар 32	278	35	+		+	+	+	
		Мөст	2010.06.28 Дугаар 75				+	+	+	+	
		Түвшин төгөлдөр хархираа	2009.02.12 Дугаар 32	1938	30	+		+		+	
		Түргэн ар бэл	2010.06.28 Дугаар 75				+		+	+	
		Хархираан тахилга	-	81			+		+	+	
7	Давст	Тусч баг	2010.09.20 Дугаар 34		11		+		+	+	
8	Малчин	Нутгийн хишиг	2010.03.18 Дугаар 12	850	9		+		+	+	
9	Өндөрхангай	Хөхийн хишиг		2229	10	+		+	+	+	
		Хорин булаг		2363	12	+			+	+	
10	Цагаанхайрхан	Бугантолгой	2004.07.05 Дугаар 15	1390	10	+			+	+	
		Чинхөгжил	2008.10.15 Дугаар 25	930	10	+			+	+	
11	Зүүнхангай	Соого нуур		4490	8	+			+	+	
		Таван цонж					+		+	+	
12	Тэс	Эвт шаазгай	2011.05.10 Дугаар 12	-	48		+		+	+	
<b>Дүн</b>		<b>27</b>		<b>21476</b>	<b>564</b>	<b>1</b>					

Ойг зөв зохистой ашиглах талаар

Увс аймгийн хувьд арчилгаа цэвэрлэгээний огтлолтоор ахуйн зориулалтын хэрэглээний мод болон иргэд, айл өрхийн түлээний хэрэгцээг хангадаг Ахуйн зориулалтаар хэрэглээний модыг /сургууль, цэцэрлэг, эмнэлэг, конторын барилга болон айлын хашаа, байшин малын хашаа барих гүүр тавих гэх мэт/ түймэрт шатсан, ойн хөнөөлт шавжид нэрвэгдэн сэргэн ургах чадвараа бүрэн алдсан ойгоос цэвэрлэгээний журмаар авч ашиглаж байна. Айл өрх, албан байгууллага, аж ахуй нэгжүүдийн түлш, малчдын хашаа саравч, иргэдийн ахуйн болон орон сууцны хэрэгцээнд зориулж ойгоос ашиглаж болох хэрэглээний модыг ойн арчилгаа, цэвэрлэгээгээр төсөлд заасны дагуу зөв зохистой ашиглуулах нь зүйтэй юм. Иймээс орон нутгийн ард иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хэрэгцээг ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх замаар шийдвэрлэх нь зүйтэй юм. Мөн хамтлаг нөхөрлөлүүд эзэмшлийн ойгоосоо ойн цэвэрлэгээний журмаар түлшний мод бэлтгэх боломжтой юм.

*Хүснэгт № 7.21. Увс аймагт сүүлийн 5 жилд арчилгаа цэвэрлэгээний огтлолтоор бэлтгэсэн модны хэмжээ*


Д/д	Сумын нэр	5 жилд арчилгаа цэвэрлэгээгээр бэлтгэсэн модны хэмжээ шоо.м	5 жилийн дундаж	2013 онд бэлтгэсэн модны хэмжээ
1	Баруунтуруун	10387	2077	2307
2	Бөхмөрөн	6591	1318	430
3	Давст	10375	2075	1927
4	Зүүнхангай	15401	3080	3500
5	Малчин	11668	2333	1860
6	Наранбулаг	7169	1433	1012
7	Өндөрхангай	23877	4775	5167
8	Сагиль	13888	2777	1112
9	Тариалан	1431	286	212
10	Түргэн	11595	2319	2158
11	Тэс	19845	3969	2586
12	Ховд	17380	3476	1150
13	Хяргас	11822	2364	2318
14	Цагаанхайрхан	13862	2772	2567
15	Улаангом	9948	1989	2675
	Аймгийн дүн	187798	37559	30981

Ойг нөхөн сэргээх арга хэмжээний талаар


Энэ арга хэмжээнд тарьц суулгац бойжуулах, ойг тарьж ургуулах, байгалийн сэргэн ургалтанд туслах ажлууд багтаж байна. Ойжуулалтын ажлыг гол усны эх, ай савыг ойжуулах, цөлжилтийг бууруулах, усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хамгаалалтын ойн зурвас байгуулахад чиглүүлэх зорилт тавин ажиллажээ. Хүснэгт 7.22. сүүлийн 5 жилд хийгдсэн ойжуулалтын ажил болон байгалийн сэргэн ургалтанд туслах арга хэмжээг сумдаар харуулав.

## Хүснэгт№ 7.22. Увс аймгийн сүүлийн 5 жилийн ойг нөхөн сэргээлтийн арга хэмжээ

д/д	Сумын нэр	Ойжуулалт /га/					Дүн	Байгалийн сэргэн ургалтанд туслах /га/					Дүн
		2009	2010	2011	2012	2013		2009	2010	2011	2012	2013	
1	Баруунтуруун			30	20		50	50	40				90
2	Бөхмөрөн			50	20		70						
3	Давст				30		30						
4	Зүүнхангай						-						
5	Малчин		10	40			50						
6	Наранбулаг		30				30						
7	Өндөрхангай	43	20	30	30		123						
8	Сагил	30	30				60						
9	Тариалан			30			30						
10	Түргэн						-						
11	Тэс					10	10	40					40
12	Ховд						-						
13	Хяргас			20	30		50						
14	Цагаанхайрхан						-						
15	Улаангом	70	120	40		65	295						
16	Өмнөговь						-						
17	Өлгий						-						
18	Завхан					15	15						
19	Зүүнговь	80					80						
	<b>Аймгийн дүн</b>	<b>223</b>	<b>210</b>	<b>240</b>	<b>130</b>	<b>90</b>	<b>893</b>	<b>50</b>	<b>80</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>130</b>



Зураг№ 7.4 Ойжуулалтын ажил 2009-2012 он /га/



Зураг№ 7.5. Бүх нийтээр мод тарих өдрөөр тарьсан модны тоо 2009-2012 /тоо, ш/

Мод үржүүлэг, тарьц суулгацын талаар

Ойжуулалтын ажлын хэмжээ нэмэгдэхийн зэрэгцээ бүх нийтээр мод тарих хөдөлгөөн өрнөсөнөөр аймгийн хэмжээнд тарьц суулгацын эрэлт хэрэгцээ нэмэгджээ. Иймээс Ойн албанд жил бүр “Тарьц суулгацын бирж”-ийг ажиллуулж тарьц суулгац худалдан борлуулах, авах хүсэлтэй иргэдийг хооронд нь зуучлах ажлыг зохион байгуулж, тэдэнд мэргэжлийн арга зүйн зөвөлгөө өгч ажиллажээ.

Увс аймгийн Мод үржүүлэх газруудын тарьц, суулгацын товчоог хүснэгт№7.23.-д үзүүлэв.

*Хүснэгт№ 7.23. Увс аймгийн Мод үржүүлэх газруудын тарьц, суулгацын тоо /товчоо/*

№	Модны нэр	Ургуулсан тарьцны тоо			Ургуулсан суулгацны тоо			Нийт
		1 нас	2-3 нас	4-с дээш	1 нас	2-3 нас	4-с дээш	
1	Хайлаас	136000	65900					201900
2	Улиас				42800	106000		148800
3	Бургас				79200	44000		123200
4	Шар хуайс	24000	46000					70000
5	Чацаргана				558000	406000		964000
6	Бүйлс	200	250					450
7	Гүйлс	300	250					550
8	гошлой				1200	2200		3400
9	голт бор	1000	500					1500
10	үхрийн нүд				52000	15150		67150
11	улаалзгана		200					200
12	интоор	3000						3000
13	тэхийн шээг		700					700
14	Шинэс	12000	51000					63000
	<b>Нийт</b>	176500	164800	0	733200	573350	0	1647850




*Зураг№ 7.6. Мод үржүүлгийн талбайд ургаж буй суулгац*

Улсын ойн санд шилжүүлсэн таримал ой

Увс аймгийн нутаг дэвсгэрт өөрийн зардлаар тарьж ургуулсан чацаргана, үхрийн нүд, улиас бургас, хайлаас зэрэг навчит модоор ойжуулсан талбай нэлээд их байгаа нь Ногоон хэрэм үндэсний хөтөлбөрийн дэд хөтөлбөр болох Ногоонгом, Чацаргана хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн юм.

2009-2012 онд өөрийн хөрөнгөөр тарилт хийсэн иргэдийн таримал ойд тооллого хийж, чанар, амьдралтын хувь өндөртэй, технологийн дагуу таригдсан, цаашид бие даан ургах нөхцөл, амьдралт сайтай гэж үзсэн нийт 193,5 га талбайд таримал ойг Сангийн сайд, Байгаль орчны сайдын хамтарсан 2008 оны 02 сарын 28-ны өдрийн 90/36 тоот тушаалаар батлагдсан “Таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах журам”-ын дагуу үнэлэн авах боломжтой хэмээн дүгнэж, акт материалыг бүрдүүлэн Ойн газарт хүргүүлж улсын ойн санд бүртгэн авсан. Улсын ойн санд хүлээн авсан таримал ойн хэмжээг зураг№ 7.7.- үзүүлэв.



Зураг№ 7.7. Улсын ойн санд хүлээн авсан таримал ойн хэмжээ.




## НАЙМДУГААР БҮЛЭГ. УСАН САН БҮХИЙ ГАЗАР, УСНЫ САВ ГАЗРУУДЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

### 8.1. Ерөнхий байдал

Увс аймгийн хэмжээнд 2013 оны байдлаар усан сан бүхий газар нийт нутаг дэвсгэрийн 1.2 хувь буюу 85420.54 га газрыг эзэлдэг. Усны сан бүхий газарт мөрөн, гол 29979.1 га буюу 35.0 хувийг, нуур цөөрөм, тойром 54714.3 га буюу 64.0 хувийг, горхи, булаг шанд 727.14 га буюу 1.0 хувийг тус тус эзэлж байна.

*Хүснэгт№ 8.1. Усан сан бүхий газар /2013 оны газрын нэгдмэл сангийн ангиллаар/*

Сумдын нэр	Бүгд	Гол, мөрний эзлэх газар	Нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар	Горхи, булаг шандын эзлэх газар
Баруунтуруун	53	53		
Бөхмөрөн	16023	15385		
Давст	101	101		
Завхан	25347	22847	2500	
Зүүнговь	3114	146	2968	
Зүүнхангай	952	74	878	
Малчин	89		53.3	35.7
Наранбулаг	525.1	78.1	447	
Өлгий	495	10	485	
Өмнөговь	7996	1388	6608	
Өндөрхангай	905.94		459	446.94
Сагил	24323	243	24080	
Тариалан	968	671	282	15
Түргэн	275	272	3	
Тэс	3552	3091	461	
Ховд	229.5			229.5
Хяргас	78	67	11	
Цагаанхайрхан	122	28	94	
Улаангом	272	272		
<b>Дүн</b>	<b>85420.54</b>	<b>29979.1</b>	<b>54714.3</b>	<b>727.14</b>



Зураг№ 8.1. Сумдын усан сан бүхий газрыг талбайн хэмжээгээр графиклан харуулбал /га/-аар

### **8.1.1. Ус ашиглалтын одоогийн байдал**

**Үерийн далан:** Нийт 7 үерийн далан бүртгэгдсэн бөгөөд тэдгээрийн 6 далан нь 1980-аад оны дунд үед баригдсан, тодорхой нэр бүхий эзэмшигчгүй байна. Улаангом сумын Арсайн далан хагас дугуу бетон доторлогоотой, төслийн хэмжээнд хүрч баригдаагүй бусад нь шороон далан байв.

**Цэвэрлэх байгууламж:** Ариутгал татуургын цэвэрлэх байгууламж нь Улаангом сумын нутагт байрлах бөгөөд 2 станцтай. 1-р станц нь бүхэл хогийг шүүрээр шүүж аваад 2-р станцад шахаж хүргүүлэн 7 тунгаагуураар усаа тунгааж талбайн аргаар цэвэрлэгээ хийдэг.

Ариутгал татуургын цэвэрлэх байгууламж нь төвлөрсөн бохирын шугамаас ирэх бохирын усыг ерөнхийдөө механик аргаар цэвэрлэдэг. 2-р станцын тунгаагуураас гарсан усаа сувгаар хаяж хөрсөнд нэвчүүлдэг ба сувгийн төгсгөл нь “Гашууны гол”-д нийлдэг байна. Цэвэрлэх байгууламжыг “Чандмань Увс” ХХК хариуцан ажиллуулдаг байна.

Үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашиглагч арьс ширний “Дөрвөн булаг” үйлдвэр нь бохир усаа 2 сувгаар авч 1-р хэсгийг бохирын төвлөрсөн шугамд, химийн хорт бодис ашигласан хаягдал усыг бохирын 2-р цооногоос машинаар соруулан тээвэрлэж Адаргана уулын бэлд хөрсөнд нэвчүүлэн хаядаг байна.

**Ус ашиглалт:** Сав газарт ус ашиглагч 146 байгаагаас үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус ашиглагч байгууллага, иргэн 43, газар тариалангийн зориулалтаар ус ашиглагч байгууллага, иргэн 103 байна.

Улаангом сумын төвлөрсөн ус хангамжийн шугамын 1, 2-р станцуудыг Чандмань-Увс ХХК эзэмшдэг бөгөөд 2-р станц нь хэрэглэгчгүйгээс одоохондоо ашиглалтанд ороогүй байна.

1-р станц нь гүн өрмийн 4 худгаас тэжээгддэг 1500 м<sup>3</sup> багтаамжтай резерварт усаа хуримтлуулан түгээдэг бөгөөд Улаангом сумын төвд шахуу байрлана. Харин 2-р станцыг 2013 оны сүүлчээр ашиглалтанд хүлээлгэн өгсөн бөгөөд нийт 6 гүний худгийн усаар тэжээгдэн 4000 м<sup>3</sup> багтаамжтай бетонон резерварт усаа нөөцлөн хэрэглэгчдэд түгээх боломжтой юм. Шинээр ашиглалтанд орж буй цэвэр усны нөөцийн худгуудаас 2 худаг нь айлын хашаан дотор орсон, гэр хорооллын дунд хэсэгт гаргасан нь ариун цэврийн бүсийн нөхцлийг хангаагүй байна.

Үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашиглагчдын бүртгэл явуулах үед сав газрын хэмжээнд ус ашиглагч 146 иргэн, ААНэгж байгууллага бүртгэгдэв. Үүнээс хамгийн их ус ашиглагч Увс аймгийн Улаангом сумын хэмжээнд 96 ус ашиглагч байна. Үүнээс ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж байгууллага 22, хүнсний зориулалтаар 5, үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашиглагч 12, газар тариалангийн үйлдвэрлэлд жимс, чацаргана тариалагч 57 иргэн, аж ахуйн нэгж байрлаж байна.

Эдгээрээс халуун ус, сауны үйлчилгээ явуулж буй 14 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын ус ашиглалтын байдлыг харахад төвлөрсөн шугамаас ус ашиглагч иргэн байгууллага 4, бусад нь хувийн гүний худгийн эх үүсвэрээр үйл ажиллагаа явуулж байна. Бохирын шугамын байдлыг хянахад төвлөрсөн шугамд 4, бохирын цооногоос хөрсөнд нь

нэвчүүлж шингээх аргаар зайлуулдаг 2, цооногоос машинаар соруулан зөөвөрлөдөг 8 халуун ус, саун байна.

Хархираа голоос 8 чиглэлд суваг шуудуугаар ус авч Тариалан сумын 74 иргэн, 2 аж ахуйн нэгж байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг. Иргэд нийт 111 га-д үр тариа, хадлан, төмс хүнсний ногоо, жимс чацаргана тариалж ардын уламжлалт энгийн усалгаат газар тариалан эрхлэн амьдарч байна.

“Алтан дуулга” ХХКомпани нь хуучин Хархираагийн 2000 га-ийн усалтын системийн 250 га-д үр тариа, хадлан тариалж өөрийн даралтат “Фрегат” агрегатаар бороожуулах усалгааг хийж ажиллаж байна.

Хархираа голын ай сав газрын дагууд хүн амын төвлөрөл, суурьшил ихтэй, нутгийн ард иргэд нь ардын уламжлалт энгийн усалгаатай газар тариалан эрхэлдэгээс эдгээр голууд нь хамгийн их ачаалалтай гол болох нь харагдаж байгаа бөгөөд ус ашиглагчдын хэрэглээ нь гольдролын хэвийн урсацанд сөргөөр нөлөөлж байгаа болно.

Улаангом сум нь нийт 7043 өрхийн 25,1 мян хүн амтай, засаг захиргааны 11 багтай, газар нутаг 260,4 мян км квадрат бөгөөд сумын 150 иргэн 563 га-д, 17 аж ахуйн нэгж байгууллагууд 492-га талбайд дээрхи голуудаас усыг бух шуудуугаар татан авч газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэн амьжиргаагаа явуулдаг байна. Эдгээрээс зөвхөн жимс, чацарганы аж ахуйд 267 га-д тариалалт хийж ашиглаж байна.

Увс аймгийн төв Улаангом сум нь “Гашууны гол”-ын эрэг дагуу байрладаг. Ихэнхи ус ашиглагчид ус ашиглах зөвшөөрөл аваагүй, ус ашиглах дүгнэлтгүй, БО-ны нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээгүй үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт № 8.2. 2013 онд шинээр гаргасан худгийн тайлан

Шинээр гаргасан худгийн тоо	Үүнээс		Шинээр худаг гаргахад зарцуулсан хөрөнгө сая.төг	Үүнээс		
	Инженерийн хийцтэй	Энгийн уурхайн		Улсын төсвийн хөрөнгөөр сая.төг	Гадаад, олон улсын байгуулын төсөл, хөтөлбөр	Иргэд малчид өөрийн хөрөнгө сая.төг
35	31	4	575.7	475.1	77.8	22.8

2013 онд шинээр 35 худаг гаргаж, 22 худаг засварласан ба түүнд нийт 641.7 сая төгрөг зарцуулсны 83.9 хувь нь улсын төсвийн хөрөнгөөр, 12.5 хувь нь гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр, 3.6 хувь нь малчдын хамтын хөрөнгө буюу бусад эх үүсвэрээр санхүүжигдсэн байна.

Хүснэгт № 8.3. 2013 онд засварласан худгийн тайлан

Засварласан худгийн тоо	Үүнээс		худаг засварлахад зарцуулсан хөрөнгө сая.төг	Үүнээс		
	Инженерийн хийцтэй	Энгийн уурхайн		Улсын төсвийн хөрөнгөөр сая.төг	Гадаад, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр	Иргэд малчид өөрийн хөрөнгө сая.төг
22	12	10	65.9	63.5	2.3	0.1

## Хүснэгт № 8.4. Увс аймгийн бэлчээрийн усан хангамж

/Сүүлийн 15 жилд засварласан болон шинээр гаргасан худгийн судалгаа/

Он	Зассан инженерийн хийцтэй худаг	Шинээр гаргасан инженерийн хийцтэй худаг	Хөрөнгийн эх үүсвэр /мян.төг/	Хамрагдсан сум	Бэлчээрийн усан хангамжийн хувь	Усжуулагдсан бэлчээр /га/	Гүйцэтгэсэн компаний нэр
1999	Өрөмдмөл худаг-1 Богино хашлагат- 2, богино яндант-7		Улсын төсөв	Бөхмөрөн, Тариалан, Давст, Наранбулаг, Завхан	33.8	11000	"Ус эрдэнэ" ХХК
2000	Өрөмдмөл худаг-7 Богино хашлагат- 2,		Улсын төсөв	Малчин, Өндөрхангай, Баруунтуруун, Өлгий, Өмнөговь, Зүүнхангай, Зүүнговь	38.3	76000	"Ус эрдэнэ" ХХК
	Өрөмдмөл худаг-9 Богино хашлагат- 24, богино яндант-1		Кёкүшюзан хөгжлийн сан	Тэс, Наранбулаг, Завхан, Ховд, Давст, Зүүнговь, Өндөрхангай, Сагил, Бөхмөрөн, Малчин, Өлгий, Хяргас, Цагаанхайрхан			"Ус эрдэнэ" ХХК
	Өрөмдмөл худаг-1		Германы ЭСЯ-ны хөрөнгөөр	Малчин			"Ус эрдэнэ" ХХК
	Өрөмдмөл худаг-2		Швецарийн Засгийн газрын хөрөнгөөр	Түргэн			"ССТ-Од"
	<b>Бүгд дүн 46</b>						
2001	Өрөмдмөл худаг-4		Өвсний үндэс	Завхан			"Ус эрдэнэ" ХХК
	Өрөмдмөл худаг-5 Богино хашлагат- 1		Ус хөтөлбөр 21	Өмнөговь, Тариалан, Тэс, Зүүнговь, Баруунтуруун	39.3	90000	"Ус эрдэнэ" ХХК
	<b>Бүгд дүн 10</b>						
2002	Өрөмдмөл худаг-3 Богино хашлагат- 1, Энгийн уурхай 1		Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн төсөл ХААСХТөсөл	Ховд, Зүүнхангай	39.8	98000	"БТБ-МСС" ХХК
	<b>Бүгд дүн 5</b>						
2003	Өрөмдмөл худаг-6 Богино хашлагат- 2,		Өвсний үндэс	Бөхмөрөн	43.2	160000	"Ус эрдэнэ" ХХК
	Өрөмдмөл худаг-1		Гаалийн ерөнхий газар	Сагил			"ССТ-Од" ХХК
	Өрөмдмөл худаг-20 Богино хашлагат- 5,		ХААСХТөсөл	Өлгий, Өмнөговь, Бөхмөрөн, Сагил, Давст			"БТБ-МСС" ХХК
	<b>Бүгд дүн 34</b>						

2004	Өрөмдмөл худаг-16 Богино хашлагат- 3,		ХААСХТөсөл	Хяргас, Баруунтуруун, Малчин, Тариалан, Улаангом, Завхан	47.5	204000	"БТБ-МСС" ХХК		
	Өрөмдмөл худаг-18 Богино хашлагат- 6,		ӨАЧД төсөл	Баруунтуруун, Зүүнговь, Тэс, Завха НаранбулагМалчин, Хяргас, Түргэн, Өндөрхангай, Цагаанхайрхан			"Ус эрдэнэ" ХХК		
	<b>Бүгд дүн 44</b>								
2005	Өрөмдмөл худаг-9 Богино хашлагат- 1,		ХААСХТөсөл	Малчин, Түргэн, Тариалан, Наранбулаг, Зүүнхангай	60.6	255000	"БТБ-МСС" ХХК		
	Өрөмдмөл худаг-11 Богино хашлагат- 5, богино яндант-5		ӨАЧД төсөл	Баруунтуруун, Зүүнговь, Тэс, Завхан, Наранбулаг, Малчин, Хяргас, Түргэн, Өндөрхангай, Цагаанхайрхан			"Ус эрдэнэ" ХХК		
	<b>Бүгд 31</b>								
2006		Өрөмдмөл худаг 12	Улсын төсөв	Өмнөговь, Завхан, Наранбулаг, Зүүнхангай, Баруунтуруун, Хяргас, Тэс, Улаангом, Түргэн	54.2	317000	"Ус эрдэнэ" ХХК		
	<b>Бүгд 12</b>								
	Өрөмдмөл худаг-13 Богино хашлагат- 3, богино яндант-9		Улсын төсөв	Ховд, Өмнөговь, Өлгий, Сагил, Давст, Наранбулаг, Өндөрхангай, Цагаанхайрхан, Улаангом, Тариалан			"БТБ-МСС" ХХК		
<b>Бүгд 25</b>									
2007	Өрөмдмөл худаг-25 Богино хашлагат- 1,	Өрөмдмөл худаг-13	Улсын төсөв	Малчин, Тэс, Сагил, Өлгий, Цагаанхайрхан, Зүүнговь, Завхан, Давст	61.7	467000	"БТБ-МСС" ХХК		
		Өрөмдмөл худаг-12 Богино хашлагат- 1,	Улсын төсөв	Өндөрхангай, Завхан, Малчин			"БТБ-МСС" ХХК		
		Өрөмдмөл худаг-14	Улсын төсөв	Ховд , Бөхмөрөн, Сагил, Өмнөговь,			"ССТ-Од" ХХК		
		Өрөмдмөл худаг-10	Улсын төсөв	Наранбулаг, Өндөрхангай Давст, Малчин			"Ус эрдэнэ" ХХК		
	<b>Бүгд 50</b>								
2008	Өрөмдмөл худаг-10 Богино хашлагат- 3,	Өрөмдмөл худаг-28	Улсын төсөв	Тэс, Зүүнговь, Баруунтуруун, Зүүнхангай, Өндөрхангай, Малчин, Хяргас, Наранбулаг, Завхан, Өмнөговь, Улаангом, Сагил, Тариалан, Өлгий, Түргэн	65.8	539000	"Энержи флоу констракшн"ХХК, "Ус-эрдэнэ" ХХК "ССТ-од" ХХК		
	<b>Бүгд 13</b>		<b>Бүгд 28</b>						

2009	Өрөмдмөл худаг-15	Улсын төсөв	Өндөрхангай, Зүүнхангай, Улаангом, Хяргас, Малчин, Баруунтуруун, Зүүнговь, Ховд, Өмнөговь, Бөхмөрөн	67.3	569000	"Энержи флоу констракшн"ХХК, "Ус-эрдэнэ" ХХК
	<b>Бүгд 15</b>					
2010	Өрөмдмөл худаг-19	Улсын төсөв	Давст, Өмнөговь, Бөхмөрөн, Түргэн, Хяргас, Улаангом, Наранбулаг, Малчин, Тэс, Зүүнговь, Өндөрхангай, Цагаанхайрхан, Завхан	69.3	607000	"Энержи флоу констракшн"ХХК, "Ус-эрдэнэ" ХХК
	<b>Бүгд 19</b>					
2011	Өрөмдмөл худаг-28	Улсын төсөв	Давст, Өмнөговь, Бөхмөрөн, Хяргас, Улаангом, Наранбулаг, Малчин, Тэс, Зүүнговь, Өндөрхангай, Өлгий Цагаанхайрхан, Завхан, Тариалан, Баруунтуруун, Зүүнхангай, Сагил,	71.8	659000	"Энержи флоу констракшн"ХХК, "Ус-эрдэнэ" ХХК
	<b>Бүгд 28</b>					
2012	Өрөмдмөл худаг-19	Улсын төсөв	Ховд, Давст, Түргэн, Өндөрхангай, Зүүнхангай, Малчин, Хяргас, Цагаанхайрхан, Наранбулаг, Өлгий, Өмнөговь, Зүүнговь, Баруунтуруун, Завхан	73.7	697000	"Энержи флоу констракшн"ХХК, "Ус-эрдэнэ" ХХК
	<b>Бүгд 19</b>					
		Бүгд 25				

### Услалтын систем

Хүснэгт № 8.5. Увс аймгийн услалтын системийн жагсаалт

/Эх үүсвэр: Баруун бүсийн ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөө/

№	Аймгийн нэр	Услалтын системийн нэр	Ашиглалтанд орсон он	Төслийн анхны хүчин чадал /га/	2012 оны байдлаар/га/
1	Увс	Шаазгай нуур	1976	60	0
2		Завхан	1976	400	0
3		Тэсийн гол	1979	2000	0
4		Нарийн гол	1979	106	0
5		Хар хаг	1976	156	0
6		Сондуултай	1979	71	0
7		Улаантолгой	1979	475	100
8		Хилэнцэг	1979	150	0
9		Улаанбулаг	1980	74	0
10		Хархираа	1982	2084	300
11		Тээлийн боом	1983	570	0
12		Хар бураагийн эх	1983	130	0
13		Улаанхотгор	1988	584	100
14		Баруунтуруун	1990	1909	600

Увс аймагт бүртгэлтэй байгаа 10 услалтын системийн 3 нь хагас дутуу, бусад нь бороожуулах тоног төхөөрөмж нь тоногдон сүйдсэнээс хүчин чадлын хэмжээнд хүрч ажиллаж чадахгүй болж уламжлалт усалгааны аргаар ашиглагдаж байна.

Тариалан сумын Тээлийн гол дээр байгаа ус хуримтлуулах усан сангийн боомтыг 2007 онд төслөөр сэргээсэн бөгөөд Наранбулагийн услалтын системийн бетонон сувагтай холболтгүй барьсан байна. Үүнээс шалтгаалан Тээлийн боом нь урсацын тохируулга хийх боломжгүй болсон ба ашиглагчид нь ашиглалтын горимыг баримтлаагүйгээс ус биш хур борооны үерийн элсээр дүүрсэн байна. Усан сангийн элс шавар нь Тариалан сумын тариаланчдын эзэмшлийн хадлангийн болон тариалангийн талбайд усаар зөөвөрлөгдсөн элс, шороогоор дүүргэгддэгээс 2 сумын ус ашиглагчдын хооронд багагүй маргаан гардаг байна.

Давст суманд орших Торхилогийн гол нь хөрш ОХУ-аас эх авч урсан ирдэг бөгөөд Увс нуурт цуггадаг. Торхилогийн гол дээр 1980-аад оны дундуур “Торхилог”-ийн услалтын системийг аймгийн УААБУТрест барьж ашиглалтанд оруулсан нь мөн ашиглалтгүй болсон байна. Уг систем нь 2 улсын хилийн ойролцоо байрладаг, төвөөсөө алслагдмал байрлалтайгаас газар дээрх байгууламжууд нь тоногдон утсан байна.

Сагилийн голын урсацанд тулгуурлан “Улаанхотгор”-ын услалтын системийг мөн ашиглалтанд оруулсан нь “Арвижих Увс” ХХК-ны мэдэлд байж мөн бага хэмжээгээр үр тариа тариалж ашиглаж байна.

1990-ээд оны эхээр хуучнаар ЗХУ-ын буцалтгүй тусламжаар Баруунтуруун суманд 2000 га-д услалтын систем барьж ашиглалтанд өгснөөс одоогоор 300 гаруй га-д тариалалт хийж байна. Услалтын системийн толгойн барилга нь сумын төвийн дээд талд оршдог бөгөөд бетонон хийцтэй, 18 м-ийн өндөртэй, /магистраль/ гол хоолойгоор усаа авч өөрийн даралт үүсгэн Оросын “Волжанка ДКШ-64” бороожуулагч агрегатаар усалгааг хийдэг байна. Толгойн барилга, далангийн хамт хувьчлагдаж “Усжуулах” ХХК-ийн мэдэлд байж үр тарианы талбайг усалж байна.

Зураг № 8.2. Услалтын системийн зураг



Увс аймгийн Тариалан сумын Хархираан услалтын системийн толгойн барилга



Увс аймгийн Баруунтуруун сумын услалтын системийн толгойн барилга

## 8.2. Гадаргын усны горим, төлөв байдал

**Гол горхи.** Хан Хөхий, Хархирааг, Түргэн, Тагнын нуруунаас эх авсан Хархираа, Түргэн Торхилог, Живэрт, Тэс, Нарийн, Сагил, Боршоо, Ирэг, Шивэр, Намир, Хангилцаг, Завхан, Нүнгүй, Баруун туруун, Зүүн туруун, Хөндлөн, Ямаат, Их бага Хөсөрлөг зэрэг 173 гол горхитой. Үүнээс үндсэн томоохон голуудад Хархираа, Нарийн гол, Тэс, Завхан, Ховд, Хүнгүй голууд орно.

Хүснэгт № 8.6. Увс аймгийн үндсэн голууд

№	Голын нэр	Урт /км/	Эх авах газар	Цутгах газар
1	Хархираа гол	100	Хархираа	Увс нуур
2	Нарийн гол	97	Бага нуур	Увс нуур
3	Тэс	568	Булнайн нуруу	Увс нуур

Мөн үндсэн голуудад тооцогдох Тэс, Нарийн, Хархираа голуудаас гадна Завхан, Ховд, Хүнгүй гэсэн томоохонд голууд байдаг. Тэс гол Булнайн нуруунаас эх авч Хөвсгөл, Завхан аймгуудыг дайран урсаар улсын хил гарч ОХУ-ын Тува улсын нутгаар 130-аад км урсаад эргэж Увс аймгийн Тэс сумын нутгаар МУ-ын нутагт орж улмаар Увс нуурт цутгадаг.

Нарийн гол Увс аймгийн нутагт Баяннуураас эх авч урсан Боригдэлийн элсийг туулж Увс нуурт цутгадаг. Урсаж байгаа газрынх нь хөрс сул, элсэнцэр учраас ус нь их булингартай байдаг онцлогтой. Эдгээр голоос гадна Хүнгүйн гол Увс аймгийн нутагт 30 гаруй км урсгалтай. Энэ бүгдээс үзвэл Увс аймгийн томоохон нуур цөөрөм, голууд байгалийн унаган төрхөө хадгалж чадсан гэж үзэх үндэслэлтэй байна.

Хүснэгт 8.7. Усны улсын тооллогын харьцуулсан тоон үзүүлэлт

Д/д	Үзүүлэлт	2007	2011
1	Гол горхи	177	146
2	Нуур цөөрөм	113	107
3	Булаг шанд	462	493
4	Рашаан	28	32
5	Бүгд	780	778

Дээрх хүснэгтээс харахад нуур цөөрөм тойрмын талбайн хэмжээ хамгийн их буюу 64 хувийг, гол мөрөн 35 хувийг, үлдсэн 1 хувийг горхи, булаг шанд эзэлж байна.

Увс аймгийн жижиг гол горхиудыг мөнх цас мөсөн голуудаас эхтэй, намдуу газрын булаг шанд, нуга намгаас эх авсан гэж 2 хэсэгт хуваан үзэж болно. Мөнх цас, мөсөн голоос эхтэй голуудын ус эхэн хэсэгтээ нэн тунгалаг байдаг хэдий ч Улаангом хот орчмоор урсан өнгөрөхдөө олон салаалж усалгаанд ашиглагдахын зэрэгцээ иргэд ахуйн болон автомашины угаалга их хэмжээгээр хийдгээс ус нь саван, угаалгын нунтаг, тос масло зэрэг ахуйн болон химийн бодисоор нэлээд бохирддог. Энэ талын асуудлыг тусгайлан судалж тодорхой тоо баримттай материал бүрдүүлэх шаардлага нэгэнт бий болсныг анхаарах шаардлагатай байна.

Булаг шанд, нуга намгаас эх авсан жижиг голуудын булаг шандууд ямарч хамгаалалтгүй зуны цагт усны эхэн дээр адуу мал олноор тийрэглэн шавж усны эхийг их хэмжээгээр бохирдуулах явдал түгээмэл үзэгдэл болсон байна.



Хүснэгт 8.8. Увс аймгийн усны нөөц км<sup>3</sup>

№	Гадаргын ус		Газрын доорх ус		Ашиглах боломжтой нийт нөөц	
	Бүгд нөөц	Үүнээс ашиглах боломжтой	Бүгд нөөц	Үүнээс ашиглах боломжтой	шоо км <sup>3</sup>	хувь
1	1.1	0.12	0.23	0.08	0.2	9.7

Гадаргын болоод газар доорхи усны нөөцийн нийт хэмжээ 1.33 км<sup>3</sup> байна. Үүнээс 82.7 хувийг гадаргын ус, үлдсэн 17.29 хувийг газрын доорх ус эзэлж байна. Эндээс харахд Увс аймаг нь гадаргын усны нөөцөөр баялаг нутаг юм. Увс аймгийн хэмжээнд 2011 оны байдлаар нийт 173 гол горхи байгаагаас, устай 171, ширгэсэн 2 гол байна.

**Нуур, тойром.** Аймгийн нутаг дэвсгэрт Увс, Хяргас, Ачит, Хар-Ус, Дөрөө, Багануур, Ногоон нуур, Үүрэг нуур, Шаазгай нуур, Олон нуур зэрэг их бага 108 нууртайгаас, 11 нь ширгээд байна. Нуур цөөрөм тойромын нийт талбай 54714.3 га бөгөөд нийт усан сан бүхий газрын 64 хувийг эзэлдэг.

Хүснэгт 8.9. Увс аймгийн зарим нууруудын гарал үүсэл

Д/д	Тектоникийн гаралтай	Мөсөн голын гаралтай	Салхины нөлөөгөөр хонхорт тогтсон	Голын хөндийн нуур
1	Увс нуур	Ачит	Бага нуур	Их түргэний нуур
2	Хяргас		Хүнгүй	
3	Хар ус			
Дүн	3	1	2	1

Томоохон нуурууд тектоникийн гаралтай байхад жижиг нуурууд салхины нөлөөгөөр үүсэх нь элбэг. Нууруудын дундаж хэмжээ 12 ам.дөр.км бөгөөд том нууруудын тоонд Увс, Хар-Ус, Хяргас, Ачит, Үүрэг нуур зэрэг нуурууд багтана.

2011 оны улсын усны тооллогын дүнгээр Монгол орны хэмжээнд нуур тойром нийт 3613 байснаас устай 3130, ширгэсэн 483 байна. Үүнээс Увс аймагт нийт 108 нуур тоологдсоноос 97 нь устай нуур байна.


Увс аймгийн хэмжээнд 2011 оны усны тооллогын дүнгээр 146 гол горхи тоологдсоноос бүгд устай, 107 нуур тойром тоологдсоноос 12 нь ширгэж 95 устай, 493 булаг шанд тоологдсоноос 19 булаг шанд ширгэж, 474 булаг шанд устай, 32 рашаан тоологдсоноос бүгд устай, байна. Ширгэсэн, усгүй байгаа газрууд нь хур бороо элбэгтэй, хур тунадас ихтэй жил сэргэдэг байна.

Монгол улсын нутаг дэвсгэр нь усны 3 ай савд хуваагддаг. Нийт газар нутгийн 19.5 хувь нь Хойд мөсөн далайн ай савд, 11.5 хувь нь Номхон далайн ай савд, 69 хувь нь Төв Азийн гадагш урсацгүй ай савд хамрагдана. Эдгээр 3 ай савын огтлолцлын цэг нь Төв аймгийн Эрдэнэ суманд орших 1854 м өндөр бүхий Хөндлөн уул юм.

### 8.3. Усны сав газрууд

#### 8.3.1. Увс аймгийн нутаг дэвсгэрт хамаарах усны сав газрууд

Монгол улсын нутаг дэвсгэр нь Хойд мөсөн далайн, Номхон далайн, Төв азийн гадагш урсгалгүй ай сав гэсэн усны 3 ай савд хуваагддаг бөгөөд Увс аймагт орших гол горхиуд Төв Азийн гадагш урсацгүй ай савд багтах бөгөөд гол төлөв Алтай нуруу түүний салбар уулс болох Хархираа, Түргэний уулсаас болон Хангайн нурууны салбар уулсаас эх авч урссан голууд байдаг.



Зураг№ 8.3. Дэлхийн усны ай сав ба Монгол орны усны сав газрууд

Тус аймагт манай орны гадагш урсгалгүй бараг бүх томоохон голууд байдаг ба тэдгээр нь Увс, Хяргас, Ачит, Айраг нууруудад цутгаж эдгээр нуурыг усаар тэжээж байдаг. Дотоодын урсгалтай голуудаас хамгийн том нь Ховд гол бөгөөд тэрээр Алтай таван богдоос эх авч Баян-Өлгий аймгийн нутгаар дамжин урссаар Увс аймгийн нутгийн гүн рүү оролгүй захлан урссаар Хар-Ус нуурт цутгадаг. Бөхмөрөн гол ОХУ-ын нутгаас эх авч урссаар Монгол улсын нутагт ирж Ачит нуурт цутгадаг. Адагтаа их олон салаалж дельта үүсгэж нуурт цутгадаг. Энэ голын дельта нь Бөхмөрөн сумын хадлангийн гол газар бөгөөд энд хадланд зориулсан услалтын системүүд байгуулах боломжтой. Ачит нуураас гарсан хоолой Зүүнхөл нуураар дамжин Ховд гол улмаар Хар-Ус нуурыг усаар тэтгэдэг гэж үзэж болно.

Хархираа гол нь Хархираа уулын мөсөн гол, мөнх цаснаас эх авч урсах ба адагтаа олон салаалж зарим салаа нь Увс нуурт хүрэлгүй хайрган хөрсөнд шургаж замхардаг.

Цагаан Шивээтийн нуруунаас эх авсан Сагилын гол, Хархираагийн гол оргилуудын баруун сугаас эх авсан Шивэр гол, зүүн хажуугаас нь эх авсан Намирын гол, Алтанхөхийн зүүн хойт хэсгээс эх авсан Сондуултын гол зэрэг нь тариаланг усжуулахад бага зэрэг ашиглагддагаас гол нь бэлчээрийн усан хангамжинд чухал нөлөөтэй.


Хангайн нуруунаас эх авсан Тэс гол зөвхөн Тэс сумын нутгаар урсаж Тэс сумын төвөөс нэлээн доор болон Тэс сумын төв тушаа Үхэг, Жирэг, Хашт-Эрэг зэрэг олон гол болон салаалсаар бүгд Увс нуурт цутгадаг. Энэ гол ингэж олон салаалж урсаснаар Тэс

сумын нутгийн хойт хэсгийг бүхэлд нь нуга намгархаг байдалтай болгодог тул хадлангийн гол газар болдог онцлогтой.

Зүүнговь сумын Баяннуур болон Дэлгэр, Баянбулгуудаас эх авсан Нарийн гол Боригдэлийн элсийг туулж урсаар адагтаа багашиг дельт үүсгэн Увс нуурт цутгадаг ба бэлчээрийн усан хангамжинд чухал ач холбогдолтой юм.

Монгол улсын нийт нутаг дэвсгэрийг 3-н ай савд хуваахаас гадна 29 сав газарт хуваан сав газрын захиргаадыг байгуулах ажил хийгдэж байгаа бөгөөд Увс аймгийн нутаг дэвсгэр нь Увс нуур-Тэс голын сав газар, Хяргас нуур-Завхан голын сав газар, Хар нуур-Ховд голын сав газарт тус тус хамаарч байна.

Зураг№ 8.4. Увс аймгийн усны сав газрын зураг



Хүснэгт№ 8.10. Увс аймгийн усны сав газрууд

Сав газрын нэр	Талбай, км <sup>2</sup>	Ай савын нэр	Төрөл	Хамраагдах эдийн засгийн бүс
Хяргас нуур- тэс голын	120706.9	Төв азийн гадагш урсацгүй ай сав	Гадаргын ус	Баруун
Хар нуур-Ховд голын	86120.9			Баруун
Увс нуур-Тэс голын	53510.2			Баруун


Дээрх хүснэгтээс харахад Хяргас нуурын сав газар талбайн хэмжээгээрээ хамгийн том, харин Увс нуур-Тэсийн сав газар хамгийн бага хэмжээтэй байна. Усных нь эх үүсвэрээс нь хамааруулан усны сав газруудыг 3 бүлэгт хувааж болох юм. Үүнд:

**Гадаргын ус бүхий сав газрууд.** Эдгээр сав газар нь Монгол орны хойд хэсэгт орших ба байнгын урсгалтай гол мөрнүүдтэй.

**Газрын доорх ус бүхий сав газрууд.** Эдгээр сав газрууд нь Монгол орны өмнөд хэсгээр орших ба байнгын урсгалтай гол мөрөн байхгүй, газрын доорх ус зонхилно

**Гадаргын болон газрын доорх ус бүхий сав газрууд.** Энд гадаргын ус маш бага үүрэг гүйцэтгэх ба сав газрын ихэнх хэсэгт нь газрын доорх ус зонхилно.

Зураг № 8.5. Усны сав газруудын усны эх үүсвэр



Тус аймгийн хувьд гадаргын ба газрын доорх ус бүхий сав газруудад хамаарагдаж байна. Энд гадаргын ус маш бага үүрэг гүйцэтгэх ба сав газрын ихэнх хэсэгт нь газрын доорх ус зонхилдог болно.

### 8.3.2. Увс аймаг дахь усны сав газруудын усны нөөц, горим

#### Гадаргын ус

Увс аймгийн томоохон голууд, тэдгээрийн сав газрын ус хурах талбайн хэмжээ, голын сүлжээний нягтшил, голын урт зэрэг усны сав газрын үзүүлэлтүүд, сав газрууд дахь голуудын тоо болон томоохон цутгал голуудыг хүснэгт 3.6.-т үзүүлэв.

Хүснэгт № 8.11. Увс аймгийн усны сав газрын үзүүлэлт

№	Гол, горхи	Талбай, ам км	Үндсэн голын урт, км	Голын дундаж уналт, %	Сав газрын дундаж өндөр, м	Нийт голын урт, км	Голын сүлжээний нягтшил км/км <sup>2</sup>	Голын зэрэг
<b>Төв Азийн гадагш урсацгүй ай сав</b>								
1	Ховд	58514	596	0.0039	2700	35799	0.612	6
2	Тэс	21027	426	0.0029	1682	5083.64	0.24	5
3	Хархираа	1298.2	69.9	0.027	2020	571.46	0.44	4

Дээрх хүснэгтээс үзэхэд Увс аймагт орших Ховд, Тэс, Хархираа голуудын нийт талбайн хэмжээ 80839,2 ам км байна. Энэ нь тус аймгийн нийт газар нутагтай харьцуулахад харьцангуй бага үзүүлэлт юм.

## Хуснэгт № 8.12. Усны тооллогын дүн /2011он/

№	Сумын нэр	Гол, горхи		Нуур, тойром		Булаг, шанд		Рашаан		Мөстөл мөсөн гол	Усан сан хөв цөөрөм		Услалтын систем		Цэвэрлэх байгууламж		Худаг					Үерийн хамгаалалтын далан	
		Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай		Тоологдсон	Устай	Тоо	Шоо метр	Тоо	Талбай, га	Тоо	Хүчин чадал	Тоологдсон	Өрөмдмөл	Богинояданг	Энгийнүүрхайн	Эвлэрсэн
1	Баруунтуруун	9	9	1	1	12	12						1	1900			14	9	5		5		
2	Бөхмөрөн	6	6	6	6	31	31	1	1								11	11					
3	Давст	6	6	1	1	36	36										7	7					
4	Завхан	4	4	9	9	15	15										34	22	5	7	7		
5	Зүүнговь	8	8	5	5	16	15	2	2				1	74			20	14	6		10		
6	Зүүнхангай	11	11	7	5	23	23	2	2								8	7	1		1		
7	Малчин	7	7	3	1	10	10	1	1								49	17	28	4	35		
8	Наранбулаг	8	8	9	9	39	37	3	3								28	28			7		
9	Өлгий	3	3	4	4	13	13	3	3								36	7	7	22			
10	Өмнөговь	4	4	11	11	39	39	3	3								82	19	7	56			
11	Өндөрхангай	36	36	11	11	27	27	6	6								25	8	17				
12	Сагил	6	6	4	4	78	69						1	600			11	11			1		
13	Тариалан	17	17	3	2	12	12						1	2083			11	2	9		1		
14	Түргэн	8	8	2	2	37	37	2	2	1	1	7.5					13	8	5			1	0.5
15	Тэс	6	6	11	11	7	5										21	4	17		16		
16	Ховд	6	6	4	4	23	23	3	3								22	11	6	5	3		
17	Хяргас	13	13	6	1	31	31	2	2								32	16	12	4	19		
18	Цагаанхайрхан	10	10	8	3	28	27	2	2								23	5	17	1	8		
19	Улаангом	6	6	2	2	16	15	1	1		6	12	2	2050	1		159	148	7			2	2
20	Дүн	146	146	107	95	493	474	32	32	1	7	19.5	6	6707	1		600	354	149	99	113	3	2.5

*Хүснэгт № 8.13. Увс аймагт тоологдсон рашааны жагсаалт /2011оны байдлаар/*

	<b>Рашааны нэр</b>	<b>Газрын нэр</b>	<b>Тайлбар</b>
1	Шар харгайн рашаан	Бөхмөрөн сум	Элэг цөс, бөөр, үе мөч
2	Урт булаг	Зүүнговь сум	Элэг цөс
3	Сар толгой	Зүүнговь	
4	Хар ус	Зүүнхангай	
5	Гивант	Зүүнхангай сум	Элэг цөс
6	Хар тэрмис	Малчин сум, Хяргас нуурын эрэг	Элэг цөс, бөөр, зүрх, нүд
7	Агуйт цүнхэг	Наранбулаг	Элэг цөс
8	Харз	Наранбулаг	Ходоод гэдэс
9	Голын рашаан	Өлгий сум	Нутгийн иргэд элэг цөсөнд уудаг
10	Голын эхний	Өлгий	Элэг цөс
11	Рашаант	Өлгий	
12	Цоргот	Өмнөговь	Цөс
13	Нэмтгэр	Өмнөговь	Нүдний
14	Ногоон	Өмнөговь	Ходоод элэг цөс
15	Хөрөө асгат	Өндөрхангай	
16	Урт булаг	Өндөрхангай	
17	Усны овгор	Өндөрхангай Уушгийн улаанд	
18	Чигжийн дээд рашаан	Чигжийн гол	
19	Модот ам	Өндөрхангай сум	
20	Чигжийн доод	Өндөрхангай	
21	Бургастай	Түргэн сум	Толгой, элэг цөс
22	Тосон булаг	Ховд сум, элэг цөс	
23	Ганц мод	Хяргас сум	
24	Хуст	Хяргас	
25	Модот	Хяргас	
26	Ганц мод	Цагаанхайрхан	Элэг цөс
27	Шар нүүр	Цагаанхайрхан сум	Ходоод гэдэс
28	Улаан уул	Улаангом	Ходоод гэдэс, элэг цөс

Увс аймагт улсын чанартай рашаанд Малчин сумын нутагт байрладаг Хар Тэрмисын рашаан хамрагдаж байна. Энэ рашаан нь элэг, цөс, нүд, чих, зүрхний төрлийн өвчнийг анагаадаг рашаан бөгөөд жилийн турш ашиглах боломжтой байдаг. Тус рашаан нь Хяргас нуурын эрэгт байрладаг.

Орон нутгийн чанартай рашаан сувилалд Зүүнговь сумын Урт булгийн рашаан, Бөхмөрөн сумын Шар харгайн рашаан, Зүүнхангай сумын Хүнхийн рашаан зэрэг 3 рашааныг орон нутгийн зориулалтаар ашиглаж байна. Рашаан төст булгууд олон байна. Түргэн сумын Буцалдаг, Өмнөговь сумын Ногоон, Малчин сумын Хүрэн морьт, Цагаанхайрхан сумын Ганц харгайт, Түргэн сумын Бургастай, Наранбулаг сумын Эмхэт, Улаангом сумын Улаан уулын рашаан зэрэг болно.

#### Гүний усны судалгаа, өнөөгийн байдал

Увс аймгийн газрын доорхи усны эрэл хайгуул, судалгаа 1960 оноос эхэлсэн гэж үздэг. Газрын доорхи ус орчин үеийн болон эртний янз бүрийн насны хурдас чулуулагт агуулагддаг. Газрын доорхи ус орших байдлаараа гидрогеологийн массив, гидрогеологийн сав газар, усжсан хагарал гэсэн гурван үндсэн хэсэгт хуваагддаг. Увс аймгийн хувьд нүх сүвийн болон ан цавын усны аль аль нь тохиолдох боловч эртний ба орчин үеийн мөстлөг, цэвдэг бүсийн тархалт, жилийн дундаж температур сөрөг утга, хүйтний улирлын урт үргэлжлэл нь олон зуун, олон сая жил нөлөөлж ирсэн. Гадаргын усны томоохон

тэжээгдэл Хархираа,Түргэн, Цагааншувуутын мөнх цас, мөстлөг, мөсөн голын болон улирлын цасан бүрхүүлийн хайлалтаар явагдана.

*Хүснэгт№ 8.14. Гүний усны хайгуулын судалгаа*

Үзүүлэлт		Хэмжих нэгж	Мөрийн дугаар	Гүйцэтгэл
А		Б	В	Г
Гадаргын усны нөөцийн нийт хэмжээ		Сая м <sup>3</sup>	1	3448.9
Газар доорхи усны нөөцийн хэмжээ		Сая м <sup>3</sup>	2	168000.0
Гадаргын усны нөхөн тэжээгдэл		Сая м <sup>3</sup>	3	
Газрын доорхи усны нөхөн тэжээгдэл		Сая м <sup>3</sup>	4	
Үүнээс	Хуримтлуулсан усны нөөц	Сая м <sup>3</sup>	5	
Хамгаалалтад авсан усны эх үүсвэр		тоо	6	779
ОХУ руу урсаж гарсан усны нийт хэмжээ		Сая м <sup>3</sup>	7	0
БНХАУ руу урсаж гарсан усны нийт хэмжээ		Сая м <sup>3</sup>	8	0
Гадаргын усны хатаж ширгэсэн эх үүсвэр 10+11+12		тоо	9	35
Үүнээс	Гол горхи	тоо	10	17
	Булаг шанд	тоо	11	12
	Нуур цөөрөм	тоо	12	6
Гадаргын усны сэргэсэн эх үүсвэр 14+15+16		тоо	13	53
Үүнээс	Гол горхи	тоо	14	8
	Булаг шанд	тоо	15	43
	Нуур цөөрөм	тоо	16	2

Газрын доорхи усны хайгуулийн ажлын үр дүнд Цагаанхайрхан, Ховд сумын төвүүд цахиуржсан шохойн чулуу, шохойжинт үндсэн чулуун дээр байрладаг нь хүний эрүүл мэндэд аюултай болохыг тогтоосон байна.

**Мөс,мөнх цаст, мөсөн гол**

Гадаргын ус сүүлийн жилүүдэд 25% багассан. Энэ нь гадаргын усны нөөцөд дулаарал хүчтэй нөлөөлж байгааг харуулж байна. Увс аймгийн нутаг дэвсгэрт Хархираа, Түргэн, Цагааншувуутын мөнх цаст оргилууд байдаг. Судалгаанаас үзэхэд Монгол орны мөсөн голууд 1940 оноос хойш 30% багасчээ. 2040 онд 50м зузаан мөсөн бүрхүүл хайлж дуусна. 100м зузаан мөсөн бүрхүүл 2050-2060 онд, 200м зузаан бол 2090 онд хаялж дуусна гэсэн тооцоо байдаг.Иймд Ховд,Бөхмөрөн сумдын нутаг дэвсгэрийн голуудын жилийн урсацын 60-90%-ийг шар усны үерийн урсац ба хайрсан цас, мөсний урсац эзэлдэг.

#### **8.4. Усны сав газрын үндсэн гол горхи, нууруудын тодорхойлолт**

##### **8.4.1 Хяргас нуур-Завхан голын сав газар**

ЗАВХАН ГОЛ Хангай нурууны ноён оргил Отгонтэнгэрийн өврөөс эх авах Буянт гол, Шар усны голын бэлчрээс эхлэн Завхан гол хэмээн нэрлэгдэнэ. Завхан гол Хангай нурууны баруун хажууг хормойлон урсаж, Айраг нуураар дамжин Хяргас нуурт цутгана.

Голын ус хурах талбай 68737.7 ам км, 808 км урт юм. Эхэндээ уулархаг, дунд хэсэгтээ говийн уулс толгодоор, адагтаа уулын хормойн элсэн манханаар урсана. Хяргас нуурын цутгал урсацын дийлэнхийг Завхан голын ус эзэлнэ. Завхан гол Шургийн голтой нийлэхийн өмнө ихээхэн хэмжээгээр салаалж Ажиг, Эрээн нуурын орчимд үлэмж газрыг намагжуулна. Энэ нь Завхан голын урсацыг зохицуулна. Завхан голын олон жилийн дундаж өнгөрөлт Гуулингийн услалтын системийн орчимд 12.0, Дөрвөлжин сумын орчимд 15.6, Айраг нуурт цутгахдаа 27.6 шоо м/с болно. Завхан гол Дөрвөлжин сумаас доош Завхан, Татхан тээлийн бэлчир хүртэл урсацын 16.7 хувийг алдана. Богд, Чигэстэй гол Завхан голын томоохон цутгалууд юм. Отгонтэнгэрийн Рашаан, түүний ар талын амнаас эх авсан рашааны гол Бага Богдтой, Өвөржоншт, Хөх нуураас эх авсан гол горхи нийлж Богдын гол болно. Хамгийн их үер 1979 онд болжээ. Богд голын ус хурах талбай 1510 ам км, 92 км урт, Чигэстэй гол 1050 ам км ус хурах талбайтай, 28 км урт юм. Богд голын олон жилийн дундаж өнгөрөлт 7.61 шоо м/с, Чигэстэй голынх 4.85 шоо м/с болно.

Завхан гол бол 6 дугаар эрэмбийн гол юм. Голдрилын дундаж өндөр 1427 м, ус хагалбарын шугамын урт 1833.35 км, түүний дундаж өндөр 2910 м, голуудын нийлбэр урт 25203.9 км, усан сүлжээний нягтшил 0.36 км/ам км, хөндийн гүн дунджаар 1483 м, түүний өргөн 88.6 км, Хортоны хуулийн голын тоо, урт, ус хурах талбайн харьцаа 3.803, 3.131 ба 6.54 тус тус байна.

**ХЯРГАС НУУР.** Хяргас нуур Хар ус нуурын системийн дотор хамгийн нам дор орших том нуур бөгөөд Алтайн хангайн уулархаг нутгаас эх авч Их нуурын хотгор руу урсах бүх голуудын эрозийн эцсийн суурь болно. Нуурын гадаргын талбай 146,8 хавт.дөр.км, хамгийн урт нь 75,07 м, өргөн 31,07 м, дундаж өргөн 19,0 км ба усны маандал 1028 м үнэмлэхүйн өндөрт оршино.Хяргас нуур тектоникийн хотгорт тогтсон учраас эргийн шугам их хэрчигджээ. Иймээс эргэн тойрны хуурай газар усны хилийн зааг харьцангуй урт, эргийн шугамын коэффициент 1,90 хүрэх бөгөөд уснаа хэд хэдэн нарийн хошуу түрж орсон байна. Тэдгээрийн томыг нуурын шугам /7 км/, чацарганы шугам /4 км/, могойн шугам /5км/ гэж нэрлэнэ.Нуурын эргээс ялимгүй дотогшлоход усны гүн 40-50м болох бөгөөд Чацарганы шугамын зүүхэнээ хамгийн их гүн 80 метрт хүрч байв. Хяргас нуурын талбай Алтайн нурууны зүүн ба хойд хажуу, мөн Хангайн нурууны баруун хажууг нилд нь хамарсан 170000 хавт.дөр.км талбайтай уудам нутаг болох тэндээс усжих бүх гол горхи их нууруудын хотгорын бүлэг нуурыг дамжсаар эцэстээ Айраг нуурт нэгдэж нуурын хоолой гэдэг ганц хоолойгоор Хяргас нуурт цутгана.



#### 8.4.2 Хар нуур-Ховд голын сав газар

ХОВД ГОЛ Монгол Алтай нурууны араас эх авах Цагаан Ховд, Хар Ховд гол хоорондоо холбоотой Хотон, Хоргон нуурт цутгаж гарснаас эхлэн Ховд нэрийг авна. Сав газрын дээд, дунд хэсэг өндөр уулсын дундуур, зөвхөн адгаас 90 км хэсэг нь Их нууруудын хотгорын тэгш талаар урсана. Голын эхээр өндөр уулын тагийн өвс ургамал, дунд хэсэгт хээр, адгаар говийн ургамал зонхилно. Ховд голын урт 596 км, ус хурах талбай 58514 ам км, хэвгий 0.0039 юм. Ховд голд Толбо, Даян, Хотон, Хоргон, Ачит зэрэг нуур илүүдэл усаа юүлэхийн хамт өндөр уулсын хур цас мөстөл, мөсөн голын усаар тэтгэгдэх тул урсац 6-7 дугаар сард хамгийн ихдээ хүрч гидрограф нь ихэвчлэн ганц оройтой байна. Голын жилийн дундаж өнгөрөлт Өлгий сумын орчимд 58.0, Баяннуур сумын орчимд 63.2, Мянгад сумын орчимд 75 шоо м/с хүрдэг. Ховд голд цутгах жижиг голууд уулнаас мултармагц урсацаа алдана.

Ховд гол бол 6 дугаар эрэмбийн гол юм. Голдрилын дундаж өндөр 1785 м, ус хагалбарын шугамын урт 1309 км, түүний дундаж өндөр 1934.0 м, голуудын нийлбэр урт 35799 км, усан сүлжээний нягтшил 0.612 км/ам км, хөндийн гүн дунджаар 854 м, түүний өргөн 98.2 км, Хортоны хуулийн голын тоо, урт, ус хурах талбайн харьцаа, 3.010, 5.848, 4.286 тус тус байна.

ХАР НУУР. Хар ус нуураас холгүй орших энэ нуур 574,8 хавт.дөр.км талбайтай бөгөөд өргөний хамгийн их 23,6 км, дундаж өргөн 15,7 км, хамгийн их урт нь 36,8 км болно. Баруун болон баруун хойд талд Гээг сайхан, Гээг Хайрхан, Чандмань, Таван Хар зэрэг уул толгод ЧоноХарайхын гол хүртэл үргэлжилээд Хар ус нуурыг Хар нуураас тусгаарлана.1132 м үнэмлэхүйн өндөрт орших Хар нуур Хар ус нуураас талбайгаараа бага мөртлөө арай гүнзгий юм. Хамгийн их гүн 6,06 м хүрэх ба дундаж гүн 4,2 м, бүх усны нөөц 2422 шоо дөр метр болно. Хар нуурт Хар ус нуурын илүүдэл ус Чоно Харайхын голоор ирж өөрийн илүүдэл усаа ууршуулахын хамт нэг хэсгийг Хомын хоолойгоор Дөргөн нуурт, нөгөө хэсгийг Татган тээгийн голоор Завхан голд өгдөг.

ХАР УС НУУР. Хар-Ус нуур нь манай орны 1000-аас дээш км<sup>2</sup> талбайтай 4 нуурын нэг юм. Хар нуур нь Хар-Ус нуураас зүүн тийш орших ба хоорондоо Чоно Харайхын голоор холбогдоно Их нууруудын хотгорын бүлэг нуурууд дотроо нилээд өндөрт орших цэнгэг устай урсгал нуур болно. Нуурын талбай бүх нууруудын хамтаар 1859,2 хавт.дөр.км, хамгийн их өргөн 26,2 км, дундаж өргөн 25,8 км, хамгийн их урт шулуунаар 72,2 км болно.

Хар ус нуур хэдийгээр том талбайтай боловч маш гүехэн нуур юм. Нуурын хамгийн гүн нь 4,4 м, дундаж гүн нь 2,0 м байна. Хар ус нуурын хотгор тектоникийн гарал үүсэлтэй. Хар ус нуурт том жижиг 10 гаруй арал байгаагаас хамгийн том нь 400 хавт.дөр.км талбайтай 30 орчим км урт усны мандлаас 272 м өндөр Агбаш хэмээх арал бөгөөд тэрээр Хар ус нуурыг хойт урд тэнцүү биш хоёр хэсэгт хуваана.

Хойт урд далайг 1,2-2,0 м гүн, 50-100 м өргөн, 20 гаруй километр урт Лүн Юм гэдэг нэртэй хоёр хоолой холбоно. Хойт далай нуур 400 шахам хавт.дөр.км талбайтай боловч нэлдээ зэгсээр хучигдаж нуур гэхээргүй бага устай болсон. Далай нуурын гүн 1,8

м-ээс хэтрэхгүй. Хар ус нуур 70450 хавт.дөр.км талбайгаас усжина. Үүний 70 хувь нь ганц Ховд голын сав газарт хамаарна. Монгол Алтайгаас эх авч урсах Ховд, Буянт Цэнхэрийн гол жилд барагцаалбал 2,2 шоо км ус нийлүүлэх бөгөөд илүүдэл усаа ууршуулахын хамт 40 км урт 50-75 км өргөн Чоно-Харайх голоор Хар ус нуурт өгнө. Хар ус ионы бүрэлдэхүүнээр гидрокарбонатын ус бүхий нуурын ангилалд багтана.

Дөргөн нуур нь Хар нуурын өмнөд хэсэгт орших 305 км<sup>2</sup> талбайтай. Хамгийн их өргөн нь 17 км, хамгийн их урт нь 24 км хүрдэг говийн томоохон нуурын нэг юм.

Хар ус нуур нь олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газрыг хамгаалах Рамсарын конвенцийн жагсаалтанд 1999 онд бүртгэгдсэн байна, Ховд аймгийн Мянгад, Дөргөн, Чандмань, Манхан, Буянт сумдын нутгийн 852997 га талбайг 1997 онд УИХ-ын 47 дугаар тогтоолоор Хар ус нуурын байгалийн цогцолборт газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авчээ.

#### **8.4.3. Увс нуур-Тэсийн голын сав газар**

ТЭС ГОЛ Хангай нурууны салбар Булнай нурууны ар талаас эх авах жижиг голуудын усыг хуримтлуулсан намгархаг хэсгээс эх авна. Тэс голыг Хөвсгөлийн уулсын баруун өмнө талаас эх авах ус ихтэй олон гол ихээхэн тэтгэж нэмэгдүүлнэ. Тэс голын жилийн дундаж өнгөрөлт Завхан аймгийн Баян-уул суманд 14.9 байснаа Монголын хилээс гарч эргэн Увсын Тэс сумын нутагт Увс нуурт цутгахдаа 60.0 шоо м/с хүрэх бөгөөд нуурын усны орлогын 57.4 % болно. Иймээс эх оронч гол хэмээн нэрлэгддэг.

Тэс гол бол 5 дугаар эрэмбийн гол юм. Гольдролын дундаж өндөр 874 м, ус хагалбарын шугамын урт 1241.56 км, түүний дундаж өндөр 2305.0 м, голуудын нийлбэр урт 5083.64 км, усан сүлжээний нягтшил 0.24 км/ам км, хөндийн гүн дунджаар 728.0 м, түүний өргөн 49.25 км, Хортоны хуулийн голын тоо, урт, ус хурах талбайн харьцаа 4.340, 3.084, 5.670 тус тус байна.

Хархираа гол бол 4 дүгээр эрэмбийн гол юм. Гольдролын дундаж өндөр 874 м, ус хагалбарын шугамын урт 195.71 км, түүний дундаж өндөр 2632.16 м, голуудын нийлбэр урт 571.46 км, усан сүлжээний нягтшил 0.44 км/ам км, хөндийн гүн дунджаар 1272.16 м, түүний өргөн 18.56 км, Хортоны хуулийн голын тоо, урт, ус хурах талбайн харьцаа 3.070, 3.264, 5.281 тус тус байна.

Түргэн гол 4 дүгээр эрэмбийн гол юм. Гольдролын дундаж өндөр 874 м, ус хагалбарын шугамын урт 182.58 км, түүний дундаж өндөр 2436.08 м, голуудын нийлбэр урт 1103.30 км, усан сүлжээний нягтшил 0.97 км/ам км, хөндийн гүн дунджаар 1038.08 м, түүний өргөн 12.14 км, Хортоны хуулийн голын тоо, урт, ус хурах талбайн харьцаа 3.780, 3.392, 5.310 тус тус байна. Энэ голын савд 1 дүгээр эрэмбийн гол 53, 2 дугаар эрэмбийн гол 12, 3 дугаар эрэмбийн гол 3, 4 дүгээр эрэмбийн гол 1 байна.

#### **Увс нуур**

Увс нуур түүний ойр орчмын Түргэн уул, Цагаан Шувуут, Торхилог-Тэсийн голын адаг, Алтан элс гэсэн экологийн орчин байгалийн цогцолборын хувьд ялгаатай боловч бие биенээсээ төдийлөн алслагдаагүй газар нутгийг хэсэгчилэн хамрах 755244.05 га талбайг 1993 оны УИХ-ын 83-р тогтоолоор Дархан цаазат газрын ангиллаар улсын тусгай

хамгаалалтанд авсан. Увс нуурын ай сав нь говь, цөлөрхөг хээр, хээр тал, ойт хээр, уул нуруу, мөнх цас, мөсөн голуудыг багтаасан эрс тэс уур амьсгалтай нутаг бөгөөд Увс нуурын ай савын дархан цаазат газрууд нь 1997 онд НҮБ-ын "Хүн ба шим мандал" хөтөлбөрийн олон улсын шим мандлын нөөц газрын сүлжээнд, 2003 онд дэлхийн өвийн сүлжээнд, 2004 онд олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар ялангуяа нүүдлийн шувууд олноор амьдардаг орчны тухай олон улсын конвенцид тус тус нэгдэн орж бүртгэгдсэн байна.

#### **8.5. Увс аймгийн 0.5км<sup>2</sup>-аас дээш талбайтай нуур тус бүрийн товч тайлбар, тодорхойлолт**

**1. Туулай нуур:** Увс аймгийн Бөхмөрөн сумын нутагт Ачит нуурт цутгах Хув-Ус голын эхэнд 2346 м өндөрт байдаг мөстлийн гаралтай нуур. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 1.3 км урт, 0.6 км өргөн, эргийн шугамын урт 3.4 км. Гадагш урсгал цэнгэг нуур.

**2. Бага нуур:** Увс аймгийн Наранбулаг сумын нутагт Увс нуурын ойролцоо 763 м өндөрт байдаг үлдэгдэл нуур. 1.6 км<sup>2</sup> талбайтай, 2.4 км урт, 1.0 км өргөн, эргийн шугамын урт 5.0 км орчим. Эргэн тойронд зэгс, дэрс, намаг ихтэй. Нүүдлийн шувууд хуран цуглардаг.

**3. Дэсэл нуур:** Увс аймгийн Наранбулаг сумын нутагт Увс нуурын өмнө 760 м өндөрт байдаг шорвог нуур. 0.6 км<sup>2</sup> талбайтай, 1.5 км урт, эргийн шугамын урт 3.8 км орчим.

**4. Баян нуур:** Увс аймгийн Зүүнговь сумын төвөөс хойш Бориг Дэл элсний дунд 931 м өндөрт байдаг цэнгэг нуур. Элсэн тарамцагт хаагдаж үүссэн энэ нуур 30.8 км<sup>2</sup> талбайтай, 11.9 км урт, 3.9 км өргөн, эргийн шугамын урт 29.0 км, усны хамгийн гүн 26.5 м, эзлэхүүн 366.9 сая м<sup>3</sup>. Элсэн бөөргүүдээс ундарга сайтай олон булаг урсаж нуурт цутгах ба Хойд гол гэдэг услаг хоолой гарч олон булгийг нэгтгэн Нарийн гол болж Увс нуурт цутгадаг. Ёроолд нь элс зонхилж гүн хотгорт хүхэр устөрөгчийн сулавтар үнэртэй алаг шавар тархсан байдаг. Усны температур 7,8 дугаар сард 20.1-24.8°C, ёроолдоо 19.4°C орчим, 11 дүгээр сараас 4 дүгээр сард хөлддөг. Нуурт Төв Азийн гадагш урсгалгүй ай савын загас байх ба нүүдлийн шувууд хуран цуглардаг. 350 км<sup>2</sup> талбайгаас усжиж гадагш урсгалтай, эрдэжилт 265 мг/л, гидрокарбонай ангийн натрийн төрлийн усанд багтана. Амралт сувилал, аялал жуулчлалд тохиромжтой.

**5. Бага нуур:** Увс аймгийн Зүүнговь сумын төвөөс хойш 990м өндөрт байдаг цул элсэн дунд байдаг гадагш урсгалгүй нуур. 2.6 км<sup>2</sup> талбайтай, 2.6 км урт. 1.4 км өргөн, эргийн шугамын урт 6,6 км. 35 км<sup>2</sup> талбайгаас усжих жижиг булаг цутгадаг.

**6. Хөх нуур:** Увс аймгийн Тариалан сумын нутаг Хархираа уулын зүүн сугад 1936 м өндөрт байдаг гадагш урсгалгүй нуур. 2.2 км<sup>2</sup> талбайтай, 3.8 км урт, 0.8 км өргөн, эргийн шугамын урт 11.4 км. Нуурт уулын олон горхи цутгадаг.

**7. Согоо нуур:** Увс аймгийн Зүүнхангай сумын нутагт 2032 м өндөрт байдаг уулын нуур. 1.8 км<sup>2</sup> талбайтай, 2.6 км урт, 1.2 км өргөн, эргийн шугамын урт 5,8 км орчим. Жижиг голоор Хар Усны голтой холбогддог. Байгалийн байдал нэн үзэсгэлэнтэй.

**8. Хангай нуур:** Увс аймгийн Зүүнхангай сумын нутгийн Ханхөхий нурууны зүүн хэсэгт 1383 м өндөрт байдаг цэнгэг нуур 2.0 км<sup>2</sup> талбайтай, 2,6 км урт, 1.1 км өргөн, эргийн шугамын урт 6.2 км. Уулын олон булаг цутгадаг.

**9. Шаазгай нуур:** Увс аймгийн Ховд сумын нутагт 1696 м өндөрт байдаг тектоник гаралтай эрдэст нуур.

8.3 км<sup>2</sup> талбайтай, 4.9 км урт, 2.4 км өргөн, эргийн шугамын урт 13,8 км урт. Нуурт жижиг булаг шүүрч орох ба гадагш урсгалгүй, эрдэсжилт 19.25 г/л, найрлагаараа карбонатын төрөлд багтана.

**10. Хар ус /Намирын/ нуур:** Увс аймгийн Өмнөговь сумын нутагт, Хархираа, Алтан Хөхий уулын хоорондын буурц хотгорт 1574 м өндөрт байдаг эрдэст нуур. 62.6 км<sup>2</sup> талбайтай, 14.1 км урт, 7.8 км өргөн, эргийн шугамын урт 60.9 км. Усны хамгийн гүн 8.2 м, бусад хэсэгт 4-6 м гүн, дундаж гүн 5.2 м буюу эзлэхүүн 326.5 сая м<sup>3</sup>. Хойд талаас хадан толгод түрж булан тохой үүсгэх ба баруун талд нь өргөн хөндий байдаг. Намирын голын адагт садраа үүсгэж намагжжээ. Зүүн эргийн дагуу олон хаягдал нууртай, эртний нуурын далан зээг ажиглагддаг. Нуурын ёроол тэгшивтэр, хүхэр устөрөгчийн сулавтар үнэр бүхий хар бор өнгөтэй лаг, наанги элс, элсэнцэр хурдастай. Том булан тохойгоор усны ургамал, элдэв замаг ургана.

Усны тунгалагшилт бага /0.1-0.4 м/ цутгал глын нөлөөгөөр баруун хэсэг нь улаавтар, бусад хэсэг нь шаравтар туяатай байдаг. Усны температур 7,8 дугаар сард өнгөндөө 17.5-23.8°C, булан тохойдарай бүлээвтэр, давсархаг устай, ерөнхий эрдэсжилт хаврын шар усны урсацын үед 4.5-6.07 г/л, зуны гажиг үед 11.737 г/л болж гидрокарбонатын ангийн натрийн төрлийн усанд багтана. Нүүдлийн шувууд цуглардаг.

**11. Бага нуур:** Увс аймгийн Наранбулаг сумын төвөөс зүүн тийш 15 км зайд 1026 м өндөрт байдаг хаягдал нуур. 1.1 км<sup>2</sup> талбайтай, 1.6 км урт 0.6 км өргөн, эргийн шугамын урт 4.0 км.

**12. Ширгэдэг нуур:** Увс аймгийн Цагаанхайрхан сумын нутагт Хяргас нуурын зүүн талд, 1091 м өндөрт байдаг, гантай үед хатдаг нуур. Хуртай үед 7.9 км<sup>2</sup> талбайтай, 7.3 км урт, 1.9 км өргөн, эргийн шугамын урт 31.4 км хүрдэг.

**13. Цавдан нуур:** Увс, Завхан аймгийн нутгийн заагт тектоник гаралтай битүү хотост 1633 м өндөрт байдаг шорвог нуур. 6.1 км<sup>2</sup> талбайтай, 4.3 км урт, 2,4 км өргөн, эргийн шугамын урт 13,0 км. Зүүн талаас Уртын гол зэрэг хэд хэдэн булаг нийлж цутгах ба голын адагт намагжсан байдаг. Усны эрдэсжилт 276.50г/кг, найрлагаараа сульфатын төрлийн сульфат натрийн доод төрөлд багтана.

**14. Өлгий нуур:** Увс аймгийн Өлгий сумын төвөөс зүүн урагш 10 км зайд дэрст хотост 1569 м өндөрт байдаг ширгэдэг нуур. 2.3 км<sup>2</sup> талбайтай, 3.8 км урт, 0.9 км өргөн, эргийн шугамын урт 8.8 км. Нуурын хойноос цутгах хэд хэдэн булгийн усаар сэлбэгддэг.

**15. Сангийн Далай /Зээрэн/ нуур:** Увс аймгийн Завхан сумын нутагт 1043 м өндөрт байдаг үлдэгдэл шорвог нуур. Нуурын баруун хойт хэсгээс бусад нь ихээхэн намагжиж ойртох аргагүй. Хуртай жилд 12 км<sup>2</sup> талбайтай, 6.8 км урт, 3.0 км өргөн, эргийн шугамын урт 22.6 км орчим болдог. Усны эрдэсжилт 302.0 г/кг, хлорт натри, хлорт магни, сульфат

магнийн давс зонхилж найрлагаараа сульфат магнийн доод төрөлд багтана. Давсны давхарга 3-4 м хүрдэг, намар хавар ашиглахад нэн тохиромжтой. Давсыг орон нутгийн чанартай ашигладаг.

**16. Их Гашуун нуур:** Увс аймгийн Завхан сумын төвөөс зүүн хойш 15 км зайтай Хяргас нуурын хотост 1010 м өндөрт байдаг үлдэгдэл шорвог нуур. 1.1 км<sup>2</sup> талбайтай, 1.8 км урт, 1.0 км өргөн, эргийн шугамын урт 5.4 км.

**17. Хойд Гашуун нуур:** Увс аймгийн Завхан сумын нутагт Хяргас нуурын өмнөт эрэгт 1060 с өндөрт байдаг үлдэгдэл нуур. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 1.7 км урт, 0.6 км өргөн, эргийн шугамын урт 3.6 км орчим. Ёроол нь хүхэр устөрөгчийн үнэр бүхий лаг шавартай, усны ерөнхий эрдэжилт 20.13 г/л, сульфат, хлорт натри зонхилж найрлагаараа карбонатын төрлийн усанд багтана.

**18. Зост нуур:** Увс аймгийн Завхан сумын нутагт Айраг нуураас 0.3 км зайд Завхан голын адагт 1030 м өндөрт байдаг цэнгэг нуур. 1.6 км<sup>2</sup> талбайтай, 2.5 км урт, 1.0 км өргөн, эргийн шугамын урт 8.6 км. Завхан голын садраа адгийн нэг Улаан-Сайрын гол цутгаж эргэж урсан гардаг.

Нүүдлийн шувууд хуран цугларах ба Төв Азийн гадагш урсгалгүй ус нуурын загасаар элбэг.

**19. Цагаан нуур:** Увс аймгийн Өндөрхангай сумын төвөөс урагших тектоник уудам хөндийд 1335 м өндөрт байдаг шорвог нуур. 2.8 км<sup>2</sup> талбайтай, 2.8 км урт, 1.9 км өргөн, эргийн шугамын урт 6.8 км. Хуртай үед

Хан Хөхийгөөс эх авдаг горхиуд цутган орно. Ойр орчинд нь Жинс, Олгой зэрэг 0.3-0.4 км<sup>2</sup> талбайтай жижиг нуур бий.

**20. Тахилт нуур:** Увс аймгийн Өндөрхангай сумын нутагт сумын төвөөс урагш 40 км зайтай урт хөндийд

1369 м өндөрт байдаг бэсрэг нуур. 3.6 км<sup>2</sup> талбайтай, 2.7 км урт, 1.9 км өргөн, эргийн шугамын урт 7.6 км. Орчинд намагжиж зэгс, дэрс ургана. Усны эрдэжилт 281.87 г/кг, хлорт натри, сульфат магни, хлорт магни зонхилж найрлагаараа сульфатын төрлийн сульфат магнийн доод төрөлд багтана. Хур бороо булгийн усаар сэлбэгддэг. Давсны нөөц сайтай хүнсний хэрэгцээ малын тэжээлд орон нутгийн чанартай ашиглаж ёроолын лаг шаврыг эмчилгээнд хэрэглэдэг.

**21. Цагаан нуур:** Увс аймгийн Өндөрхангай, Зүүнхангай сумын заагт тектоник хотгорт 1464 м өндөрт байдаг бүлэг нуурын нэг. 1.9 км<sup>2</sup> талбайтай, 2.2 км урт, 1.9 км өргөн, эргийн шугамын урт 7.0 км. Далан булаг гэдэг хэд хэдэн жижиг булаг шанд цутгах боловч гадагш урсгалгүй шорвог устай.

**22. Увс нуур:** Манай орны төдийгүй Төв Азийн хамгийн том эрдэст нуур. Далайн түвшингээс дээш 743 м өндөрт байдаг 3350 км<sup>2</sup> талбайтай, 84.0 км урт 79.0 км өргөн, эргийн шугамын урт 425 км, усны гүн 20.0 м эзлэхүүн 39.6 м<sup>3</sup>. Нуурын умард, өмнөд, өмнө этгээдэд Тагна, Хархираа, Ханхөхийн нуруу сүндэрлэж зүүн талд нь Бориг Дэл, Алтан элсэн манхан тарамцаг үргэлжилнэ. Усны хагалбар уулсаас Хархираа, Хөндлөн, Сагил, Боршоо, Хандгайт, Торхилог, Тэс, Нарийн зэрэг олон гол горхи эх авч цутгадаг.

Нуурын ус хураах талбай 71100 км<sup>2</sup>, эргийн байдал тэгшивтэр, цутгал голын адагт садраа адаг үүсэж намагжин ойн төгөл, үзэсгэлэнт баян бүрдтэй. Эргэн тойронд нь олон хаягдал нуур цөөрөмтэй. Хэд хэдэн том булан тохой жижиг арал хойг бий. Эрт цагт нуурын ус одоогийнхоос хэдэн арав дахин их байсныг нотлох эргийн далан зээг татралтын дэнж эгнэн зарим нь нуураас алс хол байдаг. Усны температур олон жилийн дунджаар 5 дугаар сард 5.8-10.4°C, 6 дугаар сард 15.1-16.5°C, 8 дугаар сард 15.9-23.6°C, 9 дүгээр сард 10.7-16.6°C, 10 дугаар сард 5.8-9.5°C, 11 дүгээр сард 2.3-3.1°C-ийн хооронд хэлбэлзэж энэ хугацаанд хамгийн их температур 27.3°C, /8 дугаар сарын эхээр/ хүрчээ. 11 дүгээр сарын 2 дугаар хагасаас 5 дугаар сарын дунд үе хүртэл хөлддөг. Мөс нь нимгэн хэврэгэ нуурын голд өрхлөж, голдуу уур мананд бүрхэгддэг. Усны тунгалагшилт 2-3 м. Гадагш урсгалгүй найрлагаараа сульфат натрийн төрөлд багтана. Ерөнхий эрдэжилт 18.5-19.7 г/л хлорт натри сульфат натри, сульфат магни зонхилдог байсан бол сүүлийн жилд түвшин гь дээшилж ерөнхий эрдэжилт 12.0 г/л болтол буурчээ.

Усны химийн найрлага, давсны бүтцэд хоолны давс зонхилж байгаа нь ус хураах сав газар дахь тунамал давсны хурдастай нягт холбоотой. Ёроолд нь лаг наанги хурдас зонхилж эргэн тойронд нь торгон элсэн хаялагатай. Ойн төгөл, баянбүрдэд элдэв жимс чацаргана, төрөл бүрийн ан амьтадтай. Зуны цагт дулаан орны төдийгүй умард тундрийн шувууд цуглардаг. Төв Азийн гадагш урсгалгүй ай савын загас жараахайтай. Дагуул нуур тойромд анагаах хурдас шавар байдаг. Агнуур спорт, усан зам амралт сувилалын чиглэлээр ашиглах потенциал боломж ихтэй.

**23. Үүрэг нуур:** Увс аймгийн Сагил, Түргэн сумын нутагт Цагаан шувуут, Түргэний уулсын хоорондын битүү хотгорт 1425 м өндөрт байдаг тектоник гаралтай нуур. 237.6 км<sup>2</sup>талбайтай, 19.5 км урт, 18.0 км өргөн, эргийн шугамын урт 65.6 км. Усны хамгийн гүн 42.0 м, талбайн 69 хувь нь 20-иос гүн хэсэгт хамрагдаж усны эзлэхүүн 6400 сая м<sup>3</sup>. Орчинд нь говийн байгаль зонхилох бөгөөд умард эрэг нь өндөр /15-30 м /, баруун хэсэгтээ намагжиж өвс ургамал шигүү ургана. Нуурт 2 жижиг хадан арал бий. Нийтдээ 3360 км<sup>2</sup> талбайгаас усждаг хэд хэдэн булаг, сайр, гол цутгахаас хилийн цаанаас эх авдаг Харигийн гол тэжээлийн зонхилох хувийг эзэлнэ. Усны гадаргын температур 7 дугаар сард цутгал голын адаг, булан тохойд 14.0-15.0°C, төв хэсэгтээ 12.1-13.0°C, 20 м гүнд 11.0°C, байдаг.

Усны тунгалагшилт 7-8 м орчим. 10 дугаар сарын сүүлээс 5 дугаар сард хөлддөг. Мөсний зузаан 1,2-1,5 м. Ёроолын 60-70 хувийг цайвар өнгөтэй лаг шавар, эргийн зурвас хэсэгт элс тархсан байдаг. Харигийн голын цутгалаас бусад хэсэгт усны ургамал байхгүй. Давсархаг устай, ерөнхий эрдэжилт өнгөндөө 5.9 г/л 20 м гүнд 6.08 г/л, 40 м гүнд 5.95 г/л, РН-9.22 хүчилтөрөгчийн хангамж өнгөндөө 8.2 мг/л, найрлагаараа сульфат натрийн төрөлд багтана.

**24. Ачит нуур:** Увс, Баян-Өлгийн аймгийн заагт 1435 м өндөрт байдаг тектоник гаралтай нуур. Монгол Алтайн нурууны хамгийн том цэнгэг нуур. 296.8 км<sup>2</sup> талбайтай, 24.0 км урт 18.0 км өргөн, эргийн шугамын урт 99.0 км. Эргийн байгаль талархаг, тусдаа булан, тохой, арал, хойн байхгүй. Нуурын хойд талаас цутгадаг голууд адагтаа их садраа

адаг үүсэж намагжиж баянбүрд, ойн төгөл үүсгэж үзэсгэлэнтэй болгожээ. Нуурын эргээс алсад татралтын хэд хэдэн дэнж зэрэгцэн орших нь эрт цагт нуурын ус их байсны ул мөр бий. Усны гүн маш бага /5м/, эзлэхүүн 665 сая м<sup>3</sup>. Ёроолд нь хүхэр устөрөгчийн үнэртэй хар бараан лаг ялзмагт шавар захын хэсэгт элс тархаж 2 м хүртэлх гүехэн усанд төрөл бүрийн замаг, зэгс шигүү ургаж нүүдлийн шувууд олноор хуран цуглардаг.

Усны температур 7 дугаар сард эрэг дагуугаа 21.5-22.8°C, 2 м гүнд 16.3-20.3°C, 3 м гүнд 16.2-14.3°C, 4 м гүнд 18.0-19.0°C, ёроолдоо 17.2°C, байдаг. 11 дүгээр сараас 5 дугаар сар хүртэл хөлдөх ба мөсний зузаан 1.1-1.3 м орчим байдаг. Нийтдээ 10500 км<sup>2</sup> талбайгаас усжих Цагаан гол, Хатуугийн гол, Бөхмөрөн, Улиастай зэрэг гол горхи цутгаж илүүдэл ус нь /Нуурын хоолой/ гэдэг өргөн талаараа Ховд голтой нийлдэг. Ерөнхий эрдэсжилт 180 мг/л, хүчилтөрөгчийн хангамж өнгөндөө 11.3 мг/л, РН-8.2 карбонат сульфат, кальц зонхилж найрлагаараа сульфатын төрлийн сульфат магнийн доод төрөлд багтана. Баруун нуурын загас жараахайтай, амралт сувилал, агнуур-спорт, аялал жуулчлал хөгжүүлэхэд тохиромжтой.

**25. Хяргас нуур:** Увс аймгийн нутагт 1028 м өндөрт байдаг тектоник гаралтай эртний нуур. Манай орны мянгаас дээш талбайтай дөрвөн нуурын нэг. 1406.8 км<sup>2</sup> талбайтай, 75 км урт, 31.0 км өргөн, эргийн шугамын урт 253.2 км, усны гүн Чацарганы шугамын ойролцоо 92 м, бусад хэсэгт 40-50 м зонхилно. 40 м-ээс цааших гүн талбайн 50 гаруй хувийг эзэлдэг. Уны эзлэхүүн 66034 сая м<sup>3</sup>, дундаж гүн 47 м. Орчин нь цөлөрхөг, нуурын араар үргэлжлэх Ханхөхийн нурууны өмнөд бэл хурын усанд эвдэрэ эрэг ганга, гуу жалга, сахриа, садраа элбэгтэй байдаг. Уулын бэлд нуурын татралтын эртний далан, зөөг эгнэж умраас нь Нуурын шугам, Чацарганы шугам, Могойн шугам гэдэг 4-7 км урт хошуу түрж ордог. Өмнө талд гь гантиг цагаан хадан цохионууд цухуйж нэн үзэсгэлэнтэй харагддаг. Нуурын ёроолд цайвар саарал өнгөтэй сулавтар хүхэр устөрөгч бүхий лаг, наанги шавар, эргийн дагууд элс, хайр, хөрзөн чулуу тархана. Нуурт Монгол Алтай, Хангайн нуруунаас эх авдаг Хүнгүй, Завхан, Ховд голд том жижиг нуур дамжиж цутгадаг. Нуурт температурын шууд урвуу үедэд үүсэж 7,8 дугаар сард өнгөндөө 18.0-20.2°C, эрэг дагуугаа 23.0-24.0°C, халж ёроолдоо 10.0-11.0°C, өвөл өнгөндөө 0.1-0.2°C, 60 м-ээс цааш 3.5-4.1°C, 12 дугаар сараас 4 дүгээр сард 0.6-0.7 м зузаан мөсөөр хучигддаг.

Зарим жилд өрхөлж хар цагаан хил үүсдэг. Усны өнгө цайвар, ногоон, хар бараавтар, тунгалагшилт 10 м. Ерөнхий эрдэсжилт харилцан адилгүй, гадаргад 8,4 г/л, 50 м гүнд 8.50 г/л, ихэнхийг сульфат-хлор, натрийн давс эзэлж найрлагаараа нүүрсхүчлийн натрийн төрөлд багтана. Усны РН хэмжээ 9.22. нуурт баруун нуурын загас, нүүдлийн шувууд элбэг байдаг. Эргэн тойронд нь анагаах рашаан ус, эрдэст нууртай. Амралт сувилал, агнуур-спорт, тойрон аялал, усан тээвэр хөгжүүлэх боломж сайтай.

Нуурын баруун хойт эрэг дээрх Хар Тэрмэсийн рашааныг түшиглэж амралт сувилал ажилладаг.

**26. Айраг нуур:** Увс аймгийн Завхан сумын нутагт Хяргас нуураас холгүй 1030 м өндөрт байдаг цэнгэг нуур. 143.3 км<sup>2</sup> талбайтай, 16.0 км урт, 13.0 км өргөн, эргийн шугамын урт 54.0 км, усны гүн Галбын хоолойн орчимд 10 м, бусадхэсэгт 4-8 м гүн

зонхилно. Усны эзлэхүүн 820 сая м<sup>3</sup>. Эргийн байдал талархаг умард талаар нь Галбын ухаа үргэлжилж Хяргас нуураас тусгаарлана. Цутгал голын адагт намагжиж зэгс шигүү ургадаг. Завхан, Хүнгүйн гол цутгаж Галбын өргөн хоолойгоор Хяргас нууртай холбогддог. Усны температур 7,8 дугаар сард 19.5-21.3°C, 2,3 дугаар сард ёроолдоо 2.0-2.5°C, 11 дүгээр сард 4 дүээр сард хөлдөж 1.0-1.3 м зузаан бат бэх мөсөөр хучигдана. Нуурын ёроолд элс хайргаас гадна хүхэр устөрөгчийн сулавиар үнэртэй харлаг ялзмагт шавар унасан байдаг. Эрдэсжилт бага /502.02. мг/л/, PH-8.58 карбонат натрийн ион зонхилж байдаг. Баруун нууруудын загас байрших ба нүүдлийн шувууд их хуран цуглардаг. Усан хангамж, агнуур-спорт, амралт сувилалын боломж сайтай.

**27. Олон нуур:** Увс аймгийн Бөхмөрөн, Ховд сумын заагт Хархираа уулаас эх авдаг Шиврийн голын эхэнд 2536 м өндөрт байдаг мөстлийн гаралтай бүлэг нуурын нэг. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 1.1 км урт, эргийн шугамын урт 3.2 км. Урсгал цэнгэг устай.

**28. Хар нуур:** Увс аймгийн Бөхмөрөн сумын нутагт Хархираа уулаас усждаг Шивэр голын эхэнд 2530 м өндөрт байдаг мөстлийн гаралтай цэнгэг нуур. 0.7 км<sup>2</sup> талбайтай, 1.9 км урт, 0.7 км өргөн, эргийн шугамын урт 4.8 км. Хур цас мөснөөс эх авах гол горхи орж гарна.

**29. Бага нуур:** Увс аймгийн Бөхмөрөн сумын нутагт Ачит нуурын зүүн хөвөөнд Товх уулын орчинд 1548 м өндөрт байдаг тектоник хотост байдаг нуур. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 1.0 км урт, 0.6 км өргөн, эргийн шугамын урт 9.6 км.

**30. Хөх нуур:** Увс аймгийн Бөхмөрөн сумын нутагт Ачит нуурын зүүн хөвөөнд 1440 м өндөрт байдаг шорвог нуур. 0.7 км<sup>2</sup> талбайтай, 1.8 км урт, 0.8 км өргөн, эргийн шугамын урт 4.4 км.

**31. Давсан нуур:** Увс аймгийн Наранбулаг, Өлгий сумийн нутгийн заагт 1570 м өндөрт байдаг шорвог нуур. 0.7 км<sup>2</sup> талбайтай, 1.8 км урт, 0.8 км өргөн, эргийн шугамын урт 4.2 км.**32. Мунын Шал нуур:** Увс аймгийн Завхан сумын нутагт Айраг нуурын баруун талд 1120 м өндөрт байдаг хатаж ширгэдэг нуур. Устай үед 0.8 км<sup>2</sup> талбайтай, 2.6 км урт, 0.6 км өргөн, эргийн шугамын урт 5.4 км хүрдэг.

**33. Мухарын тойром нуур:** Увс аймгийн Завхан сумын нутагт Мухар Хүнгүйн голын хойд талд элсний түйрэн хонхорт 1022 м өндөрт байдаг нуур. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 1.5 км урт, 0.9 км өргөн, эргийн шугамын урт 3.8 км. Өмнөөс нь хэд хэдэн булаг шанд цутгадаг.**34. Далан Түрүүн нуур:** Увс аймгийн Зүүнхангай сумын нутагт Цагаан нуурын ойролцоо 1460 м өндөрт байдаг тектоник гаралтай эрдэст нуур. 0.8 км<sup>2</sup> талбайтай, 2.4 км урт, 0.8 км өргөн, эргийн шугамын урт 5.8 км.

**35. Хаяа бүрдэн нуур:** Увс аймгийн Завхан, Ховд аймгийн Дөргөн сумын заагт 1030 м өндөрт байдаг шорвог нуур. 1.4 км<sup>2</sup> талбайтай, 2.1 км урт, 1.1 км өргөн, эргийн шугамын урт 6.4 км орчим боловч тогтворгүй.

**36. Тогоо нуур:** Увс аймгийн Завхан сумын нутагт Завхан голын баруун эрэгт 1056 м өндөрт байдаг шорвог нуур. 0.9 км<sup>2</sup> талбайтай, 1.4 км урт, 0.5 км өргөн, эргийн шугамын урт 3.4 км.



**37. Сангийн Далай нуур:** Увс аймгийн Завхан сумын нутаг Завхан голын баруун эрэгт 1060 м өндөрт байдаг шорвог нуур. 0.6 км<sup>2</sup> талбайтай, 1.4 км урт, 0.5 км өргөн, эргийн шугамын урт 3.4 км.

**38. Бударган /Хүнхийн/ нуур:** Увс аймгийн Завхан, Ховд аймгийн Дөргөн сумын заагт 1109 м өндөрт байдаг шорвог нуур. 0.6 км<sup>2</sup> талбайтай, 2.3 км урт, 0.6 км өргөн, эргийн шугамын урт 5.2 км.

**39. Бага нуур:** Увс аймгийн Түгэн сумын нутаг Увс нуурын баруун талд 759.6 м өндөрт байдаг үлдэгдэл нуур. 1.8 км<sup>2</sup> талбайтай, 2.0 км урт, 1.1 км өргөн, эргийн шугамын урт 5.1 км. Эргэн тойронд нь намагжиж зэгс шигүү ургадаг. Нүүдлийн шувууд хуран цугларч зусдаг. Усны температур 7.8 дугаар сард 19.2-21.5° хүрдэг. Ёроолдоо лаг, ялзмагт шавар, усны ургамалтай.

**40. Их шар нуур:** Увс аймгийн түргэн сумын нутагт Хархираа, Хөндлөн голын адагт 780 м өндөрт байдаг хаягдмал шорвог нуур. 0.7 км<sup>2</sup> талбайтай, 1.7 км урт, 1.4 км өргөн, эргийн шугамын урт 6.8 км.

**41. Дөрөө нуур:** Увс аймгийн Баруунтуруун сумын нутаг Алтан элсний хойно улсын хил дээр 1143 м үнэмлэхүй өндөрт байдаг эрдэст нуур. Нуурын нийт талбай 73.0 км<sup>2</sup> талбайтай, 21.0 км урт, 5.0 км өргөн, эргийн шугамын урт 56.0 км боловч манай нутагнутагт ноогдох нуурын талбай 15 км<sup>2</sup> талбайтай, 12.0 км урт, 3.5 км өргөн, эргийн шугамын урт 25.0 км. Баруун нуурын загас, нүүдлийн шувууд элбэг. Талбайн ихэнх нь ОХУ-ын нутагт хамаарна.

**42. Майхан нуур:** Увс аймгийн Бөхмөрөн сумын нутаг Алтан гадасны голын цутгал голын гольдрол 2346 м өндөрт байдаг урсгал уулын нуур. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 1.3 км урт, 0.6 км өргөн, эргийн шугамын урт 3.4 км.

10	Шүдэн уулын чулуун давсны орд	Давст сумын төвөөс зүүн зүгт 18 км-т оршино	Тус давсны ордын нөөц нь 73.2 сая тонн. Давсны зузаан нь 9-50м. Тус давсны уурхайг 1974 оноос ашиглаж эхэлжээ. Шүдэнгийн жамц давс хүнсэнд болон малын тэжээлд тохиромжтой	Дотоод гадаадын аялагчид давсны өвөрмөц тогтоц, давс олборлох аргатай танилцахаас гадна байгалийн үзэсгэлэнт Торхилог голоор аялана. Хүмүүсийн үйл ажиллагаанд өртөгдсөн
11	Төгсбуянтын хүрээний туурь	Түргэн сумын нутагт Түргэн, Буурлын Голуудын бэлчирт байрлана	Дөрвөд далай ханы гол хүрээ. Энэхүү туурь нь Түргэн сумын нутагт Түргэн, Буурлын голуудын бэлчирт байрладаг. 1758 онд суурийг нь тавьсан гол хийдийг Жигнийлин гэдэг байжээ. Төгсбуянтын хүрээ нь Чогчин, Жүд, Мамба, Чойр, Дүйнхар гэсэн таван том дацан, 22 сүм дуган, 800 гаруй ламтай байжээ. Дорно дахины таван ухааны ном судлан сургалт явуулан хурал ном хурдаг байсан. Хамгийн том цогчин дуган 120 жангийн хэмжээтэй байжээ. Тус хүрээнд 6 том тогоо байсны хамгийн том Баянцагаан гэгч	Гадаадын жуулчдын морин ба явган аялал энэ орчмоор явагддаг. Ойролцоо нь “Онцын тасархай” жуулчны баазтай. Түргэн сумын хуучин төв Баянхайрхан багийн төв. Хүмүүсийн үйл ажиллагаанд өртөгдсөн



			тогоо нь нэг удаа цай чанахад 5-6 шар цайгаар идээ хийдэг байжээ. Төгсбуянтын хүрээ нь 13 жастай байсан ба 1925 оны байдлаар жасын мал 97965 толгой буюу Далай ханы хошууны нийт малын 37.2 хувийг эзлэж байжээ. 1930 онд Төгсбуянтын хүрээний лам нарын бослого гарч, 1937 онд ихэнхи лам нарыг нь баривчлан, 1938 онд уг хийдийг тарааж, Дүйнхэрваан уулын оройгоос их буугаар хийдийг буудаж нураасан гэж нутгийн хөгшчүүл хуучлан ярьдаг.	
12	Түргэн уул	Түргэний уулс нь Ховд, Түргэн, Бөхмөрөн, Сагил, Улаангом сумын нутгийг дамжин 70 орчим км үргэлжилнэ	1993 оноос УТХ-д авсан ДЦГ. Буурал, Түргэн, Живэртэйн голуудын эх авсан нуруунуудыг дамжуулан, Цагаан дэглий уулнаас зүүн тийш Хавцалын боом хүртэлх 145.1 мянган га талбайг хамрана. Уулын тундр, ой, тайга, уулын хээр зэрэг байгалийн олон бүс бүслүүр хосолсон мөнх цас, мөсөн тогоо, хүрхрээ, агуй, хад цохио бүхий байгалийн үзэсгэлэнт газар. Түргэний уулсаас Хархираа, Түргэн, Ямаат гол эх авч урсдаг. Хар мод бургас, бушилж ургана. Ирвэс, аргаль, янгир зэрэг 30 гаруй зүйлийн ан амьтантай. Оргил нь “Дэглий Цагаан” 4278м өндөр. Уулын спортыг хөгжүүлэх боломжтой	Гадаадын жуулчдын төрөл бүрийн аяллын хөтөлбөрт багтдаг аялал жуулчлал хөгжүүлэх гол түшиц газар. Явган, морин, тэмээн аялал ихэвчлэн явагддаг. Онцын тасархай, Хархираа жуулчны бааз, Цүнхэгийн амралт энэ бүсэд байрладаг. Малчдын “Гурван хороо”, “Ямаат”, “Олон нуур” аялал жуулчлалын нөхөрлөл байдаг. Хүмүүсийн үйл ажиллагаанд өртөгдөж байгаа
13	Ямаат уул	Аймгийн баруун хойд хэсэгт Бөхмөрөн, Ховд сумын нутгийг дамжин оршино	Мөнх цас, мөсөн оргил бүхий байгалийн үзэсгэлэнт газар. Ямаат уул д.т.д. 3900м өндөр. Зүрхэн уул, Их Ямаат, Бага Ямаат, Ирвэстэй, Хонжиг, Рашаантын ам зэрэг уулс нь ховор ургамал, амьтны өлгий нутаг. Дэлхий улаан номд орсон нэн ховор ирвэс, аргаль, янгир, шилүүс гэх мэт 30 гаруй зүйлийн ан амьтантай. Алтангагнуур, Вансэмбэрүү зэрэг ховор ургамалтай төдийгүй хүрлийн үеийн хадны зураг түүх соёлын дурсгалтай, ДЦГ-ын бүс нутаг.	Байгалийн аяллын гол түшиц газар. Морин аялал, явган аяллын гол бүс. Гадаадын жуулчдын төрөл бүрийн аяллын хөтөлбөрт багтдаг. Ямаат нөхөрлөлийн гэр бааз байрладаг. Хүмүүсийн үйл Ажиллагаанд өртөгдөж байгаа
14	Баян нуур, Урт булагийн рашаан	Зүүнговь сумын нутаг Бөөрөг дэлийн элсний хойд хэсэгт оршино. Аймгийн төвөөс 150 орчим км.	Цэнгэг устай нуур. Урт нь 11.5км, өргөн нь 3.9км, 27.8 ам.км талбайтай. Баян нуурын усан хоолойд усанд орох боломжтой. Нуурын баруун хойт зүгт Урт булагийн рашаан бий. Баяннуураас Урт булаг 10км зайтай. Өвөлд хөлддөггүй, гидрокарбонат, кальц-натрит төрлийн рашаан. Ходоод, гэдэс дотор, бөөрний	Гадаад дотоодын жуулчид зорин ирдэг. Тэмээн аялал, байгалийн аялал, эмчилгээний аялал хийдэг. Орон нутгийн чанартай рашаан сувилал ажиллаж байна. Одоо зуны цагт нутгийн иргэд хувиараа майхан гэр барьж рашаан ууж амардаг. Хүмүүсийн

			өвчнийг анагаана	үйл ажиллагаанд өртөгдөж байгаа
15	Зураагийн хадны зосон зураг	Зүүнхангай сум 351 км	Овог отгоороо ан хийж байгааг дүрсэлсэн чулуун зэвсгийн үеийн зураг, дэлхийд 2 байдаг. Нөгөө нь Америкийн Аляскт бий.	Наран тал руу харсан тул нар салхи, ус бороо зэрэг байгалийн элэгдэлд орж дүрс тэмдэг нь илт бүдгэрсэн. Хамгаалах шаардлагатай
16	Можоогийн хадны зураг	Сагил сумын нутаг, 111 км. Цагаан голын эхэнд оршино	Неолитийн үеийн дурсгал. Монголд төдийгүй дэлхийд гайгахдаг дурсгал хэмээн үздэг. Монголд 2 байдаг нөгөө нь Ховдын Гурван цэнхэрийн агуйн зураг. Можоогийн хадны зурагт аргаль, янгир, тэмээ, нохой, үхэр, хүн зэргийг дүрсэлсэн. Үхрийг нум сумаар харваж байгаа болон хөтлөн явж буй хүнийг дүрсэлсэн	Нутгийн иргэдийн дунд түүх соёлын дурсгалыг хамгаалах, түүхэн үнэ цэнийг нь алдагдуулахгүй байх хамгаалалтын шинэ арга замыг тодорхойлох шаардлагатай.

## 9.2. Түүх соёлын дурсгалт газрууд

Хүснэгт № 10.2. Увс аймгийн түүх соёлын дурсгалууд

№	Түүх соёлын дурсгалын нэрс	Байршил алслагдсан зай /км-ээр/	Хамрагдах үе	Тайлбар
1	Бор нурганы Хүүхдийн овооны хос хүн хөшөө	Давст сум 140 км	Түрэгийн үе	ЗГ-ын 1998 оны 235-р тогтоолоор улс, аймгийн хамгаалалтанд орсон. Нэг хөшөө нь хугарч унасан, нөгөө хөшөө нь элэгдэлд орж цуурсан.
2	Жаажаагийн хөтлийн хүн чулуу	Наранбулаг сум, Зуслан 140 км	Түрэгийн үе	Нэг хөшөө нь хугарч унасан. Нөгөө хөшөө нь хазайж унах аюултай байгаа.
3	Нийчийн амны хүн чулуу	Хяргас сум 168 км	Түрэгийн үе	Толгойн хэсгээрээ 45хэмийн налуутайгаар хагарсан
4	Овгор хиргисүүрийн хүн чулуу	Хяргас сум 168 км	Түрэгийн үе	Элэгдэлд орсон
5	Халхайтын дэнжийн хүн чулуунууд	Тариалан сум 41 км	Түрэгийн үе	1 хөшөө нь гаднын нөлөөгөөр хугарсан
6	Хөтөл нуурын бор толгойн хүн чулуу	Малчин сум 122 км	Түрэгийн үе	Улсын хамгаалалтад орсон
7	Бургастайн хөндийн Ганц харгайтын бичигт хадны зураг	Сагил сум 83 км	Хүрэл зэвсгийн үе	Мал амьтны үржлийн үеийг бэлгэдэж дүрсэлсэн
8	Зураагийн хадны зосон зураг	Зүүнхангай сум 351 км	Чулуун зэвсгийн үе	Наран тал руу харсан тул нар салхи, ус бороонд идэгдэж дүрс тэмдэг нь илт бүдгэрсэн.
9	Можоогийн хадны зураг	Сагил сум 111 км	Төмрийн түрүү үе	Палеолитийн үеийн ийм дурсгал дотроос Монгол оронд төдийгүй дэлхийд гайгахдаг онцлог дурсгал хэмээн эрдэмтэд үнэлдэг.
10	Их сар хадны зураг	Сагил сум 94 км	Дундад зууны үе	Зурган байгаа дүрслэл нь 13-р зууны үеийн монголчуудын хувцас хэрэглэлтэй төстэй. Нутгийн хүмүүс Чингисийн хадны зураг гэдэг.
11	Зүүн турагийн тэрэм хадны зураг	Давст сум 129 км	Төмөр зэвсгийн үе	Хад чулуу нь байгалийн элэгдэлд орж нурж эхэлсэн
12	Саравхын хадны зураг	Наранбулаг сум 116 км	Хүрэл зэвсгийн үе	Аргаль, янгир их хэмжээгээр сүрэглэсэн байдлаар дүрсэлсэн.
13	Тэхтийн давааны	Давст сум 160 км	Хүрлийн үе	Мөнгөт цахирын аманд бий

	хадны зураг			
14	Үнхэлцэгийн хадны зураг	Сагил сум 92 км	Хүрлийн үе	Аргаль, янгир их хэмжээгээр сүрэглэсэн байдлаар олон тоогоор дүрсэлсэн.
15	Хад үзүүрийн хадны зураг	Бөхмөрөн сум 195 км	Хуучин чулуун зэвсгийн үе	Аргаль, янгир их хэмжээгээр сүрэглэсэн байдлаар олон тоогоор дүрсэлсэн.
16	Хар цагаан усны хадны зураг	Баруунтуруун сум 235 км	Төмөр зэвсгийн үе	Буга гөрөөс, аргаль, янгир олон тоогоор дүрсэлсэн.
17	Цагаан өтөг хадны зураг	Сагил сум 81 км	Хүрлийн үе	Аргаль, янгир их хэмжээгээр сүрэглэсэн байдлаар олон тоогоор дүрсэлсэн.
18	Шар булагийн онцын хадны зураг	Өлгий сум 139 км	Төмөр зэвсгийн үе	Улсын хамгаалалтанд орж байсан. Онц сонирхолтой хадны сүг зураг бий.
19	Чандмань уулын булш	Улаангом 2.5 км	Хүрлийн үе	Чандмань уулын булшинд 1976 онд хийсэн археологийн малталт нь олдвороороо дэлхийн соёлын түүхэнд Чандманы соёл хэмээх шинэ нэр томъёог оруулж ирснээрээ түүхэн ач холбогдолтой.
20	Долоодойн түрэг бичээс	Аймгийн ОНС музейд бий	Түрэгийн үе	1956 онд археологич Ц.Доржсүрэн Түргэн сумын Хар ус гэдэг газраас олж аймгийн музейд шилжүүлэн авчирсан. Эртний Түрэгийн Руни бичгээр 4 мөр бичигдсэн дурсгал юм.
21	Төмөр цоргын хадны бичээс	Сагил сум, Энэ газар Сагил суманд байдаг боловч уг бичээс олдохгүй байгаа 86 км	Түрэгийн үе	1981 онд археологич Д.Цэвээндорж анх илрүүлэн түүхийн эргэлтэнд оруулсан. Ердөө наймхан үсэг зурлагаас бүрдсэн монголын хамгийн баруун хойд талын дурсгал юм.
22	Ачит нуурын хадны бичээс	Бөхмөрөн сум, Баянөлгий аймгийн ОНСМ-д	Түрэгийн үе	Ачит нуураас баруун хойшоо 17 км-т шанагын хэв гэдэг газарт оршдог. 1979 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн ЭША Н.Сэр-Оджав, Д.Дорж нар илрүүлэн тэмдэглэсэн.
23	Төгсбуянтын хүрээний туурь	Түргэн сум 99 км	1758-1938 он	Улаангомоос 99 км-т Таван Дэнхэрваан уулын хажуу бэлд байдаг.

Аймгийн нутаг дэвсгэрт эртний түүх соёлын дурсгалт зүйл болох хүн чулуу 129, буган хөшөө 26, хадны сүг зураг 101 цэгт 41500 гаруй, бичиг тэмдэгт хөшөө 25, гэрэлт хөшөө 1 түүнчлэн Өмнөговь сумын Улиастайн шилд мөн Давстын Торхилог багийн нутагт эртний хотын үлдэгдэл, олон мянган хиргисүүр, цөөнгүй тооны эртний сүм хийдийн үлдэгдэл, туурь бүртгэгдсэн. Улаангомын Чандмань уулын археологийн олдвор нь эртний түүх соёлын нандин өвд тооцогддог. Аймгийн музей нийт 7749 үзмэртэйгээс хосгүй үнэт 10 дурсгал бий. Үүнд: Дөрвөд далай ханы эмээлийн мод, сийлбэртэй ган хэт бэл, Даваач хааны савал аага, Далай хааны хутга, бух ноолдооны шалбуур, Дөрвөд далай ханы ямбаны жууз, хүрэл зэвсгийн үеийн чулуун хэв, Амарсанаа баатрын хөө хуяг гэх мэт хосгүй үнэт ховор эд өлөгтэй. Одоогоос 20-15 сая жилийн өмнө амьдарч байсан хярсны ясны үлдэгдэл, чулуун болон хүрлийн үеийн дурсгалууд, Долоодойн уйгар, руни бичигт хөшөө дурсгалууд байхаас гадна баруун монголын голлох 4 ястан болох дөрвөд, баяд, хотон, халх зэрэг ястануудын амьдралын ялгаатай хэв маяг, уламжлалт ёс заншилыг харуулсан хувцас хунар, гоёл чимэглэлийн ур хийц, орц сайтай эд өлөгтэй. Аймгийн түүх соёлын дурсгалыг археологийн ангиллаар нь авч үзвэл Хүн чулуу 129 байгаагаас 6 нь түүх соёлын дурсгалын хувьд ихээхэн ач холбогдолтой төдийгүй сайн судлагдсан. Үүнд: Давст сумын Бор нурганы хүн хөшөө, Зүүнхангай сумын Зураагийн улаан хадны зураг,

Сагил сумын Могоогийн хадны зураг, Тариалан сумын Халхайтын дэнжид орших булш, хүн чулуунууд багтдаг. Аймгийн хэмжээнд нийт 101 цэгт 41500 гаруй хадны сүг зураг тэмдэглэгдсэнээс түүхийн хувьд илүү ач холбогдол бүхий 13 хадны зураг бий. Үүнд: Сагиль сумын нутагт Цагаан эндэртийн хадны сүг зураг, Цагаан голд хөх давааны атар, хэцүү хөтөлд хадны зураг, Цагаан өтөгийн хадны зураг, харгайтын хадны зураг, Могоо бужаагийн хадны зураг, Турагийн хадны сүг зураг, Давст сумын нутаг дэвсгэрт Енхэлдэгийн бэлд хадны зураг, Бургастайн хадны зураг, Шар толгойн баруун магнайд буйрын хадны зураг байрладаг. Он цагийн хувьд Хүрэл зэвсгийн үед хамаарагдах 5, чулуун зэвсгийн үед хамаарагдах 4, төмөр зэвсгийн үеийн 3, Хүннүгийн үед хамаарагдах ховор олдворууд, дундад зууны үеийн 1 хадны зураг байна.

Гэрэлт хөшөөг Хяргас сумын нутагт Да лам Цэрэнчимэдийн дурсгалд зориулж, 1916 оны 5-р сарын 20-нд босгосныг 2011 онд ЗГХЭГ-ын 100 жилийн ойг тохиолдуулан сэргээн засварлаж, түүхийн өв дурсгалд бүртгэж авсан байна.



### 9.3. ХанХөхий нурууны Улсын тусгай хамгаалалттай газар нутгаар аялах аялал жуулчлалын маршрут

#### 9.3.1. Маршрут Хяргас-Ханхөхий аялал

Хүснэгт № 10.3.

Өдөр	Аялалын нэр чиглэл		Унаа	Зай /км/	Үзэх зүйл	Түр хоноглох газар
	Хаанаас	Хаана				
	Улаанбаатар	Улаангом	Онгоц	1336	-Орон нутаг судлах музей	
1	Улаангом хот дотор		Машин	15	-Улаан уул дахь эртний булш, туурь-Улаан уулын рашаан	Зочид буудал
	Улаангом	Хяргас нуур Хар тэрмэс амралт	Машин	135	-Хяргас нуурын усанд шумбах -Хар тэрмэсийн рашаан -Өвөрмөц тогтоц бүхий шавар уул /нутгийн хэлээр явар гэдэг/ -Могойн шугам/ загас барих/ -Оргилдог булаг	Хар тэрмэсийн амралт сувиллын газар
2	Хар тэрмэс амралт	Толийн булаг	Машин	110	-Хосын багийн төв -Нүдэн нуур -Хосын овоо -Төрийн тахилгат овоо Гэрэлт хөшөө	
	Өндөрхангай сумын төв	Зүүн голын Өргөө засдаг	Машин Явган	30 5	-Орон нутаг судлах музей -Гандандаржаалин хийд -Чигжийн голын рашаан -Хийморийн овоо -Зүүн голын хүн чулуун хөшөө, бичигт хад Мандаа хиргисүүр	Өргөө засдаг
3	Өргөө засдаг	Хорин бугатын даваа	Машин	10	-Мааньтын дөрөлжийн суварга бичигтэй чулуу, -Газрын хагархай -13 овоо -Хярын нуур -Тэлээ мод	
	Хорин бугатын даваа	Алтан бургас	Машин явган	30 5	-Малчин айлын ахуй амьдралтай танилцах -Боомын гол -Салхинд алтран шаргалтах хэсэг улиас -Жинс чулуу -Шинэсэн ой, жимс, жимагэнэ -Шувуудын жиргээ -Эхийн хэвлий агуй	Алтанбургас
4	Алтанбургас	Соёо уул			-Агартагийн агуй, -Хоёр ихэр хүн чулуу -Соёо уул -Жинст хад	Соёо
5	Соёо уул	Баруунтуруун	Машин	40	-Орон нутаг судлах музей -Хиймэл нуур -Турууны гол -Өвгөн овоо -Тариан талбай	Баруунтуруун Улаангом
6	Баруунтуруун	Улаангом	Машин	190	-Баядын тахилгат Баянхайрхан уул	Улаангом
7	Улаангом	Улаанбаатар	Онгоц	1336		

## Маршрут-1 Богино аяллын саналууд

Хүснэгт № 10.4. Аяллын замын урт – 121 км , Хугацаа – 2 хоног

Аялалын зам	Унаа, зай /км/ тайлбар	Үзэх зүйлс
Улаанбаатар – Улаангом	1336 км онгоц үдийн хоол	- Чандмань уул /хүрлийн хожуу, төмрийн түрүү үеийн МЭӨ 7-3-р зууны үеийн булш, эртний түүх соёлын эд өлгийн зүйлс/, уулын оргилоос Улаангом хотыг ажиглан харах боломжтой. Хотын төвд Ю.Цэдэнбалын хөшөө-цогцолбор /монгол улсын төрийг 44 жил удирдсан зүтгэлтэн/ - Музей 13000 үзмэртэйгээс хосгүй үнэт 10 дурсгал - Таримал жимсний талбай /хотоос 1-3 км, үхрийн нүд, чацаргана/-г сонирхон жимс амталж болно.
Улаангом - Хархираа	28 км машин /үндэсний гэр, майхан, орчин үеийн сууц/	- Мөнх цаст уулнаас эх авсан Хархираа гол, цэвэр агаар, цэлмэг тэнгэрийн дор явган аялаж ой хөвч, ойн амьтад, ургамлын аймагтай танилцана. - Байгалийн үзэсгэлэнт газар байрлах амралтын хотхонд хононо.
Хархираа – Увс нуур	60 км машин	- Огзонын хүн чулуу - Нуурын усанд сэлэх, Шувуу ажиглах
Увс нуур – Улаангом	30 км машин	- Улаангом хотоор аялах - Чандмань уулын рашаан - Улаан уулан дээрээс шөнийн Улаангомыг ажиглах
Улаангом - Улаанбаатар	1336 км онгоц	Дэглий цагаан нисэх онгоцны буудлаас Чингис хаан нисэх онгоцны буудалд буух

## Маршрут-2

Хүснэгт № 10.5. Аялалын замын урт – 61 км , Хугацаа – 2 хоног

Аялалын зам	Унаа, зай /км/ тайлбар	Үзэх зүйлс
Улаанбаатар – Дэглий цагаан нисэх онгоцны буудал	1336 км онгоц үдийн хоол	
Дэглий цагаан - Хархираа	28км машин /үндэсний гэр, майхан, орчин үеийн сууц/	- Мөнх цаст уулнаас эх авсан Хархираа гол, цэвэр агаар, цэлмэг тэнгэрийн дор явган аялаж ой хөвч, ойн амьтад, ургамлын аймагтай танилцана. - Байгалийн үзэсгэлэнт газар байрлах амралтын хотхон
Хархираа – Улаангом	30 км машин	- Огзонын хүн чулуу - Чандмань уул /хүрлийн хожуу, төмрийн түрүү үеийн МЭӨ 7-3-р зууны үеийн булш, эртний түүх соёлын эд өлгийн зүйлс/, -Хотын төвд Ю.Цэдэнбалын талбай /монгол улсын төрийг 44 жил удирдсан зүтгэлтэн/ - Музей 13000 үзмэртэйгээс хосгүй үнэт 10 дурсгал - Таримал жимсний талбай /хотоос 3 км, үхрийн нүд, чацаргана/-г сонирхон жимс иднэ. - Уулын оргилоос шөнийн Улаангом хотыг ажиглан харах боломжтой. - Чандмань уулын рашаан
Улаангом - Улаанбаатар	1336 км онгоц	Дэглий цагаан нисэх онгоцны буудлаас Чингис хаан нисэх онгоцны буудалд буух

*Хүснэгт№ 10.6. Аялалын замын урт – 230 км Хугацаа - 2 хоног*

Аялалын зам	Унаа, зай /км/ тайлбар	Үзэх зүйлс
УБ – Улаангом	1336 км онгоц, үдийн хоол бензин	Чандмань уул /хүрлийн хожуу, төмрийн түрүү үеийн МЭӨ 7-3-р зууны үеийн булш, эртний түүх соёлын эд өлгийн зүйлс/, уулын оргилоос Улаангом хотыг ажиглан харах боломжтой. Чандмань уулын рашаан Хотын төвд Ю.Цэдэнбалын талбай /монгол улсын төрийг 44 жил удирдсан зүтгэлтэн/ Музей 13000 үзмэртэйгээс хосгүй үнэт 10 дурсгал Таримал жимсний талбай /хотоос 3 км, үхрийн нүд, чацаргана/-г сонирхон жимс иднэ.
Улаангом-Наранбулаг	90 км машин	Нутгийн айлд зочилж сүү цагаан идээ боловсруулах аргачилалтай танилцана
Наранбулаг-Хяргас нуур-Хар тэрмис	45км машин хоноглоно	Нуурын загас барих, загасчлах Хар тэрмисийн уулын тогтолцоо, хар улаан сүндэр үзэх, янз бүрийн өвчин анагаах рашааныг үзэх, усанд орох, элсэн дээр бие шарах
Хар тэрмис-Улаангом	90 км машин	- Уулын оргилоос шөнийн Улаангом хотыг ажиглан харах боломжтой. - Чандмань уулын рашаан
УБ буцна	1336км онгоц	

*Хүснэгт№ 10.7. Аялалын замын урт – 330 км, Загасчлах аялал*

Аялалын зам	Унаа, зай /км/ тайлбар	Тайлбар
УБ – Улаангом	1336 онгоц өдрийн хоол	1.Чандмань уулан дахь эртний булш, туурь 2. Чандмань уулын рашаан Хотын төвд Ю.Цэдэнбалын талбай 3. Музей, Долоодойн 2 бичигт хөшөө Цагаан хөшөө дахь хүн чулуу Тэрэм хадны зураг
Улаангом – Үүрэг нуурын Хөх эрэг – Улаангом	165 км майханд хоноглох	-Үүрэг нуур , Төв Азийн гадагшаа урсгалгүй гол мөрний ай савд багтдаг тул энэ нуурын загас дэлхийн өөр хаана ч байхгүй Монголын унаган загас юм. Алтайн сугас, Монгол хадран, Осмон, Нохой сугас, Давжаа сугас, Шар загас гэх мэт загастай.

**9.3.2. Эмчилгээний аяллын маршрут***Хүснэгт№ 10.8.*

Аялалын зам	Унаа, зай /км/ тайлбар	Тайлбар
УБ – Улаангом	1336км онгоц өдрийн хоол	1.Чандмань уулан дахь эртний булш, туурь 2. Чандмань уулын рашаан 3. Хотын төвд Ю.Цэдэнбалын талбай 4. Музей, Долоодойн 2 бичигт хөшөө
Улаангом – Хар тэрмэсийн рашаан сувилал Хоноглох тоогоо өөрөө шийднэ	124 км машин	- Их нууруудын хотгорт хамаарах Хяргас нуур нь д.т.д 1028м өндөрт оршдог. 1406 км кв талбайтай, 75 км урт, 31 км өргөн 80 м гүн техтоник гаралтай нуур юм. - Дэгээгээр загас барих боломжтой. - Усанд орж, наранд шарах, шавар эмчилгээ хийнэ - Хяргас нуурын хойд эрэгт байрлах дунд төрмөлийн эриний цэрдийн галавын мөлгөр хар элсэн чулуу, хувирмал занар зэрэг тунамал чулуун доороос ундран гарах рашаан нь гидрокарбонат, сульфат, магни, кальцитын найрлагатай. Ходоод элэг цөсний рашаан юм. - Цагаан идээний эмчилгээ
Хар тэрмэс-Улаангом	124 км	
Улаангом-УБ	онгоц	



## 9.3.3. Уулын бүсийн аяллын маршрутын санал

Хүснэгт № 10.9. Аяллын урт 3 – 5 хоног , Хархираан гол, Ямаат, Олон нуурын аяллын маршрут ,

Өдөр	Аяллын маршрут		Унаа	Үзэх зүйл	Түр хоноглох
	Хаанаас	Хаана			
1	Улаангом	Тариалан сум	35 км Машин	<ul style="list-style-type: none"> <li>Тариалан сумын мэдээллийн төвтэй танилцах</li> </ul>	Жуулчны бааз, Гэр буудалд
2	Тариалан	Хөндийн бэлчир	10 км Морь, Тэмээ	<ul style="list-style-type: none"> <li>Дуут чулуу, Шарын хөндий</li> <li>Түргэн урсгалт гол, Байгалийн үзэсгэлэнт тогтоц</li> <li>Хүн чулуу, Хиргэсүүр</li> </ul>	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
3	Хөндийн бэлчир	Хархираа Түргэний бэлчир	15 км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>Гурван хороо уул, Ан амьтан</li> <li>Ховор ургамал, Хархираа гол</li> </ul>	
4	Хархираа Түргэний бэлчир	Хүрэн үзүүр	18км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>85 өнгийн нуур</li> <li>Мөнх цаст уул</li> <li>Цагаан салаа</li> <li>Мөсөн гол</li> </ul>	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
5	Хүрэн үзүүр	Хархираан эхэн тахилга	20 км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>Хөх нуур</li> <li>108 нуур</li> <li>Рашааны мухар</li> <li>Вансэмбэрүү</li> </ul>	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
6	Хархираан эхэн тахилга	Олон нуур	16 км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>33 хэрээс үзэх</li> <li>Арц</li> </ul>	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
7	Олон нуур	Ямаат	15 км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>Сонгино</li> <li>Аргаль, янгир харах</li> </ul>	
8	Ямаат	Бага ямаат	14 км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>Сонгино</li> <li>Аргаль, янгир харах</li> <li>Буга</li> <li>Ургамал</li> </ul>	
9	Бага ямаат	Хотгорын уурхай	15 км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>Сонгино</li> <li>Аргаль, янгир харах</li> <li>Ургамал</li> </ul>	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
10	Хотгорын уурхай	Улаангом	130 км Машин		
11	Хотгорын уурхай	Баян-Өлгий	150 км Машин		

## Хүснэгт№ 10.10. Хархираан гол, Ямаат, Харгайтын дамжиг, Гоожуурын хүрхрээ, Шаазгай нуурын чиглэлийн аяллын маршрут, 3 – 5 хоног

Өдөр	Аяллын маршрут		Унаа	Үзэх зүйл	Түр хоноглох
	Хаанаас	Хаана			
1	Улаангом	Тариалан сум	35 км Машин	<ul style="list-style-type: none"> <li>Тариалан сумын мэдээллийн төвтэй танилцах</li> </ul>	
2	Тариалан	Хөндийн бэлчир	10 км Морь, Тэмээ	<ul style="list-style-type: none"> <li>Дуут чулуу, Шарын хөндий</li> <li>Түргэн урсгалт гол, Байгалийн үзэсгэлэнт тогтоц</li> <li>Хүн чулуу, Хиргэсүүр</li> </ul>	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
3	Хөндийн бэлчир	Хархираа Түргэний бэлчир	15 км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>Ховор ургамал, Ан амьтан</li> <li>Хархираа гол</li> </ul>	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
4	Бэлчир	Хүрэн үзүүр	18км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>85 өнгийн нуур, Мөнх цаст уул</li> <li>Мөсөн гол, Цагаан салаа, 3 хороо уул</li> </ul>	
5	Хүрэн үзүүр	Хархираан эхэн тахилга	20 км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>Хөх нуур</li> <li>108 нуур</li> <li>Рашааны мухар</li> <li>Вансэмбэрүү</li> </ul>	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
6	Хархираан эхэн тахилга	Олон нуур	16 км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>33 хэрээс үзэх</li> <li>Арц</li> </ul>	
7	Олон нуур	Рашааны мухар	15 км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>Сонгино</li> <li>Жижиг агуй</li> <li>Аргаль, янгир харах</li> </ul>	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
8	Рашааны мухар	Жижиг агуй	14 км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>Сонгино</li> <li>Аргаль, янгир харах</li> <li>Буга</li> <li>Ургамал</li> </ul>	
9	Жижиг агуй	Гоожуурын хүрхрээ	15 км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>Сонгино</li> <li>Аргаль, янгир харах</li> </ul>	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
10	Гоожуурын хүрхрээ	Шаазгай нуур	20 км явган, морь	<ul style="list-style-type: none"> <li>Ургамал</li> <li>Зуун харгайн дамжиг</li> </ul>	
11	Шаазгай нуур	Улаангом хот	170 км Машин		

## Хүснэгт№ 10.11. Онцын тасархай жуулчны баазар дамжин хийгдэх аяллын маршрут 5 – 7 хоног

Өдөр	Аяллын маршрут		Унаа	Үзэх зүйл	Түр хоноглох
	Хаанаас	Хаана			
1	Улаангом	Даваан улиастайн ам	20 км Машин	<ul style="list-style-type: none"> <li>Цагаан улиастайн аманд</li> </ul>	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
2	Даваан улиастайн ам	Хөх нуур	16 км Явган, Морь, Тэмээ	<ul style="list-style-type: none"> <li>Хөх нуур</li> <li>Шар нуур</li> <li>Халтар галуу</li> <li>Малчин айлд зочлох</li> </ul>	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
3	Хөх нуур	Адгийн зуслан	17 км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>Түргэн урсгалт гол</li> <li>Ан амьтан</li> <li>Ховор ургамал харах</li> </ul>	
4	Адгийн зуслан	Дунд хороо	18км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>Түргэн урсгалт гол</li> <li>Ан амьтан</li> <li>Ургамал</li> </ul>	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
5	Дунд хороо	Түргэн гол, Тахилгын бэлчир	40 км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>Янгир</li> <li>Ирвэс, Мануул</li> <li>Хөхтөн</li> <li>Шувуу</li> <li>Цагаан уул цэцэг</li> <li>Рашаан</li> </ul>	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
6	Түргэн гол, Тахилгын бэлчир ДЦГ	Түргэний хар үзүүр	20 км Явган,		
7	Түргэний хар үзүүр	Дэлгэрмөрөн, Бачаа, Баруун салааны бэлчир	19 км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>Төгс буянтын хийд</li> <li>Жижиг агуй</li> <li>Аргаль, янгир харах</li> </ul>	
8	Дэлгэрмөрөн, Бачаа, Баруун салааны бэлчир	Хиргэнэ жуулчны баазад хонох	18 км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>Үүрэг нуур</li> <li>Байгаль ой мод</li> <li>Ургамал</li> </ul>	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
9	Хиргэнэ	Улаангом	93 км Машинаар		

## 9.3.4. Сагил сумын аяллын маршрут 3 – 5 хоног

Хүснэгт № 10.12.

Өдөр	Аяллын маршрут		Унаа	Үзэх зүйл	Түр хоноглох
	Хаанаас	Хаана			
1	Улаангом	Сагил сум	60 км Машин	Сумын төвийн мэдээллийн төв Сумын төвийн музей үзэх	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
2	Сагил сумын төвөөс	Хүсэрлэг	40 км Явган, Морь, Тэмээ	Самшүүр Шар хамар Хүдэр, буга, согоо харах	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
3	Хүсэрлэг	Булган чих	17 км Явган, Морь	Янгир, ирвэс, хойлог, гахай харах Ёл шувуу, нохой зээх,	
4	Булган чих	Хөх дэл	18 км Явган, Морь	Ирвэстэйн мухар	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
5	Хөх дэл	Булагт	19 км Явган, Морь	Их, бага зүрхт уул Баянзүрхийн уулсаар аялах	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
6	Булагт	Шар хад	20 км Явган,	Өвөрмөц тогтоцтой байгаль үзэх	
7	Шар хад	Сагиль	25 км Машин	Ан амьтан харах Төрөл бүрийн эмийн ургамал	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
Өдөр	Аялалын маршрут		Унаа	Үзэх зүйл	Түр хоноглох
	Хаанаас	Хаана			
1	Улаангом	Үүрэг нуур	90 км Машин	Сумын төвийн мэдээллийн төв, Байгалийн ан амьтан Сумын төвийн музей үзэх	
2	Үүрэг нуур	Ямаат	70 км машин	Дуут нуур ,Рашаан Ан амьтан, Загас	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
3	Ямаат	Булгийн эх	км Явган, Морь	Заан хад Түүх дурсгалт газар Шивээ хад	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
4	Булгийн эх	Алтан гадас	Явган, Морь	Янгир, ирвэс, хойлог, гахай харах, Ёл шувуу, нохой зээх	
5	Бөхмөрөн	Баян-Өлгий	107 км Машин		Жуулчны бааз, Гэр буудалд

## 9.3.5. Ховд сумын аялал жуулчлалын маршрут5 – 7 хоног

Хүснэгт№10.13.

Өдөр	Аяллын маршрут		Унаа	Үзэх зүйл	Түр хоноглох
	Хаанаас	Хаана			
1	Улаангом	Тариалан	30 км Машин	Сумын төвийн мэдээллийн төв Сумын төвийн музей үзэх	
2	Тариалан	Шаазгай нуур	120 км машин	Шаазгай нуурын ус шавар Буулт Шувуу ажиглах	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
3	Шаазгай нуур	Шивээтэд	5 км Явган, Морь	Байгалийн өвөрмөц тогтоц Цагаантны дээрэмчдийг бут цохисон хамгаалалт шивээ үзэх	
4	Шивээт	Гоожуурын хүрхрээ	25 км Явган, Морь	үзэсгэлэнт хүрхрээ үзэх	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
5	Гоожуурын хүрхрээ	Гурван хороон бэлчир	12км Явган, Морь	Байгалийн үзэсгэлэнт тогтоц Ус байгаль Цэцэг, ховор ургамал Ховор ан амьтан Цавчим өндөр уул, мөнх цаст уул	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
6	Гурван хороон бэлчир	Хандгайтын дамжиг	5 км Явган, Морь	60 жил болсон дамжиг Өндөр хясаа дээгүүр тавьсан гүүр Загас	
7	Хандгайтын дамжиг	Харзын агуй	7 км Явган, Морь	Байгалийн тогтоцоос үүссэн сүрлэг тогтоцтой, анчид байрлах том агуй Ан амьтан байрлах	
8	Харзын агуй	Олон нуурын бэлчир	8 км Явган, Морь	Нүүдэлчдийн аж ахуй амьдралтай танилцах Үхэр саах, сүү цагаан идээ боловсруулах Хонь ямаа саах	
9	Олон нуурын бэлчир	Ирвэстэйн ам	5 км Явган, Морь	Мөнх цас Олон өнгийн нуур ус Ан амьтан Цэцэг ургамал	
10	Ирвэстэйн ам	Рашааны ам	4 км Явган, Морь	Байгалийн хосгүй сайхан хүний мөр бага гарсан унаган төрхөөрөө байгаа рашаан ус, цэцэг навч, олон өнгийн зэргийг үзэх боломжтой.	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,

**9.3.6. Тариалан сумын аялал жуулчлалын маршрут 3 – 5 хоног**

Хүснэгт № 10.14.

Өдөр	Аяллын маршрут		Унаа	Үзэх зүйл	Түр хоноглох
	Хаанаас	Хаана			
1	Улаангом	Тариалан	30 км Машин	<ul style="list-style-type: none"> <li>Сумын төвийн мэдээллийн төв , Ээж мод</li> <li>Сумын төвийн музей үзэх, Салаа мод</li> </ul>	
2	Тариалан	Шаазгай нуур	120 км машин	<ul style="list-style-type: none"> <li>Шаазгай нуурын ус шавар , Буулт</li> <li>Шувуу ажиглах</li> </ul>	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
3	Шаазгай нуур	Шивээтэд	5 км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>Байгалийн өвөрмөц тогтоц</li> <li>Цагаантны дээрэмчдийг бут цохисон хамгаалалт шивээ үзэх</li> </ul>	
4	Шивээт	Гоожуурын хүрхрээ	25 км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>үзэсгэлэнт хүрхрээ үзэх</li> </ul>	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
5	Гоожуурын хүрхрээ	Гурван хороон бэлчир	12км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>Байгалийн үзэсгэлэнт тогтоц, Ус байгаль</li> <li>Цэцэг, ховор ургамал , Ховор ан амьтан</li> <li>Цавчим өндөр уул, мөнх цаст уул</li> </ul>	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,
6	Гурван хороон бэлчир	Хандгайтын дамжиг	5 км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>60 жил болсон дамжиг</li> <li>Өндөр хясаа дээгүүр тавьсан гүүр</li> <li>Загас</li> </ul>	
7	Хандгайтын дамжиг	Харзын агуй	7 км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>Байгалийн тогтоцоос үүссэн сүрлэг анчид байрлах то</li> <li>Ан амьтан байрлах</li> </ul>	
8	Харзын агуй	Олон нуурын бэлчир	8 км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>Нүүдэлчдийн аж ахуй амьдралтай танилцах</li> <li>Үхэр саах, сүү цагаан идээ боловсруулах</li> <li>Хонь ямаа саах</li> </ul>	
9	Олон нуурын бэлчир	Ирвэстэйн ам	5 км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>Мөнх цас, Ан амьтан</li> <li>Олон өнгийн нуур ус, Цэцэг ургамал</li> </ul>	
10	Ирвэстэйн ам	Рашааны ам	4 км Явган, Морь	<ul style="list-style-type: none"> <li>Байгалийн хосгүй сайхан хүний мөр бага гарсан унаган төрхөөрөө байгаа рашаан ус, цэцэг навч, олон өнгийн зэргийг үзэх боломжтой.</li> </ul>	Жуулчны бааз, Гэр буудалд хоноглох,

## АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ . УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ОДООГИЙН БАЙДАЛ

### 11.1. Уул уурхайн газрын ашиглалтын өнөөгийн байдал, нөөцийн үнэлгээ

#### Увс аймгийн ашигт малтмалын товч мэдээлэл

19-р зууны төгсгөл, 20-р зууны эхээр Оросын газар зүйн нийгэмлэгийн жуулчид, судлаачид Төв ангийн газар зүй, ургамал амьтны аймгийн онцлог, бүтцэд судалгаа хийж эхэлсэн бөгөөд энэ ажлын явцад тухайн нутгийн геологийн тогтоц, ашигт малтмалын талаар замын тэмдэглэл хөтлөж, үндсэн дүгнэлт өгч байсан нь анхны геологийн судалгааны эхлэл болсон байна.

П.Н.Потанин, И.Д.Клеменцын нар анх Улаан даваа., Улаан мөргөний конгломератыг тодорхойлж, мөн Хар Тарвагатайн нүүрсний, чулуун давсны ордуудын тухай бичиглэл хийж, карбоны хурдсас ургамлын үлдэгдлийг олж тогтоосон байна. И.П.Рачковский энд геологийн ажил явуулж анх кембрий, ордовик, силур, девоны настай хурдсуудыг ялгасан. 1943 онд И.Э.Турищев тус аймгийн нутагт 1:1 000 000 масштабын геологийн зураглал, шалгалтын маршрутын ажил явуулж зэс төмрийн орд нээгдэх боломжтой гэж үзээд төрөл бүрийн ашигт малтмалын 42 мэдээллийг шалгасан байна. 1952 онд К.Л.Волочкович мөн 1:1 000 000 масштабын геологийн эрэл-зураглалын ажил явуулж, геологи давхрага зүй, түрмэл чулуулгуудыг ангилж Байрамын нуруу, Түргэний голын дагуу шлихийн дээжинд алтны ганц нэг ширхэгүүд байгааг тогтоожээ. 1961 онд К.Н.Совосин, И.А.Орехов нар Нүүрст хотгор, Хартарвагатай, Явар зэрэг нүүрсний ордуудад эрэл хайгуулын ажил явуулж, тус ордын геологийн зургийг зохиож, чулуун нүүрсний нөөцийг үйлдвэрийн зэргээр тооцсон байна. 1967-1970 онуудад Б.Лувсанданзан, А.Б.Дергунов нар Үүрэг нуурын орчимд судалгаа явуулж, энэ нутгийн давхрага зүйн схемийг боловсруулж, анх Үүрэг нуурын афонитын дайкийн комплексийг ялгасан байна. 1970-аад оноос эхлэж тус аймгийн нутагт 1:500 000-ны геологи-гидрогеологийн зураглалын ажлаар бүрэн бүрхэгдсэн болно. Тус ажлаар геологийн тогтоц, ашигт малтмалын төрөл зүйг тогтоосон байна. 1964 оноос эхлэж 1:200 000-ны геологийн зураглалын ажлаар тус аймгийн нутгийг бүрэн бүрхсэн бөгөөд дээрхи ажлуудын үр дүнд геологийн тогтоц, ашигт малтмалын гарал үүсэл, тархалтын онцлог зэргийг нарийвчлан судалж, хэтийн төлөв сайтай хүдрийн бүс, талбай болон хэсгүүдийг ялгаж үнэлгээ өгсөн байна. Мөн давхрага зүйг бүхэлд нь сери, давхрага, свит, ярус хүртэл ялгаж нарийвчлан ангилсан байна. Мөн интрузив чулуулгуудын насыг нарийвчлан тогтоож, петрографи, петрохими, геохимийн судалгаа хийжээ. 1977 оноос хойш 1:50 000-ны масштабын геологийн эрэл зураглалын ажлаар дэвсгэр нутгийн дөрвөний нэг хувийг бүрхсэн бөгөөд тэдгээр ажлын үр дүнд давхрага зүй, магматизм, тектоникийг нарийвчлан ялгаж ашигт малтмалаас зэс, нүүрс, алт, цайр, гянтболд, металл бус ашигт малтмалын орд илрэлүүдийг илрүүлж тэдний тархалтын зүй тогтол, байршил, гарал үүслийг тодруулж хүдрийн талбай хэсгийг ялгаж цаашид хийх эрэл хайгуулын ажлын талаар тодорхой чиглэл ба зөвлөмж өгсөн байна. Мөн тус аймгийн нутагт Монгол-Орос улсын хилийн дагуу 100 км-ийн

зурваст Оросын геологичид тус бүс нутгийн геологийн тогтоц, металлогенийн онцлогийг тодорхойлсон байна.

**Геологийн тогтоц:** Увс аймгийн нутаг дэвсгэр нь Монгол Алтайн атираат системийн Цагаан шивээтийн структурт-формацийн бүсэд хамаарагдах бөгөөд геологийн тогтоц нь архей-протерозойн хувирмал чулуулгаас палеозой, мезозойн, эх газрын тунамал вулканоген чулуулаг болон кайнозойн хурдас хуримтлалаас тогтоно. Стратиграфийн товч ойлголтыг бичвэл: Дунд архейн ангилаагүй хурдас-биотитот, анар-биотитот, хоёр гялтгануурт, эвэрхуурмаг-биотитот гнейс, доод протерозойн ангилаагүй хурдас-силлиманитот, биотит-эвэрхуурмагт, хоёр гялтгануурт, талст занар, гнейс, дунд рифейн Билүүгийн свит-анар биотитот, биотит-амфиболт серицитот занар, мета-элсжин, гравелит, венд-доод кембрийн Даагаи дэл, Ханхөхийн; Цул уулын свит болон ангилаагүй хурдас-цахиурлаг чулуулаг, бадмар бөсөл-зануужин, андези хүрэм, андезит, хүрэм. спилит, бөсөл, шохойжин, карбонатлап хлорит бүхий шаварлаг занар, доод кембрийн Баян гол, Бургастайн свит-элсжин, алевролит. аргиллит, бөсөл-алевролит, бөсөл-элсжин, хөрзөн, дунд кембрийн Уулын алтайн сери- ногоон өнгийн хувирмал элсжин, хувирмал алевролит, элсжин, цахир, серицит, доод-дунд ордовикийн ангилаагүй хурдас-андези хүрэм, андезит, риолит, тэдгээрийн бөсөл. дунд- дээд ордовикийн Ачит нурын свит-элсжин, гравелит. хөрзөн, алевролит, мергель, дээд ордовикийн Эрдэнэбүрэнгийн свит-элсжин, зануу-элсжин, граптолит бүхий шаварлаг занар, алевролит, доод силурын ангилаагүй хурдас-элсжин, хөрзөн, гравелит, алевролит,, дээд силур-доод девоны ангилаагүй хурдас-элсжин, хөрзөн, гравелит.алевоолит, доод девоны Тээлийн свит, ангилаагүй хурдас-трахиандезит, трахихуоэм, оиолит, хүрэм. дацит, тэдгээрийн бөсөл, доод-дунд девоны Дулаан хар уул, Ямаат голын свит-риолит, трахириолит, түүний бөсөл, элсжин, шаварлаг занар, мөр хөлтөн, гурвалдай бүхий шохойжин, дунд девоны Шаргалтын свит-элсжин, гравелит, алевролит. дунд-дээд девоны Цагаан шивээтийн свит-элсжин, алевоолит, хайргажин. занар, доод карбоны Байрамын свит- элсжин, гравелит, алевролит, риолит, түүний бөсөл, дунд-дээд-карбоны Улиастайн свит-элсжин, алевролит, нүүрслэг занар, хөрзөн, дээд юрагийн ангилаагүй хурдас-хайрга, хөрзөн, элсжин, шаварлаг алевоолит, доод цэрдын Гурван эрээний свит-занар. шавар, филлит, алевролит, доод неогены ангилаагүй хурдас-шүлтлэгдүү хурэм, андези хүрэм. шавар, зануу, элс, дээд неогены ангилаагүй хурдас-улаан өнгийн шавар, зануу, хайрга, мергель, дунд, дунд-дээд дөрөвдөгчийн хурдас-гол нуур, судгийн гаралтай элс, бул ба үхэр чулуу, хайрга, сайрга. хөрзөн хайргажин, элсэнцэр, шавранцар, орчин үеийн хурдас-элс, элсэнцэр, шавранцар, хайрга, бул чулуу, шавар зэрэг чулуулгаас тогтсон байна.

Интрузив чулуулаг нь аймгийн дэвсгэр нутгийн урьд хэсгээр өргөн тархах бөгөөд БХ. өргөрөгийн чиглэлтэй хагарлын хэмжээнд БХ чиглэлд сунаж байралсан том биш ботолит байдлаар оршино. Интрузив нь нас тогтоц, байрлалын байдлаараа протерозой, рифей, венд, палеозой бүхэлдээ хамаарна. Үүнд: түрүү протерозойн ангилаагүй бүрдэл-аймгийн зүүн өмнөд хэсэгт их биш талбайд тархсан өвөрхуурмагт, пироксен-өвөрхуурмагт габбро, оловин-пироксенит норит, хожуу рифейн Завханы бүрдэл ба



ангилаагүй бүрдлүүд-пироксен-эвэрхуурмагт, эвэрхуурмагт гнейс маягийн габбро, биотит-эвэрхуурмагт, биотитот гнейс маягийн тоналит, лейкократ, боржин, боржин-гнейс, биотитот, хоёр гялтгануурт, мусковитот хааяа биотит- эвэрхуурмагт ердийн лейкократ боржин, вендийн ангилаагүй бүрдэл-пироксент, пироксен-эвэрхуурмагт, оловин-пироксент, габбро-габбронорит, дунд-хожуу кембрийн ангилаагүй бүрдлүүд- тоналит, боржин, плагиоклазт биотит- эвэрхуурмагт ердийн боржин, биотит- эвэрхуурмагт, биотитот тоналит, цахирт диорит, хоёр гялтгануурт боржин, дунд-хожуу ордовикийн ангилаагүй бүрдэл-биотитот, хааяа биотит- эвэрхуурмагт их төлөв шүлтлэгдүү лейкократ боржин, биотит-эвэрхуурмагт диорит, цахирт диорит, биотит, эвэрхуурмагт боржин-диорит, дунд ордовикийн Түргэний бүрдэл биотит- эвэрхуурмагт цахирт диорит, диорит, дунд силурын Ховдын бүрдэл пироксен- эвэрхуурмагт габбро-диорит, биотит-эвэрхуурмагт диорит, хожуу девоны Хархираа, Тэсийн бүрдэл-биотитот хааяа

аймаг, түүнээс дээш терриген шохойжин, конгломератын цогцолбороос тогтоно. Энэ цогцолборыг венд доод кембрийн настай гэж үздэг. Атриашилтийн дараа девон, пермийн хурдсуудаар хучигдсан байна. Тус аймгийн нутгийн хэмжээнд илэрсэн томоохон хагарлуудаас нэрлэвэл Цагаан шивээт, Хачгай, Хархираа, Байрамын, Завхан, Үүрэг нуур, Бургастайн гопын гэх мэт олон хэгаолуудыг дурдаж болох юм.

**Металлогений онцлог:** Увс аймгийн дэвсгэр нутагт Ховд, Цагаан шувуутын, Тува-Монгол. Нуурын, Ургэмлын гэсэн металлогений 5 бүсэд Ачит нуур, Үүрэг нуур, Бургастайн гол, Туруун, Хан хөхийн, Хандгайт, Харгант, Чигэртэйн, Дааган дэл, Морьт уул гэсэн 10 хүдрийн дүүрэг ялгажээ. Тус дүүргүүдийн товч бичлэгийг хуснэгт № 2-оос үзнэ үү.

Ашигт малтмалын хувьд тус аймагт 2006 оны байдлаар нийтдээ 41 орд, 255 илрэл, ирээдүйтэй 26 эрдэжсэн цэг, олон тооны геохимийн, шлихийн сарнилын хүрээ, геофизикийн аномалууд тэмдэглэгдсэн байна.

Тус аймгийн нутагт илэрсэн ашигт малтмалын орд, илрэл, хэтийн төлөв бүхий эрдэжсэн цэгүүдийн байрлал, солбицол, хүдрийн биетийн хэлбэр, хэмжээ, агуулга, нөөц, судалгаачдын өгсөн дүгнэлт, хэтийн төлвийг Хуснэгт № 3-т үзүүлсэн болно.

**Хэтийн төлөв:** Увс аймгийн нутаг дэвсгэрт нилээд олон орд, илрэл тогтоогджээ. Аймгийн нутаг дэвсгэр нь бүхэлдээ 1:200 000 масштабтай геологийн зураглалын ажлаар бүрхэгдсэн бөгөөд нутгийн баруун, зуун өмнөд хэсгээр 1:50 000 зураглал-ерөнхий эрлийн ажил хийгдсэн нь нутгийн зөвхөн 30 орчим хувь болж байгаа нь цаашид нутаг дэвсгэрийг бүхэлд бүрхэх шаардлагатай. Тус аймаг нь алт, зэс, ховор металл, гоёл чимэглэлийн чулуу, шатах малтмалын хувьд ирээдүйтэй тул цаашид хийх судалгааг дээрх ашигт малтмалуудад хандуулж явуулах шаардлагатай.

Увс аймагт 2014 оны 5 сарын байдлаар 24 аж ахуй нэгжийн ашиглалтын 40 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна.

*Хүснэгт№ 11.1. Ашиглалтын малтмалын төрөл хувьд:*

Д/д	Ашигт малтмалын төрөл	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо	Аж ахуйн нэгжийн тоо
1	Алт	16	8
2	Барилгын материал	2	2
3	Төмөр	3	3
4	Давс	4	4
5	Холимог металл	1	1
6	Нүүрс	14	9

*Хүснэгт№ 11.2. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хэмжээг аж ахуй нэгж тус бүрээр авч үзвэл:*

Д/д	Аж ахуй нэгж	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо	Талбай, га
1	Геопромонгол	2	84.7
2	Дацантрейд	8	506.2
3	Дельфин	1	42.1
4	Зуун найман суварга	1	29.4
5	Ихтэмүүлэл	1	62.8
6	Монголиан нейшнл рийр	1	394.7
7	Мөст олон булаг	1	117.1
8	Нордпойнт	1	72.9
9	Нэгэнт	1	31.9
10	Ордос трейд	1	97.7
11	Тоосгон уул	1	122.8
12	Увс хүдэр	1	38.07
13	Хар тарвагатай	6	1308.7
14	Хелиосголд	1	64.11
15	Хорикваметалл	1	130.5
16	Хотгор	1	116.9
17	Хотгоршанага	1	814.5
18	Хүдэн	1	51.6
19	Цэрэнбадам	1	507.3
20	Эй Эл Жи Ти	1	111.5
21	Эм Си Жи Ти	1	851.9
22	Эрдэс Увс	2	102.77
23	Эрчим	1	29.0
24	Юм-Агаа	2	160.7
	Нийт	40	5849.85

Тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд 2013 онд улс, орон нутгийн төсөвт оруулсан орлогын хүснэгтээр үзүүлэв.

*Хүснэгт№ 11.3. 2013-оны төсөвт оруулсан орлого.*

Аж ахуйн нэгжийн нэр	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, сая төг	Нийт улсын төсөвт оруулсан орлого, сая төг
Хартарвагатай ХХК	37.5	275.4
Хотгор ХХК	59.1	472.9
Эрчим ХХК	8.4	57.42

*Хүснэгт№ 11.4. Увс аймгийн хэмжээнд 2013 онд үйлдвэрлэл бүтээгдэхүүн гаргалт*

Аж ахуйн нэгжийн нэр	Хөрс хуулалт, мян.м3	Хүдэр олборлолт / бүтээгдэхүүн гаргалт, мян.тн
Хартарвагатай ХХК	35.0	83.9
Хотгор ХХК	441.3	93.54
Эрчим ХХК	30.0	24.0

*Хүснэгт № 11.5. Хайгуулын тусгай зөвшөөрлийн судалгаа.*

<b>Увс аймгийн хайгуулын тусгай зөвшөөрлийн мэдээ</b>		
<b>Нийт хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо</b>	<b>ААН</b>	<b>Эзлэх талбайн хэмжээ (га)</b>
48	34	294251,09

## Хүснэгт№ 11.6. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн судалгаа

д/д	Жагсаалт	Сум/дүүрэг	Талбайн нэр	Эзэмшигч	Нийт хэмжээ (га)	Анхны нөөцийн тухай мэдээлэл	Ашигт малтмал
1	MV-000124	Тариалан	Зайсан салаа	Харгарвагатай	104.9	УЭБЗ-ийн 1995-02-13-ны тогтоол, Зайсан салаагийн алтны шороон орд, дээд доод давхарга 66.7 кг, 10632А	Алт
2	MV-000874	Давст	Шүдэн-Уул	Ихтэмүүлэл	62.84	Тодруулах	Давс
3	MV-001026	Өмнөговь	Сүүж нуур	Эрдэс-Увс	65.59	1986-06-27 ГУУҮЯ-ны ШУТЗ протокол №68 хоолны давсны нөөцийг С1-97.3 м.тн, С2-13.8 м.тн баталсан байна.	Давс
4	MV-002245	Өмнөговь	Хорхойтын адаг	Дацантрейд	101.26	АМХЭГ-ын даргын 2001-03-28-ны №30 тушаал, ЭБЗ-ийн 2001-03-22-ны №16 протокол, Хорхойтын заагийн алтны шороон орд В-70.33 кг, С-40.54 кг	Алт
5	MV-002246	Тариалан	Улаан ам	Дацантрейд	37.22	Тодруулах	Алт
6	MV-003238	Өмнөговь, Тариалан	Бургастайн голын доод хэсэг	Дацантрейд	92.87	Тодруулах	Алт
7	MV-003239	Тариалан	Учрал	Дацантрейд	57.4	Тодруулах	Алт
8	MV-005117	Зүүнхангай	Цавдан	Дельфин	42.18	Тодруулах	Давс
9	MV-010061	Давст	Шүдэн уул	Зууннайман суврага	29.39	Тодруулах	Давс
10	MV-010632	Тариалан	Зайсан салаа	Харгарвагатай	381.38	УЭБЗ-ийн 1995-02-13-ны тогтоол, Зайсан салаагийн алтны шороон орд, дээд доод давхарга 66.7 кг,	Алт
11	MV-010882	Хяргас	Ичээт	Хорикаваметалл	130.54	АМГ-ын даргын 2009.12.25-ны №618 тушаал, ЭБМЗ-ийн 2009.12.04-ний № 28-05 дүгнэлт, Ичээт нэртэй алтны шороон ордын В+С нөөцийг шлихээр 74.92кг, х.ц алт 67.54 кг, В нөөц шлихээр 62.37кг, х.ц алт 56.221 кг, С нөөц шлихээр 12.55кг, х.ц алт 11.32 кг.	Алт
12	MV-011810	Тариалан	Талын салаа-1	Ордострейд	97.77	АМХЭГ-ын даргын 2001-03-28-ны №30 тушаал, ЭБЗ-ийн 2001-03-22-ны №16 протокол, Бургастайн голын алтны шороон орд В-57.86 кг, С-29.19 кг	Алт
13	MV-011860	Тариалан	Улаан ам 1	Дацантрейд	74.46	АМГТХЭГ 2007-05-24 №184	Алт
14	MV-011933	Завхан	Шар толгой	Монголиан Нейшнл Рийр Ийрт Корпорейшн	394.76	Тодруулах	Ховор металл
15	MV-013421	Тариалан	Улаан ам-1	Дацантрейд	24.84	АМГТХЭГ-ын даргын 2007.05.24-ний 184 тоот тушаал, ЭБМЗ-ийн 2007.05.17-ны 8-04 тоот протокол, "Улаан ам-1 алтны шороон орд". Нөөцийн блок уг талбайд багтаж байгааг тодруулах шаардлагатай.	Алт

16	MV-013766	Наранбулаг	Харганат	Эй Эл Жи Ти	111.52	ЭБЗ 1995-05-05 №02-11, АМГ-ын даргын №184 тушаал, ЭБМЗ-ийн 2011.04.15-ний ХХ-07-03 дүгнэлт, "Увс аймгийн Наранбулаг сумын нутагт орших Харганатын төмрийн орд	Төмөр
17	MV-015576	Давст	Цагаан хөшөө адаг	Нэтэнт	31.99	АМГ-ын даргын 2010.02.19-ны 82 тоот тушаал, ЭБМЗ-ийн 2010.02.03-ний ХХ-01-09 тоот дүгнэлт, "Цагаан хөшөөний адгийн тоосгоны шавар" -ын орд. В зэргийн 242008 м3	шавар
18	MV-015632	Сагил	Харгайт	Геопро монгол	70.25	АМГ-ын даргын 2010.07.29-ны №303 тушаал, ЭБМЗ-ийн 2020.07.06-ны № ХХ-09-02 дүгнэлт, Нарийн салааны төв хэсгийн алтны шороон ордын бодитой В нөөцийг шлихээр 110.270 кг химийн цэврээр 103.32 кг, боломжтой С нөөцийг шлихээр 9.131 кг, химийн цэврээр 8.5 кг.	Алт
19	MV-015642	Түргэн	Хээр морьт	Тоосгон-Уул	122.77	АМГ-ын даргын 2010.06.21-ны №241 тушаал, ЭБМЗ-ийн 2010.05.28-ны №ХХ-06-11 дүгнэлт, Хээр морьтын тоосгоны шаврын орд. В зэргийн 874093 м3.	шавар
20	MV-016683	Цагаанхайрхан	Цагаанхайрхан-2	Мөст олон булаг	117.12	АМГ -ын даргын 2009.11.24-ны №540 тушаал, ЭБЗ-ийн 2009.11.12-ны ХХ-25-07 дүгнэлт, Төмөрчулуутын төмрийн орд, 8786Х талбайд В зэргийн хүдрийн нөөц 2380.95мян.тн бүхий 797.55мян.тн металл, С зэргийн 13956.85мян.тн хүдэр бүхий 4568.8мян.тн металл, 14815Х талбайд В зэргийн хүдрийн нөөц 3822.65мян.тн бүхий 1473.45мян.тн металл, С зэргийн 19210.75мян.тн хүдэр бүхий 6566.06мян.тн металл, 16690А-тай цуг	Төмөр
21	MV-016690	Цагаанхайрхан	Түргэний гол	Увс хүдэр	38.07	АМГ -ын даргын 2009.11.24-ны №540 тушаал, ЭБЗ-ийн 2009.11.12-ны ХХ-25-07 дүгнэлт, Төмөрчулуутын төмрийн орд, 8786Х талбайд В зэргийн хүдрийн нөөц 2380.95мян.тн бүхий 797.55мян.тн металл, С зэргийн 13956.85мян.тн хүдэр бүхий 4568.8мян.тн металл, 14815Х талбайд В зэргийн хүдрийн нөөц 3822.65мян.тн бүхий 1473.45мян.тн металл, С зэргийн 19210.75мян.тн хүдэр бүхий 6566.06мян.тн металл, 16683А-тай цуг	Төмөр
22	MV-016957	Зүүнхангай	Баянголын доод хэсэг	Хелиосголд	64.11	АМХЭГ-ын 1998.05.05-ны 116 тушаал, Баянголын алтны шороон ордын протоколтой. Өргөдөл гаргасан талбайд Хос алтан пирамид ХХК-аар маркшейдрийн хэмжилт хийлгэн үлдэгдэл нөөцийг тодруулсан байна. С2-5 болон С2-6 блокуудад 30.4кг алтны нөөцийн үлдэгдэлтэй.	Алт
23	MV-016965	Өмнөговь	Орлогын гол	Юм-Агаа	89.73	АМГ-ын даргын 2010.10.05-ны №426 тушаал, ЭБМЗ-ийн 2010.09.24-ны ХХ-14-03 дүгнэлт, Орлогын голын алтны шороон орд	Алт

24	MV-016998	Өмнөговь	Орлогын гол	Юм-Агаа	71.04	АМГ-ын даргын 2010.10.05-ний өдрийн №426 тоот тушаал, ЭБМЗ-ийн 2010.09.24-ний ХХ-14-03 дүгнэлт, Увс аймгийн Өмнөговь, Тариалан сумын нутаг дахь Орлогийн голын хөндийн алтны шороон орд	Алт
25	MV-017264	Сагил	Харгайт	Геопро монгол	14.44	15632-аас хэсэгчлэн шилжүүлсэн . Тодруулах	Алт
26	MV-017365	Хяргас	Дэлгэрэх	Цэрэнбадам	507.3	АМГ-ын даргын 2013.06.12-ны №241 тушаал, ЭБМЗ-ийн 2013.05.07-ны ХХ-09-08 дүгнэлт, Цагаан түнгийн алтны шороон орд, В зэргээр 89.14кг, С зэргээр 4.44кг	Алт

## Хүснэгт № 11.7. Увс аймгийн ашигт малтмалын товч мэдээлэл

